



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД
ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД
ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ**

№61

УЛААНБААТАР
2025



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД
ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулган
/2025.03.15 - 2025.07.09/

№ 61

Улаанбаатар хот
2025 он

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйл. Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх	3
2. Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээллийн талаарх статистикийн мэдээ	5
3. 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний талаар Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээлэл	6
4. 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний талаар Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээллийг хэлэлцсэн тухай	16
5. 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд Хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээлэл	37
6. 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд Хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээллийг хэлэлцсэн тухай	44
7. 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа” Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээлэл	79
8. 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа” Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээллийг хэлэлцсэн тухай	103
9. 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажил”-ын талаар Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээлэл	129
10. 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажил”-ын талаар Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээллийг хэлэлцсэн талаар	136

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ:

2024 оны 5 сарын 16 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

112 дугаар зүйл. Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх

112.1. Хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон бусад асуудлаар Ерөнхий сайд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх буюу Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдийн асуултад хариулна.

112.2. Ээлжит чуулганы хугацаанд Ерөнхий сайдын хийх мэдээллийн нэгдсэн сэдвийн жагсаалтыг тухайн ээлжит чуулган эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурлын даргад, Ерөнхий сайдын хийх мэдээллийг нэгдсэн хуралдаанаар сонсохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдэд тус тус бичгээр ирүүлнэ.

112.3. Ерөнхий сайдын мэдээллийг Байнгын хороодын хуралдаанаар урьдчилан хэлэлцэхгүй.

112.4. Ерөнхий сайдын мэдээллийг нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд өөрөө хийх ба холбогдох Засгийн газрын гишүүдийг байлцуулна.

112.5. Нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд 25 минутад багтаан мэдээлэл хийх бөгөөд Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн төлөөлөл 25 минутад багтаан үг хэлнэ.

112.6. Энэ хуулийн 112.5-д заасны дагуу Ерөнхий сайд мэдээлэл хийж, цөөнхийн төлөөлөл үг хэлсний дараа цөөнхийн төлөөлөл тус бүр Ерөнхий сайдаас асуулт асууж, үг хэлж болох бөгөөд асуулт асууж, үг хэлэх хугацаа 3 минутаас, хариулт өгөх хугацаа 5 минутаас тус тус хэтрэхгүй.

112.7. Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авах, үг хэлэх нийт хугацаа 1 цаг 30 минутаас хэтрэхгүй.

112.8. Цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлаар Ерөнхий сайд мэдээлэл хийх шаардлагатай гэж үзвэл энэ зүйлд зааснаас өөр цаг, өдөрт хийж болно.

112.9.Энэ хуулийн 112.2-т заасан мэдээллийг ирүүлмэгц сэдвийг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд 5 хоногийн хугацаанд иргэдээс асуулт асуухаар байршуулна.

112.10.Энэ хуулийн 112.9-д заасан цахим хуудсанд иргэдээс ирүүлсэн асуултыг Тамгын газар нэгтгэж нам, эвслийн бүлгүүдэд хүргүүлнэ.

112.11.Энэ хуулийн 112.10-т заасан асуултыг нам, эвслийн бүлэг ангилан багцалж, нам, эвслийн бүлэг тус бүрээс нэг гишүүн төлөөлж Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно. Асуулт, хариултыг цөөнхийн төлөөлөл эхлүүлнэ.

112.12.Энэ хуулийн 112.11-д заасан хугацаа нь энэ хуулийн 112.7-д заасан хугацаанд хамаарахгүй.

112.13.Иргэдийн асуултад Ерөнхий сайд энэ хуулийн 112.11-д заасан хугацаанд багтааж хариулт өгөөгүй бол хариултыг 3 хоногийн дотор Улсын Их Хурлын Тамгын газарт бичгээр ирүүлнэ. Тамгын газар бичгээр ирүүлсэн хариуг энэ хуулийн 112.10-т заасан цахим хуудсанд байршуулна.

---o0o---

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙСЭН МЭДЭЭЛЛИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

№	Сэдэв	Мэдээлэл хийсэн сайд	Мэдээлэл хийсэн огноо	Цөөнхөөс дүгнэлт уншсан эсэх (УИХ-ын гишүүн)	Цөөнхөөс асуулт тавьсан УИХ-ын гишүүн (Асуултын тоо)	Иргэдээс ирсэн асуултыг асуусан УИХ дахь намын бүлгийн төлөөлөл (УИХ-ын гишүүн)		Иргэдээс ирсэн асуултын тоо
						МАН	АН	
1	Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	2025.03.28	О.Цогтгэрэл, Б.Батбаатар, Б.Мөнхсоёл, А.Ундраа	О.Цогтгэрэл гишүүний 4 асуулт	М.Ганхулэг	Ц.Мөнхбат	5 иргэн 19 асуулт
2	"Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд Хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар"	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	2025.04.25	Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, Д.Пүрэвдаваа, Б.Батбаатар	Ж.Баярмаа, Дав. Цогтбаатар С.Эрдэнэболд, С.Цэнгүүн, Л.Мөнхбаясгалан, Б.Батбаатар Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Д.Жаргалсайхан нарын 9 гишүүн 18 асуулт	О.Батнайрамдал	Б.Жаргалан	4 иргэн 17 асуулт
3	"Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа"	Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан	2025.05.30	О.Цогтгэрэл, Б.Мөнхсоёл, А.Ундраа, Б.Батбаатар	Г.Ганбаатар, Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, С.Эрдэнэболд, Ц.Мөнхтуяа нарын 5 гишүүний 9 асуулт	Ж.Галбадрах	Ц.Мөнхтуяа	14 иргэн 22 асуулт
4	"Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажил"-ын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар	2025.06.27	О.Цогтгэрэл, Г.Уянгахишиг, М.Нарантуяа-Нара	Г.Очирбат, Г.Ганбаатар, Ш.Бямбасүрэн, Б.Жаргалан, С.Цэнгүүн, О.Цогтгэрэл нарын 6 гишүүний 12 асуулт	М.Мандхай	Дав.Цогтбаатар	2 иргэн 7 асуулт

---o0o---

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙСЭН ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ

1.1. 2025 ОНЫ 3 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН ДОРОЙТЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ



Л.Оюун-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс байгалийн унаган төрхөө харьцангуй хэвээр хадгалж үлдсэн дэлхийн цөөн орны нэг хэдий ч дэлхийн дулаарал, байгаль цаг уурын хувьсал өөрчлөлт, хүн амын өсөлт, нийгэм, эдийн засгийн хөгжил, хотжилт зэргээс үүдэн байгаль орчны бохирдол, газрын доройтол нэмэгдэж экосистемийн тэнцвэрт байдал алдагдах эрсдэл нэмэгдэж байна.

Дэлхийн улс орнууд төлөвлөлтийн хандлагаа өөрчилж, тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, нөөцийн хэмнэлттэй ногоон хөгжлийг гол зорилгоо болгож байна. Манай улсын хувьд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнгээр хамтарсан Засгийн газрыг байгуулж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох асуудлыг тэргүүлэх чиглэл болгож, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамыг өөрчлөн байгуулаад ажиллаж байна.

Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, хэрэгжүүлж байгаа болон цаашид авах арга хэмжээний талаар товч танилцуулья.

Нэг. Уур амьсгалын өөрчлөлтийн талаар:

Монгол Улс газар зүйн байршил, цаг уурын онцлог, нүүдлийн соёл зэргээс хамааран нийгэм, эдийн засгийн хувьд уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өртөмтгий, эрсдэлтэй орнуудын тоонд орж байгааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Монгол Улсын хөгжлийн төлөв байдлын шинжилгээ тайланд онцолсон байдаг. Манай орон “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын суурь конвенцод 1992 онд, Парисын хэлэлцээрт 2016 онд тус тус нэгдэн орж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээг эрчимжүүлэх, өөрчлөлтөд дасан зохицох чадварыг сайжруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилт тавьсан.


“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн

засгийг хөгжүүлж, 2050 он гэхэд хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн зөрүүг тэглэх олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах” зорилтыг тусгаж, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний зорилтыг шинэчилж, ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх, нүүрстөрөгчийн зах зээлийг хөгжүүлж, ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн салбар дундын зохицуулалтыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр манай орны агаарын жилийн дундаж температур сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд 2.4 хэмээр дулаарч, улсын хэмжээнд 832 нуур ширгэж, мөсөн голын талбай 29.9 хувиар багасаж, нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртөж, ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл, ган, зудын давтамж нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар бий болж байна.


Уур амьсгалын өөрчлөлтийн 2100 он хүртэлх ерөнхий төлөвөөс үзэхэд улирлын агаарын температур тогтвортой нэмэгдэж дулаарах хандлагатай бөгөөд өөрчлөлтийн тоон утга 2030 оны үед 0.7-1.4 хэм, 2050 оны үед 1.1-2.9 хэм, 2080 оны үед 1.2-6.5 хэмээр тус тус нэмэгдэж, жилд хүйтэн өдөр 8.8-36.9 хоногоор багсах, зун хэт халалт 2.8 хоногоор нэмэгдэх, өвөл хэт хүйтрэлт 2.6 хоногоор буурахаар байна.

1 дүгээр зураг. Өвөл, зуны хур тунадасны ирээдүйн өөрчлөлт



Хур тунадасны хувьд өвлийн улиралд харьцангуй их (8.7-55.4 хувь), намар болон хаврын улиралд ялимгүй их, зуны тунадас өөрчлөлтгүй байхаар байна.


2 дугаар зураг. Өвөл, зуны хур тунадасны ирээдүйн өөрчлөлт



Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой Монгол орны байгалийн нөөц, нийгэм эдийн засгийн салбарын өнөөгийн эмзэг байдал, ирээдүйн эрсдэлийн үнэлгээгээр аялал жуулчлалаас бусад салбаруудад 1-2 ангиллаар эрсдэлтэй түвшинд шилжихээр байна.

Байгалийн нөөцөөс бэлчээр хөрс, ойн нөөц, цэвдэг, мөстөл мөсөн гол, нийгэм эдийн засгийн салбараас мал аж ахуй, газар тариалан, дэд бүтэц зэрэг салбарт эмзэг байдлын индексийн үзүүлэлт 0.23-0.38-аар нэмэгдэхээр байна.

3 дугаар зураг. Хөдөө аж ахуйн салбарын уур амьсгалын эрсдэлийн индекс




Манай улсын хувьд хүлэмжийн хийн ялгаруулалтын үнэмлэхүй хувь хэмжээ бага боловч нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ногдох хувь хэмжээгээр дэлхийн дунджаас 15 дахин их байна. Хүлэмжийн хийн нийт ялгарал 1990 оноос хойш 82.1 хувиар нэмэгдсэн нь хүн амын төвлөрөл, үйлдвэрлэлийн хэрэглээ, малын тоо толгойн өсөлттэй холбоотой бөгөөд нийт хүлэмжийн хийн 51.1 хувийг хөдөө аж ахуйн салбар, 44.7 хувийг эрчим хүчний салбар, үлдсэн хувийг аж үйлдвэрийн болон барилга, тээвэр, хог хаягдлын салбар ялгаруулдаг.

Уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн өртөмтгий байгаа нь ган, зудын давтамж нэмэгдэж, малчдын амьжиргаанд үзүүлж байгаа сөрөг нөлөөллөөс ажиглагдаж байна. 2023-2024 оны өвөл нутаг дэвсгэрийн 90 хувь нь зудын өндөр эрсдэлтэй тулгарч, 190.0 мянган малчин өрхийн амьжиргаанд хүчтэй нөлөөлсөн.

Монгол Улсын Засгийн газар Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ыг 2019 онд баталж, хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22.7 хувиар буюу 16.8 сая тонн нүүрстөрөгчтэй дүйцэхүйц хэмжээгээр бууруулах зорилт тавьсан. 2020-2024 оны хэрэгжилтийн үнэлгээгээр эрчим хүч, тээвэр, барилгын салбарт хамаарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтын хэрэгжилт 39.7 хувь, мал аж ахуй, газар тариалантай холбоотой зорилт 53.9-59.7 хувь, ой, усны нөөцийг хамгаалах зорилт 70-98.3 хувь, биологийн олон янз байдлыг хамгаалах зорилт 70.6 хувь, байгалийн гамшигтай холбоотой зорилт 65 хувь, нийгмийн эрүүл мэнд 83.6 хувь, нийгмийн хамгааллын зорилт 43.1 хувьтай байна.

4 дүгээр зураг. “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ын 2020-2024 оны хэрэгжилтийн үнэлгээ




Тухайлбал: 2017-2024 онд Сайншанд, Цэций салхин цахилгаан станц болон 12 байршилд нарны станцыг ашиглалтад оруулж сэргээгдэх эрчим хүчний нийлбэр хүчин чадлыг 2016 онтой харьцуулахад 4 дахин нэмэгдүүлсэн. Сэргээгдэх эрчим хүчний суурилуулалт, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээний үр дүнд 1042.2 мянган тонн, эрчим хүчний хэрэглээний салбар болох барилгын салбараас 353.9 мянган тонн, аж үйлдвэрийн салбараас 20.5 мянган тонн, тээврийн салбараас 227.7 мянган тонн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулаад байна.

Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв аймгуудын төвд одоо ашиглаж байгаа хуучирсан үр ашиг муутай халаалтын зуухыг орчин үеийн 85 хувийн өндөр үр ашигтай зуухаар солих ажил барилга угсралтын шатанд хийгдэж байна. Эрдэнэбүрэн, Эг, Шүрэнгийн усан цахилгаан станцыг байгуулах төсөл ашиглалтад орох хугацаа хойшилсноос тус салбарын зорилтын хэрэгжилт удаашралтай байна. Харин ой, усны нөөцийг хамгаалах, биологийн олон янз байдлын хамгааллыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт 70-98.3 хувийн биелэлттэй байгаа нь 2021-2024 онд 650 булаг, шанд, рашааны ундаргын 7 эхийг хамгаалж, хөв цөөрөм 40-ийг байгуулж, гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг нийт газар нутгийн 17.8 хувьд хүргэж, газрын доорх усны хяналт шинжилгээний сүлжээний 325 цэгийн мэдээллийг нэгдсэн системд холбож, ойн арчилгаа, цэвэрлэгээг жил бүр дунджаар 34.0 мянган га, ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийг 10.9 сая га, заган ойн нөхөн сэргээлтийг 539 га-д хийж, Монгол орны ойн санг 8.48 хувьд хүргэсэн ажлын үр дүн юм.

“Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ын ойн салбарын үнэлгээний тооцоогоор 2024 онд ойн хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлсэн түвшин зорилтот түвшин 4.33 хувиас бага зэрэг давж, 4.46 хувьд хүрсэн.

5 дугаар зураг. Ойн салбарын хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх сценари болон үнэлгээний түвшин, хувиар



Азербайжан Улсын Баку хотноо 2024 оны 12 дугаар сард зохион байгуулагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын Талуудын 29 дүгээр бага хурлаас улс орнууд 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 2019 оны суурь төвшнөөс 43-аас багагүй хувиар бууруулж, дэлхийн дулаарлыг 1.5°C хэмд хязгаарлах амлалтыг дахин бататгаж, хүлэмжийн хий ялгаруулдаг голлох салбарууд болох эрчим хүч, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ыг 2025 онд багтаан ахиулан шинэчлэх, хөгжиж буй орнуудад хүлэмжийн хийн тооллогын системийг сайжруулж, ил тод байдлыг нэмэгдүүлэхийг уриалсан.

Үүнтэй холбогдуулан Монгол Улс 2035 он хүртэл эрчим хүчний салбарт сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30 хувьд хүргэх, эрчим хүчний алдагдлыг 9.1 хувиар бууруулж, үр ашгийг 40 хувиар нэмэгдүүлэх, цахилгаан авто тээврийн хэрэгслийн эзлэх хувийг 13 хувьд хүргэх, дулаан цахилгааны үйлдвэрлэлээс бусад хэрэглээнд түүхий нүүрсний хэрэглээг 50 хувиар бууруулах, аж үйлдвэрийн салбарт цемент үйлдвэрлэлийн түүхий эдийн 25-30 хувьд үнс ашиглах, хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах хувь хэмжээг 40 хувьд хүргэх, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, түймэрт шатсан талбайн хэмжээг 30 хувь, хөнөөлт шавжид нэрвэгдсэн талбайн хэмжээг 41 хувиар бууруулах зорилтыг ахиулж, Үндэсний зорилтыг 2025 оны 2 дугаар улиралд багтаан шинэчилж, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.


Хоёр. Цөлжилт, газрын доройтлын талаар:

Нэгдсэн Үндэстний байгууллагын Цөлжилттэй тэмцэх конвенцын нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан тодорхойлолтоор Монгол улсын нийт газар нутгийн 90 орчим хувь нь эмзэг бүс нутагт хамаарч, цөлжилт, газрын доройтлын үйл явцад өртөмтгий гэсэн ангилалд орсон байна.

Цөлжилтийн төлөв байдлын үнэлгээг 5 жилд тутамд хийдэг бөгөөд 1992 онд хийсэн судалгаагаар нийт нутаг дэвсгэрийн 41.3 хувьд цөлжилт илэрч байсан бол цөлжилтөд нэрвэгдсэн газар нутгийн хэмжээ жил бүр нэмэгдэж,

2020 оны байдлаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая га талбай бүхий газар нутаг цөлжилтөд тодорхой хэмжээгээр өртсөн байна. Үүний 23 хувь буюу 30 орчим сая.га талбай цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж байна.

6 дугаар зураг. Цөлжилт, газрын доройтлын төлөв байдал, 2020 он



Говь, хээрийн бүсийн хур тунадас багатай Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Төв, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай зэрэг аймгийн нийт нутаг дэвсгэрийн 50-95 хүртэл хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн судалгааны дүн гарсан.

Энэхүү судалгааг 2010 онтой (газар нутгийн 77.8 хувь цөлжилтөд өртөж, үүнээс хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлд 16.6 хувь) харьцуулахад бууралт ажиглагдаагүй, хүчтэй, нэн хүчтэй доройтолд өртсөн газрын хэмжээ нэмэгдээд байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ган, хуурайшилтын давтамж нэмэгдэж цөлжилт, газрын доройтлыг түргэтгэж байна.

1 дүгээр хүснэгт. Цөлжилтөд өртсөн газар нутгийн хэмжээ, хувь (5 жилээр)

Цөлжилтийн үнэлгээ хийсэн он	Сул илэрсэн нутаг	Дунд зэрэг илэрсэн нутаг	Хүчтэй илэрсэн нутаг	Нэн хүчтэй илэрсэн нутаг	Бүгд (Хувь)
2006 он	23.0	26.0	18.0	5.0	72.0
2010 он	35.3	25.9	6.7	9.9	77.8
2015 он	24.1	29.8	16.8	6.1	76,8
2020 он	31.5	22.1	18.6	4.7	76.9

Сүүлийн 30 жилд мал сүргийн тоо толгой 3 дахин нэмэгдэж, бэлчээрийн даац хэтэрч, байгалийн ургамал нөхөн сэргэх, үрлэх боломжийг хязгаарлаж, ургамлын зүйлийн төрөл зүйл цөөрөх, зарим зүйл ургамал устах аюулд хүрч, соргог бэлчээр багасаж экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулж байна. Доройтсон газрын 60 гаруй хувь нь цаг агаарын тааламжтай нөхцөлд бэлчээрийн менежментийг зөв хэрэгжүүлсэн тохиолдолд 3-5 жил, хүчтэй, нэн хүчтэй доройтолд өртсөн 40 орчим хувь нь 7-10 жилд сэргэх төлөвтэйг судлаачид тогтоосон байдаг.

Улсын Их Хурлаас 2020 онд баталсан Малын тоо толгойн албан татварын тухай хуулиар малын тоо толгойд төлбөр ногдуулж эхэлсэн нь бэлчээр ашиглалтыг сайжруулах, нөхөн сэргээх, орон нутгийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн давуу талтай хэдий ч тоо толгойг зохистой хэмжээнд барих эдийн засгийн хөшүүрэг болж чадахгүй байна. Монгол орны бэлчээрийн даацыг хонин толгойд шилжүүлснээр жилд дунджаар 74.3 сая толгой малтай байх боломжтой гэж судлаачид үздэг (А.Бакей, 2020) бөгөөд Үндэсний статистикийн хорооны 2024 оны тайлангаар хонин толгойд шилжүүлснээр 110.7 сая толгой мал байгаа нь даацаас 36.4 саяар хэтэрсэн байна.

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд жил бүр 200 орчим га талбайд улсын төсөв болон олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд цөлжилт, газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тухайлбал: Өвөрхангай, Булган, Говь-Алтай аймагт 50 га талбайд элсний нүүлт сааруулах механик хаалт, говийн баянбүрдийг нөхөн сэргээх ажлыг 70 га талбайд, Дундговь, Говь-Алтай, Говьсүмбэр, Өвөрхангай аймагт хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг 800 га талбайд, Говьсүмбэр аймагт байгалийн ургамал тарих ажлыг 10 га талбайд, Баянхонгор аймагт заган ойн байгалийн сэргэн ургалтыг дэмжиж 500 га талбайг хашиж хамгаалах ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн байна. Мөн төсөл хөтөлбөрийн хүрээнд Дорнод Монголын хээрийн бүсэд газрын тогтвортой менежментийг сайжруулах хүрээнд 2024 онд Сүхбаатар аймагт ухаалаг газар тариалангийн технологийг 2,317 га талбайд нэвтрүүлж, 470 га талбайд ногоон тэжээл тарьж нийт 845,981 га бэлчээрийг өнжөөх, сэлгэх, хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Цөлжилтөөс хамгаалах механик хаалт хийх туршилт судалгааны ажлыг Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг дахь “Элсэн тасархай” дахь 25.0 га талбайд хийж гүйцэтгэсэн. БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд “Цөлжилттэй тэмцэх хамтарсан судалгааны төв” байгуулах төслийг хэрэгжүүлэхээр Нийслэлийн Хан-Уул дүүрэгт 4 га газрыг шийдвэрлэж, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах судалгааны ажлыг эхлүүлээ.

Мөн БНХАУ-ын Шинжаан-Уйгурын өөртөө засах орны Экологи газарзүйн хүрээлэнтэй хамтран Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум, Чойр хотод цөлжилтөөс хамгаалах туршилт судалгааны суурин байгуулж, Замын-Үүдээс Чойр хот хүртэлх автозам болон төмөр замын дагуу цөлжилтийн үнэлгээ хийх хэмжилтийн багажуудыг суурилуулсан.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2020 онд улсын хэмжээнд хийсэн судалгаагаар эвдэрч эзэнгүй орхигдсон 30,793 га талбай байгааг тогтоож, өнгөрсөн 4 жилийн хугацаанд 8,000 га талбайг нөхөн сэргээх зорилтын хэрэгжилт 12,117 га-д хүрсэн үр дүнтэй байна. Цаашид нөхөн сэргээлт хийгдээгүй газрын эзэн холбогдогчийг тогтоож, уул уурхай, дэд бүтцийн бүтээн байгуулалтын улмаас эвдэрсэн газруудыг бүрэн нөхөн сэргээхэд анхаарч ажиллаж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар газар, ус, ой, ан амьтан, ургамлын нөөц ашигласны төлбөр 100 хувь орон нутгийн төсөвт төвлөрдөг бөгөөд 2024 онд 283.9 тэрбум төгрөг төвлөрч, 2023 оны орлогоос 30.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 57.1 хувь буюу 162.3 тэрбум төгрөг газрын төлбөр, 30.6 хувь буюу 86.9 тэрбум төгрөг усны нөөцийн төлбөр, 7.1 хувь буюу 20.1 тэрбум төгрөг ойн нөөцийн төлбөр, 5.1 хувь буюу 14.6 тэрбум төгрөг амьтны нөөцийн төлбөр, 0.1 хувь буюу 363.7 сая төгрөг ургамлын нөөцийн төлбөр бүрдүүлж байна. Энэхүү орлогын 15-85 хүртэлх хувийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд буцаан зарцуулах хуулийн зохицуулалттай бөгөөд 2024 онд улсын хэмжээнд 47.4 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 6.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 50 гаруй хувийг бүрдүүлж байгаа газрын төлбөрийн орлогоос хөрс, газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах нь чухал юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нь цөлжилт, газрын доройтлыг бууруулах бодит алхам болж, доройтсон газрыг нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход тодорхой үр дүнд хүрч, 2024 оны байдлаар 84 сая мод тарьж, бэлтгэл үе шатны гүйцэтгэл нь 42.4 хувьтай байна. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 452 мод үржүүлгийн газар үйл ажиллагаа явуулж 124 зүйлийн 63 сая ширхэг тарьц суулгацын нөөцийг бүрдүүлсэн. Энэ нь өмнөх жилийнхтэй харьцуулахад 5 дахин өссөн үзүүлэлт юм.

Мөн хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” зэрэг үндэсний хөтөлбөрүүд нь мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлэх, ядуурлыг бууруулах, цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэх, газрын тогтвортой менежментийг хэрэгжүүлэх харилцан уялдаатай бодлого гэж үзэж байна. Энэ хүрээнд малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, атаршсан талбайг тариаланд шилжүүлэх, тэг элдэншүүлгийн технологийг бүрэн нэвтрүүлэх зэрэг газрын доройтлыг бууруулахад чиглэсэн ажлыг хэрэгжүүлж, бодит үр дүн гаргахаар ажиллаж байна.

Цөлжилт, газрын доройтлын асуудал нь нэг улс, нэг аймгийн асуудал биш бүс нутаг, цаашилаад дэлхийн хэмжээнд хурцаар тавигдаж, 196 улс орон нэгдэн орсон “Ган, цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнууд ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай” Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид Монгол

Улс 1996 онд нэгдэн орсон. Энэхүү конвенцын Талуудын бага хурал 2 жил тутам зохион байгуулагддаг бөгөөд 2024 онд Талуудын 16 дугаар бага хурал Саудын Арабын хаант Улсын Эр-Рияд хотноо зохион байгуулагдсан юм.

Талуудын 16 дугаар бага хуралд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөл оролцож, “Тогтвортой хөгжлийн төлөө тэмүүлэе: Нүүдэлчдийн өв, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээр” (Go sustainable: Nomadic heritage, resilient rangeland) арга хэмжээг зохион байгуулж, улс орныхоо соёл уламжлал, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, ногоон хөгжлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, олон талт санаачилгыг дэлхий нийтэд танилцуулсан.

Талуудын 17 дугаар бага хурлыг Монгол Улсад 2026 онд зохион байгуулахаар бэлтгэл хангаж байгаа бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нар Монгол Улс Талуудын 17 дугаар бага хурал (COP17)-ыг зохион байгуулах орон болохыг баталгаажуулж, 2025 оны 02 дугаар сард Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бонн хотноо гарын үсэг зурсан.

Түүнчлэн манай улс “Бэлчээр, нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил-2026” (IYRP 2026) санаачилгыг НҮБ-ын түвшинд батлуулж, Талуудын 17 дугаар бага хурлын үйл ажиллагааг уялдуулж, “Ирээдүйн төлөөх бэлчээрийн олон улсын эвсэл”-ийг байгуулах санаачилгыг эхлүүлээд байна.

Энэхүү арга хэмжээ нь монголчуудын олон мянган жилийн турш хүн, байгалийн харилцан шүтэлцээтэй, эх болсон байгаль дэлхийгээ шүтэн амьдарч ирсэн нүүдлийн соёл уламжлал, бэлчээрийн тогтвортой менежментийг дэлхий нийтэд сурталчилж, анхаарлын төвд оруулах, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Засгийн газрын 2025 оны 28 дугаар тогтоолоор Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын Талуудын 17 дугаар Бага хурлыг зохион байгуулах Үндэсний хороог байгуулж, хурлын бэлтгэл ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий ажлын албыг Гадаад харилцааны яамны дэргэд ажиллуулж байна.

Гурав. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт газрын доройтлыг бууруулах чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

- Уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх, дасан зохицох чадварыг сайжруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, нүүрстөрөгчийн зах зээлийн шинэ механизмыг Монгол Улсад нэвтрүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийг улс, орон нутгийн төсөвт тусгаж хэрэгжүүлэх, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэхээр анхдагч хуулийн төслийг боловсруулж байна.

- Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангаж хөрсний үржил шим, чийгийг хамгаалах, механик эвдрэлээс сэргийлэх, соргог бэлчээрийг хамгаалж, байгалийн бүс бүслүүрийн онцлогт тохируулан доройтсон газрыг нөхөн сэргээх салбар дундын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна.
- Цөлжилтийг бууруулах, доройтсон газрыг сэргээх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, санаачилгыг дэмжих урамшууллын механизм, эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэх чиглэлээр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 1 хувийн татварын хөнгөлөлтөд хамруулах шаардлагыг салбарын яамнаас батлан хэрэгжүүлж эхлээд байна.
- Бүсчилсэн хөгжлийн татварын бодлогын хүрээнд Малын тоо толгойн албан татварын тухай хуульд бэлчээр хамгаалах арга хэмжээг нарийвчлан тусгаж, татварыг байгалийн бүс бүслүүрийн онцлог, малын төрлөөр ялгавартай шинэчлэн тогтоож, бэлчээрийн даацаас хэтэрсэн тохиолдолд бэлчээр, усны нөөц ашигласны төлбөр тооцох эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.
- Тусгай хамгаалалттай газрын хэмжээг 2030 он гэхэд нийт нутгийн 30 хувьд хүргэх зорилтын хүрээнд ойн сан, хүлэрт намаг бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамруулсан 35.1 сая га талбайг улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөж байна.
- Улс орны нийгэм, эдийн засгийн чухал салбаруудыг цаг агаарын гэнэтийн аюул болох үер, аянга, мөндөр, хүчтэй салхинаас хамгаалах, эрт сэрэмжлүүлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан цаг уурын радарын станцын сүлжээ байгуулах явдал чухал байна.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 15-аас доошгүй хувийг хөрсний бохирдол, цөлжилт газрын доройтлыг бууруулах арга хэмжээнд жил бүр зарцуулж, хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах чиглэлийг аймаг, нийслэлийн хэмжээнд анхаарч ажиллах шаардлагатай байна.
- Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах талаарх хуулийн хэрэгжилтийг сайжруулах, бэлчээрийн газрын хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх, нүүрстөрөгчийн зах зээлд оролцох эрх зүйн зохицуулалтыг бий болгож, санхүүгийн олон талт эх үүсвэрийг бүрдүүлнэ.

Монгол Улсад 2026 онд Цөлжилтийн конвенцын Талуудын 17 дугаар бага хурлын зохион байгуулах болон дээрх асуудлуудыг шийдвэрлэхэд Улсын Их Хурлын дэмжлэг, Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага, иргэд, хувийн хэвшил, малчид, тариаланчдын хамтын оролцоо, үүрэг хариуцлага, хүчин чармайлт чухал гэдгийг онцолж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

---oOo---

**2025 ОНЫ 3 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН
ХУРАЛДААНД УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН
ДОРОЙТЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ ХИЙСЭН МЭДЭЭЛЛИЙГ
ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ**

Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын Салбар дундын уялдааг зохицуулах хэлтсийн дарга Э.Бат-Идэр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан, тус яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Мөнхзул, Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Уур амьсгалын өөрчлөлтийн хэлтсийн дарга Н.Цогцолмаа, Цөлжилт, газрын доройтол хариуцсан ахлах шинжээч С.Баярцэцэг, тус хэлтсийн Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах бодлого, зохицуулалт хариуцсан шинжээч Ц.Мөнхбат, Усны газрын дарга З.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, мөн газрын зөвлөх Б.Отгонсүрэн, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, ХҮН намыг Б.Мөнхсоёл, Үндэсний эвслийг А.Ундраа, Иргэний Зориг Ногоон намыг Б.Батбаатар нар төлөөлж үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-д заасны дагуу цахим хуудсанд 5 иргэнээс ирүүлсэн 19 асуултыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Ц.Мөнхбат, Монгол Ардын намын бүлгийн төлөөлж С.Ганхүлэг нар иргэдийн асуултыг тавьж, хариу авав.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцод 1992 онд, Парисын хэлэлцээрт 2016 онд тус тус нэгдэн орж олон улсын хурал зөвлөгөөнд тасралтгүй оролцсоор ирсэн ч уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохоос өөрөөр давж хийсэн ажилгүй 30 жилийг үдсэн мэдээлэл та бид танилцаж байна. 19 дүгээр зууны сүүлээс өнөөг хүртэл хугацаанд дэлхийн агаарын дундаж хэм 1 градусаар нэмэгдсэн байхад манай орны хувьд сүүлийн 80 жилд 2.4 хэмээр дулаарчээ. Түүгээр тогтохгүй 1990 оноос хойш 35 жилд хүлэмжийн хийн нийт ялгарал 82 хувиар нэмэгдэж нийт нутаг дэвсгэрийн 76 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртжээ. Ширгэсэн нуурын тоо, багассан мөсөн голын талбай ч сэтгэл эмзэглэн түвшинд очсоныг уг мэдээлэлд дурджээ.

Үүнээс үүдэн ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл ган, зудын давтамж ч нэмэгдсээр байна. Ийм учраас олон улсын байгууллагууд бидний уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өртөмтгий эрсдэлтэй орнуудын тоонд оруулан нэрлэсээр ирсэн. Үүний учир шалтгааныг хариуцсан салбарынхан хүн амын төвлөрөл, үйлдвэрлэлийн тоо хэмжээ, малын тоо толгойн өсөлттэй холбон тайлбарлаж буй нь бодит байдалтай нийцэхгүй байна. Манай орны хувьд өвлийн улирлын оргил ачааллын үе дэх 1600-1800мВт эрчим хүчний ачаалал ирэх жилүүдэд өсөн нэмэгдсээр 2030 он гэхэд 3500мВт давах тооцооллыг салбарын мэргэжилтнүүд гаргадаг. 2017-2024 онуудад улсын хэмжээнд шинээр 12 байршилд нарны станц ашиглалтад оруулж сэргээгдэх эрчим хүчний нийлбэр хүчин чадлыг 2016 онтой харьцуулахад 4 дахин нэмэгдүүлсэн хэдий ч жилээс жилд өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээ шаардлага, түүний дутагдлыг нөхөх эх үүсвэрийн бүтээн байгуулалтын чадалтай харьцуулахад үлэмж хэмжээгээр бага байна.

Ерөнхий сайдын мэдээлэлд Монгол Улсын хувьд хүлэмжийн хийн ялгаруулалтын үнэмлэхүй хувь хэмжээ бага боловч нэг хүнд ногдох болон нэгж ДНБ-ий үйлдвэрлэлд ногдох хувь хэмжээгээр дэлхийн дунджаас 15 дахин их байна гэж дурджээ. Энэ нь хүлэмжийн хий ялгаруулж буй салбаруудын үр ашгийг нэмэгдүүлж ДНБ-ийг өсгөх замаар тоон үзүүлэлтийг зохистой болгох шаардлагатай байгааг харуулж байна. Гэвч мал аж ахуйн салбараас харахад малын толгойн тоо цөлжилт, ган зудын улмаас огцом буурсан идэвхгүй үзүүлэлтийг хүлэмжийн хий бууруулсан үр дүн мэтээр ашиглан өөрсдийгөө тоо баримтын хувьд хуурах нь нэг талаар улс орны эдийн засгийг агшаахад тодорхой хэмжээнд хувь нэмэр оруулж буй өрөөсгөл шийдвэр гарахуйц тоо баримт гэж харагдахаар болчихжээ. Мал аж ахуйн салбарт 2018 оны байдлаар 71 сая тоо толгойд хүрээд байсан малын тоо өнгөрсөн жил 57 сая хүрч 18 хувиар буурсан. Манай улсын газар нутгийн хэмжээгээр хэд дахин бага Шинэ Зеланд орон мал аж ахуйн салбараа хөгжүүлж нэмүү өртөг шингэсэн үнэ цэнийг дэмжсэн тогтолцоог бий болгох замаар хөдөө аж ахуйн салбараасаа жилд 40 орчим тэрбум ам.долларын экспорт хийж байгаагаас харвал хөдөө аж ахуйн салбараасаа үр ашигтай бодлого явуулах хэрэгцээ шаардлага тулгамдсан байгааг бид нарт харуулдаг.

Харин ой, усны нөөцийг хамгаалах, биологийн олон янз байдлын хамгааллыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт харьцангуй өндөр хувийн биелэлттэй байгаа нь булаг шанд, рашааны ундаргын эхийг хамгаалж, хөв

цөөрөм байгуулж, ойн арчилгаа цэвэрлэгээг жил бүр нэмэгдүүлж, ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын ажлыг нэмэгдүүлж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж буй нь тодорхой үр дүн гарч байна. Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд бүтээлчээр дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах асуудалд урт хугацааны тогтвортой бодлоготой байх шаардлагатай ба үүнтэй холбогдуулан Засгийн газраас авч хэрэгжүүлэх үндэсний зорилт, арга хэмжээний хүрээнд Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн зүгээс дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна.

Монгол Улс 2035 онд хүртэл эрчим хүчний салбарт сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30 хувьд хүргэх зорилт тавьсан. Тухайн үеийн эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг 3500МВт-д хүргэхээр зорьсны 1000 нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр байгааг эргэн харж, хөрөнгө оруулалтын бодит боломж сэргээгдэх эрчим хүчний тариф болон сэргээгдэх үүсвэрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний үнийн зөрөөг дэмжих тарифаар нөхөн олгоход эдийн засгийн тооцоолол, төсвийн дарамт зэргийг нягтлан үзэх шаардлагатай.

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний хүрээнд эрчим хүч, дэд бүтэц, хөдөө аж ахуй, ойн болон халаалт дулааны зэрэг технологид инновац нэвтрүүлэх, урамшуулах бодлогыг баримтлах, цаашлаад хувийн хэвшлийн оролцоог хангахад түлхүү анхаарах шаардлагатай байна. Монгол Улсын статистикийн тоон мэдээгээр 1990 оноос хойш жилд дунджаар 240 мянган га хүртэлх ойг ойн хөнөөлт хортон шавж болон ойн түймэрт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баярлалаа. О.Цогтгэрэл даргад 1 минут нэмье.

О.Цогтгэрэл: Манай улсын хувьд жилд орох бороо хурын давтамж хэмжээ багасаж, хур тунадасны хэмжээ илт буурсан нь хөрш зэргэлдээ орнуудын хөдөө аж ахуйн салбарт үүлэнд нөлөөлөх технологиос хамаарч буйд судалгаа болон ажиглалт хийж, илт нөлөөлж байгаа тохиолдолд хөрш орнуудтай бодлогын яриа хэлэлцээр хийх шаардлагууд байна.

Хөдөө аж ахуйн салбарт усалгаатай газар тариаланг хөгжүүлэх, малын тэжээл тариалалтыг усалгаатай технологиор дэмжих, газар тариаланд хөрс хамгаалах арга хэмжээ дорвитой хэрэгжүүлэх, ойн зурвас байгуулах, гол мөрний урсац болон үерийн усаар хуримтлуулах нуур цөөрөм хуримтлуулах зэрэг санаачилгуудыг идэвхтэйгээр хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

НҮБ-ын өмнө хүлээсэн үүрэг, тавьсан амлалтын хэрэгжилтийн тайланг гаргаж, олон нийтэд байршуулах, ногоон хөгжлийн бодлогын хүрээнд Дэлхийн ногоон сангийн санхүүжилтийн боломж, нүүрстөрөгчийн зах зээл, карбон кредит зэрэг эдийн засгийн хөшүүргийн механизмыг түлхүү ашиглах, идэвхжүүлэх, ногоон санхүүжилтийг татах чиглэлд үндэсний чадавхыг бэхжүүлэх зэрэг чиглэлд онцгойлон анхаарах шаардлага байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь дэлхий нийтэд, бүс нутаг, улс үндэстний нийтийн асуудал тул хүрээлэн буй орчиндоо хандах иргэний эерэг

хандлагаас төрийн тулхтай бодлого хэрэгжих хүртэлх бүх шатад санаачилга гарган ажиллах шаардлагатай байгааг анхаарахыг сануулъя. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл гишүүн үг хэлнэ. Индэрт урья.

Б.Мөнхсоёл: Сайн байцгаана уу, өдрийн мэнд хүргэе. Эрхэм Улсын Их Хурлын дарга, гишүүд, Ерөнхий сайд аа,

Дэлхийн нийтэд мөн манай улсын хувьд өнөөдөр болон ирээдүйд улам бүр анхаарах сэдвийн талаар Ерөнхий сайд танилцууллаа. Ерөнхий сайдын илтгэлд 1992 оноос хойших 28 жилийн хугацаанд цөлжилтөд өртсөн газар нутгийн хэмжээ 36 хувиар нэмэгдэж, нийт нутаг дэвсгэрийн 77 хувь нь цөлжилтөд тодорхой хэмжээгээр өртсөн гэлээ. Энэ нь нэг талаас дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, нөгөө талаас бэлчээрийн менежмент, сүргийн бүтэц болон бусад салбараас үүдэлтэй хүний хүчин зүйлсийн нөлөөнөөс хамаарч буй юм.

Манай улс уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын конвенцод нэгдэн орж, 2030 он гэхэд Монгол Улс хүлэмжийн хийн ялгаруулалтаа 22.7 хувь буюу 16.9 сая тонноор бууруулна гэсэн амлалт өгсөн. Тэгвэл хүлэмжийн хийн нийт ялгаруулалтын 52 хувийг бий болгож буй Хөдөө аж ахуйн салбар, 45 хувийг бүрдүүлж буй эрчим хүчний салбарт дорвитой ахиц гаргахуйц ажлууд үгүйлэгдэж байна.

Бидний өгсөн амлалт, хийж буй ажлууд, өөр хоорондоо зөрөлдөх тохиолдлууд ч байсаар байна. Тухайлбал, бэлчээрийн даацыг бууруулж, менежментийг нь сайжруулах үүднээс малын тоо толгойг 52 саяд хүргэх тооноос чанарт шилжих шаардлагатайг эрдэмтэн судлаачид тооцоод гаргачихсан. Энэхүү зорилгоор малын тоо толгойн албан татварыг 2020 онд Улсын Их Хурлаас баталсан. Гэвч уг татвар нь малын тоо толгойг бууруулж, чанарыг сайжруулах эдийн засгийн хөшүүрэг болж хараахан чадахгүй байна.

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахын тулд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг орон даяар өрнүүлэх санаачилга гарган хэрэгжиж байна. Гол нь тэрбум модоо 2030 он хүртэл тарьж ургуулах суулгацыг бэлдэж, модыг ургуулах ойг нөхөн сэргээх арчлах бизнес загвар болохуйц ойн аж ахуйг хөгжүүлэх шаардлага байна.

Ойн менежментийг цогцоор нь хөгжүүлэхэд ойн аж ахуйн мэргэжилтнүүдийг бэлдэх, хүний нөөцийг сургах, санхүү, татварын зохицуулалтаар урамшуулах, салбаруудын бодлогын зохицуулалтыг сайжруулах зэрэг арга хэмжээг авах хэрэгтэй харагдаж байна. Тухайлбал, хөдөө аж ахуйн сургуулиас гадна мэргэжлийн болон техникийн боловсролын төвүүд ч хүний нөөцийг бэлтгэхэд оролцмоор байна. Хэрэв бусад улс шиг ойн аж ахуйг хөгжүүлж, ногоон бизнесийг эдийн засгийн нэг салбар болгож чадвал тогтвортой хөгжлийн зорилго 8 болох зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлт, зорилго 13 болох

уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, зорилго 15 болох хуурай газрын экосистемийг хамгаалах зэрэг зорилгуудыг биелүүлэхэд хувь нэмэр оруулахаас гадна хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэнээр ядуурлыг бууруулах, өлсгөлөнг зогсоох зорилгуудад ч эерэг нөлөө үзүүлэх юм.

Энэ мэтчилэн аливаа бодлогыг гаргаж хэрэгжүүлэхдээ бусад салбарт үзүүлэх үр нөлөө, салбар хоорондын уялдааг харгалзан нэг сумаар олон туулай буудах бодлого, үйл ажиллагааг хөдөө аж ахуй, эрчим хүч, хог хаягдлын менежментийн чиглэлээр хэрэгжүүлмээр байна. Чадвал 2030 он хүртэлх 5 жилийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг тодорхой ахиц гаргаж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр болох юм.

Улсын Их Хурлын гишүүдийн хувьд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох зорилгоор бодлого хоорондын уялдааг хангах, ногоон хөгжлийг дэмжих эдийн засаг, санхүүгийн хөшүүрэг, зохицуулалт, нүүрстөрөгчийн зах зээл, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх зэрэг олон харилцааг зохицуулах “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” хуулийн төслийг хэлэлцэн сайжруулж, Улсын Их Хурлаар батлах нь 2025 онд хийх гол ажил болох юм.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дэргэдэх Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороог ахалж байгаагийн хувьд энэ жил Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт, уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон ядуурлыг бууруулах, зохистой хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаарх танилцуулгыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас тавьж, мэдээлэл сонсохын зэрэгцээ Улсын Их Хурлын Тамгын газар олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр Улсын Их Хуралд тайлагнадаг байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрхэн хангаж буйг давхар нягталдаг болоход анхаарч ажиллана.

Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах зэрэг Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлж, дэлхийн бусад улсын өмнө өгсөн амлалтаа биелүүлэх нь шийдвэр гаргагчид бодлого боловсруулж хэрэгжүүлэгч байгууллага бүрийн үүрэг тул бодлогын хэрэгжилт болон салбар хоорондын уялдааг хангаж ажиллах, тогтвортой хөгжлийн зорилгуудыг үйл ажиллагаандаа тусган биелүүлэх нь чухал байна. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Агваанлуvsангийн Ундраа гишүүн үг хэлнэ. Индэрт урьа.

А.Ундраа: Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлтэй танилцлаа. Бид байгальтайгаа зохицон амьдардаг нүүдэлчин соёл ахуйтай агуу уламжлалт үндэстэн билээ. Нийгэм, эдийн засгийн томоохон салбарууд мал аж ахуй, газар тариалангаас хамаардаг нь манай улс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг эмзэг хүлээж авах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Үүнийг ч олон улсын байгууллагуудаас дүгнэж хэлж байна. Хүний үйл ажиллагаанаас үүдсэн байгаль орчны нөлөөлөл, олон сөрөг үр дүн гарч байгаа нь бидний нүдэнд ил байна. Монгол Улс НҮБ-ын уур

амьсгалын өөрчлөлтийн тухай конвенцод 1992 онд, Парисын хэлэлцээрт 2016 онд тус тус нэгдэн орсон эхний улсуудын нэг бөгөөд тодорхой амлалт өгч олон улсын тавцанд үүрэг хүлээсэн.

Уур амьсгалын өөрчлөлт тэр дундаа цөлжилт, газрын доройтол эрчимтэй явагдаж буй улсын тоонд ороод байна. Нийт газар нутгийн 76.9 хувь нь цөлжилтөд өртсөн байгаа нь аюулын дохио гэж үзэж байна. Энэ үзүүлэлт сүүлийн 14 жилийн хугацаанд 4.9 хувиар нэмэгдсэн нь дэлхийн дулаарал малын тоо толгойн өсөлт, хүний зүй бус үйл ажиллагаатай холбоотой.

Манай улс олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр олон судалгаа, төсөл хөтөлбөр авч хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай. Монгол Улсын газар нутгийн тодорхой хувийг тусгай хамгаалалтад авч, тодорхой хэлбэл 30 хувь хүртэл хэмжээг тусгай хамгаалалтад авч, цаашдын хөрсний доройтол, цөлжилтөөс хамгаалахаар зорьж байгаа нь зайлшгүй хийгдэх сайшаалтай арга хэмжээ юм. Гэсэн хэдий боловч олон улсын байгууллагуудад найдаж суулгүйгээр төсвийн төлөвлөлтийг оновчтой хийх шаардлагатай байна. Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсронгуй болгож, асуудалд шинжлэх ухаанчаар хандах шаардлагатай гэдэг нь саяын мэдээллээс харагдлаа.

Бид тунхаг бичиг бүхий цаасан хэлбэрээр олон эрх зүйн баримт бичигтэй болох гэхээсээ иргэддээ уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөл байдлыг зөв таниулж, хувь нэмэр оруулахыг уриалан манлайлж ажиллах шаардлага байгааг саяны тоо баримтууд харуулж байна.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг байдлыг бууруулах, дасан зохицох, угтаж хөгжихөд хүн бүрийн хүчин чармайлт хэрэгтэй. Түүнчлэн үнэт өв соёл болох нүүдэлчин соёлыг хамгаалан түүний зэрэгцээгээр бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүйгээр бүсчлэн бүс нутаг бүрээр тоо толгойн хэм хэмжээг зохистой тогтоож, тооноос чанарт анхаарал хандуулсан бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Малчид олон малаас ашиг шим хүртэнэ. Мянгат малчин гэж шагнахаасаа нэг малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлэх, бэлчээрийн даацтай уялдуулах, амьжиргааг дэмжих бодлогыг бүсчлэн хөгжүүлэх шаардлагатай байна. Тодорхой жишээнүүд дурдвал, өнгөрсөн жилд Хөвсгөл аймагт ган гачиг тохиолдсон бол энэ жилийн өвлийн байдлаар цас хур тунадас бага унасан байгаа нь хангайн бүсэд ховор тохиолддог. Гэтэл говийн бүс нутгуудаар үер усны аюул нүүрлэсэн нь Монгол орны цаг агаар, эрс тэс уур амьсгал аль хэдийнээ аюулын түвшинд хүрснийг харуулж байна.

Хөвсгөл нуурын цөнгийн түрэлт жил бүр 6 дугаар сарын 22-ны өдөр буюу нар буцах өдөр болдог байсан бол өнгөрсөн жил 5 дугаар сарын 29-ний өдөр цөн түрсэн нь бүс нутгийн мөнх цастай уулын цас мөс эрчимтэй хайлж, усны нөөц урт хугацаандаа хойд бүс нутгуудаар ч дутагдаж болзошгүйг харуулж байна. Иймд нийт газар нутгийн 80 орчим хувь нь цөлжилтөд өртөж байгаа энэ

цаг үед төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангаж ажиллах тухайлбал, цаг уурын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээний хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн үр ашгийг нэмэгдүүлэх, үүний тулд хойд бүс нутагт төдийгүй бусад газар нутагт мод ихээр тарих, тарьсан модоо ургуулж арчлах, хоёрдугаарт аймаг, сум бүрд хиймэл нуур цөөрөм олноор байгуулах санал санаачилгыг дээр дурдсан арга хэмжээтэй уялдуулах, гуравдугаарт Тогтвортой ноолуурын хөтөлбөр зэрэг малчдын амьжиргааг дэмжсэн ажлуудын уялдаа холбоог хангаж ажиллах шаардлагатайг харуулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн үг хэлнэ. Индэрт урьж байна.

Б.Батбаатар: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүд ээ, Ноёд, хатагтай аа,

Уур амьсгалын өөрчлөлт газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний асуудалд Улсын Их Хурлын 118 гишүүнийг бүрдүүлсэн МАН, АН, ХҮН намын эрх баригчдаас томилогдсон Ерөнхий сайдын мэдээлэлд Иргэний Зориг Ногоон Намын байр суурийг төлөөлөн илэрхийлье.

Байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт нь аж үйлдвэржилт, түүхий эд, байгалийн баялгийн зохисгүй ашиглалт, үлэмж нэмэгдсэн хэрэглээ, технологи зэрэг хүний буруутай үйл ажиллагааны улмаас үүсэж байгаа. Тодруулбал хүний буруутай үйл ажиллагааны улмаас хүлэмжийн хий буюу нүүрсхүчлийн хийн ялгаруулалт нэмэгдсэнээр температурын өсөлт 2030 он гэхэд 0.7-1.4 хэмээр, 2080 он гэхэд 1.2-6.5 хэмээр нэмэгдэх тооцоо гарчээ. Температур 1 градусаар нэмэгдэхэд ДНБ 0.48 хувиар саардаг болохыг судлаачид, эдийн засагчид тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл нэг градусаар нэмэгдсэнээр өнөөдрийн нөхцөлд Монгол Улсад 456 тэрбум төгрөгийн алдагдал хүлээхээр байна гэсэн үг.

Байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар хөгжиж буй орнуудын хүн ам тэр дундаа нийгмийн ядуу давхаргад нөлөөлдөг. Дэлхийн банкны тооцооллоор 2030 он гэхэд 100 сая хүн нэмж туйлын ядууралд орох магадлалтай төдийгүй манай улсын хүн амын 1/3 хувьд шууд нөлөөлөхөөр байна. Харин 2/3 хувьд нь дам нөлөөллөө үзүүлэх хандлага байгааг бид бодолцох ёстой. Монголбанкнаас хийсэн уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг дахь нөлөөллийн судалгаанд Монгол орны агаарын жилийн дундаж температур 80 жилийн хугацаанд 2.25 градусаар дулаарсан нь дэлхийн дунджаас 2 дахин өндөр, байгалийн гамшигт үзэгдлийн тоо 2010 оноос хойш 1.8 дахин нэмэгдсэн байна. Монгол орны хувьд байгалийн гамшигт үзэгдлийн тоо эрс нэмэгдэж, температур хурдацтай нэмэгдэж байгаа нь ургацын гарцыг бууруулж, бэлчээрийн доройтол цөлжилтийг нэмэгдүүлснээр хөдөө аж ахуйн гарцыг бууруулах эрсдэл өндөр байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ өндөр, мал аж ахуйгаас хамааралтай манай улсын хувьд уур амьсгалын өөрчлөлт нь эдийн

засагт сөргөөр нөлөөлөхөөс гадна иргэдийн амьжиргаа, амьдралын хэв маяг, хүн амын нягтрал буюу хот, төв суурин газрыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх зэрэг нийгмийн олон асуудлыг дагуулна. Түүнчлэн иргэдийн эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчинд амьдрах боломж, амьдралын чанарт ч сөргөөр нөлөөлөхөөс гадна мод, ургамлын төрөл зүйл, ургалт, насжилт, бичил биетнээс эхлээд зэрлэг амьтдын тоо толгой, төрөл зүйл, бэлчээрлэлт гээд биологийн олон янз байдалд ч үлэмж өөрчлөлтийг авч ирнэ. Иргэний Зориг Ногоон намын үзэл санаа, үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг бол байгаль экологийн тэнцвэртэй байдал, экологийн чиг баримжаатай, нийгмийн даацтай эдийн засгийн хүртээмжтэй ногоон хөгжлийг тууштай дэмжиж түүчээлэн манлайлах явдал билээ.

Уур амьсгалын өөрчлөлт бол дэлхий нийт бүс нутгийг хамарсан олон улсын глобал асуудал боловч бид уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бүхий боломжийг хувь хүнээс эхлээд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, бодлого боловсруулагчид, төрийн байгууллага, олон улсын байгууллага төдийгүй бүс нутгийн болон бусад улс орнуудын хамтын оролцоог дэмжин ажиллах зарчмаар шийдэх нь зүйтэй. Нэг талаас байгаль орчны доройтол уур амьсгалын өөрчлөлтөд хүргэж буй хүний буруутай үйл ажиллагааг бууруулах, таслан зогсоож нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлт, байгаль экологийн доройтол, байгалийн гамшгийн эрсдэлд өртөж болзошгүй субьектүүдийг хамгаалах, үүсэж болзошгүй хохирлыг бууруулах шаардлагатай байна.

Иймээс Иргэний Зориг Ногоон нам Засгийн газрыг дараах чиглэлд ажиллахыг сануулж шаардаж байна. Үүнд,

Нэгдүгээрт, байгалийн нөөцийг хэтрүүлэн ашиглах, зүй бусаар ашиглах явдлыг тогтоох, хянах, таслан зогсох.

Хоёрдугаарт, хувь хүмүүсийн хүрээлэн буй орчныг бохирдуулах, доройтуулах явдлыг бууруулах, иргэдийн экологийн боловсролыг тэдний нас, сэтгэл зүйн онцлогт тохируулан дээшлүүлэх сургалт нөлөөллийн ажлыг бүх арга замаар зохион байгуулах. Мөн байгаль, экологи, уур амьсгалд эерэг нөлөөтэй авч хэрэгжүүлсэн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа боломжийг тодорхойлон дэмжих шаардлагатай.

Гуравдугаарт, хуванцрын хэрэглээг бууруулах. Ингэхдээ нэг удаагийн хуванцрын импортын татварыг нэмэгдүүлэх, зарим хэрэглээг хязгаарлах, хуванцрыг орлуулах хувилбар, цаасан хэрэглээг дэмжих зэргээр нэг удаагийн хуванцрын хэрэглээг бууруулах хуулийн төслийг санаачлан батлуулах шаардлагатай.

Дөрөвдүгээрт, олон жилийн дунджаар байгалийн гамшиг тохиолддог бүс нутгуудын хийгээд гамшигт өртөх магадлал бүхий айл өрх, иргэд, мал, эд хөрөнгийн зэргийн нарийвчилсан судалгааг гаргах. Тэдгээр эрсдэл болон учирч болох хохирлыг бууруулах үйл ажиллагааг орон нутгийн засаг захиргааны

байгууллага, онцгой байдал, цагдаагийн албатай хамтран хэрэгжүүлэх, түүнийг дэмжих, мөн тухайн эрсдэл бүхий бүс нутагт амьдарч буй иргэд, аж ахуйн нэгжид гамшгийн эрсдэлийн бэлэн байдлын талаар болон гамшгийн эрсдэлээс хамгаалуулах, хохирол багатай даван туулах боломжит хувилбарыг хэрэгжүүлэхийг дэмжих.

Тавдугаарт, тогтвортой ногоон хөгжлийг хөгжүүлэх болон инновацын кластеруудыг бий болгоход дэмжлэг үзүүлж, судлаачид, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдыг нэгтгэн байгальд ээлтэй шийдлүүдийн талаар хамтран ажиллах.

Зургаадугаарт, нар, салхи, усан цахилгаан эрчим хүч зэрэг ногоон эрчим хүчний эх үүсвэрт шилжих үйл явцыг түргэтгэх бодлого, сэргээгдэх эрчим хүчний найдвартай байдлыг нэмэгдүүлэхийн тулд эрчим хүч хадгалах технологийн судалгааг дэмжих.

Долоодугаарт, ногоон тээвэр, эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, байгальд ээлтэй хот төлөвлөлт зэрэг тогтвортой байдлыг нэн тэргүүнд тавьсан дэд бүтцийн төслүүдэд хөрөнгө оруулах.

Наймдугаарт, газар тариалан, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэргээр тогтвортой хөдөө аж ахуйн практикт инновацыг дэмжин орон нутгийн хүнсний тогтолцоог сайжруулах, газар тариаланд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Б.Батбаатар: Газар тариалан, түгээлт, хүнсний технологийн чиглэлээр ажлын байр бий болгох санаачилгыг дэмжих зэрэг шийдлүүдийг санаачлан ажиллахыг Засгийн газарт уриалж байна.

Цаашид Засгийн газар өөрөө өөртөө сөрөг хүчний хэлбэр хийцээр олон нийтийг төөрөгдүүлсэн Улсын Их Хурлын индэр дээрээс төөрүүлэх зүйл хийдгээ болимоор байна. МАН, АН, ХҮН намын хамтарсан эрх барьж байгаа 118 гишүүнтэй бүлэг Засаг дээрээ сөрөг хүчний үүргийг гүйцэтгэх ба Улсын Их Хурлын индэр ашиглахгүй байхыг дахин сануулж зөвлөж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мэдээлэл хийж дууслаа. Мэдээлэлтэй холбогдуулан Ерөнхий сайд болон салбарын сайд, ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн төлөөлөл Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Одонгийн Цогтгэрэл гишүүн, Батын Батбаатар гишүүн хоёроор тасаллаа. Батын Батбаатар гишүүн та асуултаа асууна уу?

Б.Батбаатар: Ардын намын бүлгийн дарга, АН-ын бүлгийн дарга, ХҮН намын дарга энэ 3 хүнээс асуумаар байгаа юм. Цөөнх гэж юуг үзэж байгаа юм бэ гэдгийг хариулж өгөөч гэж хүсэлт тавьж байна.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой Ерөнхий сайдын мэдээлэл орж ирж байна. Уур амьсгалын өөрчлөлт гэдэг асуудлыг хүний хүчин зүйлтэй холбоотой, холбоогүй гээд янз бүрийн байр сууриуд байдаг. Тэгэхдээ яалт ч үгүй тоогоор илэрхийлэгддэг эдийн засагтай холбоотой олон асуудал дэлхий нийтэд тулгамдаж байдаг. Тэр тусмаа хүлэмжийн хий, CO₂-ын ялгаруулалт, нүүрстөрөгчийн давхар исэлттэй холбоотой эдийн засгийн харилцаа юм. Энэ харилцааны цаана карбон кредит гээд бүхэл бүтэн том зах зээл үүсчихсэн явж байна. Тэгэхээр Монгол Улсын хувьд энэ уур амьсгалын өөрчлөлтөд оруулж байгаа нөлөө гэдэг зүйл бага гэж үзэж таарах байх. Тэгэхээр дэлхий нийтэд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөд их хэмжээний нөлөөг үзүүлж байгаа тухайлбал, агаар бохирдуулж байгаа улс орнуудын төлөх карбон кредитийн мөнгө өнөөгийн байдлаар ямар хэмжээтэй дүн байна вэ?

Өнөөдөр Монгол Улсад олгогдсон нийт зээлийн нэг орчим хувь нь ногоон санхүүжилтийн хүрээнд ашиглагддаг. Энийг 10 орчим хувь хүргэж нэмэгдүүлэх боломжтой гэдэг тоонуудыг уншиж байсан. Мөн ногоон карбон кредитийн мөнгөн дүн нь жилд 20 орчим хувиар нэмэгдэж байгаа гэсэн нэг албан бус тоонууд байдаг. Тэгэхээр Монгол Улс өнөөдөр эдийн засгийн боломж бололцоонуудыг хэрхэн, яаж ашигладаг вэ? Ямар боломжууд бид нарт байдаг вэ? Аж ахуйн нэгж, иргэд үүнд хэрхэн яаж оролцох боломжтой байдаг вэ? гэсэн тодорхой тоон мэдээллүүдийг өгөөч гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Салдангийн Одонтуяа сайд хариулт өгье.

С.Одонтуяа: Маш чухал асуулт асуулаа. Дэлхий ертөнц уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчноо хамгаалахад гарах зардлыг улсын төсвөөр ямар ч орон хийж чадахгүй гэдгийг бүгд хүлээн зөвшөөрсөн. Өмнө нь ийм сан байгуулагдаад сангийн зардлаар хийж байсан бол одоо ямар ч боломжгүй болсон. Тийм учраас заавал оролцогч талуудын сонирхлыг багтаасан хөрөнгө оруулалт байх ёстой гэдэг дээр санал нэгдсэн. Үүний нэг хэлбэр бол яах аргагүй карбоны арилжаа байгаа. Тэгэхээр манай улсад гадаадын олон байгууллагууд, гаднын Засгийн газрынхан ирээд карбоны арилжааны талаар олон санал тавьдаг. Манайд энэ чиглэлийн хууль, эрх зүйн орчин бүрдээгүй учраас Эдийн засаг, хөгжлийн яам Л.Гантөмөр сайдаар ахлуулаад манай яамтай хамтраад өнгөрсөн сарын богино хугацаанд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулаад ерөнхийдөө дуусах шатдаа явж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуульд таны хэлсэн бүх зүйлүүдийг зохицуулах боломжуудыг нээх гэж байгаа юм.

Хуулийн нэг бүлэг нь карбоны арилжаатай холбоотой байгаа. Тэгээд карбоныхаа тооллогыг яаж зохион байгуулах уу, яаж эрсдэлийн үнэлгээг хийх үү, яаж тайлагнах уу, үндэснийхээ карбон кредит бүртгэлийг яаж хийх үү гээд бүх зохицуулалтыг тусгаж байгаа. Тэгэхээр ямар ч байсан нэг эрх зүйн бичиг баримттай больё гэж байгаа.

Бусад орнуудын хувьд Засгийн газрынх нь том арилжааны хэлбэрт багтдаг. Жишээлэхэд Сингапур улс хамгийн идэвхтэй ажиллаж байгаа. Эндээ 1 тэрбум ам.доллар зарна гээд, нийтдээ 22 улстай карбоны хэлэлцээр

хийчихсэн байна. Япон 29 улстай, Швейцар 17 улстай гээд дэлхийн улс орнууд том арилжааныхаа зах зээл рүү ороод эхэлсэн. Яагаад гэхээр тухайн улс орон дотор нь хүлэмжийн хий ялгаруулж байгаа газруудад татвар нь өндөр болсон учраас бусад орноос карбоныг байгаль орчинд нь зарцуулж мөнгө олох хэлбэрт шилжсэн байгаа.

Манайд гэр хорооллыг сэргээгдэх эрчим хүчтэй холбох нэг айл бүрд 3 мянган ам.долларын нарны зай батарей байх төслийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа. Энэ төсөл нь айлаас мөнгө гарахгүйгээр яндангүй бүс болгоод, тэгээд мөнгөө карбон кредитээс ойролцоогоор жилийн 900 ам.доллар авах арилжаа-нууд байгаа. Манайд утаагүй зуух тавьсан банкнууд, банк бусууд карбон кредитийн арилжааг хийгээд явж байсан. Үүнийг эрчимжүүлэх хэрэгтэй. Орчин үед улс орнууд өрөө наймаалцдаг болсон. Жишээлэхэд сая манай Сангийн яам, Эрүүл мэндийн яам хамтраад “debt for health” гэж чухал хөтөлбөрийг эхлүүлсэн. Энэ нь эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллаад өрнөөсөө хасуулах юм. Тэгэхээр манайх яамны хувьд “debt for nature” гэдэг өрийн харилцан тооцох арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Би дахиад хэлэхэд зөвхөн төсөв төслөөр уур амьсгалтай тэмцэх, байгаль орчноо хамгаалахтай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээ больсон. Том банкнууд, санхүүгийн байгууллагууд өөрсдөө идэвхтэй оролцож байж энэ зах зээл амжилттай хөгжинө гэдгийг дэлхийн улс орнууд тодорхойлоод ирсэн учраас сүүлийн COP17¹-ын хурлуудад дандаа хөрөнгө оруулагчид, банкнууд ийм зах зээлд карбон кредитийг мөнгө болгоё, арилжаа болгоё гэсэн чиглэлээр ажиллаад байгаа. Манай улс энэ “joint credit” гээд механизмд нэгдээд олон жил болсон ч харьцангуй бага хэмжээнд явж байгаа. Манай улсын нийт эдийн засгийн 10 хувь нь ногоон эдийн засаг гэж үзэж байгаа бол 90 хувь нь хүрэн эдийн засаг байна гэхээр энэ тоог багасгах шаардлагатай байгаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.9-д заасны дагуу намын бүлэг тус бүрээс нэг гишүүн төлөөлж Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуултуудыг асууна. Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Мөнхбат асуулт асууна. Ц.Мөнхбат гишүүн асуултаа асууж эхэлье.

Ц.Мөнхбат: Монгол Улсын Ерөнхий сайд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийхтэй холбогдуулан “d.parliament” цахим системд ирүүлсэн иргэдийн асуултыг уламжилж байна.

Иргэн Батбаатарын зүгээс байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэдэн хувийг цөлжилт, газрын доройтлыг бууруулахад ашиглаж байна вэ гэдэг асуулт байна.

¹ Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын Конвенцын талуудын бага хурал

Хоёрдугаарт, сүүлийн жилүүдэд орон даяар шороон шуурга шуурах давтамж нэмэгдэж байгаа нь цөлжилтийн аюул бодит болсныг харуулж байна. 3 жилийн өмнө цөлжилт, газрын доройтол, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд мэдээлэл хийж байсан. Түүнээс хойш цөлжилттэй тэмцэх талаар ямар ахиц гарав? Энэ хугацаанд цөлжилт хэдэн хувиар нэмэгдсэн бэ гэсэн асуулт байна.

Гуравдугаарт, сүүлийн үед цөлжилтийн асуудал яригдах боллоо, одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар мэдээлэл өгнө үү гэсэн байна.

Дөрөвдүгээрт, Монгол Улсад 2026 онд зохион байгуулагдах оролцогч талуудын 17 дугаар бага хурлын ач холбогдол, бэлтгэл ажлын талаар юу хийж байгаа вэ гэдэг асуулт байна.

Тавдугаарт, одоогийн мал сүргийн тоо толгой Монгол орны бэлчээрийн даацаас үлэмж хэтэрч байгаа бөгөөд улам өссөөр байна. Үүний улмаас бэлчээрийн газар нутгийн 2/3 нь доройтсонд тооцогдож, 10 хувь эргэлт буцалтгүй доройтолд оржээ. Түүнчлэн Монгол Улсын мал аж ахуйн салбар олон улсад нүүрстөрөгч ялгаруулалтын эрчмээр хамгийн өндөрт тооцогдож байна. Манай Засгийн газар үүн дээр ямар байр суурьтай байна вэ гэсэн асуулт байна.

Зургаадугаарт, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилт болон уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ хоорондын уялдаа холбоог Засгийн газар хэрхэн харж уялдуулан ажиллаж байна вэ гэсэн байна.

Долоодугаарт, ногоон эдийн засагт шилжих шилжилтэд асар их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдах тул төрийн санхүүжилтээр нэмэлтээр хувийн хэвшлийн санхүүжилт тэр дундаа гадаад эх үүсвэрийн хөрөнгө оруулалт хэрэгтэй байна. Энэ зохицуулалтын хууль, эрх зүйн орчныг хэзээ боловсронгуй болгох вэ гэсэн асуултууд байна?

Д.Амарбаясгалан: Ц.Мөнхбат гишүүн асуултын хариултаа цаг тухайд нь аваад, тодруулаад яваад байж болно. 20 минутын хугацаанд асуулт, хариулт явуулах боломжтой. С.Одонтуяа сайд хариулт өгье.

С.Одонтуяа: Тэгэхээр иргэний асуултад хариулъя. Энэ бүх асуултуудын эхэнд нэг зүйлийг хэлэхэд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам 12 хуулийн төслийг боловсруулсан байгаа. Энэ хуулийн төслүүдэд дээр асуусан асуултуудын хариултын ихэнх агуулга багтсан болно. Жишээлэхэд цөлжилттэй хэрхэн тэмцэж байна вэ гэдэг дээр “Хөрс хамгаалах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” гэж боловсруулсан. Гэтэл Монгол Улсын Ерөнхийлөгч одоо бол урьдчилан сэргийлэх гэдэг асуудал байхгүй, 76 хувь нь цөлжсөн учраас шууд “Цөлжилттэй тэмцэх тухай хууль” болгоод оруулах нь зүйтэй гэж байгаа. О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулахдаа хэлсэн. Ус, цаг уур орчны шинжилгээний тухай хууль, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль, Байгалийн

нөөц ашигласны төлбөрийн тухай хууль гээд нийт 12 хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барина. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд манай салбарын реформ болох 12 хуулийн төслийг дэмжиж ажиллаж өгөөрэй гэж хүсэх гэсэн юм.

Нэг тодорхой асуулт асуусан. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэдэн хувийг нь цөлжилт, газрын доройтлын бууруулахад ашиглаж байна вэ гэсэн асуултын хариултанд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар газар, ус, ой, ан амьтан, ургамлын нөөц ашигласны төлбөрийг 100 хувь орон нутгийн төсөвт тусгаж байна. Жишээлбэл 2024 онд нийт 283 тэрбум төгрөг орон нутгийн төсөвт төвлөрсөн байна. Холбогдох хуулиар энэ орлогын дийлэнх хувь тухайлбал, 85 хувийг нь буцаан байгаль хамгаалах нөхөн сэргээхэд зарцуулах хуулийн зохицуулалттай хэдий ч орон нутаг зориулалтын дагуу зарцуулдаггүй байна. Манай улс байгалийн нөөцийг аймаг, сумдуудад хэрхэн ашиглаж байгаад нарийвчилсан аудит хийж үзсэн. Хуулийн хэрэгжилт анх 20 хэдхэн хувьтай байсан бол энэ аудитын дүнгээр 65 хувьтай болсон бөгөөд сүүлийн 3 жил сайжирсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж байна. Хуулийн төсөлд байгалийн нөөц ашигласны төлбөрөөс орж ирсэн мөнгийг юунд зарцуулах, газрын доройтлоос хэрхэн сэргийлэх асуудлыг зохицуулж байгаа. Ер нь улс орнууд ДНБ-ийхээ 1 хувийг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчиндоо зарцуулж байна. Манайх одоогоор 0.3 хувьтай байгаа. Гэхдээ хуулийн шинэчилсэн найруулгаар ахиц дэвшил гарна гэж үзэж байна. Аймаг, сумдуудад хийсэн аудитын дүнд үндэслэн байгалийн нөөц ашигласны төлбөрийг зориулалтын дагуу ашиглаагүй сумыг төрийн дэмжлэгээс хасна гэсэн ийм бодолтой байгаа. Тэгэхээр байгалийн нөөц ашигласны төлбөрөөс олсон орлогыг төвлөрүүлэх, захиран зарцуулах эрх мэдлийг орон нутагт нь өгсөөр байтал хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаад анхаарч цаашид зориулалтын дагуу зарцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Шороон шуурганы талаар ямар судалгаа байгаа талаар асууж байна. Тэгэхээр цөлжилтийн төлөв байдлын үнэлгээг 5 жил тутамд хийдэг. Анх 1992 онд хийсэн судалгаагаар 41.3 хувь нь Монгол Улсад цөлжилт илэрсэн байна гэж үзэж байсан бол сүүлийн 2020 оны тооллогоор бүүр 76.9 хувь нь цөлжилтөд нэрвэгдсэн байна гэсэн судалгааны дүн гарсан байгаа. Тийм учраас манай улсын хамгийн онцгой анхаарах сэдвийн нэг яах аргагүй мөн. Үүний 23 хувь нь нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөр байгаа. Энэ хөтөлбөр нь хүлэмжийн хийг бууруулах, шингээх зорилтын хүрээнд чухал ач холбогдолтой төсөл юм. Нэг талаас мод тариад хамгаалахаас гадна нийт Монголчууд, ард иргэдийн дунд эх байгалиа нөхөн сэргээж байх ёстой, бүгдээрээ нэг мод тарьдаг болох ёстой, энэ нь байгаль орчинд чухал үйл явдал болж байгааг харуулахаас гадна, дэлхийн улс орнуудтай хэлэлцээр хийхэд хөрөнгө мөнгө босгоход хөшүүрэг болдог. Манай яам 2025 оныг “Нэг сум нэг хөв цөөрөм” гэсэн санаачилгыг өрнүүлж байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдийг өөрсдийнхөө 126 сум, дүүрэгт энэ хөв цөөрмийг санаачилж манлайлж хэрэгжүүлээсэй гэж хүсэж байгаа.

Цөлжилттэй тэмцэх чиглэлээр ямар ажлууд хийж байна вэ гэсэн асуултын хариултад Монгол Хятадын хамтарсан цөлжилттэй тэмцэх төвийг байгуулахаар газрын асуудал, бүх зургийн асуудлууд шийдэгдээд амжилттай явж байна. Хятадын Засгийн газраас Монгол Улсад үзүүлж байгаа буцалтгүй тусламжийн нэг хэлбэр болж байгаа бөгөөд төвийн үйл ажиллагааны хүрээнд судалгааны олон ажил, мониторинг хийгдэх юм. Тийм учраас цөлжилтийг хэмждэг, цөлжилттэй тэмцэх туршлагыг таниулдаг ажил мөн хийгдэнэ.

COP17 хурлын талаар асуулаа. “Conference of the parties”-ийг улс орнууд COP гээд товчлоод ярьдаг. Сая Азербайжан, Саудын Арабд COP-ын хурлууд болсон.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Монгол Улсад 2026 оны 8 дугаар сард энэ хурлыг хийх нь зүйтэй гэсэн шийдвэр гарсан. Монгол Улс дэлхийн улс орнуудын чиг хандлагатай зэрэгцэн хөгжих ёстой. Цөлжилттэй тэмцэхэд Монгол Улс дангаараа хүчрэхгүй учраас дэлхийн улс орнуудтай хамтрах хэрэгтэй, сэдвийн хүрээнд санаачилгыг өрнүүлэх хэрэгтэй, хөрөнгө мөнгө босгох хэрэгтэй гэдэг үүднээс энэ хурлыг зохион байгуулахаар болсон. Энэ хурлын хүрээнд хамгийн гол сэдэв бол газар, усны нөөцийг хамгаалах, цөлжилттэй тэмцэх, ган гачигийн асуудал, бэлчээрийн асуудлыг онцгойлон авч үзэх юм. Тийм учраас COP17 хурлын хүрээнд олон чухал ажлыг амжуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.

Ц.Мөнхбат: Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилт болон уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хоорондын уялдаа холбоог Засгийн газар хэрхэн харж байна вэ гэсэн асуулт байна.

С.Одонтуяа: Засгийн газрын хурлаар хэлэлцсэн гол асуудал бол ногоон санхүүжилтийн корпорацын асуудал буюу сүүлийн жил гагцхисан, хөрөнгө оруулагч нь мөнгөө буцааж татсан, Монголын Засгийн газар амлалтаа биелүүлэхгүй байгаа талаар яригдсан. Засгийн газрын хурал дээр ногоон санхүүжилтийн корпораци шийдэгдээд, ногоон санхүүжилт орж ирэх бүх нөхцөл бүрдсэн байгаа. Хоёр дахь нь Засгийн газраас өгсөн үүрэг бол Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтарч Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн барих асуудал юм. Тэгэхээр уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хийгдэж байгаа нэг ажил бол та бүхэн мэдэж байгаа. Бид нараас хамаарахгүй хүчин зүйлүүдийн нэг дасан зохицох бодлогыг Засгийн газар гаргасан байгаа. 2 дахь нь хүний хүчин зүйлээс хамаараад уур амьсгалын өөрчлөлтийг өөрсдөө бий болгож байгаа тал дээр Засгийн газар төлөвлөгөө гаргасан. Үүний нэг нь бэлчээрийн даац, малын тоо толгойтой холбоотойгоор эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх гэсэн асуудлууд байна.

Гурав дахь асуудал нь ногоон эдийн засагт шилжих, уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хий ялгарлыг нэмэгдүүлдэг бүх хүчин зүйлийг багасгах ажлууд хийгдэж байгаа. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороон дээр хүлэмжийн хий ялгарлыг бууруулах, агаарын бохирдлыг бууруулах төлөвлөгөө

гаргаад ажиллаж байгаа. Сүүлийн 3 сард тус үндэсний хорооны зүгээс 173 том уурын зуух буюу 2,262 аж ахуйн нэгжийн түүхий нүүрс түлдэг байдлыг зогсоох шинэчлэлийн ажлыг хийхээр ажиллаж байгаа хэдий ч энэ нь зөвхөн бидний хэмжээнд шийдэх боломжгүй учраас гадаадын зээл, тусламжийг татах, гадаадад болж байгаа хуралд энэ төсөл хөтөлбөрийг танилцуулах гээд олон ажлыг хийж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулиар олон харилцааг зохицуулж байгаа бөгөөд энэ чиглэлээр олон байгууллага, үндэсний хороо, хөтөлбөрүүд байдаг тул салбар хоорондын уялдааг хангах шаардлагатай байна.

Ц.Мөнхбат: Сайд одоо танилцуулах 20-иод асуултад товчхон хариулж өгөхийг бодоорой. Иргэн Батмөнхөөс Монгол орон газар зүйн байршил, эх газрын эрс тэс уур амьсгал зэргээс хамааран дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөд эрчимтэй өртөөд байгаа 10 орны нэг гэж үзэж байна. Энэ чиглэлээр судалгаа хийгдсэн юм байна уу гэж асуусан байна. Хоёрдугаарт Монгол Улсын хэмжээнд хэдэн аймаг нэн хүчтэй цөлжилт, газрын доройтолд орж байгаа вэ? Үүнээс урьдчилан сэргийлж үр дүн өгсөн ажил байна уу гэж асуусан байна.

С.Одонтуяа: Би товчхон хариулья. 5 жил тутам хийгддэг судалгаагаар хамгийн ихээр дулааралд нэрвэгдэж байгаа газруудыг Улаанбаатар хот, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Сэлэнгэ аймгийн Баруунхараа сум, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум гэж нэрлэсэн бөгөөд эдгээр сумдууд дундажаар жилийн 3.3-3.5 хэм хүртэл нэмэгдэж байна гэсэн судалгааны дүн байна. Бусад газруудад 2-3 хэмийн дулаан байгаа. Гэтэл манай улс олон улсын өмнө дулаарлын хэмийг 1,5-аас хэтрүүлэхгүй байхаар үүрэг хүлээсэн. Өнөөдрийн байдлаар 30 орчим сая га талбай цөлжилтэд хүчтэй өртсөн бөгөөд нийт газар нутгийн 76.9 хувь нь цөлжилттэй байна гэж хариулсан.

Ц.Мөнхбат: Монгол орны нийт нутгийн 76 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн гэж үзэж байгаа юм байна. Тэгээд үүнээс хүний хүчин зүйлээс хамаарч байгаа нь хэдэн хувийг эзэлдэг вэ гэж асуужээ. Сүүлийн 4 жил ямар арга хэмжээ авч цөлжилтийн үзүүлэлтүүдийг бууруулах тал дээр ажил хийгдсэн бэ? гэж асуусан байна.

С.Одонтуяа: Манайд “АДАПТ” төслийн хүрээнд олон судалгаа хийсэн байдаг. Энэ “АДАПТ” “төсөл Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийсэн. Энэ судалгаагаар Монгол Улсын мал аж ахуйд учирдаг нийт хохирлын 90 гаруй хувь нь ган, зуд хосолсон эрсдлийн нөлөөлөл байна гэсэн дүгнэлт гарсан. Иймд малыг олноор хорогдуулдаг гамшигт үзэгдлийг урьдчилан тооцох, аль болохоор байгалийн гамшигт үзэгдэл гарахад бэлтгэлтэй байх, урьдчилан сэргийлэх зэрэг арга хэмжээ авч ажиллахад анхаарах нь зүйтэй. Тийм учраас ган, зудын хосолмол нөлөөлөл нь хамгийн их нөлөө үзүүлж байна гэж үздэг.

Өнөөдрийн байдлаар Монгол Улс хонин толгойд шилжүүлснээр 110 сая орчим толгой малтай байна гэж үздэг. Үүний 35 сая тоо толгой мал бэлчээрийн даацаас хэтэрсэн тоон үзүүлэлт байна гэж судалгаагаар гарсан. Тийм учраас бэлчээрийн маллагаатай малын тоо толгойн тодорхой хэсгийг нь эрчимжсэнд

шилжүүлэх, техник технологийн дэвшлийг хослуулах зэрэг арга хэмжээг авахгүйгээр удаан хугацаанд үргэлжилбэл уламжлалт мал аж ахуйгаар дамжин цөлжилт, хуурайшилт улам нэмэгдэнэ гэсэн судалгааны дүгнэлтүүд байна.

Ц.Мөнхбат: Говийн бүсээс сонгогдсон гишүүний хувьд 1 асуулт асууя. Усны төслийн нэгжийг байгуулах ажил ямар хэмжээнд явж байгаа вэ? Энэ ажлыг эрчимжүүлэх талаар Байгаль орчин, уур амжилтын өөрчлөлтийн яам ямар санаачилга гаргаад ажиллаж байна вэ гэсэн асуулт байна. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Хэрлэн-Тоонот, Орхон-Онги гээд усны төслүүд байгаа. Энэ төслүүд ямар шатанд байна вэ гэдэг асуултыг асууя.

С.Одонтуяа: Засгийн газрын хамгийн гол зорилтуудын нэг тэргүүлэх чиглэл бол яах аргагүй говийн бүсийн усан хангамжийн асуудал байгаа. 2025 оны төсөвт батлагдсан санхүүжилтийн дийлэнх хувийг говийн бүсийн усан хангамжийг сайжруулахад зарцуулж байна. Жишээлбэл, говийн бүсийн хот суурин газрын усны чанарт үнэлгээ хийх ажил нийт 44 сумд хийгдэхээр төсөв батлагдсан. Говийн бүсийн гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлж усны нөөцийн тархалтыг тогтооход тодорхой мөнгө хөрөнгө тавьсан. Хамгийн гол нь говьд усгүй гэдэг. Гэтэл нийт Монгол Улсын газар нутгийн 17 хувьд нь усны хайгуул хийгдсэн байдаг учраас усны хайгуулын судалгааны ажил дээр онцгой анхаарах шаардлагатай. Хэрлэн-Тоонот төслийн хувьд ТЭЗҮ нь хийгдэх шатдаа ороод “Мон гидро геологи” компани шалгараад ТЭЗҮ нь 2025 оны төгсгөлд дуусна гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тийм учраас ТЭЗҮ батлагдангуут Хэрлэн-Тоонот-ын асуудлыг хэрхэн яаж хийх вэ гэдэг асуудлыг ярьж байна.

Орхон-Онги төслийг бид олон жил ярьсан. Орхон голын асуудал бол Хархорум том хот байгуулахтай холбогдуулж Орхон голын асуудал түр хугацаагаар хүлээгдэж байгаа гэж хэлж болно. Тэгэхээр өнгөрсөн 7 хоногт Л.Гантөмөр сайдаар ахлуулаад манай ажлын хэсэг Онги голоос ус татаж Улаан нуураа сэргээх экологийн төслөө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 20 минутад асуулт, хариулт явагдаж дууслаа. Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг асуулт асууна.

М.Ганхүлэг: Баярлалаа. Цахим өргөдөл хүсэлтээр 5 иргэний 19 асуулт ирсэн байгаа. Тэгэхээр хугацаандаа тааруулаад товчхон хариулаад явах нь зөв байна. Иргэн Будсүрэнгийн асуултаас эхэлье. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам шинээр байгуулагдсан цагаас хойш уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар олон нийтэд мэдлэг ойлголт өгөх чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ гэсэн асуултыг асуусан байна. Цаг агаарын гамшигт болон аюултай үзэгдлийг урьдчилан илрүүлэх, эрт сэрэмжлүүлэх талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ? Урьдчилан сэргийлэх чиглэл дээр цөлжилт, газрын доройтлын бодлого, эрх зүйн орчныг сайжруулах талаар хийгдэж байгаа ажлууд байна уу? Энэ чиглэлээр ерөнхий багц хууль орж ирж байгаа юм байна. Энэ дотроо Бэлчээрийн тухай хууль бусад хуулиуд нь ямар байгаа вэ гээд бага

зэрэг дэлгэрүүлээд хариулаад өгөөч. Уур амьсгалын өөрчлөлт биологийн олон янз байдалд хэрхэн нөлөөлж байгаа вэ гэсэн 4 асуултыг иргэн Будсүрэн асуусан байна.

Д.Амарбаясгалан: С.Одонтуяа сайдын микрофоныг өгье.

С.Одонтуяа: Би хариулъя, манай яамныхан зарим хуулийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгөөрэй. Цаг агаарын гамшигт үзэгдлийг урьдчилан сэрэмжлүүлэх ажлын хүрээнд хэд хэдэн радарын станц суурилуулах ажлыг 2025 оны төсөвт суулгасан байсан юм. Харамсалтай нь төсвийн тандалтаар хасагдчихсан. 2023 онд Чингэлтэйн ууланд улсын төсвийн хөрөнгөөр нэг радарын станц суурилуулаад ашиглаж байсан. Одоо улсын хэмжээнд нийт нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан доплерын эффект бүхий цаг уурын радарын станцын сүлжээ байгуулах нь чухал гэдгийг ойлгож байгаа. Улсын төсвөөр энэ асуудлыг шийдвэл чухал юм. Нийт 150-400км-ийн радиус дотор бүх үүлний байршил, шилжилт хөдөлгөөнийг хянах боломжтой болох юм.

Өнгөрсөн 7 хоногт Улаанбаатар хотод муухай үнэр гараад байна гэсэн зүйл яригдсан. Агаарт юунаас болоод, ямар бодисоос болоод энэ үнэр гараад байна гэдгийг тодорхойлдог багаж байдаггүй. Иймд өнгөрсөн Засгийн газрын хурал дээр энэ багажийг Улаанбаатар хотод авъя гэсэн хүсэлт гаргасныг Ерөнхий сайд дэмжээд асуудал шийдэгдэхээр болж байгаа.

Олон нийтийг мэдээллээр хангах, мэдлэг олгох ажлын хүрээнд энэ жил Боловсролын яамтай хамтраад 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүүхэд, залуучуудад мэдлэг олгох ажлыг эхэлсэн. Энэ хүрээнд төрийн бус байгууллагуудтай хамтраад улс орон даяар мэдлэг мэдээллээр хангах ажил хийгдэж байгаа. Одоогийн байдлаар нийт 400 сургуулийн 900 орчим мянган хүүхдэд энэ мэдлэг мэдээллийг олгосон. Үүнийг цахим платформ бий болгоод хүүхдүүд энэ цахим платформоос асуулт асууж, хариултаа авдаг болсон. Үлдсэнийг нь ажлын хэсгээс хариулж болох уу?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 10 дугаар микрофон өгье.

Ц.Уртнасан: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Шинэ Засгийн газрын бүтцээр Байгаль орчин, уур амьсгалын яамыг шинээр байгуулсан. Яамны эрхэм зорилгыг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чадамжтай улс үндэстэн болно гэдэг эрхэм зорилгын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байна.

Та бүхний ярьж байгаа уур амьсгалын өөрчлөлтөд хүний үйл ажиллагаанаас хамаарч байгаа үйл ажиллагааг зохистой байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэлбэрт шилжүүлэхийн тулд олон нийтийн хандлага, соёлыг өөрчлөх чиглэл дээр яам анхаарч ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд ерөнхий боловсролын бүх шатны сургуулиуд, техник мэргэжлийн сургуулиудын сургалтын хөтөлбөрт уур амьсгалын өөрчлөлтийн сургалтын хөтөлбөрийг оруулахаар боловсролын байгууллагуудтай хамтраад

ажиллаж байна. Бүх шатын сургалтын байгууллагын хичээлийн байранд “Уур амьсгалын өөрчлөлт ба Монгол” сургалтын танхимыг байгуулах хэлбэрээр бүх шатын боловсролын байгууллагуудад уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чадамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт тавьж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд, улс төрчдийн хувьд манай яамтай хамтарч ажиллаад олон нийтэд уур амьсгалын өөрчлөлтийг нөлөөлөхүйц арга хэмжээг авч ажиллахад манлайлал үзүүлэн оролцоход яамны зүгээс мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж хамтарч ажиллахад бэлэн байна. Баярлалаа.

М.Ганхүлэг: Хуулийн төслүүдийн гол 12 хуулиуд нь ямар хуулиуд байна вэ? Бэлчээр хамгааллын тухай хууль орж байна уу?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Ц.Уртнасан: Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар манай улс Парисын хэлэлцээрт нэгдээд нийгэм, эдийн засгийн олон салбарууд дээр үндэсний хувь нэмрийг тодорхойлоод, салбар бүр дээр уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө нарийвчилсан зорилтуудаа тодорхойлсон байгаа. Тийм учраас салбар хоорондын бодлого, зохицуулалтыг уялдуулах замаар уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг сааруулах, дасан зохицох чадамжийг сайжруулах чиглэлээр эрх зүйн зохицуулалт, хуулийг боловсруулах, олон улсын нийтлэг стандартуудыг батлуулж мөрдөх зэрэг эрх зүйн зохицуулалтын бэлтгэл ажил хийгдэж байна.

Д.Амарбаясгалан: С.Одонтуяа сайдын микрофоныг өгье.

С.Одонтуяа: Нийт 12 хууль байгаа үүнд Бэлчээрийн тухай хууль гэж тусдаа хууль байхгүй. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас энэ хуулиудад өөрчлөлт оруулах байх. Манай Хөрс хамгаалах, цөлжилтийг бууруулах тухай хууль дээр бэлчээрийн асуудал яах аргагүй яригдана. Тэгэхээр олон жил явсан уламжлалт нүүдлийн мал аж ахуй бэлчээрийн даац хэтэрсэн асуудал дээр нэг тулж таарцгаах байх. Тэгэхээр манай улсын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт ямар байгаа гэдгээ сайн мэдрээд хууль дээр бэлчээрийн асуудлыг онцгой анхаарч ажиллах ёстой гэж Улсын Их Хурлын гишүүд үзэж байгаа. Нийт 12 хуулийн хамгийн чухал хууль бол Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (шинэчилсэн найруулга), Усны тухай хууль, Амьтны тухай хууль, Ойн тухай хууль (шинэчилсэн найруулга), Байгалийн ургамлын тухай хууль зэрэг хуулиудыг Улсын Их Хуралд өргөн барина. Харин биологийн олон янз байдлын асуудлыг энэ бүх хуулиудаар зохицуулна.

Манай орны хувьд улаан дансны зэрэглэлд орсон 2,000 орчим зүйл ургамлыг үнэлэхэд устаж байгаа нь 60, устаж болзошгүй 192, эмзэг 364, ховордож болзошгүй 206 зүйл ургамал байна гэж үздэг. Тийм учраас аюул, эрсдэлд орсон зүйл ургамлыг бодолцож байгаль орчноо хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтдөө

анхаарахгүй бол сүүлдээ эдийн засаг, байгаль орчинд том сорилт тулгарах асуудал ирнэ. 2050 он гэхэд Монгол Улсын бүх мөстлөг болон мөсөн уул хайлна гэсэн судалгаа байдаг. Тэгэхээр бид асар их хэмжээний усны хомсдолд орох эрсдэл үүсэж байгаа. Тэгэхээр Байгалийн нөөц ашигласны төлбөр, Усны тухай хуулиудаа шинэчилж оруулна.

М.Ганхүлэг: Иргэн Оюунтуяагийн асуултыг би танилцуулъя. Цөлжилтөд нөлөөлж буй гол хүчин зүйл болох бэлчээр, малын тоо толгойн талаар ямар бодлого барьж байна вэ? Цөлжилт нэмэгдэж байгаа бодит судалгаа нь ямар судалгаа дээр үндэслэж байна вэ? Манай улсын газар нутаг уур амьсгалын онцлог түүний нөлөөлөл нь ямар байна вэ? Илүү нарийвчлаад бэлчээрийн газрын чанарын хянан магадлагааг 5 жил тутам хийх ёстойг тодорхой хуулиар зохицуулсан байх учиртай. Авсан мэдээллээр 2010 онд хамгийн сүүлийн судалгааг хийсэн бөгөөд түүнээс хойш чанарын хянан магадлагааг огт хийгээгүй байгаа мэдээлэл байна. Тэгэхээр энэ чиглэлийн судалгаа мэдээллүүдийг яаж хийж байна вэ? Энэ хянан магадлагааг хэзээ хийх вэ? гэдэг асуулт байна.

С.Одонтуяа: Би түрүүн нэг дурдаад өнгөрсөн. Энэ манай улс 2024 оны тайлангаас үзэхээр хонин толгойд шилжүүлснээр 110 сая толгой мал байна гэж үздэг. Үүнээс бэлчээрийн даац 36.4 сая тоо толгой малаар хэтэрсэн байна гэсэн судалгааг дурдсан. Иймд бид байгалийн ургамлыг нөхөн төлөх боломжийг хязгаарлаж бэлчээр талхлагдах үндсэн нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж байгаа. Тийм учраас мал аж ахуйн түүхий эдийг бүрэн ашиглах, ашиг шим өндөр технологид шилжүүлэх, даацтай нийцсэн мал сүргийг бий болгох нь зайлшгүй чухал гэж үздэг. Судалгааны талаар өмнө нь хэд хэдэн удаа хэлсэнчлэн цөлжилт, газрын доройтлын судалгааг 5 жил тутамд хийдэг. Хамгийн сүүлд 2020 онд хийсэн судалгаагаар цөлжилт 76.9 хувьтай байна гээд дүгнэлт гарсан байгаа.

М.Ганхүлэг: Иргэн Сарантуяагийн асуулт. Уур амьсгалын өөрчлөлтөөс мал аж ахуй, газар тариалангийн салбарт үзүүлж байгаа нөлөөллийг судалж үзсэн үү? Асуултын агуулга давхардаж байна. Гэхдээ газар тариалангийн асуулт нэмэгдэж байгаа тул та газар тариалантай холбогдуулан уур амьсгалын өөрчлөлтөөс болж хамгийн их дулааралт болж байгаа газар хаана байгаа талаар асууя.

С.Одонтуяа: Яам хариулах уу?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон өгье.

Х.Мөнхзул: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мөнхзул. Монгол улс цөлжилтөд нөлөөлж буй гол хүчин зүйл бол бэлчээр болон малын тоо толгой юм. Манай улсын нутаг дэвсгэрийн 70.7 хувийг бэлчээрийн талбай эзэлж байгаа. Үүний 69 хувь нь доройтолд өртсөн тухай судалгааны дүн байгаа. Бэлчээрийн нийт талбайн хэмжээ сүүлийн 50 гаруй жилд 20 орчим хувиар буурч байгаа. Эсрэгээр малын тоо толгой 30 жилд 3 дахин өссөн. Монгол орон 80 сая гаруй хонин толгой бэлчээрийн даацтай. Гэтэл энэ тоо өнөөдөр 110 саяд

хүрч байгаа. Малын сүргийн 40 хувийг ямаа эзэлж байгаа гэсэн тооцоолол байна. Цөлжилтөд нөлөөлж байгаа гол хүчин зүйл дээр онцгой анхаараад эхний ээлжид малын тоо толгойг бэлчээрийн даацтай нийцүүлж зохистой түвшинд барих ёстой. Хоёрт нь сүргийн бүтцийг оновчтой болгох шаардлагатай. Тэгээд Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль дээр эдгээр асуудлыг зохицуулсан хязгаарлалттай зохицуулалтыг тусгах шаардлагатай. Удахгүй өргөн барина.

М.Ганхүлэг: Газар тариалангийн салбарт яаж нөлөөлж байна вэ?

С.Одонтуяа: Шороон шуурганы асуудал ноцтой болж байгаа. Тэгэхээр СОР-ыг угтаж шороон шуургатай тэмцэх талаар санаачилга гаргаад олон улсын эвсэл байгуулаад ажиллахаар бэлтгэл ажлаа хийж байгаа. Өнгөрсөн жил манай яам Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтарч хийсэн нэг ажил бол газар тариалангийн бүс нутгийг тойруулаад мод тарих ажлыг сайн хийсэн. Тэгэхээр нэг сумаар олон туулай буудаж байна гэсэн үг. Нэгдүгээрт, модоо тарьж байгаа, хоёрдугаарт, мод нь усалгаатай байна, эзэнтэй байна, хашааг тухайн газар тариалангийн компаниуд бариад хосолмол ажлыг хийж байгаа. Энэ төсөл амжилттай хийгдсэн. Энэ жил газар тариалангийн бүсийг тойруулж ойжуулах ажилд нийт 702 сая төгрөгийг төсөвлөсөн байгаа. Тэгэхээр хөрсийг хамгаалах шороон шуурганаас сэргийлэхэд чухал үүрэгтэй болж байна.

М.Ганхүлэг: Мал аж ахуйн салбарт уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлоос хамгийн их хохирч байгаа бүлэг бол малчдын бүлэг байгаа. Энэ чиглэлд нэгэн асуултыг нэмээд асууя. Малчдыг мэдлэгжүүлэх нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах хамгийн зохистой ажлуудын нэг болов уу гэж харж байгаа. Үүнд малчид болон иргэд хамаарна. Ялангуяа иргэд “Тэрбум мод” хөдөлгөөнд нэгдэх, малчид бэлчээрээ хамгаалах чиглэлд мэдлэгжүүлж оролцоог дэмжих ажлыг голчилж анхаарах учиртай. Тэгэхээр хөрс хамгаалал, бэлчээр хамгааллын асуудал, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал зөвхөн төрийн бус олон талт хамтын ажиллагааны үр дүнд үр дүнгээ өгнө гэж харж байгаа. Иймд хариу арга хэмжээний хүрээнд мод тарьж байгаа, бэлчээрээ хамгаалж байгаа иргэд, малчдыг дэмжихэд ямар ажлуудыг хийсэн бэ, хийж болох вэ? гэж асууя.

Д.Амарбаясгалан: Ажлын ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Ц.Уранчимэг: Гишүүний асуултад хариулъя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Хөдөө аж ахуйн яамтай хамтран хэрэгжүүлж байгаа олон төсөл байгаа. Эдгээр төслүүдийн хүрээнд бэлчээрийн нөхөн сэргээлтийг байгалийн ургамлын аргаар нөхөн сэргээх, ялангуяа малчдын ногоон тэжээл бэлтгэх ажлыг баруун буюу зүүн бүсийн аймгуудад тодорхой үйл ажиллагааг зохион байгуулж байна. Мөн говийн аймгуудад загийн ойг нөхөн сэргээх ажлыг малчдын нөхөрлөл, малчдын бүлгэмээр дамжуулж хамтарч зохион байгуулж байна. Мөн хөв цөөрөм байгуулах ажлыг хийж байна. 2020 онд баталсан Бэлчээрийн хуульд тодорхой нэг заалт орсон байдаг. Малын тоо толгойн албан татварын тухай хуулиар малын тоо толгойд төлбөр ноогдуулж эхэлсэн. Тодорхой хэмжээгээр энэ ойлголтыг нэмэгдүүлэх хөшүүргийг бий болгох ажлыг

хийсэн. Тэгэхээр малчид чанартай малыг бий болгож хурганы махыг борлуулж зарах, махыг нь боловсруулсан бүтээгдэхүүн болгож гаргах ажлыг “ENSURE”² төслийн хүрээнд амжилттай хийж байна. Мөн нэн ховор ургамлыг тарималжуулах ажлыг энэ төслүүдийн хүрээнд зохион байгуулж малчны нөхөрлөл, амьжиргааг дээшлүүлэхэд тодорхой ажлуудыг хийгээд явж байгаа.

Цаашид уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, бэлчээрийн уламжлалт мал аж ахуй үйлдвэрлэлд малын тоо толгойн зөв зохистой харьцааг барихад сургалтыг Хөдөө аж ахуйн яамтай хамтарсан төслийн хүрээнд зохион байгуулаад сургагч багшийг малчдын бүлгээс нь бэлтгэж байна.

М.Ганхүлэг: Энэ дээр нэмэлтээр би саналаа хэлчихье гэж бодож байна. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт 7 төрлийн урамшууллыг олгож байгаа. Газар тариалангийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд бордооны урамшуулал буюу хөрс, бордоо худалдаж авсан тохиолдолд 30 хувийг буцаан олгож байгаа. Малчдад зориулаад ноосны урамшуулал, арьс ширний урамшуулал, сүүний урамшуулал гээд хэд хэдэн урамшууллуудыг олгож байгаа. Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч нарт зориулаад тонн тутамд 100 мянган төгрөгийн урамшууллыг өгч байгаа. Тэгвэл цаашдаа энэхүү урамшууллын тодорхой дэмжлэгийг бэлэн мөнгөөр бус харин хөрс хамгаалал, бэлчээр хамгааллын чиглэлд зориулах асуудлыг Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын сайдууд анхаарал хандуулах нь зөв болов уу гэсэн саналыг би протоколд тэмдэглүүлээд, та бүхэн энэ асуудлыг цаашдаа ажил хэрэг болгоосой гэж бодож байна.

Экспортын үйл ажиллагааг тасалдуулахгүй гэх зорилго Засгийн газрын мөрийн хөтөлбөрт байгаа гэсэн хэдий ч бодит байдал дээр зорилтоосоо ухарсан алхмуудыг хийгээд байгаа. Энэ хүрээнд экспортыг тодорхой тоонд хязгаарлах, квот олгохтой холбогдолтой асуудлуудыг дэвшүүлээд байгаа. Иймд цаашид энэ чиглэлд тогтвортой, нэгдсэн байр суурьтай байж, ерөнхий агуулгаараа эдийн засгаас гадна уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг томоохон хариу арга хэмжээ болж байгаа учраас Засгийн газар нэгдсэн байр суурьтай байгаасай. Малчдын амьдрал ахуйг гол бүрдүүлж байгаа мах болон түүхий эдийн экспортыг нэмэгдүүлэх чиглэлд бид бүхэн явах ёстой юм гэсэн саналыг хэлмээр байна.

3 дахь асуудал бол малын хөлийн татвар. Малжуулах хөтөлбөрийг малын индексжүүлэлт болон бэлчээрийн даацтай хэрхэн уялдуулж ажиллаж байгаа вэ? Цаашид шинжлэх ухааны үндэслэлтэйгээр салбарын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхэд та бүхэн маань анхаарч ажиллаарай гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Ингээд үдээс хойших нэгдсэн хуралдаан дээр Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

---oOo---

² “Ensure” төсөл- “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах” төсөл

1.2. 2025 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН, ХУРИМТЛАЛЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ



Л.Оюун-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.2-т заасны дагуу Улсын Их Хурлын өнөөдрийн чуулганы хуралдаанд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг та бүхэндээ танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “... Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж байгалийн баялгийг ашиглах суурь зарчмыг баталгаажуулсан билээ.

2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас батлан батлан хэрэгжиж эхлээд байна.

Энэхүү хууль батлагдсанаар Монгол Улс газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэж, Монгол Улсын иргэн бүр газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг тэгш, шударга хүртэж эхэлснийг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Уг хуулиар Үндэсний баялгийн сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор хуримтлуулах, хуримтлагдсан хөрөнгийг олон улсын зах зээлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар өнөөгийн үнэ цэнийг өсгөх, арвижуулах зориулалт бүхий **Ирээдүйн өв сан**, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан эдийн засаг, нийгмийн үр өгөөж бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх **Хөгжлийн сан**, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд

тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх **Хуримтлалын сан** гэсэн 3 төрөлжсөн сантай байхаар хуульчилсан.

Өнгөрсөн 1 жилийн хугацаанд бид төрөлжсөн сангуудад орлого төвлөрүүлж, сангуудын хөрөнгийг хөрөнгө оруулалтад оруулах замаар арвижуулж, иргэн бүр хуримтлалын нэрийн данстай болж, газрын хэвлийн баялгийн үр өгөөжөөс хүртэж, хуримтлалын нэрийн дансандаа хуримтлалтай болж эхэлснийг онцлон хэлэх нь зүйтэй юм.

Ирээдүйн өв сангийн тухайд уг сан нь өнөөгийн болон ирээдүйн Монгол Улсын иргэдэд чиглэсэн урт хугацааны санхүүгийн баталгаа болох юм. Сангийн хөрөнгө тогтвортой өсөж 2024 оны жилийн эцсийн байдлаар сангийн хөрөнгө 1.2 тэрбум ам.долларт хүрчээ. Уг сангийн хөрөнгө 2025 онд 1.7 тэрбум, 2026 онд 2.4 тэрбум, 2027 онд 3.2 тэрбум, 2028 онд 3.9 тэрбум, 2030 он гэхэд 4-5 тэрбум ам.долларт хүрэх төсөөлөлтэй байна.

Ирээдүйн өв сангийн хөрөнгийг олон улсын санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж байгаа бөгөөд энэ оны 3 дугаар сард Монголбанктай гэрээ байгуулсны үндсэн дээр уг санд төвлөрсөн 1,183.0 сая ам.долларыг Англи, Франц, Люксембург улсын төв банканд хадгалуулахаар байршуулсан.

Хөгжлийн сан нь хөгжлийн бодлогыг тогтвортой санхүүжүүлэх, улсын урт хугацааны чадамжийг нэмэгдүүлэх бодлогын хэрэгсэл болохоор төлөвлөгдсөн бөгөөд өөрөөр хэлбэл нийслэл Улаанбаатар хотын замыг засах, түгжрэлийг бууруулах зэрэг нийгэмд тулгамдаж буй томоохон төслийг олон нийтийн саналд тулгуурлан санхүүжүүлэх боломжтой болсон. 2026 оноос энэхүү сангийн эх үүсвэрээр хөгжлийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж эхэлнэ гэж найдаж байна.

Харин Хуримтлалын сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий сан гэж би дээр дурдсан билээ.

Иргэн бүр эрүүл мэндийн үйлчилгээнд хүртээмжтэй хамрагдаж, чанартай боловсрол эзэмшиж, орон сууц худалдан авах санхүүгийн эх үүсвэртэй болсноор өөрийн болон гэр бүлийн ирээдүйгээ өөрчлөх, цаашлаад эх орныхоо хөгжилд чухал хувь нэмэр оруулах суурь болох тул Монгол Улсын Засгийн газраас тус сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, арвижуулахад онцгойлон анхаарч байна.

Хуримтлалын санд 2024 онд уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгаас 495.6 тэрбум төгрөг төвлөрсөн. Сангийн орлого жил бүр нэмэгдэж, 2030 он гэхэд сангийн нийт хөрөнгө 3.0 их наяд төгрөгт хүрэх төсөөлөл байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Хуримтлалын болон Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанкна дахь төрийн сангийн дансанд байршуулна. Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд бодлогын хүүгээс багагүй хувиар хүү тооцох, эсхүл бодлогын хүүгээс багагүй өгөөжтэй, санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулна” гэж заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах, нийслэлийн агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах, иргэдийг орон сууцжуулах, ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 онд Хуримтлалын санд төвлөрсөн мөнгөн хөрөнгөөс 480.2 тэрбум төгрөгийг арилжааны банкуудаар дамжуулан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн эх үүсвэрт хөрөнгө оруулан ажиллалаа.

Монголбанкнаас 2024 онд ипотекийн зээлийн санхүүжилтэд 1,208.0 тэрбум төгрөгийг банкнуудад олгосон бөгөөд энэхүү санхүүжилтийн 39.8 хувийг Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгө эзэлж байна. Энэ хүрээнд нийт 10,422 иргэн, үүнээс Хуримтлалын сангийн эх үүсвэрээр 4,183 иргэн (нийслэлд 2,099, орон нутагт 2,084 иргэн) ипотекийн зээлд хамрагдсан. Ингэснээр иргэдийн зээлийн хүсэлтийг шийдвэрлэх хугацаа 3-6 сараар наашилж, ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо нэмэгдсэн зэрэг эерэг үр дүнгүүд гарч эхэлсэн.

Түүнчлэн Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанкна дахь дансанд байрших хугацаанд бодлогын хүүгээр, хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулснаас хойш хугацаанд хөрөнгө оруулалтын хүүгээр тус тус тооцож, 2024 онд хүүгийн орлогод 4.9 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд төвлөрүүлсэн байна.

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын санд 507.1 тэрбум төгрөг, хүүгийн орлогоор 55 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр, Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562.1 тэрбум төгрөг байхаар тус тус хуульчилсан нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 12 орчим хувиар өссөн байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалт “Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэж, хөтлөх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах”, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт “Хуримтлалын сангийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг Монгол Улсын иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд бүртгэнэ” гэж тус тус заасны дагуу 2024 онд Монгол Улсын Засгийн газраас “Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журам”-ыг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Уг журмаар иргэдийн хуримтлалын нэрийн дансыг нээх, бүртгэх, нэрийн дансны үлдэгдэлд өгөөж тооцох, иргэн өөрийн нэрийн дансны хөрөнгийг гэр бүлийн гишүүний хэрэгцээнд зориулж нэг удаа шилжүүлэх, Иргэний хуулийн холбогдох заалтын дагуу өвлөх боломжтой байхаар зохицуулсан.

Түүнчлэн, Хуримтлалын сангийн хөрөнгийг 2030 он хүртэл зөвхөн хөрөнгө оруулалтад оруулан өсгөж иргэний нэрийн дансанд тодорхой хуримтлал үүссэний дараа 2030 оноос иргэн нэрийн дансан дахь хуримтлалаараа эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг гадаад улсад эмчлүүлсэн тохиолдолд уг зардалд, Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын төлбөрт, орон сууц худалдан авах урьдчилгаа төлбөрт тус тус зарцуулахаар журамд тусгасан.

Бид 2024 онд Монгол Улсын нийт 3,565.9 мянган иргэнд хуримтлалын нэрийн данс үүсгэж, иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд 138.9 мянган төгрөгийн бүртгэл хийж, И-Монгол системийн Профайл цэсийн «Чингис Хаан» Үндэсний баялгийн сан хэсгээс иргэн өөрийн нэрийн дансны үлдэгдлийг хянах нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцны урт хугацааны санхүүжилттэй уялдуулах, тогтолцооны шинэчлэлийг эхлүүлэх, шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, нэгдсэн бодлого, шийдэл гаргах зорилтыг хэрэгжүүлэхээр “Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо”-г 2024 оны 09 дүгээр сард байгуулсан.

Үндэсний баялгын сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны нэн тэргүүний зорилт нь орон сууцны урт хугацааны бодлого тодорхойлох, ипотекийн зээлийн эх үүсвэр, хүртээмжийг нэмэгдүүлэх, урт хугацаанд хэрэгжүүлэх санхүүжилтийн загварыг тодорхойлох явдал юм.

Түүнчлэн, анх удаа орон сууц авч буй залуу гэр бүл, олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон нийслэлээс орон нутаг руу шилжиж байгаа иргэдийг нэн тэргүүнд орлогод нийцсэн орон сууцаар хангах нь чухал байна.

Иймд Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцны хөнгөлөлттэй хөтөлбөрийн санхүүжилттэй урт хугацаанд уялдуулах чиглэлээр орон сууцны бодлого хэрэгжүүлэгчид болон олон улсын байгууллагын төлөөлөл, банк санхүүгийн салбартай хамтран ажиллаж байна.

Түүнчлэн нийслэлийн агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах, иргэдийг орон сууцжуулах хүрээнд 2025 оныг “Нийслэлийн дэд бүтцийг дэмжих жил” болгосон. “УБ ХЕТ 2040” болон 6 дэд төвүүдэд тулгуурлан 2025-2032 он хүртэл гэр хорооллын газар чөлөөлөлт, орон сууцжуулалт, инженерийн дэд бүтэц, түүний хүчин чадал, хөрөнгө оруулалт, орон сууцны хөнгөлөлттэй ипотекийн зээл, санхүүжилтийн тогтолцоог сайжруулах талаар төлөвлөгөө боловсруулж байна.

Дэд төвүүдийг түшиглэн гэр хорооллыг орон сууцжуулах ажлын хүрээнд 2025-2028 онд 27.3 мянга, 2029-2032 онд 62.9 мянга нийт 90.9 өрхийн орон сууц нийлүүлэхээр төлөвлөн нийслэл, төр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас Хуримтлалын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд иргэд “И-Монгол” төрийн үйлчилгээний цахим системээр дамжуулан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас авах ногдол ашгаа бэлэн мөнгөөр хувийн харилцах дансандаа авах, хуримтлалын нэрийн дансандаа шилжүүлж авах, эсхүл нийслэлийн дэд бүтэц, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хандивлах гэсэн гурван сонголт хийх нөхцөлийн бүрдүүлэн асуулгыг **02 дугаар сарын 19-26-ны** өдрүүдэд явуулж, нэмэлтээр мэдэгдэл хүргэх системээр холбогдон мэдээллээр хангаж идэвхжүүлсэн бөгөөд нийт **505,318** иргэн саналаа өгснөөс **481,809** иргэн ногдол ашгаа “бэлэн мөнгөөр авна” гэж, **22,242** иргэн “хуримтлалын нэрийн дансандаа шилжүүлнэ” гэж, **1,267** иргэн “хандивлана” гэж санал өгсөн.

Хоёрдугаар албан ёсны санал асуулгыг **4 дүгээр сарын 04-09-ний** өдрүүдэд явуулж нийт **271,365** иргэн саналаа өгснөөс **259,867** иргэн ногдол ашгаа “бэлэн мөнгөөр авна” гэж, **11,042** иргэн “хуримтлалын нэрийн дансандаа шилжүүлнэ” гэж, **456** иргэн “хандивлана” гэж саналаа өгсөн бөгөөд **4 дүгээр сарын 11-16-ны** өдрүүдэд өмнөх судалгаанд оролцож, “Хуримтлалын сан” болон “Хандивлах” гэсэн санал өгсөн, санал өгөх эрхтэй нийт **10,494** иргэнд зориулан дахин баталгаажуулалтын санал асуулгыг явуулсан.

Баталгаажуулалтын санал асуулгын үр дүнд нийт **261,556** иргэн ногдол ашгаа “бэлэн мөнгөөр авна” гэж, **8,491** иргэн “хуримтлалын нэрийн дансандаа шилжүүлнэ” гэж, **314** иргэн “хандивлана” гэж саналаа эцсийн байдлаар баталгаажуулсан байна.

Иргэд улсын хэмжээний санал асуулгад идэвхтэй оролцож байгаагаас харахад Үндэсний баялгийн сан тэр дундаа Хуримтлалын сангийн зорилго, ач холбогдлыг ойлгож эхэлсний илрэл гэж миний зүгээс үзэж талархаж байна.

Цаашид Үндэсний баялгийн сангийн бодлогыг иргэдийн хүсэл сонирхолд нийцүүлж, иргэн өөрийн хүсэлтээр хуримтлалын нэрийн дансандаа нэмэлт орлого хуримтлуулах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор төрөөс олгож буй татварын буцаан олголт, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж, бусад дэмжлэгийг хуримтлалын нэрийн дансанд хуримтлуулах эсэх талаар “И-Монгол” төрийн үйлчилгээний цахим системээр дамжуулан иргэдээс санал авахаар бэлдэж байна.

Мөн Үндэсний баялгийн сан нь Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах бөгөөд 2030 он гэхэд төрөлжсөн сангуудын хөрөнгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, 2050 он гэхэд ил тод, нээлттэй, хараат бус, тогтвортой өсөлттэй, байгалийн баялгийн өгөөжийг иргэддээ тэгш хуваарилдаг, олон улсад өрсөлдөх чадвартай Үндэсний баялгийн сангийн загварыг бүрэн төлөвшүүлэхээр Засгийн газар зорьж байна. Энэ зорилгыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагууд, хувийн хэвшил, мэргэжлийн оролцогч талууд болон иргэд, олон нийтийн итгэлцэл, оролцоо, дэмжлэг хамгаас чухал юм.

Иймд Монгол Улсын Засгийн газар «Төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагын менежмент хийх бэлтгэлийг хангах хүрээнд сангийн хөрөнгийн бодлогын хэрэгжилтийг хангуулахад болон стратегийн ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох хэлэлцээ хийхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, мөн сангийн үйл ажиллагааг гадаад, дотоодод сурталчлан таниулах, иргэд, олон нийтэд Үндэсний баялгийн сангийн талаарх үнэн зөв мэдээлэл өгөх, түгээн дэлгэрүүлэх, сургалт судалгаа, мэдээлэл хийж ажиллах чиг үүрэгтэй “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийг энэ оны 02 дугаар сард байгуулсан.

Байгалийн баялгаа иргэн бүрд тэгш, шударга хүртээх цор ганц арга бол “Баялгийн сан” бөгөөд Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар бий болсон төрөлжсөн сангийн нэг болох Хуримтлалын сангаар дамжуулан иргэн бүрдээ хуримтлалын нэрийн данс үүсгэн хуримтлал бий болгож байгаа нь томоохон эхлэл юм. Цаашид сангуудын үйл ажиллагааг тогтвортой байлгах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, улмаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сангууд бий болгоход бусад улс орнуудын сайн туршлагыг судлан, хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Бусад улс орны баялгийн сангийн тогтолцоо, зохицуулалтыг судлан үзэхэд Үндэсний баялгийн сан нь Тогтворжуулалтын сан, Хадгаламжийн сан, Ирээдүй хойч үеийн сан, Тэтгэврийн сан, Валютын нөөцийн хөрөнгө оруулалтын сан, Стратегийн хөгжлийн сан, Хуваарилалтын сангийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд улс орнуудын хүн амын тоо, газар зүйн байршил, байгалийн баялаг, үндэсний соёл, нийгэм, эдийн засгийн чадамж, хөгжлийн түвшин зэргээс хамаарч баялгийн санг удирдах өөрийн улсын хөгжлийн түвшин, хэрэгцээ шаардлага, онцлогт тохирсон стратегийг тодорхойлж, баялгийн сангийн практикийг хэрэгжүүлж ирсэн байна.

Өөрөөр хэлбэл эдгээр сангууд нь улс орнуудын байгалийн баялгийн орлого, төсвийн ашиг, гадаад валютын албан нөөц зэргээс бүрдсэн багц хөрөнгийг урт хугацаанд арвижуулах, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, мөн ирээдүй хойч үедээ хуримтлал үлдээх, санхүүгийн нөөц бүрдүүлэх зорилготойгоор үүсгэн байгуулагддаг. Баялгийн сангууд нь өнөө үед дэлхийн санхүү, эдийн засгийн тогтолцоонд жинтэй байр суурь эзэлдэг стратегийн хөрөнгө оруулалтын тоглогч болон хөгжиж байна.

Сүүлийн жилүүдэд баялгийн сангуудын удирдаж буй хөрөнгийн хэмжээ тогтвортой өсөж өдгөө дэлхий дахинд 100 гаруй сан нийтдээ 13 их наяд ам.долларын хөрөнгө удирдаж байна. Энэ нь дэлхийн ДНБ-ий 10 орчим хувийг эзэлж байгаа нь тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөө асар их болсныг илтгэнэ.

Баялгийн сангуудын хөрөнгийн эх үүсвэр нь улс орны онцлог болон эдийн засгийн бүтэцтэй уялддаг. Жишээлбэл: Газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын экспортын орлогод суурилсан баялгийн сангуудын дунд Норвегийн “Government Pension Fund Global” (GPF), Абу Дабигийн “Abu Dhabi Investment Authority” (ADIA), Кувейтын “Kuwait Investment Authority” (KIA), Катарын “Qatar Investment Authority” (QIA) зэрэг нэр хүндтэй сангууд багтдаг. Эдгээр нь байгалийн

нөөцөөс бий болсон орлогыг ирээдүйн хэрэгцээнд зориулан хуримтлуулж, эрсдэл багатай, өгөөж өндөртэй байдлаар олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг.

Төсвийн илүүдэл болон гадаад валютын нөөцөд суурилсан сангуудын хувьд Хятадын «China Investment Corporation» (CIC), Сингапурын «Government of Singapore Investment Corporation» (GSIC), мөн төрийн өмчит «Temasek Holdings» нь онцлох жишээ юм. Эдгээр сангууд нь төсвийн ашиг, гадаад валютын нөөцөөс үүсэх илүүдлийг хөрөнгө оруулалтад шилжүүлж, үндэсний хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой ажилладаг.

Хөрөнгө оруулалтын чиглэлээр баялгийн сангууд уламжлалт үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө зэрэг салбараас хальж, ногоон эрчим хүч, нүүрстөрөгчийн төсөл, нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжлийн зорилт (SDG)-ыг дэмжих хөтөлбөр, шинэ технологи (хиймэл оюун ухаан, финтек, үүлэн тооцоолол, ухаалаг дэд бүтэц) зэрэг ирээдүйд чиглэсэн салбар руу хөрөнгөө төвлөрүүлж эхэлсэн. Энэ нь зөвхөн санхүүгийн өгөөжийг чухалчлах бус, мөн нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх зорилгыг давхар агуулж байна.

Баялгийн сангийн тоглогчид хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнууд руу тэлж, дэлхийн хуваарилалт тэнцвэржих хандлага ажиглагдаж байна. 2025 оны 02 дугаар сард АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп анх удаа дотоодын дэд бүтэц, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулж, улсын өрийг бууруулах зорилготой төрийн баялгийн сан байгуулах захирамж гаргаад байна.

Мөн Индонези улс «Danantara» нэртэй баялгийн санг шинээр байгуулж, анхны хөрөнгө оруулалтаа 20 тэрбум ам.доллараар эхлүүлэн, байгалийн баялгийн боловс-руулалт, хиймэл оюун ухаан, шинэ үеийн технологи зэрэг салбарт хөрөнгө оруулахаа зарлаад байна.

Монгол Улсын Засгийн газраас Баялгийн сангийн хуулийн хэрэгжилтийг хангуулахад онцгойлон анхаарч буйгаа дахин хэлэхийг хүсэж байна.

Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.

--oOo--

**2025 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН
ХУРАЛДААНД ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН, ХУРИМТЛАЛЫН САНГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ХИЙСЭН МЭДЭЭЛЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААР**

Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Зах зээлийн хэлтсийн захирал П.Мөнхбаяр, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Нийгмийн даатгалын ерөнхий газар дарга Б.Батжаргал, “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ий гүйцэтгэх захирал Б.Тэмүүлэн, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, “Эрдэнэс Монгол” ХХК-ий гүйцэтгэх захирал С.Наранцогт, Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны ажлын албаны дарга Л.Энхжаргал, Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга А.Хишигбаяр, “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн гүйцэтгэх захирал М.Энхсайхан, И-Монгол академи УТҮГ-ын захирал Б.Мягмарнаран, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн ахлах шинжээч Ш.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Дэд дарга Ү.Амарбат, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Үндэсний баялгийн сан, хуримтлалын сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин, ХҮН намыг Г.Уянгахишиг, Үндэсний эвслийг Д.Пүрэвдаваа, Иргэний Зориг Ногоон Намыг Б.Батбаатар нар төлөөлж үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу цөөнхийн төлөөллөөс Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, С.Эрдэнэболд, Л.Мөнхбаясгалан, Ж.Баярмаа, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Д.Жаргалсайхан нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, “Эрдэнэс Монгол” ХХК-ий Гүйцэтгэх захирал С.Наранцогт, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Зах зээлийн хэлтсийн захирал П.Мөнхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Дав.Цогтбаатар, Б.Батбаатар нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-д заасны дагуу цахим хуудсанд 4 иргэнээс ирүүлсэн 17 асуултыг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нар асууж, хариулт авав.

Б.Пүрэвдорж: Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Хурал дахь цөөнхийн төлөөлөл Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Хишигдэмбэрэлийн Тэмүүжин үг хэлнэ.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд ирүүлсэн Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилтийн талаарх Ерөнхий сайдын мэдээлэлтэй танилцаад Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс дараах дүгнэлт өгч байна.

1.Үндэсний баялгийн сангийн хуулийг сайжруулж, тогтолцоо засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 2024 оны 4 дүгээр сард Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг Засгийн газраас өргөн барьсан төслөөр Улсын Их Хурал баталсан.

Уг хуулийн дагуу Үндэсний баялгийн сан байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь ололттой. Гэсэн хэдий ч төрөлжсөн сангуудын чиг үүргийн давхцал, орлогын эх үүсвэрийн оновчгүй хуваарилалт, улс төрөөс хараат бус мэргэжлийн удирдлага засаглалын зарчмуудыг олон улсын сайн туршлагаас өөр өөр эрх баригчдын сонирхолд нийцүүлэн баталсан. Үүнээс үүдэлтэй сөрөг талууд нь өнгөрсөн ганцхан жилийн дотор илт мэдрэгдэж, ажиглагдаж байна.

Тухайлбал, Үндэсний баялгийн сангийн хөгжлийн сан нь улсын төсвийн хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл, Хөгжлийн банк зэрэг одоогийн механизмуудтай давхацсан тодорхой бус чиг үүрэгтэйгээр хуульчлагдсан байна. Үүний улмаас тус сан одоо хүртэл байгуулагдаагүй бөгөөд цаашид үр дүнтэйгээр ажиллах эсэх нь тодорхойгүй байна. Уг санд зөвхөн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд давсан орлогын 50 хувийг төвлөрүүлэхээр заасан нь төсвийн зардал ихээр тэлж, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ унаж буй энэ цаг үед бодитойгоор хэрэгжих боломжгүй харагдаж байна. Ийм орлого бий болсон ч гэлээ тэр нь төсвийн тогтвортой байдлын санд хуримтлагдаж, хямралын үед төсвийн алдагдлыг нөхөн тэнцвэржүүлэлтийн зорилтоор ашиглагдах жишигтэй байна.

Үндэсний баялгийн сангийн өөр нэг төрөлжсөн сан болох хуримтлалын сан нь нийгмийн халамжийн чиг үүргийг хэрэгжүүлдэг Засгийн газрын тусгай сан болсон нь олон улсын баялгийн сангуудын жишгээс зөрж байна. Эдгээрээс үзэхэд дээрх хоёр сан үнэн хэрэгтээ Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан төсвийн дагуу зарцуулагдах ёстой орлогыг төсвөөс гадуур Засгийн газар дур мэдэн зарцуулах боломжтой эх үүсвэр болон хувирчээ. Энэ нь Үндэсний баялгийн сангийн тухай хуульд сангуудын бүтэц, зарлага гаргах зориулалт, засаглалын тогтолцоог Засгийн газарт эрх өгөх байдлаар тааруухан хуульчилсантай холбоотой байна. Үндэсний баялгийн сангийн хамгийн том хэсэг болох ирээдүй өв санд хуримтлагдаж байгалийн баялгийн өгөөжийг хойч үедээ өв болгон үлдээх ёстой орлогоос өнөөгийн Засгийн газар сүүлийн 2 жил дамнан зарцууллаа.

Уг санд орох ёстой АМНАТ-ийн орлого 65 хувийг Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар дамжуулан 2024 онд 20 хувь, 2025 онд 40 хувь болгож бууруулсан. Ингэснээр 3 орчим их наяд төгрөгийн ирээдүйн хуримтлалыг Засгийн газрын сонгуулийн амлалтад зориулжээ гэхэд хилсдэхгүй байна.

2. Үндэсний баялгийн санд улс төрөөс хараат бус мэргэжлийн хөрөнгө оруулалтын менежмент дутагдаж байгаа тухай

Олон улсын баялгийн сангуудын алтан стандарт болох Сантьягогийн зарчимд зааснаар Баялгийн сан амжилттай ажиллах гол шалгуур нь улс төрөөс ангид байдал, мэргэжлийн хөрөнгийн удирдлага, хараат бус бүтэц юм. Харин Монгол Улсад баялгийн орлого нь улс төрийн сэдэлтэй популист амлалтуудад зориулагдаж байгаагаас үндэсний баялгийн сан бодит үр өгөөжгүй болдог. Өмнөх алдаа дахин давтагдах эрсдэлтэй байна. Зарим баримтаар тодотгоё. 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн өмнө хуримтлалын сангаас иргэдийг орон сууцжуулах боллоо хэмээн сурталчилсан. Улмаар тус сангийн 2024 оны орлого болох 480 тэрбум төгрөгийг ипотекийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт зарцуулсан бол 2025 онд мөн 500 гаруй тэрбум төгрөгийн орлогыг бүхэлд нь ипотекийн зээлд зарцуулахаар төлөвлөжээ.

Хуримтлалын сан нь иргэн бүрийн нэрийн дансанд хуваарилагдаж өсөж, боловсрол, эрүүл мэнд, орон сууцын зориулалтаар авч ашиглах зориулалттай. Гэтэл 6 хувийн хүүтэй ипотекийн зээлд сангийн хөрөнгийг зарцуулснаар хуульд заасан бодлогын хүүгээс багагүй хувиар өсөж байх шаардлага хангагдахааргүй байна. Иймэрхүү үндэсний баялгийн сангийн хөрөнгийг Засгийн газрын халамжийн шинжтэй төсөлд ашиглаж байгаа нь хуримтлалыг дотоод эдийн засгийн хямрал эрсдэлээс хамгаалах хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх боломжгүй болгож байна. Энэ янзаар үргэлжилбэл иргэн бүрийн нэрийн данс дахь мөнгө нь бодитойгоор авч ашиглах гэхээр бодитой байдаггүй шилний цаадах чихэр шиг болж болзошгүй байна. Ирээдүйн өв сангийн үлдэгдэл болох 1.2 тэрбум орчим ам.долларыг гадаад зах зээл дээр өндөр зэрэглэлтэй хувьцаа бонд зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд оруулж өсгөж үржүүлэх ёстой. Гэтэл төрийн санд олон жил байлгасны эцэст өнгөрсөн сараас Монголбанкны гадаадын төв банк дахь дансанд байршуулжээ.

Мөн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр бөөндөн баталсан хуулиудын дотор Ирээдүй өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар тус сангийн хөрөнгө оруулалтын мандатыг батлах менежмент хэрэгжүүлэх корпорацыг байгуулах, түүний Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүдийг гэрээ байгуулах нэрээр томилох бүх эрх мэдлийг Ерөнхий сайдад олгосон нь сангийн хөрөнгийн удирдлага үр ашиггүй байх, төрийн байгууллага, албан тушаалтнаас хэт хараат байх нөхцөл байдалд оруулсан байна.

Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн болон үйл ажиллагааны удирдлагыг Төв банк, Засгийн газрын холбогдох яаманд хэрэгжүүлэхээр хуульд заасан. Цаашид улс .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Минут нэмж өгчихье.

Х.Тэмүүжин: Үндэсний баялгийн сантай холбогдуулан хийж буй дүгнэлтээс гадна төгсгөлд нь нэмж дурдахад энэ удаагийн үндэсний баялгийн талаарх болон өмнөх олон удаагийн Ерөнхий сайдын мэдээлэл нь олон нийт, хууль тогтоогчдын мэдэхийг хүссэн авах шаардлагатай мэдээллийг агуулаагүй, зөвхөн Засгийн газрын пропаганд хийхийг хүссэн мэдээллээр хязгаарлагдаж байна. Үүний цаана төрийн эрх барих дээд байгууллага болон гүйцэтгэх засаглалын хоорондын харилцааны том зарчмууд бүдгэрч байна. Цаашид энэхүү парламентын дэгийг парламентын ардчилал хөгжсөн улсуудын жишигт нийцүүлж Ерөнхий сайдын мэдээллийн цаг биш Улсын Их Хурлын асуулгын цаг болгон өөрчлөх шаардлагатай байгааг Ардчилсан намын бүлэг үзэж байна.

Өөрөөр хэлбэл Ерөнхий сайд өөрийн хүссэн сэдвээр биш, иргэд, хууль тогтоогчдын асуултад өмнөөсөө хэн нэгэн сайдыг илгээх биш заавал биеэр ирж хэдэн хуудас цаас унших биш үзэл бодлоо уралдуулан мэтгэлцдэг байх дэгийг..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүнд баярлалаа. Одоо Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг гишүүн үг хэлнэ. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын эрхэм гишүүд, Ерөнхий сайд аа,

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөлөөс дараах дүгнэлтийг гаргаж байна.

Үндэсний баялгийн сангийн хуримтлалын сангийн үйл ажиллагаа амжилттай ажиллаж байгаа тухайд мөн Ирээдүйн өв сангийн хөрөнгийг олон улсын санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагааг зохион байгуулж эхэлсэн талаарх мэдээллийг сонслоо.

Гэхдээ энэ нь өөрөө удирдан зохион байгуулах ажиллагаа явж байгаа талаар мэдээлэл байх боловч бид асуулга асуух эрхгүй байгаа учраас үг хэлэх хүрээнд тодруулах олон асуултууд байна гэдгийг дурдмаар байна. Мөн түүнчлэн

Ерөнхий сайдаас гаргаж байгаа мэдээлэлд тухайлбал олон улсын санхүүгийн байгууллагад төвлөрүүлээд байгаа Ирээдүйн өв сангийн хөрөнгөөс төвлөрүүлсэн хөрөнгийг ямар өгөөжтэйгөөр байршуулсан юм. Ямар хөрөнгийн хэрэгсэлд, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулсан юм гэдэг талаар нарийвчилсан мэдээлэл байхгүй байгаа учраас дүгнэлт хийхэд боломжгүй байгаад байна.

Түүнчлэн хуримтлалын нэрийн данстай болж байгаа хэдий боловч энэ мэдээллээс харахад хуримтлалын сангийнхаа хөрөнгийн зарцуулалт талдаа хуулийнхаа өөрийнх нь зорилгыг умартаад байна уу гэж хэлмээр санагдаж байна.

Өөрөөр хэлбэл хуримтлалын санд хуримтлагдсан 480 тэрбум төгрөгийг орон сууцын хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн эх үүсвэрт хөрөнгө оруулсан гэж байна. Тэгвэл хөрөнгө оруулалтын өгөөж нь хэд юм бэ? Энэ хуримтлалын сангийн 480 тэрбум төгрөгт сарын, жилийн хэдэн хувийн өгөөжтэйгөөр байршуулсан бэ гэдэг мэдээлэл бид нарт ирсэнгүй. Танилцуулагдсангүй.

Тэгвэл нэгтгэсэн дүнгээр нь харахад 2024 оны хүүгийн орлого 4.9 тэрбум төгрөг гэдэг бол нийт хөрөнгийнхөө 1 хувьтай тэнцүү байна. Энэ нь өөрөө хуримтлалын сангийн хөрөнгийг хэрхэн өгөөжтэй байршуулах талаар хуулийнхаа зохицуулалтыг зөрчөөд явж байгаа мэт ойлголтыг төрүүлж байна.

Тийм учраас 4.9 тэрбум төгрөгийн хүү хэдэн сарын хугацаатай ямар хэмжээтэй хөрөнгөөс бодогдсон хүү вэ гэдгийг бидэнд мэдээлэлдээ өгсөн бол ойлгомжтой болох байлаа гэдгийг хэлмээр байна.

Мөн түүнчлэн Үндэсний хуримтлалын сангийн хөрөнгийг хэн удирдаж байгаа талаар, хэрхэн удирдаж байгаа талаар мэдээллийг бид авах хүсэлтэй байна. Өөрөөр хэлбэл “Чингис хаан Үндэсний баялгийн сан” гэж нэрлэсэн. Гэтэл шилэн дансны мэдээлэл дээр “Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК” буюу төрийн өмчит ХХК-ий хэлбэрээр байгуулагдсан харагдаж байгаа. Шилэн дансны мэдээлэл дээр бол огт мэдээлэл байхгүйгээс гадна тухайн хуримтлалын санг ХХК хэлбэрээр удирдан зохион байгуулж явах нь хэр зөв зүйтэй вэ гэдэг асуудал урган гарч ирж байна. Энэ талаар мөн мэдээлэл авах хүсэлтэй байна. Энэ асуудлаар асуулга явуулах шаардлагатай байна гэж үзэж байна.

Энэ бүхэн дээр үндэслээд хэлэхэд Ардчилсан намын бүлгийн саналтай санал нэгдэж байгаа зүйл бол хуримтлалын санг төрийн сан шиг болгомооргүй байна. Өөрөөр хэлбэл төрийн хуримтлалын сан иргэн бүрийн нэр дээр хуримтлагдаж байгаа мөнгө. Ер нь хуримтлалын сангийн зорилго юу вэ? Энэ нь өгөөжтэй байх ёстой. Гэтэл Засгийн газар өөрөө удирдах замаар тэр өгөөжөөс үл хамаараад, Засгийн газрын хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх бас нэг халаас болж ашиглах юм бол энэ хуримтлалын сан гэж байгаагийн зорилго алдагдах гээд байна. Тэгэхээр хуулийнхаа зарчмыг барьж ажиллах тал дээр Засгийн газрыг үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг эргэж хараач гэдэг саналыг хэлмээр байна.

Энэ хуримтлалын сан гэдгийг ийм маягаар удирдан зохион байгуулаад явах юм бол цаашид бид хуримтлалын санг тэтгэврийн сангийн чиглэл рүүгээ

оруулах, хуримтлалын сангийн хөрөнгийг тэтгэврийн шинэтгэлээ хийхэд зарцуулбал иргэн бүрд очих өгөөжийг тодорхой болгох, тэгш шударга хуваарилалт дээр ойлгомжтой болоход нөлөөтэй юм. Ийм учраас энэ хуримтлалын сангийн мөнгөний удирдлага, зохион байгуулалтын талаар дэлгэрэнгүй мэдээллийг авмаар байна. Нөгөө талаасаа хуульд заасан зорилго, зорилтынхоо хүрээнд зарцуулалтыг хийхийг Засгийн газраас хүсмээр байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн танд баярлалаа. Өмнө нь Батын Батбаатар гишүүн үг хэлэх ёстой байсан байхгүй байна. Одоо индэрт Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн үг хэлнэ.

Д.Пүрэвдаваа: Эрхэм гишүүд, эрхэм дарга нартаа энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхий сайдынхаа үгийг анхааралтай сонслоо. Танин мэдэхүйн шинжтэй, түүхийн шинжтэй, үр дүнгийн шинжтэй мэдээлэл өгсөнд талархаж байгаагаа илэрхийлье.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиараа Ерөнхий сайддаа хандаж үг хэлэх боломж олдсонд талархууштай байгаагаа илэрхийлэх нь зүйтэй байх.

Нэгдүгээрт, Үндэсний баялгийн сан болон хуримтлалын сангийн ил тод байдлын асуудлыг хөндмөөр байна. Ерөнхий сайд нь заавал мэдээлэл хийсний дараагаар мэдээллээ олж авдаг, явц нь ямар байгааг мэддэг асуудлыг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Ялангуяа уул уурхайн баялгийн эх үүсвэрээс орж буй орлогын бүртгэл, тайлагнал, сан руу орсон мөнгөн хөрөнгө, түүний хөрөнгийн ашиглалт, бодит үр дүнд хүрсэн талаарх цаг үеийн мэдээ холбогдох хуулиар байнгын ил байх ёстой. Тэр нь шилэн дансны сайт болон бусад мэдээлэл авах боломжийн сувгууд дээр байхгүй байгаа нь иргэдийн олон нийтийн итгэл буурах хандлагатай байна шүү гэж хэлмээр байна.

Дараагийн нэг зүйл бол Үндэсний баялгийн санд бол АМНАТ-өөр дамжуулаад мөнгөн хөрөнгө цугларч байгаа юм. Тэгээд энд орхигдож байгаа асуудал нь тухайн орон нутаг болоод байна. Ялангуяа орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг бүрдүүлэхдээ хүн ам болон газар нутгийн хэмжээг тооцож үзэж байгаад жил болгон төсвийнхөө хөрөнгө оруулалтын 5-10 хувийг байршуулж байгаа. Энэ бол аймаг, орон нутагт ялангуяа уул уурхайгаар баян, уул уурхайн үйл ажиллагаа явдаг аймаг орон нутгийн эрх ашиг, иргэдийн болоод байгаль орчны эрх ашиг ноцтойгоор зөрчигдөж байна гэж харж байгаа.

Тийм учраас төрөлжсөн сангийн нэр төрөл ба “Ирээдүй өв сан”, “Хуримтлалын сан”, “Хөгжлийн сан” гэсэн 3 сангаас бүрдэж байгаа энэ “Үндэсний баялгийн сан” дээр орон нутгийн хөгжлийн сангийн тодорхой хувийг энэ сангаас олгох нь зүйтэй юм гэдэг байр суурийг илэрхийлж байна.

Хоёрдугаарт, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр гэж нийт борлуулал-тын орлогоос 5 хувь авдаг. Оюу толгой компанийн жилийн борлуулалтын орлого ойролцоогоор 5 тэрбум ам.доллар байгаа. Тэгэнгүүт 2009

онд байгуулсан гэрээгээр бид ердөөсөө 5 хувь дээр тогтворжуулаад барьчихсан. Эрдэнэт болон Монгол Улсын бусад зэсийн баяжмал олборлож байгаа компаниуд 5 дээр нэмэх нь 11 хувийн татвар авдаг. Өнөөдөр зэсийн үнэ 9400 гарчихсан. 9000 ам.доллараас даваад гарчихсан. Тэгэхээр 11 хувиар авч болох орлогоо бид нар алдаад байна. Энэ дээр Засгийн газар ажиллаач. Зоригтой, хурдтай хөгжил гээд 3 нам эвссэн. 11 хувийг Оюу толгой компаниас авах энэ асуудлаа ярих цаг нь болсон байх гэж хэлмээр байна.

Дээрээс нь өнөөгийн цаг мөчид алтны үнэ түүхэндээ дээд цэгтээ хүрч байгаа юм. 1 килограмм алт 360 сая төгрөг болсон. Өнөөдөр манай ам.доллар маань 3600 руу орж 100 мянган ам.доллар 1 килограмм алт болчихоод байна. Тэгэхээр зэрэгцээд манай нүүрсний үнэ уначихсан. Энэ баялгийн сандаа төвлөрүүлж болох өөр эх үүсвэр байгаа учраас Алт хөтөлбөрийн асуудлаар Засгийн газар хурдтай зориглооч гэж бас хэлмээр байна. Сая Ардчилсан нам, ХҮН намынхан маань шүүмжлэлтэй хандаж байх шиг байна. Нэгэнтээ гэрээгээ ил болгоод бид нар хамтарсан засаг байгуулаад явж байгаа юм чинь та бүхэн алт хөтөлбөрийг орлого талдаа нэмэгдүүлэхэд ажиллах нь зүйтэй байх гэж хэлье.

Тэгээд хамгийн сүүлд ил тод байдал бид нар авторитар гэдэг тэр дэглэм рүү ойртоод дөхчихсөн байгаа учраас энэ баялгийн сангийнхаа явцын хяналт дээр хөндлөнгийн байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийг оролцуулах хаалга үүдийг нээж өгөөч гэж Ерөнхий сайддаа хандан хэлмээр байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүнд баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан Ерөнхий сайд болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн төлөөлөл Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү?

Баялгийн сан бол анхных нь биш. Ер нь баялгийн сан 5 удаа байгуулагдсан. Өөрөөр хэлбэл хамгийн анхных нь бол Монгол Улсыг хөгжүүлэх сан гэж 2007 онд байгуулагдсан. Тэгээд энэ байгуулагдаад анх гараа дээрээ бараг дампуурсан. Яагаад гэвэл 2008 оны улс төрийн сонгуульд мөнгө амлах бол амжилтад хүрэх юм байна гэж үзээд АН 1 сая төгрөг, МАХН 1.5 сая төгрөг тараагаад эндээс эхлээд явсан байгаа.

Дараагийнх 2009 онд Хүний хөгжлийн сан гэж байгуулагдаад, дандаа зарлага нь орлогоосоо давдаг учраас энэ сан амжилттай ажиллахгүй явсаар байгаад 10 гаруй жил яваад Төсвийн тогтворжуулалтын сангийн тухай хуулиар солигдож байхгүй болсон байгаа.

Төсвийн тогтворжуулалтын сангийн тухай хуулийн дагуу “Тогтворжуулалтын сан” байгуулагдаад, 2010 оноос хуульд нийтдээ 13 удаа нэмэлт, өөрчлөлт ороод, үндсэн зорилгоосоо тэс хазайж явсан учраас тус сан үр дүнгүй байгаа.

4 дэх сан бол 2016 онд байгуулагдсан “Ирээдүй өв сан” байгаа. 2030 он хүртэл энд хуримтлагдсан мөнгийг ерөөсөө огт хүрэх ёсгүй байсан.

Гэвч үе үеийн Засгийн газар эндээсээ авч, төсвийн цоорхойгоо нөхдөг. Энэ байдлаасаа болоод “Ирээдүйн өв сан”-гийн үйл ажиллагаа нь өнөөдөр доголдоод явж байгаа юм.

Өнөөдөр Баялгийн сангийн тухай хууль батлагдаж байна. Бас тодорхой хэмжээгээр хамтарсан засгийн үед энэ баялгийн сангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх оролдлого, зүтгэл байна. Гэвч сангийн үйл ажиллагаанд чиглэсэн тодорхой санал хэлж цаашид анхаарах зүйлүүд байна. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд явагдсан 4 сангийн асуудал дээр хамгийн гол нь сангийн эх үүсвэрийг нь дандаа төсөв 2 буюу төсвийн цоорхойг нөхөх, дээрээс нь төсөвгүйгээр сангийн зарцуулалтаар бусад төсөв 2 болгож ашиглах явдал хэрээс хэтэрсэн байсан.

Дээрээс нь сангууд дээр бол сангийн засаглал байхгүй, мэргэжлийн баг байхгүй байгаагаас болж энэ сангууд чанартай үйл ажиллагаа явуулж чадаагүй.

Гуравдугаарт нь сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт сул байсан. Үүнээс болж доголдсон байгаа.

Дөрөвдүгээрт нь сангийн хөрөнгийг өсгөх, арвижуулах эрх зүйн орчин байхгүй учраас ерөөсөө өсдөггүй нөхцөл байдалтай байсан.

Тавдугаарт нь улс төрийн шийдвэрээр сангийн хөрөнгийг дураараа зарцуулах нөхцөл байдал их байсан. Тийм учраас энэ баялгийн сан дээр гадаад менежменттэй, дээрээс нь зөв зүйлд зарцуулдаг шууд бэлэн мөнгө тараагаад ард иргэдэд өгчихдөг биш ийм сан байгаасай гэж хүсэж байна. Тэгэхээр ер нь бол Монгол Улс сүүлийн 10 жилийн дотор 100 тэрбум ам.долларын баялгийг экспортолсон. Гэвч өнөөдрийн байдлаар 115 сая ам.долларын өртэй байна. 1 хүнд 40 сая төгрөгийн өртэй болсон ийм үзүүлэлттэй байна. Тийм учраас баялгийн сангийнхаа менежментийг зөв болгох, орлогыг арвижуулахад сайн ажиллаасай гэж Засгийн газраас хүсэж байна. Ингээд дараагийн хүн Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Дав.Цогтбаатар: Ерөнхий сайдад баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд баярлалаа. Мэдээлэл өгч байгаад. Бид Үндэсний баялгийн сан гээд зөвхөн уул уурхайн баялгаас орж ирэх орлого, тэдгээрт удирдлага, менежмент хийх талаар ярилцаж явж байгаа. Тэгээд сая манай бүлгийн байр суурийг Х.Тэмүүжин гишүүн илэрхийлсэн. Энэхүү байр суурьтай санал нэгтэй байгаа.

Дээрээс нь нэмж хэлэх хэдэн асуудлууд байгаа. Тухайлбал, Засгийн газраас оруулж ирж байгаа онгоцны түлшийг хувийн хэвшил хийгээд өнөөдрийг болтол явчихсан ажлыг төр өөр дээрээ дахиад хувийн онгоцны түлш зардаг компани байгуулаад, хувийн хэвшилтэйгээ өрсөлдөж борлуулах юм шиг харагдаж байгаа ийм үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгээд хувийн хэвшилдээ үнийнх нь дээд хязгаарыг тогтоож өгөөд, үүнээс дээш гаргахгүйгээр та нар хийж чадна гэвэл төр заавал орж онгоцны түлш авчирч зарах шаардлагагүй гэдэг дээр бодож үзээд, дахин оруулж ирвэл зүгээр байна гэсэн санал хэлэх гэж байгаа юм.

2 дахь санал нь бид хувийн хэвшлээ дэмжинэ гээд сүүлийн 30 жил ярьж, хувийн хэвшлээ 30 жил дарамталсан. Нэг жишээ нь Монголбанкны өөдөөс хараад сууж байгаа Ард кино театр гэдэг барилга нураад, хувийн хэвшил хөрөнгө оруулалт татаж ирээд, шинээр бүтээн байгуулалт хийгээд хөрөнгө оруулалт татаад ирье, ажлын байр нэмэгдүүлье гэхээр тэрийг нураагаад, бүр балгас болгоод хэн ч ашиглаж чадахааргүй, хувийн хэвшил нь ч ашиглаж чаддаггүй, төр нь ч ашиглаж чаддаггүй хотынхоо төвд нурсан байшинтай, тэрийг нь тойруулж нэг татсан хашаатай ийм нийслэл болоод байна. Тэгээд энэ талбайг тойроод ийм дүр зураг байгаа. Ардчилсан намын нэр дээр яригддаг байсан СТӨ-ний хүзүүвч хүртэл одоогийн байдлаар гацчихсан байгаа. Тэгэхээр бусад хувийн хэвшлүүд рүүгээ анхаарал хандуулаад, хувийн хэвшил нь өөрсдөө хөрөнгө оруулалт олж ирээд зөвхөн уул уурхай гэхгүйгээр хөрөнгө оруулалт оруулж ирээд үйл ажиллагаагаа явуулъя гэж байгаа бол нээлттэй бодлого барьж, тэднийг дэмжих шаардлагатай байна гэж санал хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Эрдэнэболд: Зарчмын хувьд олон жил удтал ярьсан шударга ёсыг тогтоох, баялгийн тэгш хуваарилалт, цөөн хүмүүст хамааралтай байгаа далд эдийн засгийг ил гаргаж ирэх, эдийн засгаа либералчлах гээд олон зүйл энэ баялгийн сантай шууд холбоотой болчихоод байгаа.

Асуултуудаа асуухаасаа өмнө мэдээллийн чанартай асуултын суурь болгож хэлэхэд 1960-аад оны сүүлээр жишээлбэл Норвегийн баялаг илрээд 30 гаруй жил буюу 1997 он хүртэл судалгаа явуулж байгаад Норвегийн баялгийн санг байгуулж, 29 жилийн өмнөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Тэгээд 2012 онд тус сангийн үйл ажиллгааг судлах зорилгоор очиж байхад улсын төсөв, баялгийн сангийнх нь харьцаа нь жишээлбэл баялгийн сангийнх нь хэмжээний 3.5 орчим хувьтай тухайн жилийнх нь улсын төсөвт тэнцэж байсан. 2022 онд түүхэндээ хамгийн дээд хувьцааны ханшаас үүдэлтэй алдагдал буюу 147 тэрбум ам.долларын хохирол амсаад явж байсан. Гэхдээ буцаагаад 3 жилийн хугацаанд нөхөгдөөд явчихаж байгаа юм. Энд ямар зүй тогтол харагдаж байна гэхээрээ Норвеичууд их ухаалаг хүмүүс.

Нэгдүгээрт, гадаад улс дахь үл хөдлөх хөрөнгүүдийг худалдаж авч, түүнийг түрээслэх байдлаар нөгөө мөнгөө хөдөлгөөнд оруулж, ашигтай салбарууд руу хөрөнгө оруулалт хийсэн.

Хоёрдугаарт, тодорхой томоохон баталгаатай байж болохуйц газруудын хувьцааг авна. Гэхдээ хувьцааг 50 дээр нэмэх 1 ч юм уу мажорити хувьцаа авахгүйгээр үр өгөөжийг нь тооцдог. Гэхдээ үүний цаана олон судлаачид, мэргэжилтнүүд юунд хөрөнгө оруулалт хийвэл зөв бэ гэдэг дээр байнга ангуучилж байдаг. Энэ нь шийдвэр гаргалт буюу баялгийн сангаа улам арвитгахтай шууд холбоотой бодлогыг хэрэгжилтийн үр дүнд статистик анализ хийгээд бодож байдаг. Гэтэл манай улсын хувьд Ерөнхий сайдын мэдээллээс харахад 2030 он гэхэд бол 4-5 тэрбум ам.доллар хүрнэ гэж тооцож байгаа. Тэгээд жишээлбэл Англи, Франц, Люксембург Улсын төв банканд одоогийн байгаа мөнгөө

байршуулчихсан, хадгалуулчихсан гэж байгаа. Тэгэхээр зарчмын хувьд одоо бид тодорхой орж ирж байгаа мөнгийг аль нэгэн улсын банканд байршуулах гэхээсээ илүүтэйгээр тодорхой хэмжээнд Норвег маягийн байдлаар хөрөнгийн зах зээл смарт технологид ч юм уу хөрөнгө оруулах боломж бололцоог судалсан уу? Судалсан бол энэ ер нь ямар боломжтой байна вэ гэдэг асуулт 1 дүгээр асуулт нь байгаад байгаа юм.

Гуравдугаарт нь саяын намын бүлгүүдийн илтгэлд.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Эхлээд Ерөнхий сайд хариулчихъя. Тэрний дараа нэмэлт.

Л.Оюун-Эрдэнэ: С.Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Дэлхий дээр уул уурхайн баялгаас бүрддэг янз бүрийн баялгийн сангууд буюу 100 гаруй баялгийн сан байна. Зарим нь Норвегийн сантай төстэй буюу бүрдсэн орлогоо арвижуулах байдлаар асуудлаа шийддэг сангууд байгаа. Зарим баялгийн сан нь дэд бүтэц болон бусад асуудлуудаа шийдэхэд нь зохистой менежмент хийдэг. Казакстанд тухайлбал, баялагийн сангаар улсынхаа томоохон асуудлуудыг шийдвэрлэдэг. Зарим нь иргэдийн эрүүл мэнд, боловсрол, орон сууц зэрэг хөтөлбөрт зарцуулдаг хадгаламжийн сан байгаа. Тухайн улс бүр өөр өөрийн үндэсний онцлогт тохирсон менежментийн зохист хэлбэрийг судлаад уул уурхайн төслүүдээ олон нийтийн дэмжлэгтэй болгох арга хэлбэрийг ер нь баялгийн сан гэж үздэг юм байна.

Манай Улсаас Норвегийн санг судлахаар холбогдох албаны хүмүүс очиж үзэж байсан. Манай Улсын хувьд гол асуудал бол ирээдүйдээ хадгалахыг зөв гэдэг боловч өнөөдрийнхөө асуудлыг шийдмээр байдаг. Өнөөдрийн асуудал шийдэгдэхгүй байгаа учраас уул уурхайн төслүүд өгөөж багатай байна гэдэг шүүмжлэл дагуулдаг. Дээрээс нь иргэдийн дансанд шууд хуримтлагдахгүй учраас захиран зарцуулах болон засаглалын хувьд хяналт тавих боломжгүй байна гэдэг асуудлууд яригддаг. Тэгэхээр Үндэсний баялгийн сан буюу 1 жилийн өмнө батлагдсан энэ хууль 3 зүйлийг Үндсэн хуульд заасны дагуу нэгдсэн удирдлагаар хангах эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болно. Мэдээж 1 жил гэдэг бол дүгнэлт хийх хугацаа мөн. Гэхдээ одоо бид нарын хувьд ярилцаад, ирээдүйд яаж олон нийтийн дэмжлэгтэй уул уурхайн хөрөнгө оруулалтыг бий болгох вэ гэдэг бол Үндэсний баялгийн сангийн хамгийн гол концепц байна. Тэгээд ойлголтоо нэгтгэж байж хөрөнгө оруулагчид болон компаниудтай 34 хувьтай холбоотой хэлэлцээрийг хийхгүй бол өөр өөр ойлголттой байгаа учраас энэ асуудлыг оруулж ирэхээр улс төрийн асуудал нь хөрөнгө оруулалт болон бусад асуудлаасаа ялангуяа Үндэсний баялгийн сангийнхаа асуудлаас өмнө гарчих гээд байгаа учраас өнөөдөр үндэсний баялгийн сангийн асуудлын талаар мэдээлэл өгөөд ярилцах нь зүйтэй гэж үзэн оруулж ирж байгаа.

Мэдээж Ирээдүйн өв сантай холбоотой асуудлын менежментийг эрсдэлийн хамгийн бага байхаар Монголбанкны хадгаламж хийх нь зүйтэй гэж үзсэн байгаа. Энэ эрх зүйн орчноор цахим компаниудын хувьцаа авах ч юм уу эсвэл хөрөнгө оруулалт хийх ч юм уу хамгийн эрсдэл багатай газар хөрөнгө оруулалт хийх боломж нь эрх зүйн хувьд нээгдсэн. Одоо 3 сан нэгдээд Чингис

хаан сан гээд нэрлэгдээд явж байгаа. Энэ асуудал яригдаад, зарлагдаад явж байгаа ийм цаг үе байна. Цаашдаа хараат бус гаднын удирдлагаар удирдуулах нь зүйтэй гэдэг дээр Эрдэнэс Монголд чиглэл өгчихсөн.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар 3 минутаар асууна, нэмж асуухгүй юм байна. Тэгэхдээ 1 минут нэмээд өгчихье.

С.Эрдэнэболд: Пүрэвдорж даргад баярлалаа. Ер нь бид нар удтал ярьсан энэ хулгай, дээрэм, хууль бус хөрөнгийн асуудал, дээрээс нь улс төржилт, мөнгө, далд эдийн засаг, баян ядуугийн ялгаа, үнэт зүйлсийн доройтол гээд бүх зүйлийг мэдээж нэг алхмаар бүгдийг шийдэж чадахгүй ч гэсэн хамгийн эхний алхам бол бүх юмыг хуулийн дагуу болгох, ил тод болгох, нээлттэй болгох, "inclusive economics" буюу хүртээмжтэй эдийн засгийн чиглэл рүү алхам хийх ёстой гэж үзэж байгаа. Энэ утгаараа ирээдүйн өв сан буюу баялгийн сантай холбоотой асуудлыг итгэл үнэмшилтэйгээр дэмжиж байгаа.

Гэхдээ менежментийн хувьд, эрсдэлийн хувьд, ил тод байдлын хувьд, олон нийтийн хяналтын хувьд, мэргэжлийн байдлын хувьд гээд олон талаас нь хэлэлцүүлгийн явцад бид цаашдаа энэ асуудал дээр чамбай хандаж, аль болохоор улс төржихгүйгээр хандаасай гэж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Энэ баялгийн сантай холбоотойгоор төр ахиад мөнгө хуримтлуулаад, тэгээд зарцуулалтыг нь төрөөс дахиад хийнэ гэж ярьж байгаа юм. Гэхдээ өнөөдөр бид нар 33 их наядыг зарцуулж байгаа засагтай байгаа. Нэг зүйлийг харахаар бид дандаа ирээдүй цаг дээр иргэдээ гоё болчихно. Ирээдүй цаг дээр бид асуудлыг нь шийдчих юм шиг ярьдаг. Урин дулаан цаг ирчихээр дахиад утааны асуудлаа мартаад хаяж байгаа юм шиг байна. Тэгэхээр Ерөнхий сайдаас зайлшгүй асуух зүйл гарч ирчихээд байна даа.

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын албанаас болохоор хувийн компаниуд руу шингэрүүлсэн хийн түлшийг ирэх 2025-2026 онд ашиглаад яв гэдэг чиглэл ч юм уу, албан бичиг ирээд яваад байгаа. Тэгээд утааны тухай асуудлыг шийднэ гээд бөөн үндэсний хороо байгуулаад, хэлэлцээрүүд хийгээд яваад байсан. Тэгээд эцэст нь Монгол Улс өөрөө шингэрүүлсэн хийн түлшийг сонгосон юм уу? Энийг хэн ямар замаар, хэдэн төгрөгийн үнэтэйгээр нийлүүлж байгаа юм бэ? Энэ ямар байдлаар ялангуяа шийдлүүд нь гараагүй байхад хувийн компаниуд руу хорооноос шууд шаардлагууд тавиад явж байх нь хэр зөв юм бэ? Иргэдийн хувьд болохоор саяхан гэхэд хэдэн хүн амь насаараа хохирлоо, хордлогод орж угаартсан хэдэн мянган хүн байгаа. Тэгэхээр энэ хүмүүс дээр дахиад ирэх өвөл Таван толгой шахмал түлшийг ашиглаад байж байх уу? Тэгэхээр хавар болоод ирэхээр энэ утааны асуудлаа орхичихдог. Тэгээд шийдэл нь ерөөсөө гараагүй, тал талд өөр өөр бодлогууд яваад байхаар чинь хувийн аж ахуйн нэгжүүд нь бизнес төлөвлөлтөө хийгээд явахад хүндрэлтэй байдаг. Иргэд нь бүр амь нас, эрүүл мэндээрээ хохироод явж байна. Тэгээд энэ ирээдүй

цаг дээр баялгийн сангийн асуудлуудыг шийдээд ч байдаг юм уу, ирээдүйд энэ асуудлууд шийдэгдэнэ гэж харах гэхээсээ өнөөдрийн цаг үе дээрээ, урин дулаан цаг дээр ч гэсэн бид утааны шийдлүүдээ тодорхой гаргаж ирэх ёстой гэж харж байна. Тэгэхээр Ерөнхий сайдын хувьд та 2025-2026 оны өвөл ямар байдлаар халаалтыг шийдэх юм бэ? Яаж явах юм бэ гэдэг дээр тодорхой хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгөх үү? Хэлэлцэж байгаа асуудалтайгаа холбогдуулаад асууна шүү дээ. Үндэсний баялгийн сангийн тухай асуудал хэлэлцэж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар үндэсний баялгийн сантай холбоотой асуудал дээр асуулт, хариулт энэ цаг дээр яригдах нь зүйтэй байх даа. Шаардлагатай тохиолдолд дэлгэрэнгүй мэдээллийг хотын удирдлагууд болон мэргэжлийн хүмүүсийг нь байлгаж байгаад, бэлдэж байгаад ярих нь зохистой байх. Баялгийн сантай наад асуудлыг уялдуулаад ярихад Үндэсний баялгийн сан дээр бид шийдлээ гаргамаар байгаа юм. Дараах хоёр асуудлууд байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын экспортын 90 хувь уул уурхай гэдэг. Энэ үнэн. Тэгэхээр уул уурхайн төслүүдийг өнөөдрийн байгаа асуудлуудаа шийдэхэд зарцуулмаар байна гэдэг. Энийг шийдэх нь зүйтэй. Гэтэл төсвөөр дамжуулж асуудлыг шийдэх ёсгүй гэдэг. Ингээд төсөв алдагдалгүй батлах нь зүйтэй гээд баталчихсан. Төсөв бол цаашдаа зөвхөн боловсрол, эрүүл мэнд, төрийн албан хаагчдын цалинтай холбоотой асуудлыг шийддэг хэв маяг руу явна гэсэн үг. Энэ ч зөв байх. Тэгвэл яаж шийдэх вэ гэдэг асуудал үүснэ. Та агаарын бохирдлын асуудал ярьж байна. Сая Х.Тэмүүжин гишүүн давхар төсөв яваад байна гэж байна. Тэгээд хаагуур нь явах вэ? Үүнийг бид прагматик яримаар байгаа юм. Иргэдэд бид өөр өөрсдийнхөө бодлоор мэдээлэл өгчихдөг. Тэгэхээр яах вэ гэхээр дунд нь бид зэлтэрийн гацаа гэдэг шиг хөгжлөө гацаачих асуудал руу орчихож байгаа юм. Тийм учраас үндэсний баялгийн сангийн концепц бол ирээдүй үедээ хадгалъя. Гэхдээ тэр нь АМНАТ-ийн 50 орчим хувь байг. Хөгжлийн сандаа зарцуулъя. Уул уурхай ашиглаж байгаа орон нутаг түрүүлж хөгждөг байя гэдэг асуудлыг эрх зүйн хувьд хуульчилж тодорхой болгох нь зүйтэй юм.

Иргэдийн нэрийн дансанд хуримтлал үүсгэе. Энэ нь зохих түвшинд ямар байх вэ? 34 хувийн ногдол ашиг нь хаанаа орох юм. АМНАТ нь хаанаа орох юм гэдэг зарчмыг тогтохгүйгээр том тоо яриад, уул уурхайн төслүүдийг хөдөлгөх нь зүйтэй гэж яриад, тэгээд бид дахиад дорoo хий эргэчхээд байна. Иймд Улсын Их Хурлын гишүүд та бүхэн маань их нухацтай бодоорой гэж хүсэж байна.

Одоо уул уурхайн баялгаар дэд бүтцийн асуудлыг шийдэж болохгүй. “Valeu exchange” хийх нь бол буруу гээд шийдчих шиг амархан юм байхгүй. Төсвөөр бас ийм асуудлыг шийдэж болохгүй. Зөвхөн квот хэлбэрээр ч юм уу хувийн хэвшлээр шийдүүлнэ гээд. Гэтэл хувийн хэвшил ашигтай бизнест орно. Хувийн хэвшил нийслэлийн дэд бүтцийг шийдвэрлэх тийм үүрэг хүлээхгүй. Тийм учраас энэ бүх зүйлүүдээ баялгийн сангаар дамжуулж бусад улстай адилхан хөгжлийн сандаа ямар зарчмаар хандаж асуудлуудаа шийдвэрлэх вэ? Ямар

зарчмаар хадгаламж үүсгэх вэ? Ямар зарчмаар уул уурхайг ашиглуулж байгаа орон нутаг давуу эрх эдэлж хөгжих вэ? Энэ зүйлийг хамтдаа нээж өгөх нь Үндэсний баялгийн сан юм.

Иймд бид ойлголтоо нэгтгэх нь туйлын чухал юм. Энэ дотор агаарын бохирдол-той холбоотой, нийслэлтэй холбоотой олон асуудлууд баялгийг хэрхэн зөв зохистой ашиглах вэ гэдэг менежмент дээр байгаа. Яагаад гэвэл экспортын 90 хувь уул уурхай байдаг. Цаашдаа аялал жуулчлал, хөдөө аж ахуй, эрчим хүч гээд тэргүүлэх салбаруудыг гаргаж ирж болох боловч цаг орно. Ойрын 15-20 жил, 30 жил магадгүй уул уурхайн салбар Монгол Улсын тэргүүлэх салбар хэвээр байх болно.

Тийм учраас олон нийтийн дэмжлэг авдаг, нийгмийн дэмжлэг авдаг, орон нутгийн дэмжлэг авдаг уул уурхайн хөрөнгө оруулалт, уул уурхайн салбарыг хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг бол Баялгийн сан. Өөрөөр хэлбэл нийгмийнхээ тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх боломжит механизм руу явах ёстой гэсэн үг. Өнөөдөр энэ механизм оновчтой биш байсан учраас уул уурхайн салбарт тодорхой хэмжээнд нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдал байхгүй байгаатай холбоотой гэж хариулъя.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Говийн гишүүний хувиар асуух асуулт байна. Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан байдаг. Энэ хууль батлагдахаас 2 сарын өмнө “Энержи ресурс”, “Эм Си Эс” компани өөрийн эзэмшдэг байсан Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт байршилтай Баруун нарангийн уурхайг 88 сая ам.доллараар зарсан байдаг. Энэ бол мэдээлэлд ойрхноо далимдуулж, амжиж зарсан. 2011 онд Баруун нарангийн уурхай 980 сая ам.доллараар үнэлэгдэж байсан түүхтэй. Тэгээд Хятадын логиستيкийн “Жи Ай Ю” компанид зарсан. Энэ компани нь “Энержи ресурс” компанитай 20 жилийн турш урт хугацааны гэрээ байгуулчихсан байсан. Тус компанийн түүх бол дандаа төрд өөрийнхөө төлөөллийг суулгаж байгаад мэдээ, мэдээллийг түрүүлж авах байдлаар хөлждөг ийм компани. Тэгэхээр Ерөнхий сайд, Хууль зүйн сайд, Улсын Их Хурлын дарга гурвуулаа нэг танхимд суугаад, надад асуулт асуух боломж олдсон дээр нь нэг асуулт асууя.

Ухаа худгийг “Энержи ресурс” компани авсан нь Засгийн газрын тэмдэглэлд дурдсанаар хууль зөрчиж авсан байна гэж Засгийн газраас дүгнэлт гарсан. Үүнтэй холбоотойгоор тогтоолын төслийг өргөн барихаар болсон. О.Алтангэрэл сайд тогтоолын төслийг Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгаланд өргөн барьсан боловч одоо хүртэл авахгүй байгаа талаар О.Алтангэрэл сайд мэдээлэл хийсэн. Улсын Их Хурлын дарга аа, яагаад авахгүй байгаа юм бэ?

Ерөнхий сайд, О.Алтангэрэл сайд 2 хариулаач. Үнэхээр та нар бүрдүүлэлт дутуу хийгээд, хууль бус зүйл хийгээд өргөн бариад байгаа юм уу? Одоо Ухаа худаг, Төгрөг нуур гээд хэрэлдэж байх хооронд “Энержи ресурс” компани Ухаа худгаа зарчих юм биш биз дээ. Ийм асуулт байна.

Тэгэхээр Засгийн газрын тэмдэглэлд дурдсанаар Ухаа худагтай холбоотой хууль бус үйл ажиллагааг хянан шалгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн барьсан гэсэн. Яагаад авахгүй байгаа юм бэ? Өргөн барих чин зориг чинь хэвээрээ юу? Ингээд хэрэлдэж байх хооронд Ухаа худгийг зарчих вий дээ гэсэн бодол байна. Хардалт байна.

Д.Амарбаясгалан: О.Алтангэрэл сайд эхлээд хариулах уу? Би хариулах уу?

Засгийн газраас Ухаа худагтай холбоотойгоор Улсын Их Хуралд тогтоолын төсөл өргөн барихаар ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газраас бүрдэл хангасан эсэхтэй холбоотой асуудлыг нягталж үзээд, баримт материал дутуу байсан тул хуульд заасны дагуу баримт бичгийг гүйцээж ирүүл гэсэн шаардлага бүхий хариу бичгийг Засгийн газарт хүргүүлсэн. Хариу бичиг хүргүүлсэнтэй холбогдуулаад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал сайдын гарын үсэгтэйгээр нэмэлт материал ирсэн байгаа. Ирсэн нэмэлт материал болон өргөн барих тогтоолын төсөлтэй холбоотойгоор Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Дүн шинжилгээний хэлтэс хууль зүйн дүгнэлт гаргаж байгаа юм. Тэр хугацаа өнөөдөр буюу 4 дүгээр сарын 25-ны өдрөөр дуусгавар болж байгаа. Уг дүгнэлттэй холбогдуулаад өнөөдөр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр энэ асуудлаар бид олон талаас нь ярилцлаа. Энэ хуралд Хууль зүйн сайд оролцож асуудлыг хэлэлцсэн. Тэгээд даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд энэ асуудлыг ирэх 7 хоногт дахин хэлэлцэх нь зүйтэй гэж мөн зарим мэдээ, баримт материалыг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулах шаардлага байна гэж үзсэн.

Тэгэхээр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр энэ асуудлын талаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн барихтай холбоотой зөрчлийн 2 асуудал үүсэж байгаа юм.

Нэгдүгээрт, Засгийн газар иргэний хуулиар аж ахуйн нэгж, иргэнтэй хийсэн гэрээг зөв, буруу гэдэг асуудлыг Улсын Их Хурал шууд татаж авч дүгнэж байгаа байдал нь өөрөө зарчмын хувьд зөв үү, буруу юу? Улсын Их Хурал энэ асуудлыг хэлэлцэх нь зөв үү, буруу юу? гэдэг дээр дүгнэлт гаргаж, албан ёсны хариу өгөх процесс явагдаж байгаа гэсэн үг.

Хоёрдугаарт, энэ асуудал нь хэлэлцэгдээд явснаар Улсын Их Хурлаас гарах гэж буй тогтоол нь 2007 онд гарсан Улсын Их Хурлын тогтоолтой агуулга нэг буюу Улсын Их Хурлаас нэгэнт өгөгдсөн үүрэг даалгаврыг Засгийн газар хэрэгжүүлэх үүрэгтэй. Тэр үүргийг хэрэгжүүлээгүй дахиад Улсын Их Хурлаас үүрэг даалгавар өгөөч гэдэг хэлбэрээр тогтоолын төсөл өргөн барьсан байдал нь зарчмын хувьд зөв үү, буруу юу. Нэг ёсондоо Улсын Их Хурлаас нэгэнт шийдвэр гараад, Засгийн газар хэрэгжүүлээд, Улсын Их Хуралд эргэж мэдээлэх үүрэгтэй байтал дахиж үүрэг өгөөч гэж хандаж байгаа байдал нь Улсын Их Хурлаар хэлэлцэх ёстой юу, үгүй юү гэдэг асуудал яригдаж байгаа юм.

Тэгэхдээ үүнтэй холбоотойгоор эцэслэсэн шийдвэр гараагүй байна. Эцэслэсэн шийдвэрийг Улсын Их Хурлын даргын зөвлөлийн бүрэлдэхүүний

хүрээнд асуудлыг ярьж, зөвлөлийн гишүүд Улсын Их Хурлын дарга болон Улсын Их Хурлын үйл ажиллагаанд зөвлөх үүрэгтэй оролцдог учраас саналыг нь сонсож нэгтгэж шийдвэр гаргая гэсэн байдлаар асуудалд хандаад явж байна. Өнөөдөр энэ асуудлыг албан ёсоор хэлэлцсэн байгаа гэдгийг хэлье. О.Алтангэрэл сайд нэмж хариулах уу?

О.Алтангэрэл: Улсын Их Хурлын даргын хэлсэнчлэн даргын дэргэдэх зөвлөлөөр энэ асуудлыг хэлэлцсэн. Засгийн газрыг төлөөлж байр сууриа илэрхийлсэн. Үүний түрүүнд Эрдэнэт үйлдвэртэй холбоотой шийдвэр гаргасан тухай Засгийн газрын тогтоолыг Улсын Их Хурал хэлэлцэж хүчингүй болгож байсан. Мөн энэ шийдвэрийг нь Үндсэн хуулийн цэц хянан хэлэлцээд, зөв жишиг байна гэдэг асуудлыг ярьсан. Хамгийн гол зарчмын шинжтэй асуудал нь Улсын Их Хурлаас ямар ч шийдвэр гаргасан Засгийн газар биелүүлэх үүрэгтэй. Хүндэтгэж хүлээж авна. Гэхдээ Улсын Их Хурлын албан ёсны бүтцээр хэлэлцүүлж өгөөч гэдэг хүсэлтээ Улсын Их Хурлын даргын зөвлөлд тавьсан.

Өөрөөр хэлбэл Байнгын хороогоор хэлэлцээд, тогтоолын төслийг боловсруулах болсон үндэслэлийг сонсоод Улсын Их Хурал өөрийнхөө шийдвэрийг гаргаач гэсэн утгатай. Таван толгойн орд газартай холбоотой эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл бүхий 2 боть стратегийн орд газар буюу “Энержи ресурс” компанийн эзэмшиж байгаа ордыг тойроод юу болсон юм бэ гэдэг бүх баримтыг сүүлийн 1950 оноос эхэлж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энэ дээр 2 зүйл байгаа. О.Алтангэрэл сайд ялгааг нь сайн судалж олох ёстой болов уу гэж байгаа юм. Эрдэнэтийн 49 хувьтай холбоотой асуудал Засгийн газрын тогтоол гарчихсан. Нэг ёсондоо Улсын Их Хурлын эрхэд Засгийн газар халдаж өмнүүр нь тогтоол, шийдвэр гаргаж хэрэгжүүлчихсэн. Энэ асуудалтай холбохоор тогтоол мөн үү, биш үү гэхээр тогтоол биш тэмдэглэлээр үүрэг өгчихсөн гэж байгаа. Тэгээд Засгийн газар Иргэний хуулийн дагуу иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ хэлцэл хийгээд асуудал шийдчихсэн байдаг. Тэгэхээр тэр асуудлыг магадгүй хууль шүүхийн байгууллага зөв, буруу гэдгийг нь дүгнээд шүүгээгүй байхад нь Улсын Их Хурал татаж аваад, хэлэлцээд зөв, буруу гэдэг асуудлыг яриад явах нь Улсын Их Хурлын хувьд хийх ёстой ажил мөн үү, биш үү гэдэг дээр хуулийн мэргэжлийн байгууллагынхан ажиллаж байна. Түүнээс биш Улсын Их Хурал үүнийг хэлэлцэхгүй гэж татгалзаж байгаа зүйл байхгүй. Бид зарчмын хувьд ер нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагч иргэд Монголынхоо төрд итгэлтэй байх уу үгүй юү. Ер нь хууль зөрчсөнтэй холбоотой асуудал нь хаана хэн дүгнэж цэгнэж эцсийн шийдвэр гаргадаг байх юм бэ? Ер нь тэгээд Улсын Их Хурал аж ахуйн шинж чанартай ажлуудыг Засгийн газрын өмнүүр ороод хийгээд байх уу, үгүй юү гэдэг зарчмын асуудлууд яригдаад байгаа учраас цаг хугацаа алдаж байна. Түүнээс энийг хэлэлцэхгүй гэж буцааж байгаа зүйл алга. Хэлэлцье гээд оруулаад ирэхээр зөрчлүүд байгаа учраас үүнийг яаж арилгаж, хуулийн зөрчилгүй асуудлыг Улсын Их Хуралд оруулж хэлэл-цүүлэх вэ? Улсын Их Хурал гэдэг байгууллага эцсийн шийдвэр гаргадаг байгууллага. Магадгүй Улсын Их Хурал асуудалд хөнгөн гоомой хандаад, шийдвэр гаргасан тохиолдолд Улсын Их Хурлын шийдвэр цаашлаад Цэц дээр очиж шийдэгддэг болно. Нэг ёсондоо аж ахуйн шинж чанартай Засгийн газрын

үйл ажиллагааны эцсийн шийдвэр нь Улсын Их Хурал ч биш Үндсэн хуулийн цэц дээр очиж шийдэгддэг нөхцөл рүү оруулах уу, үгүй юү гэж байгаа асуудал юм. Өмнө нь 2-3 удаа Үндсэн хуулийн Цэц дээр тийм шийдвэр гарсныг та бүгд мэдэж байгаа. Бүгдээрээ шүүмжлэлтэй ханддаг. Хоёр, гурван стратегийн орд, бензин шатахууны нийлүүлэлттэй холбоотой асуудал дээр Улсын Их Хурлаар дутуу шийдвэр гарснаас болоод Үндсэн хуулийн цэц дээр очоод эцсийн шийдвэр болчихдог. Ингээд гүйцэтгэх засаглалын эрхэнд, магадгүй хуулиар, цаашлаад Үндсэн хуулийн цэцээр асуудалд ханддаг хэлбэрт шилжих үү, үгүй юү гэдэг асуудал хөндөгдөж байна. Л.Мөнхбаясгалан гишүүнээ, энэ асуудлаар эцсийн шийдвэр гараагүй байгаа. Ирэх 7 хоногт тодорхой болчихно. Ерөнхий сайд нэмэлт хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Засгийн газрын хувьд, Ерөнхий сайдын хувьд Ухаа худаг нь байна уу, Төгрөг нуур нь байна уу, эсвэл бусад орд нь байна уу энэ тийм чухал асуудал биш гэж үзэж байгаа. Ерөөсөө өнөөдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн талаар мэдээлэл хийж байгаа нь бид стратегийн орд гээд байгаа ойлголтоо цэгцэлье. Хэдэн стратегийн орд байгаа юм бэ? Энэ мэдээллээ нэг болгоё. Тэгээд стратегийн ордоос орж ирж байгаа АМНАТ-ийн хэдэн хувийг энэ 3 сангийнхаа хаана нь өгөх юм бэ? Тоглоомынхоо дүрмийг тодорхой болгочихъё. Тэгээд хэлэлцээрт оръё гэж байгаа. Тийм учраас Засгийн газрын байр суурь бол бүгдийг нь оруулж ирж ярилцах ёстой. Мэдээж ямар шийдвэр гаргах вэ гэдэг нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал. Тэгээд энэ асуудлыг нэг мөр ойлгож байж хөрөнгө оруулагчид болон компаниудтай нь .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Үндэсний баялгийн сангийн асуудлаар Ерөнхий сайдын мэдээлэл хийсэнтэй холбогдуулаад асуух, санал болгох зүйл байна. Тэрнээс өмнө Үндэсний баялгийн сан биш Ерөнхий сайдын мэдээллийн цагийн тухайд хэлмээр зүйл байгаа. Одоогийн хуулийн зохицуулалтаар цөөн хүн асуулт асуугаад, хариултаа авна гэж байгаа. Тэрний дараа иргэдийн асуултыг Улсын Их Хурлын гишүүд дамжуулж асуугаад, хариулт авна гэж байгаа. Засгийн газрын сайдууд өөрийнхөө намын хүмүүст иргэний нэр бариад асуултаа 10, 20-оор нь бичиж өгчхөөд, нөгөөдүүл нь буцаагаад хариултыг нь дуржигнатал уншаад өгчхөөд байгаа юм байна лээ. Түрүүчийн мэдээллийн цагаас харахад ийм тоглоом тоглоомооргүй байна. 118 гишүүн нэг дор цуглаж, Засгийн газар байгуулчхаад цөөнх гэж юугаа ярьдаг юм бэ? Нөгөө Засгийн газрын кабинетын зарчим нь хаана явж байна. Одоо асуулт асууж байгаа, үг хэлж байгаа гишүүд бол цөөнх биш засагт бодлогоо хэрэгжүүлж байгаа улс төрийн намын гишүүд шүү дээ. Энэ парламентад Иргэний Зориг ногоон нам, Үндэсний эвсэл хоёр албан ёсоор засагт ороогүй цөөнх байгаа. Ингэхээр энэ асуулга, мэдээллийн цагаар дамжуулж өөрсдийнхөө сонирхлоо Улсын Их Хурлын танхим дотор илэрхийлж, төрийн бодлого, засгийн бодлогод шургуулдаг ийм ажил хийж байна. 118 гишүүн үүндээ гаршиж байна гэж үзэж байна. Үүнийгээ өөрчилмөөр байна. Улсын Их Хурлын даргад байнга хэлж байгаа. Энэ тал дээрээ анхаараасай гэж хүсэж байна.

Үндэсний баялгийн сангийн тухай мэдээлэл хийсэн. Энэ хүрээнд Үндэсний баялгийн сангаа яаж өргөжүүлэх вэ, орлогыг нь яаж нэмэгдүүлэх вэ, нэмэлт эх үүсвэрийг яаж бий болгох вэ гэдэг дээр анхаарах ёстой. Нөгөө талдаа орлогыг нь нэмэгдүүлж байгаа бол буцаагаад тэрийг хэрхэн захиран зарцуулж, ямар зорилгоор ашиглаж ямар газар хадгалуулж байна. Юунд ямар зориулалтаар байршуулж байна вэ гэдэг үзэл баримтлалыг бий болгох хэрэгтэй. Мөн томоохон төслүүд, 14 МЕГА төсөл гээд ярьж байгаа. Энэ зүйлүүдэд хэдэн хувь нь орж байх ёстой юм. Тийшээ орох ёстой юм уу, орох ёсгүй юм уу?

Дээрээс нь Монголын 3 сая иргэн 2 сая 500 мянган зээлдэгч байж байгаа шүү дээ. Бүгдээрээ банк болон банк бус, ломбардны ажилчид болоод хувирчихсан. Бүтээгээд байна, бүтээгээд байна, тэд нарын хүүг төлөөд өөртөө үлдэх юмгүй болчихож байгаа. Үндэсний баялгийн сан банкнуудад болон Монголбанк дээр байршихад зээлийн хүүг бууруулах, иргэдээ чөлөөлөх чиглэлд ажиллаж болохгүй юу. Энэ чиглэл дээр анхаарах ёстой зүйл байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн үг хэллээ. Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууж, үг хэлж болно.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Ерөнхий сайдын мэдээлэл дунд ийм өгүүлбэр байна. Сангийн орлого жил бүр нэмэгдэж, 20, 30 гэхэд сангийн нийт хөрөнгө 3 их наяд төгрөгт хүрэх төсөөлөл байна гэж байна. Энэ сангийн бүрдлүүд бол манай төсвийн тэнцвэржүүлсэн орлого нэмэгдэлтэй буюу ашигтай гарч байж, түүнээс нь авах хуультай байгаа. Гэтэл өнөөдрийн байдлаар эхний улирлын байдлыг өмнөх оны эхний улирлын байдалтай харьцуулахад манай төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл хасахтай явж байгаа. 353 тэрбумын алдагдалтай явж байгаа. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 их наяд байсан. Тэгэхээр хэд дахин буурсан нь эндээс харагдаж байна.

Нөгөө гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, экспортын бараа бүтээгдэхүүн болох нүүрс маань юу болчихсон явж байгааг бид бүгд сайн мэдэж байгаа. Нүүрсний экспорт гэхэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 883 сая ам.доллараар буураад, өөрөөр хэлбэл 42 хувиар буурчихсан явж байна. Үнэ нь 129 ам.доллар, 105 ам.доллараар зарж байж ашигтай гараад, ашгаасаа энэ сангуудад төвлөрүүлнэ гэж, төлөвлөсөн үнэ нь бараг 50-иад ам.доллараар буурчихсан явж байна. Энийгээ алтаар нөхнө гэж яриад байгаа. Гэтэл алт чинь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47 сая ам.доллараар буурчихсан явж байна. Ингээд бүх зүйл хасах үзүүлэлттэй буурчихсан яваад байна.

Нийт орлогыг бид бүхэн мэдэж байгаа. 1.2 их наяд буюу 16 хувиар буурчихсан явж байна. Экспортын гол бүтээгдэхүүн нүүрс бараг 45-55 хувийг нь бүрдүүлж байгаа. Экспортын нийт орлого яаж буурснаа ярилаа. Тэгээд ирээдүй гэдэг гоё нэрийн доор баялаг гэдэг гоё нэр хоч юм шиг ийм юмыг яриад байна. Гэтэл өнөөдрийн бодит амьдрал чинь ямар байгаа юм бэ? Та энэ дээр санаа зовж байна уу? Тэр баялаг бүтээх сан гэж ярихаасаа өнөөдөр ард түмний амьдралыг та яая гэж бодож байгаа юм бэ? Гадаадын хөрөнгө оруулалт дээр ямар бодлого барьж байгаа юм бэ? Энэ баялгийн санд хуримтлуулна гээд хийж байгаа ажил

чинь нэг талаасаа зөв боловч нөгөө талаасаа гаднын хөрөнгө оруулагч нарт яаж тусах юм бэ? Гаднын хөрөнгө оруулалт орж ирэх баталгаа байгаа юм уу? Таны энэ дээр тусгасан 2030 он гэхэд 3 их наядаар арвижих баяжих боломж, гарц гаргалаа харагдаж байгаа юм уу? Та ер нь 6 жил төрд өндөр дээд албан тушаал хашлаа. Ерөнхий сайдаар ажиллаад та 5 дахь жилдээ орж байна. Та хэтэрхий вакумжаад амьдралаас хэтэрхий тасарчихсан юм биш үү? Цаана чинь иргэдийн амьдрал ямар байгааг та мэдэж байгаа юм уу? 145 мянган төгрөг тараагаад, тэгээд бүгдээс нь хөрөнгө эзэмшигч болгочихсон. Тэгээд 3 сая хүн хөрөнгө эзэмшиж байна гээд өнөөдөр статистик дээр орчихсон. .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: С.Баярцогт даргын асуултад хариулъя. Улс төржиж байгаа учраас би бас улс төржиж хариулъя. Яг бодитоор Хөгжлийн банк ямар байдалтай болчихсон байлаа. Эрдэнэтийн 49. Саяын яригдаад байгаа стратегийн ордууд ямар үед хэний гараар ороод юу болчихлоо. Энэ байдлыг цэгцлэхэд нэлээдгүй хугацаа орсон. Би энийг ярихгүй яваад байгаа. Одоо энэ стратегийн ордууд орж ирэх материалуудаас өөрсдийнхөө хийсэн зүйлийг сайн харна биз. Гэхдээ би өөртэй чинь юм ярихгүй ээ. Цаана чинь үг хэлүүлээд байгаа тэр хэдэн нөхдүүдтэй чинь би байр сууриасаа нэг их хазайхгүй ээ. Сүүлийн 20 гаруй жил бантан зуураад, Монгол Улсын өмч хувьчлалыг хэдэн ордтой нь аваад будаа болгочихсон байгаа зүйл удахгүй энэ материалаар орж ирнэ. Ийм зүйл дээр залуу хүн байж битгий хүний өмнөөс хачин юм яриад бай.

Д.Амарбаясгалан: Б.Пунсалмаа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Пунсалмаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Баялгийн сангийн тухай ярьж байна. Баялгийн сангаар уул уурхайн орлогыг бүх ард түмэнд тэгш хувь хуваарилах, ирээдүйдээ өвлүүлэх сан. Энэ санг сайн яваасай гэж бүх ард түмнээрээ хүсэж байгаа. Тиймээс ч стратегийн ач холбогдолтой 34 хувь, хувийн хэвшлүүд төрд шилжүүлэх ажил шат дараатайгаар гэрээнүүд тодорхой хэмжээнд амжилттай явж байгаа. Энэ бол ард иргэдийн хүсэл шүү гэж хэлэх гэж байгаа юм.

Хоёрдугаарт нь баялгийн санд орж ирсэн хөрөнгийг төсвийн алдагдлыг нөхөхөд ирээдүйд бүү оруулаарай. Ингэх юм бол энэ сан өсөхгүй. Мөн энэ санд орж ирсэн мөнгийг хуримтлалын сангаар дамжуулаад, ард иргэдэд шууд тараачихмааргүй байна. Энэ өөрөө инфляцыг өсгөөд байна. Тэгэхээр энэ тал дээр анхаармаар байна. Ер нь Норвегийн Санг манай баялгийн сангийн хувьд жишиг сан болгож авч үздэг. Норвегийн санг хэн удирддаг вэ гэхээр улс төрчид нь удирдахгүй байна. Норвегийн санг бол Норвегийн төв банкны дэргэд байдаг Санхүүгийн корпорац удирдаж байна. Энэ корпорац нь сангаа өсгөөд, үржүүлээд, нэмэгдүүлээд, хадгалаад ард түмэн нь энэ сангийн үйл ажиллагааг нь хянаад ажилладаг. Сангийн яам нь сангийн үйл ажиллагаанд эрх зүйн орчныг нь сайжруулж өгөөд ажилладаг. Яг үүнтэй ижилхэн манай баялгийн санг Монголбанкны дэргэд санхүүгийн том корпорац бий болгоод ажилламаар байна. Улмаар баялгийн сангийн хөрөнгийг өсгөдөг, нэмэгдүүлдэг, хадгалдаг,

ард иргэддээ хянуулдаг тогтолцоонд шилжих хэрэгтэй байна. Цаашдаа энэ дээр анхаараач. Та бүгдийн бодол санаа энэ санал дээр ямар байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Анхааръя гээд энэ цаг дээр та бүгдтэй ярих гээд оруулж ирээд байна. Тэгэхээр баялгийн сантай холбоотой ойлголтоо цэгцлэх нь чухал байгаа. Судалгаа хийгээд үзэхээр жишээлбэл, АМНАТ-ийн талаар ч ойлголт цэгцтэй биш байна. Өнөөдөр АМНАТ-ийн 65 хувь “Ирээдүйн өв сан”-д, “Тогтворжуулалтын сан”-д тодорхой хэсэг, орон нутагт 10 хувь байгааг ч судалгаа хийгээд үзэхээр парламентын түвшин ч нэг ойлголттой биш, иргэдийн хувьд ч биш, аж ахуйн нэгжүүдийн хувьд ч, хөрөнгө оруулагчдын хувьд ч бүрэн ойлголтгүй байгаад байна. Тэгээд уул уурхайн компаниудтай уулзаад асуудлуудыг ярилцаж байна. Тухайлбал, Орано-ийн үед бас нэлээдгүй уулзалтууд хийсэн. Ингээд Баялгийн сангийн хуулийн дагуу 34 хувь зайлшгүй авах ёстой гэдэг зүйл дээр бид тусгай АМНАТ-өөр орлуулах хувилбарыг гаргаад, Улсын Их Хурлаар баталсан. Ингээд 10 хувь нь тухайн аж ахуйн нэгжтэй эзэмшлийн хувь тохироод, 24 хувийг орлуулсан анхны хэлцлийг Улсын Их Хурал баталсан. Энэ бол сайн загвар болсон. Одоо олон хөрөнгө оруулагчид томоохон төслүүд дээр хамтран ажиллахаа илэрхийлж байгаа юм. Харин бид АМНАТ буюу роялти нөөцийн төлбөр гэдэг ойлголтоо үндэсний баялагтай уясан байдлаар нэгдсэн ойлголтыг өгөхгүй бол болохгүй байгаад байна. Энэ ойлголтыг бүрэн өгөхгүй бол жишээлбэл уул уурхайн төслийг орон нутаг дэмжихгүй байгаад байна. Яагаад вэ гэхээр уул уурхайг дэмжлээ гээд манай орон нутагт ямар хэрэгтэй юм. Иргэдийн хувьд ч гэсэн надад ямар хүртээмжтэй юм. Ирээдүйд хадгална, менежмент сайжруулна гэхээр тэр ирээдүйд хуримтлагдаж байгаа хуримтлал ямар байдлаар хэдэн жилийн дараа надад хүртээмжтэй байх юм бэ? Зарим гишүүдийн хэлж байгаа дэд бүтэц болон агаарын бохирдол гээд олон асуудалд зарцуулъя. Зарцуулах механизм нь хаана байгаа, яаж оновчтой болгох вэ гэдэг дээр ойлголтоо нэгтгэх ёстой болчихоод байна. Энэ бүх зүйлийг хийсний дараа стратегийн орд эзэмшигч компаниудтай хэлцэлд уриалж байгаа. Үүнийг АМНАТ-өөр орлуулах уу, эсвэл борлуулалтын орлогын тодорхой хувиар орлуулах уу? Тэгээд үүнийг эрүүл мэндийн салбарт зарцуулах уу, боловсролд зарцуулах уу, орон сууц руу зарцуулах уу? Хэдэн хувийг нь иргэдийн хадгаламж болгох юм бэ? Орон нутаг буюу ялангуяа уул уурхайг дэмжиж байгаа орон нутаг яаж тулгамдсан асуудлаа шийдэх юм бэ гэдэг механизмыг Засгийн газрын хувьд тодорхой болгох нь зүйтэй.

Тийм учраас бид дахин дахин ярих ёстой. Дахин дахин мэтгэлцэх ёстой. Энэ мэтгэлцээнээс олон нийт мөн ойлголт авах ёстой. Ингээд хөрөнгө оруулагчид, үндэсний компаниуд, орон нутаг, иргэний нийгмийн байгууллагууд, улс төрчид нэгдсэн ойлголттой болж байж ирээдүйн Оюу толгой, ирээдүйн Таван толгой, ирээдүйн уул уурхайн төслүүд хөдлөх учиртай. Тэгэхгүй бол бид нар олон зүйл ярьсаар байгаад, нийгмийн хувьд ямар ч уул уурхайн төслийг хөдөлгөх нь буруу юм байна гэсэн ойлголтыг төрүүлэх юм. Энийг ер нь тэр чигт нь ирээдүйд буюу олон жилийн дараа ашиглах нь зүйтэй юм байна гэдэг дүгнэлтэд 60-аас дээш хувь нь оччихоод байна. Энийг олон улсын хэмжээнд

шийдсэн цорын ганц гарц бол ерөөсөө Баялгийн сангийн хууль. Эсвэл татвар. Тийм учраас энэ асуудал дээр бидний хувьд байр сууриа нэгтгэх нь зүйтэй гээд өнөөдөр оруулж ирж байна. Тийм учраас өнөөдөр хэлэлцэх асуудал дээрээ төвлөрөөд, өгөгдсөн тоонууд болон мэдээллүүдээ нэгтгэх нь өнөөдрийн энэ цагийн зорилго гэж үзэж байна.

Бусад сэдвээр мэдээж бидний хувьд дахиж оруулж ирээд ярилцах боломж байгаа учраас өнөөдөр бол Баялгийн сан, тэр дундаа АМНАТ-ийг хэрхэн хуваарилах вэ? Баялгийн сангийн 3 данс хоорондоо хэрхэн хяналт тэнцэлтэйгээр засаглалын хувьд зөв зохион байгуулалттай байх вэ? Хууль батлагдаад нэг жил болчихлоо. Нэг жилийн дүгнэлт юу байх вэ? Цаашлаад ирээдүйд яаж зөв менежмент рүү явах вэ гэдэг дээр төвлөрч яривал цаг маань зөв болох болов уу гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууя.

Г.Уянгахишиг: Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотой тодорхой 3 асуулт асууя.

Нэгдүгээрт, хуримтлалын сангийн хөрөнгийг ямар өгөөж, ямар хугацаатайгаар байршуулаад 495 тэрбум төгрөгийн хөрөнгийн өгөөж нь 1 хувьтай тэнцэх буюу 4.9 тэрбум төгрөг байгаа вэ? Энэ хүрээнд Засгийн газрын 2025 оны 72 дугаар тогтоолоор баталсан хөрөнгийн удирдлагын бодлогоор Монголбанк хөрөнгийн удирдлагыг хийж байгаа. Тэгвэл тухайн бодлогын 4.2-т ямар хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд оруулж болох вэ гэдгийг тодорхой зааж өгсөн. Мөн түүнчлэн 4.1-д өгөөжийн хэмжээ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 13-т заасан өгөөжөөс доошгүй байна гэдгийг тодорхой зааж өгсөн байгаа. Тийм болохоор ямар хувь хэмжээтэй, ямар хүүтэй, ямар хугацаатай, ямар нөхцөлтэйгөөр энэ орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрт хөрөнгө оруулсан бэ гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаар асуулт нь Ирээдүйн өв сангийн хөрөнгийг гаднын санхүүгийн байгууллагад байршуулсан байна. Тэгвэл энэ нь ямар хугацаатай, ямар хувь, хэдэн хувийн өгөөжтэй, ямар нөхцөлтэй хөрөнгө оруулалтын санхүүгийн хэрэгсэлд байршуулсан бэ гэсэн 2 дугаар асуулт.

3 дугаар асуулт нь Чингис хаан баялгийн сан ХХК гээд шилэн данс дээр гарч ирж байгаа. Тэгээд шилэн дансанд оруулаад харахаар Үндэсний баялгийн сангийн хөрөнгийг зохион байгуулахад зориулагдсан хуулийн этгээд гэж гарч ирээд байгаа. Гэхдээ тэр дотор ямар ч мэдээлэл одоогоор ороогүй байна. Тэгэхээр Чингис хаан баялгийн сан гэдэг нь ХХК-ий хэлбэртэйгээр байгуулагдчихаад байна уу? Тэгээд энийгээ яаж зохицуулах гэж байгаа вэ? Статус нь ямар юм бэ гэдэг талаар мэдээлэл авмаар байна. Яг ийм 3 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Н.Учрал сайд.

Н.Учрал: Үндэсний баялгийн сангийн хууль батлагдсаны дараа хуримтлалын сан дахь хуримтлалыг нэмэгдүүлэх ажлууд хийгдсэн. Уул уурхайн

компаниудын 34 хувийн ногдол ашиг бол хуримтлалын санд төвлөрч байгаа гэсэн үг. Өнгөрсөн хугацаанд 490 орчим тэрбум төгрөг уул уурхайн төрийн өмчийн 7 компанийн ногдол ашгийн хуримтлал бий болсон. Үүнийг эрүүл мэнд, орон сууц, боловсролд зарцуулах буюу одоо үедээ хүртээх хууль, эрх зүйн орчинтой болсон. Үүний дараа Засгийн газраас тогтоол гарсан. Тогтоол бол хуримтлалын сангийн мөнгийг хэрхэн иргэдэд хүртээх талаар журам гаргаад, хуримтлалын санг одоогийн хуулиар бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр хариуцдаг. Тэгэхээр боловсрол, эрүүл мэнд, орон сууцны юунд зарцуулах вэ гэдэг дээр иргэд хүсэлтээ гаргаад, хүсэлт гаргасны дараа түүн дээр журмын дагуу Монголбанкнаас тухайн хуримтлагдсан хуримтлалыг иргэдэд хүртээх ажил хийгдэнэ гэсэн үг.

Засгийн газар дээр яриад Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг концептоор нь дахин эргэж харах шаардлагатай байна гэж үзэж байгаа. Энэ ч утгаараа Ирээдүй өв сан гэдэг нь “saving” буюу хадгаламж юм. Нэрийн данстай иргэд өөрөө хуримтлалын мөнгөө ирээдүйд хэрэглэх бололцоог 2030 он хүртэл түгжчихсэн байгаа учраас цаашдаа үүнийг зарцуулах боломжийг нь хуулиар нээх, цаашлаад одоогийн хуулиар Ирээдүйн өв сангийн хадгалагдаж байгаа буюу АМНАТ-ийн 65 хувиар хадгалагдаж байгаа мөнгийг бол 2030 оноос хойш санхүүгийн хэрэгсэлд оруулах бололцоог хуулиар нээчихсэн байдаг.

Одоогийн хуримтлалын санг Монголбанкны бодлогын хүүгээр нэмэгдүүлээд явдаг. Хөгжлийн сан дахиад тусдаа сан байгаад байна. Гэтэл Хөгжлийн сан бол бодит утгаараа хөрөнгө оруулалтын сан шиг ажиллаж огт чадахгүй байгаа. Тэгэхээр таны хэлж байгаа саналуудыг цаашдаа Үндэсний баялгийн сангийн хууль дээр бүтэн концепцын өөрчлөлт хийхгүй бол болохгүй нь. Хуримтлалын сангийн үр өгөөжийг нэмэгдүүлэе гэвэл зайлшгүй төрийн эзэмшлийн 34 хувиас гадна стратегийн ордуудад тооцогдож байгаа тэр ордуудын 34 хувийг хэрэв Улсын Их Хурлаас АМНАТ-өө нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн хуваахаар нэмэгдүүлэх эсэхийг шийдсэний дараа тэр нэмэгдүүлсэн хэсэг нь хуримтлалын сан руу шууд очдог байх нөхцөлийг зайлшгүй бүрдүүлэх шаардлагатай байна.

Тийм учраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг Засгийн газраас оруулж ирээд, өнөөдрийн иргэдэд хэрхэн зарцуулах бололцоог нь нээх вэ гэдэг ийм том алхам хийх ёстой. Ирээдүйдээ зарцуулахыг нь хадгаламж хэлбэрээр буюу цаашлаад Норвеги улс шиг нөгөө тэтгэвэртээ гарахдаа давхар тэтгэврийн тогтолцоотой адилхан Баялгийн сангаас тэтгэврээ авдаг тогтолцоонд шилжүүлэх үе шаттай алхмуудыг баялгийн сан дээр хийж явж байж энэ байгалийн баялагтаа ард түмэн үнэхээр эзэн болж байгаа юм байна гэдэг нь мэдрэгдэнэ. Тэр ч утгаараа эхний алхмууд хийгдэж байгаа. Энэ бол үе шаттай хийгдэх алхмууд.

Тэгээд түрүүн олон асуулт асуугдаад байсан дээр Сангийн яам тодорхой хариултуудыг өгөх байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Л.Энх-Амгалан сайд нэмж хариулъя.

Л.Энх-Амгалан: Г.Уянгахишиг гишүүн тоо асуугаад байх шиг байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар хуримтлалын сангийн хөрөнгийг Төв банкны бодлогын хүүгээс багагүйгээр арвижуулахаар хуульчилчихсан. Энэ зохицуулалтын дагуу Монголбанктай 2024 оны 5 дугаар сарын 09-ний өдөр гэрээ байгуулсан. Энэ гэрээ нь 5 дугаар сарын 09-нд дуусна. Энэ гэрээгээр бодлогын хүүгээр тооцож өгөөж өгнө гэж тохирсон учраас бол 30 тэрбум төгрөгийн өгөөж авах юм. 483 тэрбумаас 30 тэрбум төгрөг. Үүний 4.9 тэрбум төгрөг өнөөдөр Монголбанкнаас 2024 оны эцсээр манай дансанд орж ирсэн. Одоо 5 дугаар сарын 09-нд жилийн гэрээ дуусахад цаана нь байгаа 35 тэрбум төгрөгийн өгөөжийг авч хуримтлалын дансанд байршуулж иргэдийнхээ дансанд энэ өгөөжийг хуваарилах ажил байгаа.

Д.Амарбаясгалан: Наранцогт захирал хариулт өгье. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

С.Наранцогт: Г.Уянгахишиг гишүүний асуултад тодруулж хариулъя. Хуримтлалын сангийн хөрөнгө бол иргэдийн хадгаламж Монголбанкны бодлогын хүүгээр өсөж байгаа. Энэ хөрөнгийн менежментийг Монголбанк хариуцаж байгаа. Тэр ипотекийн зээлд оруулсан асуудлын хувьд тэр мөнгийг аваад үрсэн асуудал байхгүй. Хөрөнгийн удирдлагын ажил хийгдэж байгаа талаар Л.Энх-Амгалан сайд тодорхой хэлчихлээ. Бодлогын хүүгээр ямар ч тохиолдолд өсөөд явна. Чингис хаан компанийн тухай асуусан. Энэ бол Улсын Их Хурал Баялгийн сангийн тухай хуулийг дагалдуулж гарсан тогтоол дээр баялгийн санг 2030 он хүртэл хуримтлуулаад, үүнээс цааш олон улсын ассет менежментийн компаниар удирдуулахаар тусгасан. Тэгэхэд бид тодорхой мөнгөтэй болно. Дээр нь нэмээд боловсон хүчнээ бэлдэнэ. Хууль, эрх зүйгээ сайжруулна. Энэ ажлыг хийх ../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. 8 дугаар микрофон.

С.Наранцогт: Таны асуугаад байгаа хүүгийн тооцоо хийх, бүх ажлыг хийх бэлтгэл ажлыг хангаж байгаа компани болохоос биш хөрөнгийг удирдаж байгаа зүйл байхгүй. 2030 оноос хойш энэ компани өөрөө Ассет менежмент компани болох зорилго тавьж ажиллаж байгаа гэсэн үг. Үүн дээр компаниудаас зөвхөн оролцож байгаа нь Эрдэнэс Монгол бөгөөд орлого төвлөрүүлэгч, Эрдэнэс Монгол энэ орлогыг төвлөрүүлж өгч байгаа. Ирээдүйн өв сангийн хөрөнгийн менежментийг Монголбанк хийж байгаа. А зэрэглэлтэй олон улсын санхүүгийн хөрөнгөд оруулж байгаа гэсэн мэдээлэлтэй байна. Нарийн тоо авъя гэвэл энд Монголбанкны төлөөлөл ирчихсэн сууж байна.

Д.Амарбаясгалан: Монголбанкнаас хэн байна. 3 дугаар индэр дээрээс нэмэлт хариулт өгье.

П.Мөнхбаяр: Гишүүний асуултад нэмж тодруулъя. Ирээдүй өв сангийн хөрөнгийг Монголбанк болон Сангийн яамны хооронд 2025 оны 3 дугаар сарын 7-ны өдөр харилцан хадгаламж байршуулах гэрээ байгуулаад, энэ хүрээнд хөрөнгийн удирдлагыг хийж гүйцэтгэж байна. Хөрөнгийн удирдлагыг нэгдүгээрт эрсдэл, хоёрдугаарт хөрвөх чадвар, гуравдугаарт өгөөж гэсэн дарааллаар

валютын нөөцийг удирддаг бөгөөд энэ хүрээнд удирдлагыг нь хэрэгжүүлээд явж байна. Одоогийн байдлаар хамгийн хөрвөх чадвартай 3 Төв банкны хадгаламж дээр байршуулсан. Өгөөжийн хувьд 4.32 хувийн өгөөжтэй. Энэ дээр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Ерөнхий сайд маань сая хүнтэй муухай харьцлаа. Бид бүхэн цөөнх, сөрөг хүчний байр суурийг илэрхийлж, тэр тусмаа эмэгтэй хүн үг хэлж байна. Энэ улс оронд болж байгаа ч юм байгаа, болохгүй ч юм байгаа. Монголын Үндэсний статистикийн хорооноос 2024 он, 2025 оны 1 хүний амьдрах зардлыг гаргасан байна. Статистикийн мэдээгээр өнөөдөр 24 хувиар өсчихсөн байна. Амьдрал дордож байна. Хүмүүсийн амьжиргаа муу байна. Үүнийг хэлсэн. Энийг хэлүүлэх ёстой. Өнөөдөр Монгол Улсыг удирдаж байгаа хүн энэ зэргийн үгийг сонсож байх ёстой. Тэгэхэд өнөөдөр Улсын Их Хурлын гишүүн үгээ хэлж байхад Монгол Улсын Ерөнхий сайдад ийм байдлаар эмэгтэй хүнийг хэлнэ гэдэг бол хэрдхийлгэм эвгүй байлаа. Энэ дээр Монгол Улсын Ерөнхий сайд цаашид анхаараарай.

Надад 2, 3 асуулт байсан юм. Тэрийгээ яаралтай асуухгүй бол минут маань хүрэхгүй болж байх шиг байна. 2007 онд Улсын Их Хурлын тогтоолоор стратегийн ордуудыг баталсан. Эхнийх 16, дараа нь 39 орд. Үүнээс хойш стратегийн ордуудын 34-50 хувийг Монгол Улс ашиг хувь байдлаар авна гэсэн ажил хэрэгжихгүй яваад байсан. Тэгээд Ардчилсан намын бүлгийн 5, 6 гишүүн аймаг, орон нутгаараа тойроод, энэ хуулийг хэрэгжүүлэх, ашиг орлогоос ард иргэдийнхээ амьдралыг сайжруулах, тулгамдаж байгаа олон асуудлаа шийдвэрлэх дээр санал санаачилга гаргаад явсан. Энэ Үндэсний баялгийн санд төвлөрүүлэхийг бид бүхэн дэмжиж, ард иргэдээсээ санал авсан.

Үндсэндээ бол Монгол Улсын Засгийн газрын хийж байгаа ажил буюу Улсын Их Хурал бүхий хүмүүсийн ажил бол энэ зүгт байгаа гэж бодож байгаа. Гэсэн хэдий ч төрийн сайд хүн нь яахаараа та нар явж байдаг юм гэсэн байдалтай бүр нэг хүнийг онцлоод, их хэмжээний худал гүтгэлэг, янз янзын зүйлүүдийг бол ярьсан. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр Засгийн газар үүний төлөө байгаа юм уу? Энэ ажлыг хийж хэрэгжүүлэхийн төлөө байгаа юм уу? 1 дэх асуулт.

Хоёрдугаарт, стратегийн ордуудыг цааш нь нэмэх асуудлыг ярьж байна. Ард иргэд. Энэ 39, 16-д ороогүй зөндөө ордууд байна. Үүн дээр ямар ажиллагаанууд хийж байгаа вэ?

Дараагийн асуудал нь Оюу толгойн борлуулалтын орлого Монголбанкаар орж ирэхгүй байна. Энэ Монголбанкаар оруулж ирэх ёстой. Өнөөдрийн валютын өсөлт Монгол мөнгөний ханшийн уналт бол их хурдацтай явж байна. Энэ дээр Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хурлын ямар бодлого шийдвэр байна вэ гэдгийг олон хүн бид нараас асуусан. Энэ дээр хариулт авъя гэж бодож байна. Мөн дээрээс нь бид бүхэн Үндэсний баялгийн санг хамгийн сайн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Баялгийн сан бүрдэх процесс Оюу толгой, Эрдэнэт гээд нэлээдгүй юм болсон. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Оюу толгойн 2.3 тэрбум ам.доллар тэглэгдэхгүй болохоор 34 хувьтай холбоотой асуудлыг баялгийн сангийн 1 бүрэлдэхүүн хэсэг гэж хуульчлах боломжгүй болчихоод байсан юм. Ингээд энэ бас нэлээдгүй асуудал болсон. Эрдэнэттэй холбоотой асуудал нэлээдгүй асуудал болсон. 49-тэй холбоотой асуудал маргаантай байхаар Эрдэнэтийн 34 хувь хуримтлалын санд орох боломжгүй болчихоод байсан. Дээрээс нь Хөтөл зэрэг олон асуудлууд гарсан. Тэгээд энэ бүх асуудлуудыг шийдэж байж өнгөрсөн жил хууль батлагдсан. Энийг бол Д.Жаргалсайхан гишүүн сайн мэдэж байгаа байх. Үүнтэй холбоотой олон асуудал дээр нэлээдгүй олон төвөгтэй зүйл өнөөдөр яригдаад, одоо яах вэ гэхээр стратегийн орд эзэмшиж байгаа компаниудтай хэлцэл хийх зайлшгүй шаардлага үүсэж байгаа. Өнөөдрийн энэ ярьж байгаа олон ордууд, өнөөдрийн уур амьсгалын цаана байгаа, наана цаана олон ил далд тоглолтуудаас болж байгаа юм байгаа. Энийг бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Үүний ард бид нар гарах учиртай. Ингэхгүйгээр цаашдаа томоохон уул уурхайн төслүүдийг хөдөлгөх боломжгүй. Нийгэм хүлээн зөвшөөрөхгүй. Тийм учраас өнөөдөр үнэнээ яриад, ил тод ярилцаад, парламентаар оруулж ирж асуудлуудаа яриад, тэгээд шинэ төслүүдийг өмнөх алдаагаа давтахгүйгээр гаргах ийм зүйл рүү явах нь зүйтэй. Эхний асуултад би танд ингэж хариулъя.

2 дахь асуултын хувьд би тухайн гишүүн рүү хандаж хэлж байгаа юм биш. Урьд нь хэд хэдэн удаа давтагдаад, би өөртэй нь уулзаж ярьж байсан. Зарчмын байр суурь нь өөр байгаа зарим улс төрчид өнөөдрийн Үндэсний баялгийн санг бүрдүүлэхтэй холбоотой асуудал дээр удаа дараалан ил далд саад хийж байгаад би бухимдаж тэгж хэлж байгаа юм. Энэ байр суурь дээрээ би байна. Тэр хүмүүсийн хувьд хэлэхэд ямар нэгэн байдлаар залуучуудыг өмнөө турхирах биш, асуудал байвал ил тод гарч ирээд, мэтгэлцээнээ шууд хийх ёстой. Стратегийн ордууд хэн эзэмшиж байгааг бид нар мэдэж байгаа. Үүний цаана ямар ямар асуудлууд байгааг бас мэдэж байгаа. Тийм учраас эрхэм гишүүд та бүхэн ийм зүйлд бас битгий автаарай. Одоо удахгүй хавар, намрын чуулганы хамгийн том сэдэв бараг энэ болох байх. Олон янзын зүйлүүд гарах байх. Энэ том нөхцөлүүдтэй адилхан.

Тийм учраас нэгэнт цагаа өнгөрөөчихсөн байгаа улс төрчид өөрсдийнхөө хэлж чадахгүй байгаа асуудлыг эрх ашиг нь зөрчигдөөд ирэхээр энд тэндээс энгийн залуучуудаар дамжуулж, эсвэл хэвлэл мэдээллээр дамжуулах байдлаар бохир технологио энэ цаг үеийн улс төрд хэрэглэх гээд хэрэггүй гэж би хэлж байна. Энэ дээр би дахиад ч ийм байр сууриуд бас илэрхийлнэ.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-т заасны дагуу намын бүлэг тус бүрээс 1 гишүүн төлөөлж, Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуултуудыг

асууна. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Батбаярын Жаргалан асуулт асууна. Гишүүнд асуулт асуух зөвшөөрөл 20 минутын хугацаатай олгогдоно. Энэ хугацаанд асуулт, хариулт явагдана.

Б.Жаргалан: Юуны өмнө асуултуудыг асуухаас өмнө Улсын Их Хурал бол чөлөөт мэтгэлцээний талбар байх ёстой гэдгийг дахин хэлье. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 112.2-т заасан Ерөнхий сайдын хийх мэдээллийг нэгдсэн хуралдаанаар сонсохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдэд бичгээр ирүүлнэ гэсэн заалт бас зөрчигдчих шиг боллоо. Яагаад гэхээр сая Ерөнхий сайд мэдээлэл хийхдээ бидэнд тарааснаас өөр мэдээлэл уншихсан. Тухайлбал Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулна гэх мэтчилэн зүйлс нь энэ тараасан мэдээлэл дээр байгаагүй. Тэгэхээр цаашид Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээ баримтлаад, зарчмын шинж чанартай том өөрчлөлтүүдийг хөнгөн хуумгай ярьж болохгүй байх. Тэгээд 7, 7 хоногоор бодлогоо өөрчлөөд явах нь зөв үү үгүй юү гэсэн ийм зүйл байна.

Иргэдээс Ерөнхий сайдын илтгэлтэй холбоотой асуултууд ирснийг багцалж асуухаар бэлтгэсэн байгаа. Тэгээд юуны өмнө бага зэрэг түүх ярья. Монголын төр бол ой санамжтай байх ёстой. Ерөнхий сайдын мэдээлэл гэж тарааж өгсөн материалд 2024 оны 4 дүгээр сард Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсанаар Монголчууд бид байгалийн баялгаасаа тэгш шударга хүртэж эхэлсэн гэж удаа дараа дурдагдсан байгаа. Харин сая та яриандаа үүнийгээ засварласан байна. Бид ямагт өмнөх түүхээ санаж, алдаа онооноосоо суралцаж байх ёстой. Байгалийн баялгийн хуваарилалт хүртээмжийн асуудал өнгөрсөн 20 гаруй жилийн Монголын улс төрийн гол сэдэв байлаа. Баялгийн сан байгуулах санал санаачилгыг Ардчилсан намын үе үеийн гишүүд манлайлж ажилласан бөгөөд хамгийн анхны баялгийн сан 2006 онд Монгол Улсыг хөгжүүлэх сан нэртэйгээр байгуулагдаж байлаа. Уг санд хуримтлагдсан хөрөнгө хүүхдийн мөнгө хэлбэрээр Монголын айл өрх бүрд хүрч байсан төдийгүй дэд бүтэц зэрэг улсын хөгжилд нэн шаардлагатай хөрөнгө оруулалтад зарцуулсан байдаг. Улмаар Хүний хөгжил сан байгуулсан. Мөн Монгол Улсын иргэн бүрд Хүний хөгжил сан гэсэн нэртэй дэвтэр байсныг хүмүүс санаж байгаа байх. Цаашлаад 2016 онд Ирээдүй өв сангийн тухай хууль батлагдаад явж байна. Үндэсний баялгийн сангийн хууль бол жилийн өмнө буюу 2024 оны 4 дүгээр сард батлагдсан. Тэгээд энэ хуулийг батлахдаа, мөн сая хуулийн өөрчлөлт гэж дурдахдаа өмнөх сангуудаасаа та ямар сургамж авсан бэ гэдэг эхний асуулт байна. Тэгээд олон асуултууд байгаа учраас товч хариулахыг хүсье.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Өмнөх сангууд дээр сургамж авах ёстой зүйл өнөөдрийн бидний яригдаж байгаа удирдлага зохион байгуулалтын асуудал. Тэгэхээр энэ дээр дүгнэлт хийгээд, нэгдсэн сангаа яаж зөв удирдах вэ гэдэг асуудал.

Би дахиад хэлэхэд АМНАТ-ийг юу гэж нэрлэх вэ? Үндэсний баялгийн сангийн төлбөр гэх үү? Энгийг нийгэм нэг мөр ойлгох ёстой. Тэгж байж уул уурхайн төслүүдийг дэмжинэ.

Хоёрдугаарт өмнөх хугацаанд уул уурхайн талаар ярьж байгаагаар Стратегийн орд гэсэн ойлголтоо цэгцлэх ёстой. Энэ дээр мэдээллийн зөрүү их тул олон маргааны сэдэв бол үүнтэй холбоотой. Энэ асуудлаа шийдээгүй учраас баялгийн сангаа бодитой бүрдүүлэхэд эрх зүйн орчин байсан мөртөө улс төрийн зоримог шийдлүүд дээрээ парламент бүтэн нэг талдаа бас гарч чадаагүй зүйл байгаа.

Б.Жаргалан: 2016-2024 онд Монгол Улс нийт 72.4 тэрбум ам.долларын эрдэс бүтээгдэхүүн экспортолжээ. Нүүрс, зэс, алт, төмрийн хүдэр, газрын тос гэх мэт байгалийн баялгаа экспортолсноос нийтдээ 72.4 тэрбум ам.доллар олсон байна. Өнөөдрийн ханшаар 260.6 их наяд төгрөг. Бид аливаа тоон мэдээлэлд баримжаатай хандах ёстой. Гадаад зах зээл өсөлттэй байх үед борлуулалт нэмэгдсэн нь сайн хэрэг. Нөгөө талдаа төсөв энэ үед ихээр тэлсэн. Төр томорсон. Энэ хугацаанд ирээдүй өв санд дор хаяж 3-3.5 тэрбум ам.доллар хуримтлагдсан байх ёстой атал өнөөдөр Ирээдүйн өв санд 1.2 тэрбум ам.доллар байгаа гэж тайлагнаж байна. Ирээдүй өв санд хуримтлагдсан байх ёстой хөрөнгө хаачсан бэ? Түүнчлэн хуульд заасанчлан ирээдүйн өв сангийн хөрөнгө тогтмол орлого олж байх ёстой. Сангийн хөрөнгийг зэрэглэл өндөр, эрсдэл багатай бонд, хувьцаа зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тухай бүр байршуулах ёстой атал яагаад хөрөнгө оруулалт хийхгүй, Төв банкны дансанд байршуулсан гэж тайлагнаж байна. Уг сангийн хөрөнгө гадаад валютын албан нөөцөд тооцогдож байгаа юу гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Ирээдүй өв санд валютын нөөцөд тооцогдож байгаа. Би дахиад хэлье. АМНАТ-ийн 65 хувь төвлөрч байгаа учраас энэ орлого бүрдэж байгаа. Харин Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар хөгжлийн асуудал болон дахиад хэлэхэд хуримтлалтай холбоотой асуудлыг хэрхэн зөв зохистой хуваарилалтыг хийх вэ гэдэг өнөөдрийн тулгамдсан асуудал болчихоод байна. Судалгаа хийгээд үзэхээр уул уурхайн өгөөжийг зөвхөн 34 хувийн ногдол ашиг гэж ойлгоод байна. Ногдол ашиг байхгүй болохоор уул уурхайн төсөл бүхэлдээ үр өгөөжгүй байна гэж иргэд ойлгоод байгаа юм.

Гэтэл АМНАТ-ийн 65 хувь төсөв бүрдүүлж байгаа, төсвийг тэлж байгаа гэдгийг тэр бүр ойлгохгүй байгаа. Үүнийг Сангийн яам орлогоо бүрдүүлж байгаа гэж ойлгож байгаа. Дээрээс нь орон нутаг өөрийнхөө дэд бүтцийн хөгжлийн асуудалд хэрэгжиж байгаа уул уурхайн төслүүдээс яаж санхүүжиж байгаа вэ гэдэг АМНАТ-ийн 10 хувь бас тодорхой биш байгаа. Үүнийг орон нутгийн удирдлагууд ажлаа сайн хийж байна гэж ойлгоод байгаа юм. Үүнээс болоод компанийн нэр дээр байгаа орлого, зарлагын хяналт тэнцэл, тайлан Үндэсний баялгийн санд иргэдийн хувьд нээлттэй харагдахгүй байгаа. Тийм учраас ил тод байдлыг бий болгочихвол томоохон компаниуд болон хөрөнгө оруулагчидтай бидний хувьд хэлцэлд ороод, ирээдүйн төслүүд нийгмийн дэмжлэгтэй, иргэний нийгмийн байгууллагууд ч гэсэн дэмждэг байх асуудлууд үүснэ. Энэ асуудлаар толгой эргүүлээд байгаа хэсэг бүлэг хүмүүс байгаа. Үүнийг бид нар нэвтэлж гаргах учиртай. Ингэхгүйгээр цаашдаа уул уурхайн төслүүд ч явахад Монголд

туйлын хүнд. Орон нутагт ч гэсэн том төслүүд хэрэгжихэд туйлын төвөгтэй байдалд орно.

Тийм учраас үүнийг хийх нь өнөөдрийн мэтгэлцээн, таны ярьж байгаа асуултад ялангуяа Ирээдүйн өв сантай холбоотой асуудлыг яаж менежмент хийх вэ гэдэг бол туйлын чухал асуудал болчихоод байгаа юм.

Б.Жаргалан: Тэгэхээр иргэдийн дэмжлэг байж байж уул уурхайн төслүүд хөдөлнө. Явна. Цаашдаа их мөнгө хуримтлуулна гэж та хэлж байна. Гэхдээ яагаад иргэд эргэлзээд байгаа вэ гэхээр түрүүний миний хэлдэг өнгөрсөн 8, 9 жилийн хугацаанд бид улс орноороо 72.4 тэрбум ам.долларынхоо уул уурхайн байгалийн баялгийг гадагшаа гаргачихсан байна. Тэгээд үүнийхээ эсрэг бидэнд үзүүлж харуулах зүйл байхгүй байгаад байна. Иргэдийн амьдрал, амьжиргаа бодитоор сайжрахгүй байгаад байна. Нөгөө дэд бүтэц, нийгмийн асуудлууд шийдэгдэхгүй байгаад байна гэсэн шүүмжлэл байгаад байгаа учраас нийгмийн дэмжлэг сул байгаад байна. Тэгэхээр цаашид энэ асуудал дээр уул уурхайгаас орж ирж байгаа мөнгийг яаж бодит амьжиргаанд бодит эдийн засаг руу чиглүүлэх вэ гэдэг асуудал дээр анхаарах ёстой гэж харж байна. Тэгээд үүн дээр ногдол ашгийн асуудал, төрийн өмчит компаниудын үр өгөөжийн тухай асуудал яригдана. Манай төрийн өмчит компаниуд дийлэнх нь орлого олж байгаа. Компаниудын дийлэнх нь уул уурхайн чиглэлийн компаниуд байгаа. Тэгээд төрийн өмчит компаниуд дээр жишээлбэл 58 мянган ажилтан байгаа гэж байна. Энэ асуудал бас асуудал болоод байгаа. Жишээлбэл иргэдэд очих ёстой ногдол ашгийг наана нь компанийн зардлаар зарцуулалт хийгээд яваад байна гэсэн асуудал ярьж байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор 2 дугаар сард Эрдэнэс Монгол нэгдлийн доор Чингис хаан Үндэсний баялгийн сан гэдэг төрийн өмчит компани байгуулсан байна. Тэгээд Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн болон үйл ажиллагааны удирдлагыг төв банк болон Засгийн газрын холбогдох яаманд хэрэгжүүлэхээр хуульд заасан байдаг. Цаашид улс төрийн нөлөөгүй олон улсын менежмент ажиллуулах тухай их ярьсан. Гэтэл энэ компани байгуулаад Баяраагийн Тэмүүлэн гэх захирал сая томилчихсон байж байна. Энэ компани жишээлбэл хэдэн орон тоотой, ямар төсөвтэй вэ? Санхүүжилт нь хаанаас гарах вэ?

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар 2030 он хүртэл Ирээдүйн өв санг цоожилсон байгаа. Тэгээд түүнээс хойш санхүүгийн хэрэгсэлд ялангуяа эрсдэлгүй санхүүгийн хэрэгслүүд Засгийн газрын бонд, үнэт цаас авахад ассет менежмент хийх, хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын сангийн хуулиар хөрөнгө оруулалтын менежментийн компани удирддаг. Тэгээд тэр утгаараа явах ёстой. Цаашдаа одоо байгаа сангуудынхаа менежментийг зөв зохион байгуулахын тулд бэлтгэл ажлыг хангуулах зайлшгүй шаардлага байгаа. Ер нь нийгмийн шүүмж ч байдаг. Иргэдийн шүүмж ч байдаг. Яагаад өнөөдөр энэ хөрөнгийн удирдлагыг шинэ түвшинд гаргахгүй байгаа юм бэ? Яагаад байгаа мөнгийг байгаагаар нь байлгаад байдаг юм бэ? Үүнийг үржүүлдэг, хөрөнгийг нь үржүүлэх үйл ажиллагааг яагаад хийхгүй байгаа юм бэ гэдэг дээр бэлтгэл

ажлыг хангуулахын тулд Чингис хаан үндэсний баялгийн сангийн менежментийн компани. Нэг ёсондоо энэ компани бол зүгээр төслийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа. Энэ чинь 12-13 хүний орон тоотой. Тэгээд энэ залуучууд мэргэжлийн санхүүч нар, хуульчид, ерөнхийдөө бэлтгэл ажлыг хангуулах чиглэлээр төслийн үйл ажиллагааг явуулж байна гэсэн үг. Тэгэхээр энэ бол ямар нэгэн мөнгө санхүү удирдаад байгаа хууль, эрх зүйн боломж угаасаа байхгүй. Тийм учраас Чингис хаан баялгийн санг цаашдаа хэрхэн зөв удирдах вэ гэдэг чиглэлийн бэлтгэл ажлыг хангуулж байгаа, нийгэм олон нийтэд санхүүгийн зах зээлийн талаар, хувьцааны талаарх ойлголтуудыг өгөх ажлыг хийж байна гэсэн үг. Өнөөдөр төрийн албан хаагч нарыгаа уриад, баялгийн сангийн менежментийг нь аваад яваач, ажиллаач гээд тухайлан цаг гаргаад явах тийм бололцоо байхгүй. Эрдэнэс Монгол нэгдэл дэргэдээ төслийн компани дээрээ олон улсад зөвшөөрөгдсөн, хуульч, санхүүч, олон улсын банк, санхүүгийн байгууллагад ажиллаж байсан мэргэжлийн чадвартай залуучуудыг уриад, бэлтгэл ажлыг нь хангуулж байгаа. Тэгэхээр угаасаа хуулиараа ч Ирээдүй өв сан менежментийг авч явахад мэргэжлийн хөрөнгө оруулалт, менежментийн компанийг ажиллуулна. Тэгэхээр хөрөнгө оруулалт, менежментийн компанийг урьж ажиллуулахад баялгийн сангийн менежментийг хэрэгжүүлж байгаа компани бэлтгэл ажлыг хангуулж байна гэж ойлгож болно. Тэрнээс биш энэ компани бол ямар нэгэн хөрөнгө санхүү удирдах чадамжтай хууль, эрх зүйн боломж ч угаасаа байхгүй. Тэгэхээр энэ бол зүгээр ийм төслийн хэлбэртэйгээр бэлтгэл ажлыг хангуулж байна гэж ойлгож болно.

Б.Жаргалан: Тэгэхээр Улсын Их Хурал дээр төрийн өмчит компаниудын тоог цөөлье. Үр өгөөжийг нь нэмэгдүүлье гэсэн зүйлийг байнга ярьж байгаа. Тэгэхээр нэг талаар яриад байгаа боловч нөгөө талдаа Засгийн газраас ийм сүртэй нэртэй компаниуд байгуулаад, тэгээд тэрний мэдээлэл нь ил тод биш, сая мэдэж байна. Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК гээд ийм сүртэй нэртэй компани байгуулчихсан гэдгийг. Ингээд байхаар итгэлцэл төрөхгүй байгаад байна. Иргэдийн дэмжлэг бий болохгүй байгаад байна гэдэг асуудал бас байна. Уг нь бол хэрэв нэгэнтээ гадаадын ч гэдэг юм уу, олон улсын менежментийн баг сонгох гэж байгаа бол заавал шат дамжлага байхгүй. Тэр иргэдэд хувьцааны талаар мэдээлэл олгох боломж бололцоонууд зөндөө байгаа. Санхүүгийн зохицуулах хороо ч байна, Хөрөнгийн бирж нь ч байна. Тэгээд заавал давхардсан бүтцүүд хийгээд байх тусам энэ итгэлцэл, дэмжлэг суларна. Тэгээд хуримтлалын сангийн 2024 он, 2025 оны орлогыг бүхэлд нь ипотекийн зээлийн эх үүсвэрт зарцуулж байгаа гэж тайлагнасан байна. Энэ дээр бол иргэдээс их асуулт ирсэн байна. 2024 онд хуримтлалын санд төвлөрсөн 480 тэрбум төгрөгийг нийтдээ 4,184 иргэний ипотекийн зээлд зарцуулсан гэжээ. Тэгэхээр хуримтлалын нэрийн дансанд байршсан мөнгөө иргэн бүр өөрийн орон сууц, боловсрол, эрүүл мэнддээ зарцуулах эрхтэй байна гэсэн ойлголт, хүлээлттэй яваад байгаа. Гэвч өнгөрсөн жил сангийн мөнгийг нийт иргэдэд бус зөвхөн 4000 хүний ипотекийн асуудлыг шийдвэрлэхэд зориулжээ. Энэ ипотека руу зарцуулах шийдвэр ямар үндэслэлээр хаанаас гарсан бэ? Тэгээд яагаад ер нь төсвийн шинж чанартай зарцуулалтад зарцуулаад байна вэ? Хуримтлалын сангийн хөрөнгө өгөөж олох ёстой. Бодлогын хүүгээс багагүй хувиар өсөж байх ёстой гэж хуульд заасан байгаа. Тэгээд түрүүн Г.Уянгахишиг гишүүний асуугаад байдаг 2024 онд хүүгийн орлого 4.9 тэрбум төгрөг олсон. Тэгэхээр 480 тэрбум төгрөгийн өгөөж 4 тэрбум

төгрөг гэхээр бас чамлалттай байна. Цаашид хуримтлалын санд хуримтлагдсан гэх иргэн бүрийн нэрийн дансанд байгаа гэх 138,993.0 төгрөг ойрын хугацаанд хэд хүртэл нэмэгдэх боломжтой вэ гэж иргэн Дөлгөөнзаяа асуусныг уламжилж байна.

Д.Амарбаясгалан: Л.Энх-Амгалан сайд хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Баялгийн сангийн тухай хуулиараа 3 сан байгуулсан. Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөрөнгө оруулалтын сан. Тэгээд хуримтлалын сан дээр иргэд дээрээ данс нээгээд, уул уурхайн компаниудын 34 хувиас хуваарилж байгаа дивидент³ ногдол ашгийг цуглуулж, иргэдийнхээ дансанд хуваарилалт хийж байгаа. Өнөөдөр иргэд бүх дансныхаа үлдэгдлийг харах боломжтой байгаа. Тэгэхээр хуримтлалын сан дээр хуримтлагдаж байгаа мөнгө өөрөө 2030 он хүртэл тодорхой хуримтлагдах ёстой юм. Тодорхой цаг хугацаа бас энд хуримтлал хийх цаг хугацаа хэрэгтэй байгаа. Тэгэхээр сая 1072 ширхэг хувьцаа шиг шууд данс руу нь өгчихнө гэсэн үг биш шүү дээ. Яагаад гэвэл хуримтлал үүсэх байхгүй юу. Тэр үүссэн хуримтлалаар нь ирээдүйд харин. ...

Б.Жаргалан: Иргэдийн хуримтлалыг яагаад ипотект зарцуулаад байна вэ гэдэг байна.

Л.Энх-Амгалан: Харин тийм. Одоо би танд тайлбарлах гэж байна. Үүссэн хуримтлалыг ирээдүйд эрүүл мэнд, боловсрол, орон сууцад зарцуулна гэдэг, хуулийн зохицуулалттай. Тэгэхээр иргэдийн данс дээрх хуримтлалыг хөрөнгө оруулалтын хуримтлалын сан хэлбэрээр, нөгөө талдаа хөрөнгө оруулалтын сангийн хэлбэрээр ажиллах ёстой шүү дээ. Тэгээд угаасаа хуульчилсан. Сая та өөрөө хэлж байна. Баялгийн сангийн тухай хуулиар энэ хуримтлалын сангийн өгөөж бодлогын хүүгээс багагүй байна гэж. Тэгэхээр Монголбанктай гэрээ хийгээд, Монголбанк хөрөнгийн менежментийн удирдлагыг хийж байгаа. Өнгөрсөн жил хийсэн. Энэ хөрөнгийн менежментийн удирдлагыг хийсэн нэг арга хэрэгсэл нь ипотекийн санхүүгийн эх үүсвэр болгосон. Гэхдээ энэ тал дээр Монголбанктай нэг жилийн гэрээ хийсэн. Энэ нэг жилийн гэрээгээр 480 тэрбум төгрөгийг ипотекийн сангийн санхүүжилтэд оруулаад, үүнээс хүртэх өгөөжийг бодлогын хүүгээс багагүй байна гэхээр 30 тэрбум төгрөг болж байгаа. Тэгэхээр оны төгсгөл буюу 12 дугаар сарын 31-ний өдрөөр өгөөж 4.9 тэрбум төгрөг авсан. Одоо гэрээ 5 дугаар сарын 09-ний өдөр дуусах учраас гэрээгээ дүгнээд үлдэгдэл 25 тэрбум төгрөгийг хуримтлалын данс дээр авч, иргэдийн хуримтлуулж байгаа мөнгөний өгөөжийг хүү хэлбэрээр нь өгөх юм.

Б.Жаргалан: Сүүлийн асуулт. Үндэсний баялгийн санд төвлөрөх хөрөнгийг аль болох арвижуулах, нэмэгдүүлэх үүрэгтэй байгаа. Тэгээд харамсалтай нь 2025 оны төсөв батлах үед Ирээдүй өв санд төвлөрүүлэх АМНАТ-ийн хувийг бууруулж, төсвийн орлого бүрдүүлсэн. Тэгвэл сая Засгийн газраас өргөн бариад буцаагаад татчихсан байж байгаа Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд Баялгийн сангийн орлогыг бууруулж болзошгүй заалт тусгагдсан байгаа. Төрийн өмчит компаниуд МЕГА төслүүд бариулах зорилгоор ашигт малтмалаа бараа солилцоогоор бартердаад

³ Дивидент – гэдэг нь хувьцаа бүрд тооцож гаргасан ашиг

эхлэх юм бол баялгийн санд төвлөрөх мөнгөн орлого илт багасах нь тодорхой. Энэ талаар ямар тооцоо судалгаа хийсэн бэ?

Л.Оюун-Эрдэнэ: Н.Учрал сайд хариулт өгье. Тэгээд ер нь баялгийн сангийнхаа хуримтлалыг нэмэгдүүлэх гээд бүх талаар оролдож байгаа. Одоо долоохон компани төрийн эзэмшлийнхээ 34 хувийн ногдол ашгийг 1 жилийн дотор хуримтлуулахад 480 тэрбум төгрөг хүрнэ гэдэг бол төрийн эзэмшлийн ногдол ашиг буюу 34 хувийн ногдол ашиг, төрийн өмчийн компаниуд өөрөө ашигтай ажиллаад эхэлбэл баялгийн сангийн хуримтлал жил ирэх тусам нэмэгдэх юм. Ер нь цаашид ашиггүй ажиллаж байгаа төрийн өмчийн компаниуд хэрэггүй. Ерөөсөө ямар ч шаардлага байхгүй. Энэ бол баялгийн сан дээр илэрнэ. Иргэд И-Монголиа аппликэйшнийг гаргаад үзэхээр компани баялгийн санд багахан хувь хэмжээний ногдол ашиг хуримтлуулж өгөхгүй байна. Энэ компани хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу гэдэг асуултыг тавьж эхэлнэ. Тийм учраас энэ бол нэг хэлбэр.

Цаашлаад хувийн хэвшлийн үйл ажиллагаанд төр нэг их ногдол ашиг аваад, хувь хувьцаа эзэмшиж явдгаасаа илүүтэйгээр ер нь бол шууд тэр амнаас нь ашигт малтмалын нөөцийг баялгийг ашиглаж байгаа бол төлбөрийг нь авдаг. Тэгээд тэр хувийн хэвшлийн үйл ажиллагаанд оролцоод байдаггүй. Тэгээд худлаа үнэн хэдэн хүнийг тэжээх гэж Төлөөлөн удирдах зөвлөлд нь хүн суулгадаг байдлаасаа салах ёстой. Тийм учраас сая Ораногийн гэрээн дээр ч гэсэн зөв жишиг гарсан. Түүнтэй адилхан баялгийг ашиглаж байгаа бол уурхайн компаниуд төлбөрөө төл. Тэр төлбөр нь шууд иргэдийн хуримтлалын дансанд орно. Тэгээд жил болгон санхүүгийн тайлангийн жил нь дууссаны дараа иргэд гар утсаа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 20 минутын хугацаа дууссан байна. Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал асуулт асууна.

О.Батнайрамдал: Баярлалаа. Ерөнхий сайдын хийх мэдээлэлтэй холбогдуулан иргэдийн үлдсэн асуултыг асуух дэгтэй байгаа. Иргэн Өлзийбатаас дараах асуултуудыг асуусан байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дэмжиж байгаа. Сингапур, Норвегт, Саудын Араб, Казахстан шиг Монгол Улс болох ёстой. Үүнийг хийхийн тулд стратегийн ордуудын эзэмшлийг хэрхэн тодорхойлох вэ гэдгээс шууд шалтгаална. Тийм учраас их тодорхой хэдэн асуулт тавьсан байна. Асуулт нэг бол тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулах тухай Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолыг дурдаад, үүндээ Ухаа худаг ордын стратегийн ач холбогдол бүхий ордод авах, эндээс төр ямар хувь эзэмших вэ? Засгийн газар энэ дээр ямар шийдэлтэй вэ? Энэ яагаад удаад байна гэсэн асуултыг тавьсан байна.

Хоёрдугаарт, 2007 оны 27 дугаар тогтоолтой холбоотойгоор 39 стратегийн ордын жагсаалт дотор 18 дээр эрэмбэлэгдсэн нийгмийг 2 талцуулаад байгаа Төгрөг нуурын ордыг дурдсан байна. Энэ Төгрөг нуурын ордыг төрийн мэдээлэлд хувь хэмжээг нь авах хэлцэл яагаад шийдвэрлэгдэхгүй байна вэ? Үүнд хэр их хугацаа шаардах вэ гэж асуусан байна.

Мөн үргэлжлүүлээд Засгийн газрын БЭТ Батзандан 2025 оны 4 дүгээр сарын 14-нд дурдсан Баян хөндийн Алтаннар, Хармагтай, Халзан бүрэгтэй зэрэг 8 ордыг Засгийн газарт саналаа оруулсан. Энэ дээр ямар нэмэлт мэдээлэл байна. Мөн Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумын нутаг дэвсгэр дамнасан Баян хөндий, Алтан нар ордуудын талаар асуусан байна.

Мөн эдгээр нэмэлт ордуудаас гадна стратегийн орд газрыг анхнаас нь стратегийн ордын жагсаалд оруулахгүй байх зорилгоор албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглаж жижиглэн олон хуваах ийм болзошгүй эрсдэл байна. Энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ гэсэн хоёр багц асуултыг иргэн Өлзийбат асуусан байна. Хариултаа авчхаад, дараагийнхаа асуултуудыг нь үргэлжлүүлж асууя.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Тэгээд 18 жилийн хугацаанд стратегийн ордод тооцуулах тухай тогтоолоо Улсын Их Хуралд оруулж ирээгүй ер нь юу болгосныг та бүхэн нэг, хоёр жишээнээс харж байгаа шүү дээ. Тэгээд орчин үеийн залуучууд их өөр болсон юм билээ. Түрүүн Б.Жаргалан гишүүн хэлж байсан. Чингис хаан баялгийн сангийн менежментийн компанид өндөр боловсрол эзэмшсэн залуучуудыг орж ажиллуулж, тэр дэлхийн хөрөнгө оруулалтын менежментийн компанийг урьж авчрах, менежментийг сайжруулах ассет менежмент хийлгэх гээд бид нар урьж залж байгаа. Яг үнэндээ. Тэгэхгүй бол энэ төрд чинь ажиллах хүнгүй болчихоод байна. Тэгээд нөгөө өгөөжийг нэмэгдүүлэх ажлуудыг хийлгэхэд дэлхийн хэл усаар ярих гаднын менежмент олж ирэхэд бас зүдэрч байгаа байхгүй юу. Тэгээд энэ залуучууд өөрсдөө нөгөө оффшороор дамжуулаад яаж мөнгө төгрөг гаргадаг юм, яаж үндэстэн дамнасан хэлхээ холбоо үүсгэдэг юм, яаж жонхууруулдаг вэ гэдгийг надаар хэлүүлэлгүй гаргаж ирээд олон улсын биржээс мэдээ мэдээллийг нь аваад нэгтгээд гаргаад ирж байна. Тэгээд баримтууд гаргаад тавихад зүгээр нэг дээр нь нэг ийм юм болдог. Түүн шиг одоо бид нар цаашдаа нөгөө нуурыг нь харахгүй худгийг нь хараад, овоог нь харахаар овоолохыг нь харахгүй байдаг ийм зарчимгүй үйлдлээ бол таслан зогсоогоод баялгийн сан дээр тэгш хандах ёстой. Хэлэлцээр хийх ёстой. Тэгээд байгалийн баялгийг хэн нэгэн бүтээгээгүй. Бүгдтэй нь тэгш сайхан хэлэлцээр хийгээд асуудлаа шийдэх юм бол баялгийн сангийн хуримтлал нэмэгдэнэ гэж ойлгож байгаа. Тийм учраас бүгдэд тэгш хандъя гэдэг энэ зарчмаар баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэх гээд ажиллаж байгаа. Тэгээд энэ хүрээнд асуудлаа шийдээд явна.

Тэгээд бид нар нэг зүйлийг ойлгох ёстой. Хэрвээ янз бүрийн орд газрууд байгалийн баялаг дээр хуулийн хариуцлагатай асуудал тухайлбал татвараас нуугдсан, оффшороор дамжуулсан янз бүрийн асуудал байвал үүнийг хуулийн байгууллага тогтооно. Бусдаар баялгийн сангийн хэлэлцээр тусдаа асуудал. Бүгдэд нь тэгш хандана. Улсын Их Хуралд оруулж ирнэ. Тэгээд асуудлуудаа хамтдаа шийдээд явна. Хуулийн хариуцлагын асуудал бол хуулийн байгууллагад янз бүрийн баримтууд олдсон бол түүнийг хуулийн байгууллагад илгээнэ, түүнийг хуулийн байгууллага шалгана. Гэхдээ үүнээс үл хамаараад монголчууд

байгалийнхаа баялагтаа эзэн болох ажил бол тасралтгүй хийгдээд явна гэдэг ийм байр суурьтай байгаа.

Д.Амарбаясгалан: О.Батнайрамдал гишүүн үргэлжлүүлэн асууя.

О.Батнайрамдал: Дараа нь иргэн Ганбаярын тодорхой нэг асуулт байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК болгож орон нутгаас нь боловсон хүчин нөөцөө бүрдүүлж болохгүй юу. Иргэн Ганбаярын 2 дахь асуулт. Асуулт давхцаж байгаа ч гэсэн иргэний асуултыг асуух ёстой. Эрх зүйн зохицуулалтаа сайн хийж иргэн бүрд бодитой хүрсэн бүх шатандаа үнэнч шударга ажилламаар байна. Эрх мэдэл албан тушаалаа ашиглаж боломжийг дээгүүрээ хүрдэг байж болохгүй байна. Үүн дээр бол бухимдалтай хандаж байна. Иймд тэгш хүртээмжтэй зохицуулалт хийх талаар дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч, бодлоо хэлээч гэсэн ийм 2 асуултыг иргэн Ганбаяр асуусан байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Ганбаярт баярлалаа. Өнөөдөр бид Баялгийн сангийн тухай хуулийг сонгодог агуулгаар нь батлаад, хэрэгжиж эхлээд нэг жил болж байна. Хэрүүлтэй уруултай зөндөө юм болсон. Би бас хэлсэн. Оюу толгойтой холбоотой 2.3 тэрбум ам.доллар тэглэгдэх гэж Улсын Их Хурлаар гурван ч удаа мэтгэлцээн өрнөсөн. Эрдэнэтийн 49-тэй холбоотой асуудал бас бөөн юм болсон. Наад Дархан төмөрлөг, Хөтөл гээд. Гэхдээ энэ бүх зүйлийн үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг өнгөрсөн жил баталж чадсан. Намууд зөвшилцөж чадсан. Өнөөдөр мэдээж нэг жилийн дараа нэгдсэн 3 сангийн тухай ярьж байна. Тэгээд дэлгэрэнгүй тайлбарла гэсэн учраас стратегийн ордын 34 хувь болон түүнтэй тэнцүүлж зөвшилцөх борлуулалтын орлого эсвэл АМНАТ, үүнийг хэрхэн томьёолох вэ гэдгийг өнөөдөр ярьж байна. Үндэсний баялгийн сангийн төлбөр гэх үү, роялти гэдэг ойлголтыг хэрхэн тодорхойлох вэ? Энэ бол иргэдийн хуримтлалын нэгдсэн сан. Гэхдээ энэ хуримтлалын сан нь банк шиг боловсрол, эрүүл мэнд, орон сууцад зарцуулагдана. Жишээлбэл орон нутаг руу иргэд шилжиж байгаа бол давуу байдлаар тэр сангаас түрүүлж зээл авах ч юм уу ийм боломжийг менежментийн баг бүрдүүлнэ. Энэ бол хуримтлалын сан. Тийм учраас өнөөдөр маргаан болоод байгаа стратегийн ордуудын 34 хувьтай холбоотой асуудлыг яаж АМНАТ-өөр юм уу эсвэл борлуулалтын орлогоор эсвэл 34 хувиар нь байлгах вэ гэдэг хуримтлалын нэгдсэн сан хэрэгжих хамгийн том сорилт өнөөдрийн мэтгэлцээний гол асуудал болчихоод байна. Энэ асуудал үе шаттайгаар Улсын Их Хурлаар орж ирнэ. Тус бүрдээ нэлээдгүй мэтгэлцээнтэй. Энэ дээр парламентын гишүүд манай иргэдийн хувьд ч тэр туйлын мэдээллээ нягталж, хэрсүү хандах ийм чухал сорилт дундуур бид нар гарна. Тус бүрдээ томоохон асуудлууд дагуулна.

2 дахь нь бол Хөгжлийн сан. Сая Б.Жаргалан гишүүн ч бас асууж байна. Үнэн. Яагаад уул уурхайн баялгийг ашиглуулаад байгаа мөртөө манай орон нутаг хөгжихгүй байгаа юм бэ гэдэг асуудал. Энэ бол аргагүй учир нь АМНАТ-ийн 65 хувь нь шууд ирээдүйд гэж хуваарилагдаж байгаа учраас зөвхөн улсын төсөв бүрдэх дээр уул уурхайн томоохон төслүүд нэмэр болж байгаа юм. Гэтэл манай

төсөв уул уурхайн төслүүдийг яваад байхаар дагаж тэлээд байна гэж байгаа. Цаашлаад бид нар төсвийг бол уур уурхайн бус орлогоор уул уурхайн орлогын зохих хувиар бүрдүүлдэг байх эрх зүйн орчин руу Үндэсний баялгийн сангаар дамжиж шилжих учиртай. Ингээд зарим жил мэдээж нүүрсний ч юм уу, зэсийн үнэ өсвөл түүгээрээ дамжаад шууд дэд бүтцийнхээ төслийг хийдэг байх ёстой. Багасчихвал хийхгүй байх ёстой. Тийм учраас энэ асуудлууд дээр бид нар нэг жилийн дараа өнөөдөр дүгнэж ярилцаж байна. Цаашлаад Засгийн газар дээр дүгнэж яриад, бүлгүүд дээр танилцуулаад, тодорхой хэд хэдэн эрх зүйн орчныг өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байгаа. Энэ бол Хөгжлийн сан. Зарчим нь иргэд, орон нутаг уул уурхайн төслийг дэмжиж байгаа бол түрүүлж хөгжих зарчим. Энэ нь олон нийтийн дэмжлэгтэй байлгах тал дээр туйлын чухал юм.

Мэдээж ирээдүйд хадгалагдах Ирээдүйн өв сан. Ирээдүйн өв сангийн арвижуулах менежментийг боловсронгуй болгох асуудал. Энэ 3-ын нэгдсэн менежментийг Үндэсний баялгийн сан гэж нэрлэж байгаа. Тийм учраас Үндэсний баялгийн сангаа хамгаалах учиртай. Хуулиа хэрэгжүүлэх ёстой. Хэлцлүүдээ хийх ёстой. Тэгээд баялаг Үндсэн хуулийн дагуу өнөөдөр ба ирээдүйн иргэдэд иргэдийн сайн сайхан амьдрахад асуудлаа шийддэг байх ёстой. Яагаад гэвэл экспортын 90 хувь учраас.

О.Батнайрамдал: Бас нэг асуулт байсан нь Дарханы Төмөрлөгийн үйлдвэртэй холбоотой. Энийг жоохон дэлгэрүүлж хариулмаар байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэр гэлтгүй ер нь төрийн өмчит компаниуд, тэр дундаа хамгийн том орлогыг бүрдүүлэгч бол дандаа уул уурхайн компаниуд байгаа. Тэгэхээр нэг ёсондоо газрын баялгийг ашиглаж байгаа төрийн өмчит компаниуд орлогын дийлэнхийг бүрдүүлдэг. Тэгэхээр төрийн өмчит компаниудын ил тод байдлыг хангах сайн засаглал руу шилжүүлэх процесс өөрөө Үндэсний баялгийн сангийн хууль хэрэгжихтэй шууд холбоотой. Тэгэхээр Үндэсний баялгийн санд нэг комплект гараад байгаа. Жишээлбэл Тимасеки. Тимасеки бол төрийн өмчит компаниудын нэгдэл. Олон улсад бол “serving development fund” буюу Монголоор орчуулах юм бол “Хөгжлийн сан” гэсэн үзэл баримтлалтай явж байсан. Тэгэхээр орлого хэн бүрдүүлж байна. Орлогоо сайн бүрдүүлж чадсан уу? Тэгвэл бидэнд хуваарилалт байна гэсэн үг. Тэгэхээр энэ орлогыг сайжруулах үйл ажиллагаа өөрөө төрийн өмчит компанийн шинэчлэл, тэр дундаа “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрчист Монгол” ХХК хэрхэн цаашдаа энэ шинэчлэлийг сайн хийж чадах вэ гэдэгтэй нэг ёсондоо шууд холбоотой гэсэн үг. Энэ шинэчлэл сайн хийгдэхгүй бол бид хэчнээн сангууд ярьсан ч тэр нь мөнгөжиж өгөхгүй гэсэн үг. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор эдгээр төрийн өмчит томоохон компаниудыг иргэн Ганбаярын асуулт болох Дарханы төмөрлөгийн үйлдвэр гэж жишээ аваад байна. Олон нийтийн компани хэзээ болох вэ? Орон нутгаас боловсон хүчнээ татдаг шийдэл рүү хэзээ орох вэ гэсэн тодорхой асуултыг асууж байна.

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Уул уурхайн компаниуд бол Эрдэнэс Монгол нэгдлийн доор Үндэсний Баялгийн сангийн хуулиараа төвлөрсөн. Эрчист Монгол буюу уул уурхайн бус төрийн өмчит компаниудыг Эрчист Монголын доор нэгтгэсэн бүтээмж нэмэгдүүлэх зорилготойгоор 2 нэгдэл бий болж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ 2

нэгдэл бол цаашдаа баялгийн сангийнхаа хуулийн концепцын хүрээнд хөгжлийн сан буюу хөрөнгө оруулалт хийдэг, томоохон төслөө санхүүжүүлдэг, ашиг орлогоо нэмэгдүүлдэг төсвөөс гадуур төслүүдээ санхүүжүүлдэг нэгдлийг бий болгож байгаа. Тэгэхээр энэ нэгдлүүд цаашдаа Баялгийн сангийн тухай хуулиар Эрчист Монгол ч гэсэн өөрөө ногдол ашгийнхаа тодорхой хувийг баялгийн санд төвлөрүүлдэг болж чадвал ашиггүй компаниуд шаардлагагүй болно гэсэн үг. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдээс сая өргөн мэдүүлчихсэн байгаа төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулийг хамтдаа баталж чадвал янз бүрийн улс төрийн нөлөөтэй томилгоонууд цаашдаа хийгдэхгүй болно. Энэ шинэ төрийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулиар бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд гүйцэтгэх захирлын босго шаардлага нь асар өндөр болж байгаа. Энд янз бүрийн шахааны томилгоо нөлөөлөх бололцоо хэцүү болно. Яагаад гэвэл ашиггүй ажиллуулж байгааг нь татан буулгаад явчихаар ашигтай ажиллуулж чадах сайн менежерүүдийг томилох шаардлага үүснэ. Ингэснийхээ хэрээр төрийн өмчит компаниудын захирлуудын нэр хүнд, компаниудын нэр хүнд түүнийгээ дагаад өснө. Эрдэнэс Монгол ч бай, Эрчист Монгол ч бай баялгийн сандаа ногдол ашгийнхаа тодорхой хувийг хуримтлуулдаг болохыг бид шаардана. Цаашдаа энэ засаглал өөрөө зөв болно. Баялгийн сангийн хөгжлийн сан өөрөө хөрөнгө оруулалтын сангийнхаа жишгийн дагуу төслүүдээс санхүүжүүлдэг статустайгаар болгоё гэдэг утгаараа энэ хоёр нэгдэлд хувааж бүтээмжийг нэмэгдүүлэх, хэмнэлт бий болгох, тэгээд захиргааны орон тоонуудыг багасгах чиглэлээр ажлууд хийгдээд явж байгаа. Одоо Улсын Их Хуралд Нийтийн өмчийн тухай хуулийг бариад нийтийн өмчийн хууль нийтийн өмчит компанийн засаглал ил тод байдлыг сайжруулах хууль батлагдсанаараа компани бие дааж засаглах бололцоо бүрдэнэ гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

О.Батнайрамдал: Үүнтэй холбоотойгоор нэмэлт мэдээллийг Учрал сайдаас тодруулчихмаар байна. Эрдэнэс Монголын санхүүжилтээр “Би Ди Юү Интернэйшнл” гээд олон улсын консалтинг компани цаашдаа Эрдэнэс Монголын ирээдүй хаашаа чиглэх вэ гэсэн томоохон судалгааг одоогоос 6, 7 жилийн өмнө хийсэн байдаг. Эрдэнэс Монгол дээр 1000-аад хуудас бүхий олон улсын консалтинг компанийн хийсэн судалгаа байгаа. Тэр компани Эрдэнэс Монголд юу гэж зөвлөсөн бэ гэхээр Эрдэнэс Монгол өөрөө баялгийн сан болж хувирах ёстой. Тэр дундаа хөгжлийн сан болж дотоод Фортеолли компанитай үүнийхээ олон улсын баялгийн сангийн Сантьягогийн зарчмаас⁴ эхлүүлээд хэрэгжүүлээд явах ёстой гэсэн зөвлөгөөг өгсөн байдаг. Тэгэхээр сая Ерөнхий сайдын хэлснээр хэлцлүүд явахын хажуугаар баялгийн сангийн концепт болон холбогдох бүх зүйлээ ойлгомжтой болгох ёстой. Нэмэлт, өөрчлөлт оруулна гэж байгаа бол энэ 3 сан дотроо тэр дундаа хөгжлийн санг олон улсын зарчим руу шилжүүлэх нь зүйтэй гэж бодож байна. Тэгээд сая Учрал сайд тайлбарласан шиг дотроо уул уурхайн, уул уурхайн бус гээд хуваагдана уу? Хамгийн гол нь олон улсын баялгийн сангийн зарчмыг биелүүлсэн ийм сан болж хөгжих ёстой. Тэгэхээр энэ дээр Учрал сайдаас нэмэлт тайлбар авчихъя.

⁴ Сантьягогийн зарчим – ХЗҮХ-ээс 2013 онд хийсэн “Уул уурхайгаас олох эх үүсвэр бүхий тусгай сангийн эрх зүйн зохицуулалт” бодлогын судалгааны 13-14 дүгээр хуудас

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Тийм хөгжлийн сан бол цаашдаа хөрөнгө оруулалтын сангийн жишгээр ажиллах ёстой. Одоо хуулиараа Эрдэнэс Монгол нөгөө баялгийн сангийн орлого төвлөрүүлж байгаа хуулийн этгээд. Цаашдаа Баялгийн сангийн орлого төвлөрүүлэх бол нэг чиг үүрэг нь, нөгөө чиг үүрэг нь улс орны хэмжээний томоохон төслүүдээ санхүүжүүлээд, түүнийхээ хариуд ашиг орлого нь нэмэгдэж байдаг хэлбэрт орох нь зөв гэж үзэж байгаа. Баялгийн сангийн хуулийнхаа дагуу хэлэлцээрүүд явагдана. Хэлэлцээрүүд явагдахад “due diligence”⁵ гэж хяналт шинжилгээг хийх хэрэгтэй. Хяналт шинжилгээг хийгээд стратегийн ордуудын 34-ийг авна. 50 хувь дээрээ хэлэлцээр хийнэ. Гэхдээ хэн ч гэсэн шинэ машин авахад хүртэл ядаж будагтай байна уу, замасктай байна уу гэдгээ шалгаж байж авах ёстой. Тэр утгаараа ажиллана гэж ойлгож байгаа. Тэгэхээр хэлэлцээрийг хяналт шинжилгээ хийж байж хийнэ.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ингээд Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг нэгдсэн хуралдаанаар сонслоо. Оролцсон гишүүддээ баярлалаа.

---oOo---

⁵ “due diligence” – зохих шалгалт

1.3.2025 ОНЫ 5 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД “БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ХҮҮХЭД БҮРД СУРАЛЦАХ ТЭГШ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ”-НИЙ ТАЛААР ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ



С.Амарсайхан: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Аливаа улсын хөгжлийн суурь нь боловсрол байдаг бөгөөд эдийн засгийн өсөлт, инновацийг удирдаж, хөдөлмөр эрхлэлт, бүтээмжийг нэмэгдүүлэн хувь хүний болон улсын хөгжил, дэвшлийг түүчээлж байдаг бол бид боловсролын үр дүнг салбарын хүрээнд хэмжиж, дүгнэж ирсэн байна.

Дэлхийн банкны 2024 онд хийсэн тооцооллоор, иргэдийн 2021 оны худалдан авах чадварыг тухайн жилийн хөдөлмөрийн бүтээмжтэй харьцуулахад 14.0 мянган ам.доллар байсан

бөгөөд хэрэв тухайн жилийн хөдөлмөрийн бүтээмж Сингапур улсын бүтээмжийн түвшинтэй ижил түвшинд байсан бол худалдан авах чадвар 18.4 мянган ам.доллар байх боломж байгаа нь боловсролын салбарт хөрөнгө оруулалт хангалтгүйгээс үүдэн бид 5.7 тэрбум ам.долларын боломжийг алдсан гэсэн дүгнэлт гарчээ. Манай улсын хөдөлмөр эрхлэх насны хүн амыг цаашид нэмэгдэнэ гэж үзвэл, хүмүүн капиталын түвшин доогуур байгаагаас үүдэн гарах эдийн засгийн алдагдал улам бүр нэмэгдэхээр байна. Иймээс боловсролоор дамжуулан хүний хөгжилд хийж байгаа хөрөнгө оруулалт нь эдийн засгийн ирээдүйн өсөлтөд хийж буй хөрөнгө оруулалт юм.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүний хөгжил зорилтыг хэрэгжүүлэх эхний үе буюу 2030 он гэхэд тэгш хүртээмжтэй, чанартай, насан туршийн суралцахуйд суурилсан боловсролын тогтолцоог хөгжүүлэхээр ажиллаж байна.

Энэ зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд боловсролын салбарт бодлогын шинэчлэл, арга хэмжээг хэрэгжүүлэх суурь нөхцлийг 2023 оны 7 дугаар сард батлагдсан багц хуулийн шинэчлэлээр бий болгож чадсан. Шинэчилсэн хуулиар боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах ерөнхий зорилгын дор засаглал, санхүүжилт, хөтөлбөр, багш, үнэлгээ, цахим шилжилт гэсэн 6 шинэчлэлийн чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосон.


Боловсролын засаглалын шинэчлэлээр тус салбар мэргэшсэн удирдлагатай байх нөхцөл хангагдаж, сургалтын байгууллагын зөвлөл, удирдах зөвлөлд олон талын төлөөллийг оролцуулж, шийдвэр гаргах зохицуулалттай боллоо. Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлд

байгууллагын гүйцэтгэх удирдлагын томилгоо хийх, санхүүжилт, хөрөнгө оруулалт, сургалтын бодлогын шийдвэр бие даан гаргах боломжийг бүрдүүллээ.

Мөн багшийн сургалтаа бие даан зохион байгуулах, төсвийн тодорхой хэсгийг хамт олонтойгоо зөвшилцөн шийдвэр гаргах, зарцуулах, сургууль хөгжүүлэх сангаа удирдах зэрэг эрх мэдлийг цэцэрлэг, сургуулийн удирдлагад шилжүүллээ.

Засаглалын энэ шинэчлэл нь бодлого тогтвортой хэрэгжих, байгууллага эрэлт, хэрэгцээндээ нийцсэн уян хатан үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг олгож байна. Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт санхүүжилт тогтвортой нэмэгдэж байгаа бөгөөд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж төсвийн хэмжээг 2021 онтой харьцуулахад 2.5 дахин нэмэгдүүллээ. Боловсролын төсвийн хувь хэмжээ улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь өссөн ба 2021 онд 18 хувь байсан бол 2025 онд 19.6 хувь болсон.

7 дугаар зураг. Боловсролын салбарын санхүүжилт ба төсвийн хэмжээ



Цэцэрлэг, сургуулийн хувьсах зардлын хэмжээг 2021 онтой харьцуулахад цэцэрлэгт дунджаар 36.4 хувь, ерөнхий боловсролд 51.6 хувиар тус тус нэмэгдүүллээ.

Өмнө нь нэг сурагчид ногдох хувьсах зардлыг цэцэрлэг, бага, дунд, ахлах анги гэсэн 4 түвшинд 910.0 мянгаас 1.0 сая төгрөгөөр тооцож олгодог байсан бол 2022 оноос хувьсах зардлыг үе шаттай нэмэгдүүлж, багшийн цалин хөлс, түүнд ногдох эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, сургалтын үйл ажиллагааны зардал, цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааны урсгал зардал, багшийн хөгжлийн зардал, багшийн эрүүл мэндийн үйлчилгээний зардал, цахим хэрэглээний зардал, анги танхимын ариутгал, цэвэрлэгээний зардал, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлуудыг санхүүжүүлдэг болсон. Анги бүрийн хувьсах зардлыг 1.4-2.4 сая төгрөг болгож нэмэгдүүлсэн байна. Санхүүжилт нэмэгдэхийн хэрээр боловсролын хүртээмж болон чанарт багагүй үр дүн гарч байна


8 дугаар зураг. Хувьсах зардлын өөрчлөлтүүд



Нэг. Боловсролын хүртээмжийн талаар:

1.1. Өнөөгийн нөхцөл байдал: Боловсрол иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд шууд нөлөөтэй бөгөөд чанартай боловсрол эзэмшиж, олон жил сургалтад хамрагдсан хүн сайн ур чадвартай байж, хөдөлмөр эрхлэх боломж байдаг. Иймээс иргэдийн боловсролд хамрагдсан жилийг нэмэгдүүлэх нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх суурь нөхцөл болох юм.

9 дүгээр зураг. Сургалтад хамрагдсан байдал ба хөдөлмөр эрхлэлт



2024-2025 оны хичээлийн жилийн байдлаар 3-5 насны нийт хүүхдийн 94.1 хувь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа ба 2021 онтой харьцуулахад өссөн байна. Энэ өсөлтөд 2023-2024 онд хэрэгжүүлсэн “Сугалаагүй цэцэрлэг” арга хэмжээ хамгийн үр дүнтэй байсан.

Энэ хичээлийн жилд бага боловсролын (1-5 дугаар анги) хамран сургалтын цэвэр жин 97.7 хувь, дунд ангийн (6-9 дүгээр анги) хамран сургалтын цэвэр жин 96 хувь, ахлах ангийнх 97 хувьтай байна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролоос гадуур үлдсэн хүүхдүүдийн дийлэнх нь хөгжлийн бэрхшээлтэй, малчин өрхийн, эрх нь хязгаарлагдсан гэх мэт ялгаатай бүлгийн хүүхдүүд байна.

10 дугаар зураг. Цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж буй суралцагчдын тоо, хувиар



Эдгээр хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлсний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй 2,150 хүүхэд цэцэрлэгт, 6,273 хүүхэд ерөнхий боловсролд хамрагдаж байна. Үүний цаана хөгжлийн бэрхшээлийн улмаас сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй байгаа 814, ерөнхий боловсролд хамрагдаж чадахгүй байгаа 1,263 хүүхэд байсаар байна.

Эдгээр хүүхдүүдийг боловсролд хамруулах чиглэлээр Засгийн газраас анхаарал хандуулж ажиллаж байгаа бөгөөд эхний ээлжинд танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хүүхдэд чиглэсэн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ бүхий Дэмжих төвийг 2025 оны хичээлийн жилээс ажиллуулж эхэлнэ. Дэмжих төвөөр дамжуулан хэрэгжүүлэх энэ үйлчилгээ эхэлснээр 2,077 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдана.

2024 оны хичээлийн жилээс эхлэн эрх нь хязгаарлагдсан 37 хүүхдийн 34-ийг ерөнхий боловсролд хамруулж байна. Мөн 2025 оны 05 дугаар сараас эхлэн боловсролд хамрагдаагүй байсан 302 лам хүүхдийг ерөнхий боловсролд хамруулж, шаардлагатай хэрэглэгдэхүүн, сурах бичгээр хангаж байгаагийн 287 нь Энэтхэг улсад шавилан суралцаж буй хүүхдүүд байна.


Хамран сургалтын тоо тогтмол өсөж байгаа ч 2050 он хүртэлх хүүхдийн тооны өсөлт болон сургуулийн хүртээмжтэй холбоотой асуудал тулгамдаж байна. Өөрөөр хэлбэл 2050 он хүртэлх цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн тооны өсөлтийн урьдчилсан таамаглалаас харахад хүүхдийн тооны хамгийн оргил үе 2028-2030 онд тохиохоор байна.

Сургууль, цэцэрлэгийн барилгыг барих хугацаа дунджаар 3-5 орчим жил байдаг гэж үзвэл энэ оргил үеийг давах бэлтгэлийг одооноос хийхээс өөр аргагүй нөхцөл байдалтай байна.

11 дүгээр зураг. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчийн тоо


Богино, дунд хугацаанд Монгол Улсын сурагчийн тоо өсөх төлөвтэй:

- Богино, дунд хугацаанд дахь хүн амын өсөлт,
- СӨБ, ЕБС-д заавал хамруулах ёстой



Төрийн өмчийн сургуулийн 2/3 нь 2 ээлжээр хичээллэдэг:

- Төрийн өмчийн сургуулийн сурагчийн 88 хувь нь 2 ээлжтэй сургуульд суралцдаг



Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн гуравны хоёр нь хоёр ээлжээр хичээллэж байгаа бөгөөд нийт ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа хүүхдүүдийн 88 орчим хувь хоёр ээлжээр хичээллэж байна гэсэн үг юм.

Энэ нь хүүхэд сургуулийн орчинд хичээлээс гадуур авьяас, сонирхлоо хөгжүүлэх үйл ажиллагаа, дугуйлан, клубт хамрагдах боломжгүй болгож байна. Олон улсын ПИСА үнэлгээний 2022 онд хийгдсэн үр дүнгийн шинжилгээгээр сургуулийн ээлжийн коэффициент нэгээр буурахад суралцагчийн математикийн оноо 8-аар нэмэгдэж байсан.

Сургууль нэг ээлжтэй болгох нь хүүхдийн цогц хөгжлийг хангах, сургалтын чанар сайжрах, сургуулийн ачаалал бууруулахад, түүнчлэн “Хамгийн сайн сургууль гэрт ойр сургууль” болгох гол хүчин зүйл тул цаашид бүх сургуулийг нэг ээлжтэй болгох нь Засгийн газрын үйл ажиллагааны зорилт болж байна. 2024-2025 оны хичээлийн жилд Орхон аймгийн 7 дугаар сургууль нэг ээлжийн сургалтын зохион байгуулалт, төлөвлөлтөөр үйл ажиллагаа явуулж байна. Энэ туршлага дээр үндэслэн үндэсний хэмжээнд нэг ээлжтэй сургуулийн төлөвлөлт, зохион байгуулалтыг шинэчлэн, 2025 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

1.2. Авч хэрэгжүүлэх арга хэмжээ: Дээрх зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр боловсролын хөрөнгө оруулалтыг 2021 оноос хойш 40 хувиар нэмэгдүүлж, 2020 оноос хойш 277 цэцэрлэг, 200 сургуулийг ашиглалтад оруулаад байна.

2025 онд нийт 60 цэцэрлэг, 85 сургууль, 16 дотуур байрын хөрөнгө оруулалтыг төсөвт тусгаж, ондоо багтаж 390 хүүхдийн ортой хоёр цэцэрлэг, 4,840 суудалтай 14 сургууль ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Хэдийгээр жил бүр цэцэрлэг, сургуулийн суудлын тоог нэмэгдүүлж байгаа ч хүүхдийн тооны өсөлттэй нийцэж чадахгүй байгаа тул 2025 оны хичээлийн жилээс зарим богино хугацаанд үр дүн гарах боломжтой арга хэмжээг хэрэгжүүлэхээр бэлтгэл хангаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн бүлэг дүүргэлтийг бууруулах, малчин өрхийн бага насны хүүхэд гэртээ

ойрхон суралцах боломжийг олгох зорилгоор багийн бага сургууль, хотхоны бага сургуулийг байгуулна.

12 дугаар зураг. 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт



2025 оны 9 дүгээр сараас Улаанбаатар хотын бүлэг дүүргэлт өндөртэй Баянгол, Хан-Уул, Баянзүрх дүүргийн зарим байршлын томоохон хороолол, хотхонуудад бага сургууль байгуулж ажиллана.

Засгийн газраас 2026 оныг “Боловсролын дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан 3-18 насны хүүхдийн боловсролд хамрагдалтыг 100 хувьд хүргэх, нэг бүлгийн хүүхдийн тоог стандартын түвшинд хүргэх зорилтыг дэвшүүлж, 2028 он хүртэл 95 цэцэрлэг, 108 сургуулийг шинээр барьж, бүх тавилга, хэрэглэгдэхүүнийг хангахад 2.8 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөөд байна.

Монгол Улсын 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөлд 45 цэцэрлэг, 45 сургуулийн барилгыг шинээр эхлүүлэхээр тусгасан бөгөөд 2026 оны төсөвт шаардагдах хөрөнгө оруулалтын санхүүжилтийг батлуулах хэрэгтэй байна.


Дээрх хөрөнгө оруулалтыг 2028 он хүртэл үе шаттай хийснээр 15,720 орны хүчин чадалтай 95 цэцэрлэг, 66,910 суудлын хүчин чадал бүхий 108 сургуультай болно. Ийм нөхцөл бүрдсэнээр дунд хугацаандаа хүүхдийн хөгжил, хамгааллийн үзүүлэлтүүд ахиж, багшийн ачаалал буурах бөгөөд үүний үр дүнд сургалтын чанарт эерэг үр дүн гарна.

Дэд бүтцийн хөрөнгө оруулалтаас гадна хүүхдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэхэд үдийн хоолны үйлчилгээ чухал нөлөө үзүүлдэг. 2024-2025 оны хичээлийн жилд 677.0 мянган хүүхдэд хоолны үйлчилгээ үзүүлж байна.

Сургууль, цэцэрлэгийн хоолны үйлчилгээг жил бүр сайжруулах арга хэмжээ авч байгаа ч одоо өгч буй хоол хүүхдийн бие бялдрын хөгжилд шаардагдах илчлэг, шим тэжээлийн түвшинд хараахан хүрээгүй байна. Тухайлбал, 2024 онд цэцэрлэгийн хүүхдүүдэд шаардагдах илчлэг, шим тэжээлийн 76 хувийг хангасан хоолоор үйлчиллээ. Цаашид шаардлагатай илчлэг, шим тэжээл бүхий хоолоор

үйлчлэхэд 2026 онд 122.6 тэрбум төгрөг, 2027-2028 онд 529.5 тэрбум төгрөг шаардлагатай байна.

13 дугаар зураг. Хүүхдийн бие бялдрын хөгжилд шаардагдах илчлэг, шим тэжээлийн түвшин



Нийгмийн үзүүлэлтийн 2023 онд хийгдсэн түүвэр судалгаагаар үндэсний хэмжээнд бага насны нийт хүүхдийн 50 гаруй хувь нь зохистой хооллож чадахгүй байна гэсэн үр дүн гарсан. Үүнийг сайжруулахад цэцэрлэг, сургуулийн хоолны үйлчилгээ чухал үүрэгтэй бөгөөд үр дүнг сайжруулах, эрүүл зохистой хоолоор хангах нь тэргүүлэх зорилт болж байна.

Нийслэлийн хэмжээнд цэцэрлэг, зарим сургуульд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар хүнс нийлүүлэлтийг зохион байгуулж, хүүхдийн хоолны батлагдсан норматив зардлаас өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлэн орон нутгийн төсөвт ногдол ашиг төвлөрүүлж байгаа нь хүүхдийн хоолны чанар, хүртээмжийг бууруулахад шууд нөлөөлж байна.

Түүнчлэн хэрэв бид бүх сургуулийг нэг ээлжтэй болгох, хичээл зохион байгуулалт, төлөвлөлтөд олон улсын жишгээр өөрчлөлт оруулбал цаашдаа дунд, ахлах ангийн суралцагчдад ч мөн хоолоор үйлчлэх шаардлагатай бөгөөд үүнийг эрх зүйн талаас оновчтой зохицуулах хэрэгцээ байна.

Иймээс Монгол Улсын Засгийн газар **“Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”**-ийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын намрын чуулганд өргөн барихаар ажиллаж байна.

Боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлэх нь урт хугацаандаа иргэдийн хөдөлмөр эрхлэлт, орлогод сайн үр нөлөөтэй байдаг. Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгаагаар боловсролд хамрагдсан нэг жил бүрт хөдөлмөр эрхлэх боломж **6.5 хувиар нэмэгддэг** гэдгийг тооцвол боловсролд хамрагдалтыг тогтвортой нэмэгдүүлэх нь ирээдүйд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ гэж харж байна.

Үүнээс гадна Монгол банкны тооцооллоор боловсролд хамрагдсан жил нэгээр нэмэгдэхэд **хөдөлмөрийн орлого 3.8 хувиар өсдөг** байна. Хөдөлмөр эрхлэлт нэмэгдэхийн хэрээр бидний урт хугацааны бодлого “Алсын хараа 2050”-д

зорьж буй иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах зорилт сайн хэрэгжилттэй байна.


Хоёр. Боловсролын чанарын талаар:

Хэдийгээр иргэдийн боловсролд хамрагдалтыг тогтвортой нэмэгдүүлж байгаа ч боловсролын чанар, үр дүн, өгөөж тэгш бус хэвээр байна. Тухайлбал олон улсын үнэлгээгээр (ПИСА 2022) алслагдсан бүс нутгийн, ялангуяа баруун бүсийн хүүхдүүдийн математикийн суурь чадвар эзэмшилт хамгийн доогуур байна. Тэд Улаанбаатар хотын үе тэнгийн хүүхдээс долоо хүртэл жилийн хоцрогдолтой байна. Ялангуяа үндэсний цөөнх суралцагчдын сурлагын хоцрогдол хамгийн их байна. Энэ нь жил бүр зохион байгуулагддаг элсэлтийн шалгалтад ч мөн ажиглагддаг үр дүн юм.


Энэ хоцрогдол сургууль, цэцэрлэгийн дэд бүтэц, ачаалал, бүлэг дүүргэлт, багшийн дутагдал, хэрэглэгдэхүүн, лабораторийн тоног төхөөрөмж, цахим хэрэглэгдэхүүний хангалт, мөн үндэсний цөөнх хүүхдийн хос хэлний ур чадвартай шууд хамааралтай байна. Энэ хоцрогдлыг нөхөхийн тулд боловсролын салбарт 274 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт, хөрөнгө оруулалт шаардагдах тооцооллыг Боловсролын яам, Дэлхийн банктэй хамтран хийгээд байна.

Үндэсний цөөнх хүүхдийн сурлагын хоцрогдлыг арилгах чиглэлээр хос хэлний боловсрол, сургалтын талаар баримтлах чиглэлийг 2025 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа ба энэ чиглэлийг хэрэгжүүлснээр казах, тува иргэдийн нийгмийн тэгш оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд хэл, соёлоо хадгалан өвлүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

14 дүгээр зураг. Математикийн суурь чадвар эзэмшээгүй хүүхдийн эзлэх жин



15 дугаар зураг. Хоцрогдлыг нөхөх, боловсролын чанар, хот, хөдөөгөөр



Хоцрогдлыг нөхөх, боловсролын чанарыг хот, хөдөөд ижил түвшинд хүргэхэд шаардагдах дээрх хөрөнгө оруулалтыг алслагдсан бүсийн болон нийгэм эдийн засгийн доогуур үзүүлэлттэй сургуулиудад хийж чадвал энэ бүсийн хүүхдүүдийн гүйцэтгэлд (ПИСА) дунджаар 14 хувийн ахиц гарах урьдчилан тооцоололтой байна.


2.1. Багшийн хангалт, чадамжийн талаар:

Сурлагын хоцрогдлоос үүдэлтэй боловсролын чанарын ялгааг бууруулахад багшийн хангалт, чанар, чадамж үндсэн хүчин зүйл юм. Багшийн дутагдал нь сургалтын чанар муудах, нэг багшид ирэх сургалтын цагийн ачаалал нэмэгдэх гэх мэт сөрөг үр дагавартай байдаг.

Энэ хичээлийн жилийн мэдээгээр төрийн өмчийн цэцэрлэгийн мэргэжлийн багшийн хангалт 93.7 хувь, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт 97.1 хувьтай байна. Мэргэжлийн багшийн хангалтын хувь өндөр харагдаж байгаа ч нэг ч багшийн дутагдалгүй байгаа цэцэрлэг, сургуулийн эзлэх жин бага байна.

Багшийн дутагдлыг бууруулах, хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор их, дээд сургуульд элсэгчдийн тоог нэмэгдүүлж, чанарыг сайжруулах чиглэлээр тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлсэн байдаг ч төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтэд тодорхой ахиц гараагүй байна. Тухайлбал, 2017-2018 оноос эхлэн элсэлтийн шалгалтын өндөр оноотой, багш бэлтгэх их, дээд сургуулийн элсэгчдэд санхүүгийн дэмжлэг, тэтгэлэг өгч байсан хэдий ч 2023 оны мэдээллээр эдгээр төгсөгчдийн 30 хувь нь багшаар ажиллаж, 9.5 хувь нь багшаар ажиллаж байгаад гарсан байна.

16 дугаар зураг. Багшаар төгсөгчдийн мэргэжлээрээ ажилд орсон байдал



Хэрэв багш бэлтгэх их, дээд сургуулийг төгсөгчид 100 хувь багшаар ажиллана гэж үзвэл төгсөгчийн тоо тухайн жилд шаардлагатай багшийн эрэлтийг бүрэн хангах боломжтой, гэтэл төгсөгчдийн 33.5 орчим хувь нь багшийн ажилд орж байгаа нь дутагдал үүсгэх шалтгаан болж байна.

Боловсролын салбарын 2024 оны дата аналитик системийн сүүлийн 10 жилийн тооцооллоор одоо зах зээлд 20 орчим мянган багш мэргэжилтэй боловч багшаар ажиллахгүй байгаа иргэд байна. Эдгээр иргэнийг багшийн ажилд татан оролцуулах нь багшийн дутагдлыг нөхөхөд чухал арга хэмжээ юм.

Үүнээс гадна багш нар, тэр дундаа эхний 6-8 жилдээ ажиллаж байгаа залуу багш нарын шилжилт хөдөлгөөн, ажлаас гаралт өндөр байна. Энэ түвшин хэвээр хадгалагдвал дунд болон урт хугацаандаа олон багш дутагдах эрсдэлтэй байна.

Багш мэргэжил эзэмшсэн ч багшаар ажиллахгүй байх, эсвэл багшаар ажилд ороод эхний 6-8 жилдээ ажлаасаа гардаг асуудлууд нь ихэвчлэн багшийн цалин хөлсний хэмжээ, нийгмийн баталгаа бүрэн хангагддаггүй, сургуулийн удирдлага, менежмент сул байдал, эцэг, эх, асран хамгаалагчийн зүгээс ирдэг дарамт, хэт олон хүүхдээс үүдэлтэй багшийн ачаалалтай холбоотой байна.

Дээрх нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах чиглэлээр Засгийн газраас багшийн дутагдлыг нөхөх, чадавхыг сайжруулах “Багшийн гурван тулгуурт бодлого” цогц арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна:

- Боловсролын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд багшийн нийгмийн баталгааг өмнөх жилүүдээс сайжруулж багш мэргэжлээр тасралтгүй 15 жил ажилласан багшийн 740 хүүхдийн дээд боловсролын сургалтын төлбөрт 3.2 тэрбум төгрөг, багш мэргэжлээр суралцаж буй 4,862

оюутанд 15.6 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг үзүүлээ. Ингэхдээ сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг авч суралцсан төгсөгчидтэй төгсөөд дор хаяж таван жил багшаар ажиллах гэрээ байгуулж байна.

- Шинжлэх ухааны чиглэлээр их, дээд сургууль амжилттай төгссөн иргэнийг багшийн ажилд татан оролцуулж, чадварлаг залуу үеийг багш болгох ажлыг эхлүүлээд байна.
- Их, дээд сургуулиа амжилттай төгссөн иргэдийг тодорхой шаардлага хангасан тохиолдолд багшлах эрхийн сургалтад хамруулж, багшийн ажилд гэрээгээр ажиллуулж байна. Энэ оны 3 дугаар сарын сүүлийн мэдээллээр багшлах эрхийн гэрчилгээ олгох сургалтыг 129 багш төгсгөж, 53 багш буюу төгсөгчдийн 41 хувь нь нийслэл болон орон нутгийн ерөнхий боловсролын сургуульд багшаар ажиллаж, Монгол Улсын Боловсролын их сургуульд 35 иргэн сургалтад хамрагдаж байна.
- Сургалтын цагийн норм 19 цагт хүрдэггүй зарим багш нарыг хөрвүүлж, ижил төстэй хичээл заалгах, багш бэлтгэх их, дээд сургуулийн 4 дүгээр ангийн оюутнуудыг дадлагажигч багшаар, мөн тэтгэвэрт гарсан ахмад 916 багшийг цөөн цагаар ажиллуулж байна.
- Багшийн ажлын ачааллыг бууруулах чиглэлээр бага ангийн 44-өөс дээш хүүхэдтэй бүлэгт багшийн туслах ажиллуулах шийдвэр гаргаж, Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн 44-өөс дээш хүүхэдтэй бүлэгт ажиллах багшийн туслахыг Монгол Улсын Боловсролын их сургуулийг түшиглэн сургаж байна.
- Алслагдсан бүс нутгийн сургуулийн багшийн дутагдлыг нөхөх чиглэлээр цахим сургалтыг зохион байгуулж, энэ хичээлийн жилд ахлах ангийн 36,491 хүүхэд алслагдсан байдлаас үл шалтгаалан цахимаар амжилттай суралцах боломжийг бий болгож байна.
- Багш ажил дээрээ тасралтгүй сурч, хөгжих боломжийг дэмжиж, 2024 оны гүйцэтгэлээр цэцэрлэг, сургуулийн багшийн хөгжлийн сургалт, үйл ажиллагаанд зориулан 11.7 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд 2025 онд 13.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан байна.

17 дугаар зураг. Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардлын гүйцэтгэл



- Багш нарын шилжилт хөдөлгөөн, ажлаас гаралтад сургуулийн удирдлага, зохион байгуулалт ихээхэн нөлөө үзүүлдэг. Иймээс сургууль, цэцэрлэгийн менежментийг сайжруулах арга хэмжээг 2023 оноос эхлэн хэрэгжүүлж байна.
- Багшийн мэргэжлийн чадамжийг сайжруулах, тасралтгүй хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор бүсүүдэд “Багшийн хөгжлийг дэмжих төв”-ийг багш бэлтгэх их, дээд сургуулийг түшиглэн байгуулж, үйл ажиллагааг эхлүүлээд байна.

18 дугаар зураг. “Багшийн хөгжлийг дэмжих төв”-ийн үйл ажиллагааны чиглэл



- Багшийн ажлын ачааллыг бууруулах, ээлжит хичээл төлөвлөх хугацааг багасгах зорилгоор багш бүрийг виртуал туслах багштай болгох ажлыг Гүүгл компанитай хамтран эхлүүлж, системийг хөгжүүлж байна.
- Гарааны багшийн стандартыг батлуулж, багш бэлтгэх их, дээд сургуулийг хөтөлбөрийг нийцүүлэх, мөн ажлын байранд гарсан багшийн стандартыг боловсруулж мөрдөнө.

Цаашид багшийн дутагдлыг нөхөх, чадамжийг сайжруулах чиглэлээр багш мэргэжлээр төгссөн боловч багшийн ажил эрхлэхгүй байгаа иргэдийг цэцэрлэг, сургуульд багшаар ажиллуулах, залуу багш нар тогтвор суурьшилтай ажиллахад шаардлагатай дэмжлэг үзүүлэх, ажлын байран дээр тасралтгүй хөгжих боломжийг олгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Багш ажлын байрандаа тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр багшийн нийгмийн баталгааг тэдний ажил, амьдралын тодорхой мөчлөг бүр дэх эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн хангах, цэцэрлэг, сургуулийн удирдлага, зохион байгуулалтын чадавхыг сайжруулах, суралцагч төвтэй соёлыг бий болгох сургууль, цэцэрлэгийн менежментийг сайжруулна.

Мөн багш бэлтгэх тогтолцооны шинэчлэл хийж, багш бэлтгэх, багшийг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагааг багш бэлтгэх их, дээд сургуульд түшиглэн зохион байгуулж, шаардлагатай дэд бүтэц, лаборатори, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөөд байна. Ялангуяа байгалийн ухааны сургалтын чанарыг сайжруулах, хүүхдүүдэд шинжлэх ухаанч ур чадварыг хөгжүүлэхэд багш бэлтгэх их, дээд сургуулийг орчин үеийн лаборатори, тоног төхөөрөмжөөр хангах хөрөнгө оруулалтыг хийх шаардлагатай байна.

Багшийн дутагдал, чанарын асуудал манай улс төдийгүй, дэлхийн орнуудын ч хувьд ч мөн адил тулгамдсан асуудал болж байна. ЮНЕСКО-ийн 2024 онд гаргасан “Багшийн дутагдал ба багш мэргэжлийн хувьсан өөрчлөлт” тайланд 2030 он гэхэд дэлхийн улсуудад 44 сая багш нэмж хэрэгтэй болно гэж дүгнэсэн байна.

2.2 Сургалтын хөтөлбөрийн талаар:

Боловсролын чанарыг хэмждэг чухал хэмжүүр нь иргэдийн эзэмшсэн ур чадвар байдаг. Хүн амын шинийг санаачлах, бүтээх ур чадварыг хөгжүүлснээр шинжлэх ухааны ололт, технологи, инновацийн хөгжилд ахиц гардаг. Үйлдвэрлэл, бүтээн байгуулалтад шинэ технологи, инноваци нэвтрэхийн хэрээр бүтээмж нэмэгдэж, бизнесийн үр ашиг өснө. Цахиурын хөндийн орлогын их өсөлт тухайн бүсийн ерөнхий боловсролын, их, дээд сургуулиудын СТЭМ (шинжлэх ухаан, инженерчлэл, технологи, математик) боловсролд хийсэн хөрөнгө оруулалттай шууд хамааралтай байсан жишээ байдаг.

2024 оноос эхлэн сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын хөтөлбөрийг хүүхэд, залуучуудын инновацийн ур чадвар, англи хэлний чадамжийг хөгжүүлэх, Монголын уламжлал, түүх, соёлын үнэт зүйл, төлөвшилтэй иргэнийг хөгжүүлэх чиглэлээр шинэчилж байна.

Сургалтын хөтөлбөрөөр сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын зорилгод нийцсэн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийн цогц чадамжийг Монгол суралцагчид эзэмшүүлэх бөгөөд чадамж нь дараах суурь болон ерөнхий чадамжаас бүрдэнэ.

2 дугаар хүснэгт. Суурь болон ерөнхий чадамжийн үзүүлэлтүүд

Суурь чадамж	Эх хэл, бичиг үсэг Математик Шинжлэх ухаан (байгалийн ба нийгмийн) Компьютерын ухаан ба цахим технологи Англи хэл болон бусад гадаад хэл Биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал
Ерөнхий чадамж	Бүтээлчээр, шүүн тунгаах сэтгэлгээ Суралцах арга барил Харилцаа, хамтын ажиллагаа Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил Тогтвортой хөгжил Үндэсний болон дэлхийн өв соёл

Боловсролын багц хуулийн шинэчлэлээр Англи хэлийг ерөнхий боловсролд судлах үндсэн гадаад хэл байхаар заасантай холбогдуулан 3 дугаар ангиас эхлэн заах зохицуулалтыг үзэл баримтлалд тусгаж баталсан. Үүний дагуу энэ хичээлийн жилд хот, хөдөөгийн ерөнхий боловсролын 105 сургуулийн 3-4 дүгээр ангид Пийрсон англи хэлний хөтөлбөрийг туршилтаар хэрэгжүүлж байна. 2025 оны 9 дүгээр сараас ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар

ангиас эхлэн Англи хэлийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлнэ. Мөн кодчлол, компьютерийн ухааны хичээлийг хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан бага ангиас эхлэн заахаар төлөвлөж байна.

Засгийн газрын баталсан хөтөлбөрийн үзэл баримтлалын хүрээнд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг 2024 оноос эхлэн шинэчилж эхэлсэн ба 2028 он хүртэл үргэлжлэх юм.

Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн нэг онцлог нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжлөөс гадна нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадвар, үндэсний өв, соёлын талаарх ойлголт, мэдлэгийг хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөж байна. Тухайлбал, сургуулийн өмнөх боловсролоор бага насны хүүхдийн тоо тоолол, хэл яриа, нийгэм сэтгэл хөдлөл, эрүүл мэнд хөдөлгөөний ур чадварыг хөгжүүлж, хөгжим, урлагийн анхан шатны мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ.

Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй зэрэгцүүлэн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг мөн шинэчлэн хэрэгжүүлнэ. Хүүхдийн гэрийн даалгаврын ачааллыг бууруулах зорилгоор дасгал ажлын дэвтрийг албан ёсоор хэрэглэж эхэлнэ. Шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэглэгдэхүүн, лаборатори, тоног төхөөрөмж шаардагдах бөгөөд үүнд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг олон талт байдлаар шийдэх боломжийг судалж байна.


Шинэчилсэн хөтөлбөрийг 2025 оны 9 дүгээр сараас эхлэн сургуулийн өмнөх боловсролд үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхлэх бөгөөд үр дүнд нь бага насны хүүхдийн хөгжлийн индексийн түвшинг 2028 он гэхэд 90 хувьд (2024 онд 86.4 хувь) хүргэж ахиулна.

2.3. Цахим боловсролын талаар:

Боловсролын чанарын ялгааг арилгахад технологийн дэвшлийг ашиглах нь багшлах хүний нөөцөд дэмжлэг болж, мөн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал түлхэц болж байна. Боловсролын салбарт технологийн дэвшлийг нэвтрүүлж, цахим шилжилтийг эхлүүлсэн. Цахим шилжилтийн хүрээнд боловсролын бодлого төлөвлөлтийн их өгөгдөлд суурилсан дата аналитик систем, хиймэл оюун ухаанд суурилсан багшийн туслах, цахим сургууль, сургуулийн менежментийн, сургалтын платформууд, контентын сан, цахим сурах бичиг, үнэлгээг цахимжуулах, блокчэйн технологийг нэвтрүүлэх ажлууд явагдаж байна.


Боловсролын бодлого төлөвлөлтөд их өгөгдөлд суурилсан дата аналитикийг <https://bi.esis.edu.mn/#/projects/47> ашиглах ажлыг 2023 оноос эхлүүлэн өнөөдрийн байдлаар ерөнхий боловсролын салбарын үзүүлэлтийн 80 гаруй хувийг дата аналитикаар тооцоолох боломжтой боллоо.

19 дүгээр зураг. Сургалтын байгууллагын дэд бүтэц



НҮБ-ын Хүүхдийн сангийн ГИГА (GIGA) санаачлагын тусламжтай сургуулиудын интернэт холболтын нөхцөл байдлыг бодит цагийн горимоор хянах боломжтой болсон. 2025 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар нийт сургуулиудын интернэтийн дундаж хурд 53.25Mbps байна.

20 дугаар зураг. Нийт сургуулиудын интернэтийн дундаж хурдын зураглал



Хэдийгээр интернэтийн нөхцөл байдал, хурд жил ирэх тусам сайжирч байгаа ч хүртээмж, ухаалаг хэрэглэгдэхүүний хангалт харилцан адилгүй байна. Тухайлбал мэдээллийн технологи хичээлд шаардлагатай компьютер, тоног төхөөрөмжийн хангалт аймаг бүрт харилцан адилгүй байна.

Боловсролын салбарын цахим шилжилт нь сургалтын байгууллагын алслагдсан байдлыг ойртуулах, багшийн дутагдлыг нөхөх, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгийн хэвлэлтэй холбоотой зардалд хэмнэлт гаргах боломжтой байна. Монгол Улсад 2023 оноос эхлэн хэрэгжүүлж ирсэн “Мэдлэ” цахим сургууль үүний сайн жишээ юм.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН МАТЕРИАЛЛАГ НӨӨЦ

Нийт багцтайгаа
 43,681

Стандарт хангасан багцтайгаа
 26,862

Засвар хяргалттай багцтайгаа
 4,515

Стандарт хангагчтай багцтайгаа
 12,304

Хяналттай багцтайгаа
 50,431

СУРГУУЛИЙН МАТЕРИАЛЛАГ НӨӨЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сургуулийн нэр: Хичээлийн түр: 1-д ангилал:

(АИ) Мэргэлийн төлөөлөгч: (АИ)

Сургуулийн нэр	Хичээлийн түр	1-д ангилал	Засвар хяналттай	Стандарт хангагчтай	Стандарт хангасан	Хяналттай
Сургуулийн нэр	Хичээлийн түр	1-д ангилал	Засвар хяналттай	Стандарт хангагчтай	Стандарт хангасан	Хяналттай
Хүтэлтэй аймаг	Мэргэлийн төлөөлөгч	Ангилал	0.0	0.0	1.0	201.0
Батдун сумын Бүрх	Мэргэлийн төлөөлөгч	Техник хяналттай	1.0	0.0	12.0	18.0
Увс сумын Бүрх	Мэргэлийн төлөөлөгч	Техник хяналттай	0.0	0.0	77.0	74.0
Хүтэлтэй аймаг	Мэргэлийн төлөөлөгч	Техник хяналттай	2.0	5.0	6.0	35.0
Батдун сумын Бүрх	Мэргэлийн төлөөлөгч	Техник хяналттай	0.0	0.0	15.0	202.0
Увс сумын Бүрх	Мэргэлийн төлөөлөгч	Техник хяналттай	0.0	0.0	0.0	24.0

22 дугаар зураг. “Мэдлэ” цахим ахлах сургуулийн суралцагчдын тоо


22 дугаар зураг. “Мэдлэ” цахим ахлах сургуулийн суралцагчдын тоо



Ерөнхий боловсролын байгалийн ухааны сургалтад цахим сургалтын платформ, “Мэдлэ” контентын сан, цахим сурах бичиг, хөдөлгөөнт үзүүлэн, онлайн гэрийн даалгавар, олон мянган сонирхолтой интерактив агуулга (3D үзэгдэл, сургалтын хэрэгсэл, видео, дасгалууд) бүхий үр дүнтэй ангид хэрэглэх үзүүлэнгийн, мөн суралцагчид гэртээ сурах, давтахдаа ашиглаж болох программ хангамжийг <https://www.mozaweb.com/mn/> ашиглаж эхлээд байна.

94

23 дугаар зураг. Ерөнхий боловсролын бага ангийн интерактив сурах бичгийн агуулга, дасгалын загвар



Ерөнхий боловсролын бага ангийн 33 сурах бичгийн агуулга, дасгал, даалгаврыг интерактив болгож, 13.5 мянга орчим дасгал, даалгаврын сантай бүрдүүлсэн. Цахим шилжилттэй холбоотой тулгамдаж буй нэг асуудал нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдал, хэрэглээ байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан Засгийн газраас “Нийгмийн сүлжээ /social media/-нд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль”-ийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барихаар ажиллаж байна.

Цаашид өндөр хурдны интернэт холболтыг бүх анги танхимд хүргэх, эх хэл дээр (Монгол, казах, тува, дохионы хэл) цахим контентыг нэмж хөгжүүлэх, цахим сургууль, цахим сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд гадаад дахь Монгол хүүхдүүд цахимаар ерөнхий боловсрол эзэмших, эх хэл, соёлын цахим сургалт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд цахимаар суралцах, боловсрол нөхөн эзэмшүүлэх цахим сургалт гэх мэт арга хэмжээг төлөвлөөд байна.

Боловсролыг дэмжих жилийн хүрээнд хүүхэд бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран сурах, тэд хамгийн сайн хичээлд суух, хамгийн сайн багшаар заалгах боломжийг нэмэгдүүлэхийн тулд багш бүрийг, хүүхэд бүрийг өндөр хурдны интернэт бүхий орчин, ухаалаг хэрэгсэл ашиглан сурах боломжоор хангах, эх хэл дээрх цахим контентыг нэмэгдүүлэх, хиймэл оюун ухаанд суурилсан дата аналитик системийг бүх түвшинд хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Ингэснээр боловсролын үр нөлөө нэмэгдэж, хот, хөдөөгийн боловсролын чанарыг ялгааг бууруулах, хүүхэд бүр өөрийн онцлогтоо тохируулан сурах боломж бүрдэх бөгөөд дунд, урт хугацаандаа боловсролын индексийн түвшинг ахиулах юм.

2.4. Боловсролын үнэлгээний талаар:

Боловсролд зарцуулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн үр дүн болон сургалт, үйл ажиллагааны гүйцэтгэл, чанарыг үнэлэх үнэлгээ нь Боловсролын багц хуулийн нэг шинэчлэл юм. Шинэчилсэн хуулиар боловсролын чанарыг

олон улсын болон үндэсний түвшинд үнэлэхээр тусгасантай холбогдуулан 2022 онд Монгол Улс анх удаа олон улсын сурлагын амжилтын үнэлгээ ПИСА-д хамрагдсан. Энэ нь Монгол Улсын суурь боловсролын чанарыг дэлхийн 81 улстай харьцуулж дүгнэхэд чухал алхам болсон.

Харин үндэсний түвшинд сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын чанарыг 2023 онд үнэлж, үр дүнг олон нийтэд танилцуулсан.

3 дугаар хүснэгт. Үндэсний түвшинд сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын чанарыгн үнэлгээ, 2023 оноор

Эрэмбэ	Сургалтын байгууллагын нэр	Нийт оноо	Сургалт	Эрдэм шинжилгээ	Гадаад харилцаа	Орлог үйлчилгээ
1	МУИС /Монгол улсын их сургууль/	83.5%	94% Дэлгэрэнгүй	91% Дэлгэрэнгүй	41% Дэлгэрэнгүй	73% Дэлгэрэнгүй
2	АШУУИС /Ангалзхын шинжлэх ухааны үндэсний их сургууль/	75.4%	86% Дэлгэрэнгүй	65% Дэлгэрэнгүй	50% Дэлгэрэнгүй	83% Дэлгэрэнгүй
3	ШУТИС /Шинжлэх ухаан технологийн их сургууль/	71.8%	82% Дэлгэрэнгүй	66% Дэлгэрэнгүй	30% Дэлгэрэнгүй	81% Дэлгэрэнгүй
4	МУБИС /Монгол улсын боловсролын их сургууль/	65.6%	82% Дэлгэрэнгүй	41% Дэлгэрэнгүй	37% Дэлгэрэнгүй	83% Дэлгэрэнгүй
5	ХААИС /Хадгас аж ахуйн их сургууль/	60.2%	72% Дэлгэрэнгүй	40% Дэлгэрэнгүй	30% Дэлгэрэнгүй	82% Дэлгэрэнгүй
6	Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль	56.1%	59% Дэлгэрэнгүй	48% Дэлгэрэнгүй	40% Дэлгэрэнгүй	70% Дэлгэрэнгүй
7	Санхүү, эдийн засгийн их сургууль	52.3%	84% Дэлгэрэнгүй	10% Дэлгэрэнгүй	30% Дэлгэрэнгүй	64% Дэлгэрэнгүй

Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансааг 2023-2024 онд олон улсын *Times Higher Education* байгууллагатай хамтран үнэлж, үр дүнг олон нийтэд нээлттэй зарласан нь их, дээд сургуулийн ангилал, чанарт чухал дүгнэлт байлаа. Үнэлгээг цаашид тогтвортой, ямар нэг субъектив нөлөөлөлгүй хийхэд дээд боловсролын өгөгдөл, мэдээллийн системийг хөгжүүлэх, дата мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, цахимжуулах шаардлагатай байна.

Мөн олон улсын дээд боловсролын үнэлгээгээр Times Higher Education 2025 оны дэлхийн их сургуулиудын чансаанд нийт 2092 их сургууль багтсан байна. Эдгээр нь дэлхийн 115 улс, бүс нутгийг хамарсан бөгөөд нийт 2860 их сургууль мэдээлэл ирүүлснээс шалгуурыг хангаж, чансаанд багтсан тоо юм.

Монгол Улсын Их Сургууль 1501 дүгээр байрт жагссан нь дэлхийн хэмжээнд судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2,092 их сургуулийн дунд багтсан чухал амжилт юм.

2022 оноос эхлэн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн шинэчлэлээр цэцэрлэг, сургуулийн багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг хэрэгжүүлж байна. Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн багшийн мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, сургалтын байгууллагын менежментийг сайжруулах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн.

Гүйцэтгэлийн үнэлгээнд 1-4 дүгээр түвшинд эрэмбэлэгдсэн багш нарт үндсэн цалингийн 15-40 хувийн нэмэгдлийг сар бүр тооцож, улирал бүр олгож байна. Багшийн болон байгууллагын 2022-2024 онд хийгдсэн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд тогтмол ахиц гарч байна. Тухайлбал, 2023 онд сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж 74.5 хувь байсан бол 2024 онд 78.6 хувь болж өссөн байна. Цэцэрлэг, сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн 2022-2024 онд нийт 52.9 мянган багшид 111.0 тэрбум төгрөгийн урамшуулал олгоод байна.

4 дүгээр хүснэгт. Цэцэрлэг, сургуулийн багшийн үнэлгээ, 2022-2024

№	Цэцэрлэгийн багшийн үнэлгээ	Багшийн тоо	Урамшуулалд зарцуулсан мөнгөн дүн	№	ЕБС-ийн багшийн үнэлгээ	Багшийн тоо	Урамшуулалд зарцуулсан мөнгөн дүн
1	2022 он	2906	3,238,814.0	1	2022 он	12296	14,543,753.7
2	2023 он	3279	5,663,394.4	2	2023 он	14623	24,382,121.4
3	2024 он	3560	11,694,986.0	3	2024 он	16242	51,745,886.5
НИЙТ		9745	20,597,295.2	НИЙТ		43161	90,671,761.6

2025 оны 2-3 дугаар сард анх удаа мэргэжлийн боловсролын сургууль болон политехник коллежийн сургалт, үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэллээ. Цаашид гүйцэтгэлийн үнэлгээний зохион байгуулалт, даалгавар боловсруулалтад гарч буй асуудлыг шийдвэрлэх, хүнээс хамаарсан нөлөөллийг багасгах зорилгоор үнэлгээг бүхэлд нь цахимжуулж эхлээд байна. Үүнтэй холбогдуулан сургууль, цэцэрлэгийг цахим хэрэглэгдэхүүнээр хангах, интернэтийн хурдыг нэмэгдүүлэх, серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Түүнчлэн 2024 оноос эхлэн хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрийн шинэчлэлээр хөтөлбөрт хүүхдийн нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг хөгжүүлэх агуулгыг тусгаж байгаатай уялдуулан зөөлөн ур чадварын үнэлгээг нэвтрүүлнэ.

Гурав. Хүний нөөцийн шилжилтийн талаар:

“Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд салбар болон бүс, орон нутгийн хэмжээнд нэгдүгээрт, цахимжуулалт, хиймэл оюун ухаан, технологийн шилжилт, хоёрдугаарт, ногоон шилжилт, гуравдугаарт, хүний нөөцийн шилжилт хийх чиглэлээр стратеги, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Хүний нөөцийн шилжилт нь иргэдийн хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлт гаргах зорилготой юм. Хөдөлмөрийн бүтээмжийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг багасгах, иргэдийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар нэмэгдүүлнэ.

Статистик мэдээллээр (2024 он) барилга, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний эрэлт хамгийн өндөр байсан байна. Нийлүүлэлт талаас нь үзвэл, 2024-2025 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн 40,906 суралцагчдын 59.9 хувь нь инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж, 20.5 хувь нь үйлчилгээний мэргэжлээр суралцаж байна.

Мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг 2023 онд төгссөн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт нь нэг жилийн дараа буюу 2024 оны 12 дугаар сарын байдлаар нийт төгсөгчдийн 62.3 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж, 16.8 хувь нь дараагийн боловсролын түвшинд элсэн суралцсан байна. 2023 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт өмнөх хичээлийн жилийн хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдөөс 3 хувиар өссөн байна.

24 дүгээр зураг. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, хөтөлбөрөөр, хүйсээр, 2024-2025 оны хичээлийн жилийн эхний хагас жилд



Харин их, дээд сургуулийн 150,282 суралцагчдын 26.3 хувь нь бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн, 17.8 хувь нь эрүүл мэнд, нийгмийн халамж, 13 хувь нь инженер, үйлдвэрлэл, барилгын мэргэжлээр суралцаж байна.


Зээлийн сангийн тэтгэлэг, буцалтгүй тусламжид хамрагдсан суралцагчдын ихэнх нь санхүү, хууль, эрх зүй, эрүүл мэнд, бизнесийн удирдлагын мэргэжлээр суралцаж байна.

5 дугаар хүснэгт. Нийт суралцагчид, боловсролын түвшин, мэргэжлийн ерөнхий чиглэлээр, 2024-2025

Мэргэжлийн ерөнхий чиглэл	Нийт суралцагчид	Дипломын боловсрол	Бакалаврын боловсрол	Магистрын боловсрол	Докторын боловсрол
Нийт суралцагчид	150,282	2,620	117,344	24,830	5,488
Боловсрол	19,933	-	13,897	4,939	1,097
Урлаг, хүмүүнлэг	11,667	-	9,543	1,077	1,047
Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	10,485	-	8,643	1,384	458
Бизнес, удирдахуй, хууль, эрх зүй	39,561	-	28,110	10,141	1,310
Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	3,775	-	2,727	724	324
Мэдээлэл, харилцааны технологи	7,783	26	7,334	384	39
Инженер, үйлдвэрлэл, барилга угсралт	19,490	182	17,800	1,339	169
Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг	2,127	-	1,281	662	184
Эрүүл мэнд, нийгмийн халамж	26,775	2,412	20,642	3,362	359
Үйлчилгээ	7,978	-	6,659	818	501
Ерөнхий суурь хөтөлбөр	708		708	-	-

Цаашид 2030 он хүртэл хөдөлмөрийн зах зээлд 69.9 мянган мэргэжилтэн шаардлагатай болох тооцоолол байгаа бөгөөд ихэвчлэн ус хангамж, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн салбарт эрэлттэй байхаар байна. Үүний дагуу эрэлттэй мэргэжлийн хөтөлбөрт суралцагчийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллана.

25 дугаар зураг. Эрэлттэй мэргэжлийн хөтөлбөрт хамрагдсан хүний тоо, мэргэжлээр



Түүнчлэн Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан МЕГА төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр 165 хөтөлбөрийг 23 их, дээд сургууль хэрэгжүүлж байна. 2024-2025 оны хичээлийн жилд МЕГА төслүүд дээр ажиллах боломжтой 5.3 мянган суралцагч 44 хөтөлбөрөөр суралцаж байна.

6 дугаар хүснэгт. 14 МЕГА төсөл дээр ажиллах боломжтой хөтөлбөрөөр суралцагчид, сүүлийн 5 жилд

Боловсролын түр, Хөтөлбөрийн нэр		Хичээлийн Жил					
Нийт		Нийт	2020-2021	2021-2022	2022-2023	2023-2024	2024-2025
Бакалавр	Нийт	21,664	3,525	3,796	4,141	4,810	5,392
		18,299	2,868	3,085	3,459	4,132	4,755
	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	1,259	289	281	205	228	256
	Ашигт малтмалын эрэл хайгуул	49	1	1	6	16	26
	Биотехнологи	982	168	154	162	242	256
	Биохими	355	63	65	60	85	82
	Газрын тос боловсруулах үйлдвэрийн инже...	73			17	21	35
	Газрын тосны боловсруулалтын технологи	10					10
	Газрын тосны инженер	704	172	157	144	125	106
	Дулаан хангамжийн инженерчлэл	19					19
	Дулааны процессын автоматжуулалт	121			28	35	58
	Дулааны цахилгаан станцын инженерчлэл	547			128	163	256
	Металлурги, металлын технологи	224	15	21	26	52	110
	Робот ба хиймэл оюун ухаан	274		44	68	87	75
	Сэргэгдэх эрчим хүч	2,220	478	441	401	415	485
	Төмөр замны цахилгаан холбоо, телемехан...	407	104	108	101	68	26
	Төмөр замын автоматик ба телемеханик, х...	134				57	77

Цаашид мэргэжилтэй ажилтанг богино хугацаанд бэлтгэх зорилгоор мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид ажлын байр болон анги танхимын хосмог сургалтыг хэрэгжүүлнэ. 2024-2025 оны хичээлийн жилд таван политехник коллежид уул уурхай, эрчим хүч, барилгын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй хамтран 149 иргэнийг хосмог сургалтаар бэлтгэж байна. Ирэх хичээлийн жилээс эрэлттэй байгаа мэргэжлээр олон иргэнийг сургана.

Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоонд тулгамдаж буй нэг асуудал нь ур чадварын зөрүүтэй байдал. Ур чадварын зөрүүг арилгахад нэг талаас ажил олгогч, нөгөө талаас боловсролын сургалтын байгууллагын хамтын ажиллагаа чухал.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам хамтран мэргэжил бүр дээр шаардагдах ур чадвар болон сургалтын байгууллагад эзэмшүүлэх ур чадварын нийцлийг хангах салбар дундын цахим системийг хөгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

26 дугаар зураг. Ур чадварын нийцлийг хангах салбар дундын цахим системийн хөгжүүлэлт




Монгол Улсын их, дээд сургуулиуд судалгаанд суурилсан сургалт хязгаарлагдмал, судалгаа, хөгжүүлэлтийн хүний болон материаллаг нөөц сул, судалгаа, хөгжүүлэлтийн санхүүжилтийн тогтолцоо бүрдээгүй, төгсөлтийн дараах сургалтад олгох санхүүгийн дэмжлэг хангалтгүй гэх мэт бэрхшээлтэй тулгардаг. Үүнээс улбаалан их, дээд сургууль болон судалгааны хүрээлэн, үйлдвэрлэл, бизнесийн хамтын ажиллагаа, түншлэл сул, технологи дамжуулалт, инноваци нэвтрэлт хангалттай түвшинд хийгддэггүй. Энэ нь тэдний эдийн засаг дахь оролцоог сулруулж байна.

Их, дээд сургуулийн судалгааны чадавхыг бэхжүүлж, судалгааны их сургуулийг хөгжүүлэх нь урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын тэргүүлэх зорилтуудын нэг юм. Судалгааны их сургуулийг байгуулж, хөгжүүлэх чиглэлээр олон улсын донор байгууллагатай хамтран ажиллаж, суурь судалгаануудыг хийж, сургууль байгуулах тухай эрх зүйн зохицуулалтыг Дээд боловсролын тухай хуульд тусгаж батлуулсан. Үүний дагуу судалгааны их сургуулийг байгуулж, үе шаттай хөгжүүлэхэд эхний ээлжинд 30.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай ба эх үүсвэрийг Азийн хөгжлийн банктэй зөвшилцөж байна.

Ур чадварын зөрүүгээс гадна хиймэл оюун, технологи, инновацийн нэвтрэлт хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байранд хувьсал, өөрчлөлтийг бий болгож байна.

7 дугаар хүснэгт. YAMAT дахь ажлын байрны технологийн нөлөөгөөр өөрчлөгдөх хувь



Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хийсэн дүн шинжилгээгээр ирээдүйд гараар гүйцэтгэдэг ажил технологийн нөлөөгөөр байхгүй болох эсвэл хиймэл оюун ухаан орлохоор байна. Нөгөө талаас ногоон шилжилтийн нөлөөгөөр ногоон ур чадварын эрэлт өсөх болно. Хиймэл оюун ухаан, технологи, ногоон шилжилт бүхий ажлын байрууд шинээр үүсэх хандлагатай байгаа тул мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрт энэ чиглэлийн агуулга, үр дүнг тусгах, иргэдэд шинэ ур чадвар эзэмших, тасралтгүй суралцах боломжийг бий болгох нь салбар дундын, тэргүүлэх зорилт байна.

Боловсролын тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх, чанар, үр дүнг сайжруулах, хүний нөөцийн шилжилтийг хэрэгжүүлэх “Боловсролыг дэмжих жил”-ийн хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэх, бодлогын арга хэмжээнд шаардагдах хөрөнгө оруулалт, төсвийн эх үүсвэрийг бий болгоход бүх талын дэмжлэг, хамтын ажиллагаа чухал юм.

Цаашид дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын хүрээ, эх үүсвэрийг тодорхойлж, санхүүжилтийн эх үүсвэрийг олон улсын хөгжлийн донор байгууллага болон үндэсний томоохон аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагатай хамтран шийдэхээр ажиллаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

--oOo--

2025 ОНЫ 5 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД “БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ХҮҮХЭД БҮРД СУРАЛЦАХ ТЭГШ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ”-НИЙ ТАЛААР ХИЙСЭН МЭДЭЭЛЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, тус яамны Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Дээд боловсролын газрын дарга Ж. Ариунболд, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Тамираа, Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адьяасүрэн, Боловсролын зээлийн сангийн дарга О.Сийлэгмаа, Нийслэлийн боловсролын газрын дарга Б.Амартүвшин, Боловсролын үнэлгээний төвийн дарга Г.Гантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Тамгын газрын тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа”-ны талаар мэдээлэл хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу цөөнхийн төлөөллөөс Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, ХҮН намыг төлөөлж Б.Мөнхсоёл, Үндэсний эвслийг төлөөлж А.Ундраа, Иргэний Зориг Ногоон намыг төлөөлж Б.Батбаатар нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, С.Эрдэнэболд, Ц.Мөнхтуяа нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-д заасны дагуу цахим хуудсанд 14 иргэнээс ирүүлсэн 22 асуулыг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах нар асууж, хариулт авав.

Д.Амарбаясгалан: - Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

Одонгийн Цогтгэрэл гишүүнийг индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдын боловсролын салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын талаар танилцуулсан мэдээлэлд үндэслэн Улсын Их Хурал дахь АНын бүлгээс дараах дүгнэлтийг танилцуулж байна. 2025 оны төсөвт боловсролын салбарт 4,5 их наяд төгрөг буюу нийт Монгол Улсын нийт төсвийн 20 хувийг зарцуулахаар тусгасан нь 2021 оноос хойш 2,5 дахин өссөн дүнтэй үзүүлэлт гарсан хэдий ч боловсролын чанарт дорвитой ахиц дэвшил авчирсангүй. Хөрөнгө оруулалт нь оновчгүй хуваарилагдаж, удирдлагын бодлого тодорхой бус байсаар байна. Өнөөдрийн байдлаар ерөнхий боловсролын сургуулиудын 66 хувь нь 2 ээлжээр хичээллэж, хот, хөдөөгийн боловсролын хүүхдийн ялгаа улам их гүнзгийрсэн байдалтай байна.

Хот байгуулалт, газар зохион байгуулалтын бодлогод сургуулийн газрын асуудал тусгагддаггүй нь ирээдүйн боловсролын хүртээмжид эрсдэл учруулж байна. Сургуулийн зориулалттай газрыг өөр зориулалтаар ашиглах явдал байсаар байгаагаас сургууль, цэцэрлэгүүдийг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан барьж байгуулах нөхцөл бүрдээгүй хэвээр байна. Сурагчдын эрүүл өсөлтийн суурь нь зохистой хоол тэжээл бөгөөд сургуулийн үдийн хоолны чанарыг сайжруулах бодлого, зохион байгуулалт хангалтгүй байгаагаас бага, дунд ангийн сурагчдын хоолны чанар шаардлагад нийцэхгүй байгаа гомдол тасрахгүй байна. Багшийн дутагдлыг арилгах зорилгоор олон жил ярьсан ч үр дүнтэй бодлого хэрэгжээгүй. Тэтгэлгээр багш бэлтгэх хөтөлбөрүүдийн үр дүн хангалтгүй. Төгсөгчдийн 2/3 нь багшийн мэргэжлээр ажиллахгүй байна. Энэ нь багшийн цалин хөлс, өрсөлдөх чадваргүй, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангалтгүй байгаатай холбоотой.

Сүүлийн жилүүдэд бага ангийн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх ажлыг эхлүүлсэн ч 3-5 дугаар ангийн хөтөлбөрийн шинэчлэл зогсож, хэрэгжих боломжгүй байдалтай байна. Боловсролын салбарт шинэчлэлт хийгдээгүй, бодлогын тодорхойгүй байдал үргэлжилж байгааг илтгэнэ. 2024 онд нийтлэгдсэн ПИСА үнэлгээнд Монголын сурагчдын 66 хувь нь уншсан зүйлээ бүрэн ойлгох чадамжгүй, 51 хувь нь математикийн анхан шатын түвшнээс доогуур үнэлгээ авчээ. Байгалийн ухаанд 0.2 хувь нь ахисан түвшний ойлголттой байгаа нь суурь боловсрол бүхэлдээ хямралд орсныг харуулж байна. Энэ үнэлгээ манай улсын боловсрол дэлхийн түвшинд хаана явааг харуулсан ч Засгийн газраас тодорхой бодит шинэчлэлт хийгдээгүй хэвээр байна. ЮНЕСКО-гийн 2019 онд Монголын боловсролын системд хийсэн үнэлгээнд дурдахдаа хэсэгчлэн өөрчлөлт хийх нь үр дүнгүй, эрс шинэчлэл явуулах шаардлагатай, үгүй бол том сорилтуудтай нүүр тулна гэж анхааруулсан. Мөн тус байгууллага Монголын боловсрол өрсөлдөөнт эдийн засгийн хэрэгцээг хангаж чадахгүй байна гэсэн дүгнэлт нь өнөөдрийн хөдөлмөрийн зах зээл дээр ил тодоор илэрч байна. Ийм нөхцөлд боловсролын суурь асуудлыг зөвтгөх бус, эрс шинэчлэх шаардлагатай байна. Бодлогын уялдаа, сургалтын чанар, багшийн ур чадвар, удирдлагын хариуцлагыг цогцоор нь сайжруулах цогц бодлогыг эрх баригчдаас бодит байдал шаардаж байгааг сануулъя. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл үг хэлнэ. Индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: Юуны өмнө Боловсролын сайд П.Наранбаярт энэ жилийг боловсролын жил болгож зарласантай холбогдуулаад олон шинэ ажлыг санаачлаад, хүүхэд бүрд боловсрол зайнаас үл хамааран чанартай боловсрол, сургалт, сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр олон ажил санаачилж хийж байгаад талархаж явдгаа үүгээр хэлье.

Ерөнхий сайдын мэдэгдэлтэй холбогдуулаад хэд хэдэн асуудлыг хөндөх ёстой юм болов уу гэж бодож байна. Саяын танилцуулсан мэдээлэлд 2026-2028 онд улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 108 сургууль, 95 цэцэрлэг шинээр барина гэж гарлаа. Үүнд 2,8 их наяд төгрөгийг хөрөнгө оруулалтад зарцуулахаар төлөвлөж байна. 2025 онд төсвийн тухай хуульд нийт хөрөнгийн зардал 3,5 их наяд төгрөг, үүнээс Боловсролын сайдын төсвийн багцад хөрөнгийн зардал 472.7 тэрбум төгрөг байхаар батлагдсан. Энэ их хэмжээний хөрөнгө оруулалт бусад салбарын хөрөнгө оруулалтыг шахах вий, бусад салбарын зайлшгүй хөрөнгө оруулалт хойшлогдож, санхүүжилтгүй төсөл, арга хэмжээний тоо нэмэгдэж, үнэ цэнээ алдах вий гэсэн болгоомжлол байна. Миний бие төсөв цаглаврын ажлын хэсэгт байгаа. Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл бодож санаачлахаар бэлдэж байна. Үүнтэйгээ холбогдуулаад асуудал хөндөж хэлмээр байгаа юм. Төлөвлөлтийг бодитоор хийх шаардлага байгаа учраас улсын төсөв, нийслэлийн төсвөөс хэдэн төгрөг зарцуулагдах, эх үүсвэр юунаас гарах вэ гэдгийг нарийн бодитой төлөвлөх шаардлага байна.

Хоёрдугаарт, дээд боловсролын чанартай холбогдуулан асуудал хөндмөөр байна. 2007 оноос хойш их, дээд сургуульд элсэгчдийн тоо нэмэгдэхээр байгаа. Гэтэл манай дээд боловсролын чанаргүй байгаа тухай олон жил яригдсаар байгаа боловч саяын хийсэн Ерөнхий сайдын мэдээлэлд дээд боловсролын чанарыг сайжруулахтай холбоотой дорвитой шийдлийг хангалттай хөндөж чадсангүй. Тэгэхээр дээд боловсролын салбарт реформын шинжтэй олон өөрчлөлт хэрэгтэй байна. Ганцхан жишээ дурдахад хувийн цэцэрлэг, сургуулийн жилийн төлбөрөөс хэд дахин бага хэмжээний төлбөртэй учраас их, дээд сургуулиудаас чанарын тухай ярих, чадвартай боловсон хүчин татах боломж хомс байна гэдгийг хэлмээр байна.

Гуравдугаарт, хөндмөөр байгаа өөр нэг асуудал бол мэргэжил, техникийн боловсрол, сургалтын салбарын асуудал байгаа. Шинэ сэргэлтийн бодлого МЕГА төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах хүчнийг бэлтгэх чухал салбар мөн. Тэгэхээр энэ салбар олон жил гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төсөл хөтөлбөрөөр урагшилж эхэлсэн. Өөрөөр хэлбэл Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль /ГМТИС/ байна. Мөн 2 жилийн хугацаатай сургалт явуулдаг Коосэн сургалтын хөтөлбөр гэж байна. Үүнээс гадна дотоодын боломж нөөц, төлөвлөлт стратеги, алсын хараагаа юу гэж тодорхойлсон бол. Энэ тал дээр анхаарч ажилламаар байна гэж асуудал хөндмөөр байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа Цөөнхийн төлөөлөл Агваанлуvsангийн Ундраа гишүүн үг хэлнэ, индэрт урьж байна.

А.Ундраа: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. Ерөнхий сайдын хийх мэдээллийг Шадар сайд уншиж танилцууллаа. Энэ мэдээлэлтэй уншиж бас сонсож танилцаад дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурал дахь Үндэсний эвслийн зүгээс гаргаж байна. Ерөнхий сайдын мэдээллээс үзэхэд бэлдсэн үг зөвхөн албан боловсролын тэр дундаа сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд боловсролын хүрээнд асуудлыг хөндөж тавьсан байна. Мэдээж боловсролын шатлалд бага, дунд боловсрол эзэмших явдал өсвөр насны хүүхдийн асуудал, хүүхдийн үдийн хоолны асуудал, сургууль, соёлын, засвар үйлчилгээний асуудал, байр хүртээмжийн асуудал нэн чухал. Харин үүнээс гадна анхаарал хандуулах шаардлагатай хэд хэдэн асуудлын талаар хөндөж хэдэн үг хэлье.

Нэгдүгээрт, Монгол Улсын хувьд үйлдвэржих зорилгын хүрээнд олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилт тавьж буй энэ цаг хугацаанд Монгол Улсын дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын түвшний сургалтын чанар, хамрагдалт, төгсөгчдийн ажлын олдоц, мэргэжлээрээ ажиллах боломж, хүсэл сонирхолд анхаарал хандуулж, чанартай боловсрол эзэмшсэн, чадварлаг мэргэжилтний шинэ үеийг бий болгох бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг анхаармаар байна. Үйлдвэржилтийн бодлого, хүний нөөцийн бодлого, боловсролын бодлогын хоорондын уялдаа холбоог сайжруулж, ажлын талбар дээр шаардлагатай байгаа мэргэжлээр хүүхэд, залуучуудыг суралцуулдаг бодлого руу шилжихгүй бол чухал мэргэжлээр тэр дундаа шинжлэх ухааны тулгуур мэргэжил эзэмшсэн салбарын цөөн хэдэн залуу эрдэмтэд гадагш дүрвэж байна. Жишээлэхэд хавдрын эмчилгээний доз /dose/ бодох физикч байхгүй байгаа. Хөдөө орон нутагт математик, физик, хими, биологи, заах багш байхгүй. Үйлдвэрүүдэд техник, технологийн чиглэлээр багаж, тоног төхөөрөмжийн дизайн шинээр хийх нь битгий хэл байгаа тоног төхөөрөмжийнхөө тохиргоог хийх, “calibration” хийх мэргэжилтэн байхгүй, шинэ төгсөгч ажилд олдохгүй, олдсон мэргэжилтнүүдээ ажлын байран дээр дахин сургах, үйлдвэрүүд, бизнес эрхлэгчид өндөр өртгөөр мэргэжилтнээ өөрсдөө бэлтгэх давхар зардлын дарамтад орж байгааг анхаармаар байна. Энэ нь боловсролын бодлого алдагдсаны тод жишээ. Өнөөдөр Монгол Улсад боловсролын бодлого, философи нь тодорхой тогтоогүй байгааг харуулж байна.

Хоёрдугаарт, боловсролын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүд зарим үед хэрэглээний шинжлэх ухаан, суурь шинжлэх ухааны ялгааг ч мэдэхгүй байна. Энэ нь боловсролын салбарын хөгжлийн тушааг холоос хайх хэрэггүй гэдгийг харуулж байна. Засгийн газраас энэ жилийг боловсролын жил болгон зарласан. Угтаа боловсролын бус жил гэж байх ёсгүй бөгөөд жил бүр боловсролын жил байх учиртай төдийгүй Монгол Улсын хамгийн том, хамгийн тэргүүн зэргийн МЕГА төсөл бол хүүхэд бүрийг нэг ээлжээр хичээллэдэг чанартай сургалттай сургуульд боловсрол эзэмших боломжоор хангах учиртай юм.

Өнөөдөр өгөгдсөн тоон мэдээлэл дунд өнгөц дүгнэлтүүд цөөнгүй байна. 2 ээлжээр хичээллэж байгаа гэдэг баримтуудын цаана ганцхан жишээ дурдахад Баянгол дүүргийн 141 дүгээр сургууль дээр бодит хүчин чадал нь 960 хүүхэдтэй сургууль одоогоор 4,200 хүүхэдтэй хичээллэж байна. Төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийн тайланг хангалттай сайн харагдуулахын тулд коридор,

багш нарын өрөө, номын сан гээд боломжит бүх газраа хана босгож хичээлийн анги танхим байгуулсан. Тэгсэн хэдий ч багтахгүй, зарим хичээл цахим хэлбэрээр нэр төдий додомдож байгаа нөхцөл байдал үүсээд байна. Түүнчлэн хүүхдийн бие бялдрын хөгжлийн чухал хичээл болох биеийн тамирын хичээлийг нэг зааланд 4-5 анги нэгэн зэрэг давхцан орж байгаа нь хүүхдүүдээ хөгжүүлэхээр сургаж байгаа юу, сургууль байгуулж байгаа юу, эсвэл 2 ээлжээр хичээллэж байгаа гэсэн нэр зүүх гэж ажиллаж байна уу гэдгийг асуух нөхцөл үүсээд байгааг харуулж байна.

Гуравдугаарт, төгсөгчдийн мэргэжлийн ур чадвар, иргэний төлөвшил, ёс суртахууны хүмүүжлийн байдлыг сайжруулж, хариуцлагатай, санаачилгатай ажиллах, ачаалал даах төлөвшилтэй төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл өгүүлж байна. Их, дээд сургуулиудын хөтөлбөрт шинэчлэл хийх шаардлагатай байна. Онол практикийг хослуулсан хөтөлбөрөөр төгсөгчдийг ирээдүйн ажилд нь бэлддэг үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагууд их сургуулиудтай судалгаа шинжилгээ хамтран ажилладаг тогтолцоог бүрдүүлж, ойрын ирээдүйд их, дээд сургуулиудын орлогын эх үүсвэрийг солонгоруулж, санхүүжилтийн зарим хэсгийг төрөөс гаргадаг бол судалгаа шинжилгээнээс бусад орлогын эх үүсвэрээ бүрдүүлж чаддаг судалгааны их сургуулиудтай болгох зорилтыг тавьж ажиллах цаг хэдийн болсон байна. Аливаа улсын хөгжлийн цөм нь их, дээд сургуулийн судалгаа шинжилгээ, түүнийг тойрсон ажлууд дээр үндэслэдэг байх нь чухал бөгөөд цаашдаа Шинжлэх ухааны академийн судалгааны хэсгийг их, дээд сургуулиудтай нийлүүлж, судалгааны хүрээлэнгийн хэлбэрээр хүчирхэгжүүлэх шаардлагатай байна гэдгийг энэ нөхцөл харуулж байна.

Дөрөвдүгээрт, ажиллагсдын суралцах эрэлт хэрэгцээнд нийцсэн насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна. Тасралтгүй суралцаж мэргэжил эзэмших, хөрвөх бололцоо бүрдүүлэх, их, дээд сургуульд бакалаврын зэрэг аваад цаашдаа насан туршдаа тэр мэргэжлээрээ ажилладаг цаг үе өөрчлөгдөж байна. Үүнд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут сунгаж өгье.

А.Ундраа: Боловсролын судалгааг зөвхөн сургууль доторх сургалтын хүрээний асуудалд чиглүүлдэгийг өргөжүүлж, төгсөлтийн дараах шатын боловсрол, эдийн засгийн өсөлт, боловсрол, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн гэмт хэрэг, боловсрол гэр бүл төлөвлөлт зэргээр боловсрол судлалын ахисан түвшний асуудлуудад анхаарч судалгааг санхүүжүүлэх зэрэг асуудлуудыг хөндөх хэрэгтэй байна. Ерөнхий сайдын мэдээллээс үүн дээр одоогоор хариулт олж харсангүй. Үндэсний эвслийн зүгээс боловсролын салбарын бодлогын судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд цаашдаа боловсролын философитой болох, дүн шинжилгээнд суурилсан бүтээлч шүүмж өрнүүлэх аливаа талуудтай хамтран ажиллах боломж нээлттэй байгааг дурдахыг хүсэж байна. Анхаарч хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Иргэний Зориг Ногоон намын дарга, Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар үг хэлнэ. Индэрт урьж байна.

Б.Батбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас хэрэгжүүлж буй боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд туссан томьёоллын талаар сөрөг хүчний хувьд Иргэний Зориг Ногоон намыг төлөөлөн байр сууриа илэрхийлье. Иргэний Зориг Ногоон нам Монгол хүний өнөө болон хойч үеийнхний сайн сайхан амьдрах баталгааг хангах зорилгын үүднээс тэдний амьдралыг тэтгэх тогтолцоог найдвартай хамгаалах, эдийн засгийн хүртээмжтэй, нийгмийн даацтай, байгаль экологийн тэнцвэртэй хөгжлийг бий болгох нь улс орны хөгжлийн үндсэн тулгуур гэж үздэг нам юм. Төр засгийн бодлого бол хүний сайн сайхан, аз жаргалтай амьдралын төлөө байх ёстой. Үүний суурь нь боловсролын бодлого, түүний хөрөнгө оруулалтаар илэрхийлэгдэнэ.

Боловсролын чанар, хүртээмж, тэгш байдлыг сайжруулах нь эдийн засаг, нийгмийн бүх салбарын хөгжилд хүчтэй түлхэц болдог. Бид хүнийхээ хөгжилд суурилсан, урт хугацааны тогтвортой хөгжлийг нягт төлөвлөх нь хамгаас чухал гэж үзэж байна. Хүний хөгжил гэдэг нь хүний мэдлэг, ур чадвар, амьдралын чанар, эрүүл мэнд, орлогын түвшин, оролцооны боломж зэрэг олон үзүүлэлтээс хамаардаг. Тэр дундаа боловсрол бол хүний хөгжлийг дэмждэг хамгийн чухал үзүүлэлт юм. Гэхдээ боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ боловсролын чанарыг орхигдуулж хэрхэвч болохгүй. Иргэдийн боловсролын түвшин, чанарыг нэмэгдүүлснээр хөдөлмөрийн зах зээл дээрх ажиллах хүчний бүтээмж хэд дахин нэмэгдэж инновац, технологийг нэвтрүүлэн, эдийн засгийн хөгжлийг хурдасгах боломжтой.

Түүнчлэн боловсрол нь ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэдийн орлого, амьдралын чанарыг сайжруулан, нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлэх гол хөшүүрэг юм. Боловсролын хүртээмж чанарыг нэмэгдүүлэхэд боловсролд зарцуулж буй улс орны төдийгүй хувь хүний хөрөнгө оруулалт, цаг хугацаа нь ирээдүйд өсөн нэмэгдэх үр өгөөж, бүтээмжийг хэд дахин нэмэгдүүлдэг нь олон судалгаагаар нотлогдсон. Өөрөөр хэлбэл ирээдүй хойч үе, хүүхэд залуус, иргэдийнхээ боловсролд оруулж буй хөрөнгө оруулалт бол хамгийн зөв бөгөөд өндөр үр өгөөжтэй хөрөнгө оруулалт билээ. 2024 оны байдлаар боловсролын салбарын урсгал зардал 4.2 их наяд төгрөг болж энэ нь ДНБ-ий 5 хувьтай тэнцэж байна. Түүнчлэн 2021 онд 915 тэрбум төгрөг байсан багш нарын цалингийн сан 2024 онд 2.3 их наяд төгрөг болж нэмэгдсэн. Багшийн тасралтгүй хөгжил, сургалтын хэрэглэгдэхүүн, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж зэрэгт суурилсан зардал нэмэгдэж, 2024 онд 113.6 тэрбум төгрөг болсон. Гэвч улс орны эдийн засгийн хөгжил, инфляц, төгрөгийн худалдан авах чадвар зэргээс хамааран багш боловсон хүчний орлогод чанарын өсөлт гарч чадсангүй.

Дэлхийн улс орнууд байшин барилга, зам гүүрт хөрөнгө оруулахаас илүүтэй хүндээ хөрөнгө оруулалт хийхийг чухалчилдаг болоод удаж байна. Энэ нь хөгжлийн үндэс юм. Гэтэл бид төсөв мөнгөнийхөө хэдэн хувийг зарцуулж байгаа билээ. Бодох ёстой асуудал. Түүнчлэн хот, хөдөөгийн төдийгүй улсын болон хувийн сургуулийн сургалтын чанар ялгаатай, багш, боловсон хүчний хөгжих боломж, сургалтын хэрэглэгдэхүүн, суралцах, хөгжих орчин зөрөөтэй

хэвээр байна. Хөдөө орон нутгаас хот суурин газарт чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний үндсэн шалтгаан болдог. Монгол Улсын хамгийн том баялаг бол газрын дор хэвлийд байгаа байгалийн баялаг бус хүмүүн капитал юм гэдгийг мартаж болохгүй. Иргэний Зориг Ногоон намын зүгээс төрийн аливаа төлөвлөгөө, бодлого, шийдвэр, хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа нь иргэдийн өдөр тутмын амьдралд эергээр тусаж, иргэдийн амьжиргаа, эрүүл мэнд, боловсрол, аюулгүй байдал зэрэг бүхий нөхцөлийг сайжруулсан иргэн төвд байвал холбогдох төлөвлөгөө, бодлого, шийдвэр, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг зөв гэж хардаг.

Тиймээс Иргэний Зориг Ногоон нам хүртээмжтэй, тэгш хамран сургах боломжийг бүрдүүлэх боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тус салбар дахь технологи, инновацын хөгжлийг дэмжих, сургалтын хөтөлбөрийг тухайн салбарын өндөр хөгжиж буй улс орны туршлагатай уялдуулах, сургалтын олон талт нөхцөлийг бүрдүүлэх, багшлах боловсон хүчнийг гадаад, дотоодын сургалтын түвшин өндөр сургуулиудад мэргэшүүлэх ур чадварыг дээшлүүлэх, энэ хүрээнд тэтгэлэг хамрагдах давуу боломжийг бүрдүүлэх зэрэг төлөвлөгөөг мөрийн хөтөлбөртөө тусган, боловсролын салбарт хийгдэж буй аливаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжин ажиллаж байна. Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулахад төрөөс сургалтын бодлогын тогтвортой байдлыг хадгалах, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, өрхийн амьжиргаа, нөхцөл, суралцагчийн онцлог, сурахуйн чадамжид нийцсэн олон улсын болон бүс нутгийн шат шатын боловсролын хөгжил, бодлого, эрэлт шаардлагад тохирсон өөрийн орны уламжлал сэтгэлгээний ондоошлыг шингээсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг тогтмол үнэлж, үнэлгээнд суурилсан ялгаатай дэмжлэгийг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Түүнчлэн суралцагчдын сургалтын хэрэглэгдэхүүн, байгалийн шинжлэх ухааны хичээлүүдийн лабораторийн тоноглол хэрэглэгдэхүүний тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхийн хамт багш, боловсон хүчний хөгжил, сургалтын шинэлэг арга зүйг сургалтад нэвтрүүлэх, багшийн ёс зүй, харилцаа, нийгмийн болон эрүүл мэндийн баталгааг хангах чиглэлд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах ёстой. Шат, шатны сургалтын байгууллагын байршил, өмчлөлийн хэлбэр, суралцагчдын тоо, хөтөлбөрийн ялгаатай байдлаас үл хамааран сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хангалтад анхаарах. Байгалийн ухаан, мэдээллийн технологийн хичээлийг лабораторид, технологи, хөгжим, биеийн тамирын хичээлийг зориулалтын кабинет, спорт зааланд хичээллэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын чанар, хөтөлбөрийн биелэлтэд нэгдсэн хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

Сайн боловсрол ирээдүйн сайн сайхан амьдралын урилга болдог. Өнөөдрийн боловсролд оруулж буй нэг төгрөг бүр ирээдүйн хөгжлийн хөрөнгө оруулалт байдаг. Маргаашийн нийгмийн даацтай хөгжил, эдийн засгийн хүртээмжтэй байдал бол өнөөдрийн боловсролын сайн бодлого, зөв шийдэл, оновчтой хөрөнгө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх цөөнхийн төлөөлөл нэрсээ өгье. 5 гишүүнээр тасаллаа. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Г.Ганбаатар: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурлын даргаа энэ Ерөнхий сайдын мэдээллийн цагийг ер нь Шадар сайдын мэдээллийн цаг гээд нэрлэчихвэл яасан юм бэ? Өнгөрсөн 10 сарын хугацаанд Ерөнхий сайд мэдээллийнхээ цаг дээр гуравхан удаа орж ирэхийг үзлээ. Нэг удаа орж ирэхдээ Ж.Баярмаа гишүүнийг С.Баярцогт гээд бөөн дуулиан тариад явчихсан. Тэгээд үндсэндээ Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу Эдийн засгийн хөгжлийн сайд Л.Гантөмөр Ерөнхий сайдын оронд мэдээлэл хийсэн бөгөөд үүнээс С.Амарсайхан сайд 3 удаа мэдээлэл хийсэн. Ер нь өндөр хөгжилтэй парламент ёс хөгжсөн орнуудын Ерөнхий сайд нь тэр дээр ч биш, сөрөг хүчнийхээ лидерийн өөдөөс харж сууж байгаад, өнгөрсөн хугацаанд гарсан алдаа оноо хийгээд, мөрийн хөтөлбөрөө мэтгэлцэж ярилцдаг. Тэр индэр дээр суучхаад нэг мэдээлэл хийсэн болоод, тэгээд бид нар нэг асуусан болоод өнгөрөөд байхаар өнөөгийн ийм байдалтай болно.

Нийгмийн суурь салбар болсон эрүүл мэнд, боловсролын чухал асуудлууд яригдаж байхад өнөөдөр Ерөнхий сайд байхгүй. Тэр огцрох ч байна уу, огцрохгүй ч байна уу энд орж ирээд ярьж байх ёстой. Ямар бэрхшээл боловсролын салбарт тулгараад байгаа юм. Бид ний нуугүй парламенттайгаа ярилцаад, хүндрэл нь юунд байна, эрх зүйн орчинд байна уу, эдийн засаг, санхүү нь дутаад байна уу энэ бүгдийгээ ярьж байх ёстой. Тэгтэл Шадар сайдыг өөрийнхөө оронд оруулчихаад нэг мэдээлэл хийсэн болоод, нөгөөдөх нь уншсан болоод өнгөрч байна. Өнөөдөр хөдөө орон нутагт байдал ямар байгаа юм. Багш нар байхгүй, ажиллах орчин байхгүй, хөдөө орон нутагт англи хэлний багш, математикийн багш заасан нэртэй явж байна. Сая тойрогт ажиллаж байхад Өмнөговь аймгийн Цогтцэций сум Монгол Улсын хамгийн их төсвийг бүрдүүлдэг Өмнөговь аймаг энэ жилийн хувьд төсөвт бүрдүүлэх орлого нь 1,7 их наяд төгрөг. Тэгэхэд Цогтцэций сумд Борын нэрэмжит 1 дүгээр сургууль нь нурчихсан, аль 2019 онд 6 жилийн өмнө тендер авсан “Грийн ресурс констракшн” гэж хариуцлагагүй компани одоо хүртэл сургуулиа ашиглалтад оруулаагүй. 3 мянга гаруй хүүхэд подвал болоод анги танхим хэсээд 3 ээлжээр хичээллээд байж байна. Өнөөдрийн энэ мэдээллийн цаг дээр нийт сургуулийн 66 хувь нь 2 ээлжээр хичээллэж байна гэж байна. Тэгвэл Монгол Улсын говьд 3 ээлжээр хичээллэж байгаа газрууд зөндөө байж байна. Багш нар алга байна, хүрэлцэхгүй байна. Тэгээд ийм байж байхад ядаж өөрийнхөө цаг дээр орж ирээд жаргал, зовлонгоо яриад, парламенттайгаа асуудлуудаа ярьж чадахгүй ийм байна шүү дээ энэ Ерөнхий сайд.

Одоо Ерөнхий сайд байхгүй юм чинь Боловсролын сайдаас асууя. П.Наранбаяр сайдаа Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг яаж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр Улсын Их Хурлын гишүүн иргэдийн өмнөөс асуулт асуух минут байхгүй. П.Наранбаяр сайд хариулт өгөх үү?

П.Наранбаяр: Тэгэхээр багшийн дутагдлын асуудал, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сургуулийн өнөөдрийн байдлыг та ярилаа. Өнөөдөр 2 болон түүнээс дээш ээлжээр хичээллэж байгаа ангийн тоо нийт бүлгүүдийн 88 хувь нь байна. Энэ талаар таны хэлдэг үнэн. Багшийн дутагдал ноцтой хэмжээнд хүрсэн.

Ноднин жилийн 9 сард 4,500 орчим багшийн дутагдал байсан бол мөн оны 11 сард нь 1,500 болсон. Тэгээд багшийн дутагдлыг арилгахын тулд 6 багц арга хэмжээг Засгийн газрын тогтоолоор оруулаад хэрэгжүүлж байгаа. Цаашдаа энэ олон сургууль, цэцэрлэгийг шинээр бариад явахад 20 орчим мянган багш дутна гэсэн тооцоо байдаг. Тэгэхээр багшийн дутагдлыг арилгахын тулд орон нутагт ажиллаж байгаа багшийг дэмжих иж бүрэн бодлого хэрэгтэй. Бид орон нутагт багш, ялангуяа сумын түвшинд очиж ажиллавал шууд 40 хувийн нэмэгдэл болгож эхэлсэн. Энэ хүрээнд зарим хэмжээнд амжилттай явсныг үгүйсгэхгүй. Гэхдээ одоо сумд очоод ажиллаж байгаа багш нарт орон байр хэрэгтэй байна. Барилга, хот байгуулалтын яамтай яриад багш нарыг ипотекийн зээлд хамруулах, мөн орон нутагт очиж ажиллах залуучуудад мөн багш нарт зориулсан байрыг барьж байгуулах хэрэгцээ шаардлага байгааг хэлье.

Өмнөговийн сургуулиудад таны хэлж байгаа тохиолдлууд байгаад байгаа. Өнөөдөр 108 сургууль, 95 цэцэрлэгийг 2028 оноос өмнө буюу 2026, 2027 онуудад эрчимтэй барья гэсэн бодлого энэ асуудлыг бүрэн шийдэхэд чиглэж байгаа юм. Хуучирчихсан барилгууд дээр бидний хийсэн тооцоогоор 79 байршил дээр эдгээр хуучирсан сургуулиудыг шинэчлэхээр ярьж байгаа. 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар байгалийн шинжлэх ухааны хичээлүүдэд зориулсан физикийн биологи, дизайн, технологийн 4 төрлийн лабораторийг нийт 2.9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр ажиллаж байгаа. Монгол Улсад хүүхэд хаана ч сурсан, хаана ч хичээлд хамрагдсан эдгээр бүх тохиолдолд тэгш хүртээмжтэй боловсролын үйлчилгээг авдаг байх ёстой. Үүний төлөө боловсролыг дэмжих жилийг зарлуулж хийж байгаа.

Жил бүр боловсролын жил байх ёстой гэдэг бол үнэн. Өнөөдрийн боловсролын салбарт оруулж байгаа нийт хөрөнгө оруулалт бол тийм их хэмжээний хөрөнгө оруулалт биш. Гэвч эх үүсвэрээс хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах боломжтой. Жишээлбэл эх үүсвэрээ яаж харж байна гэхээр боловсролын хөрөнгө оруулалтад шаардлагатай нийт 3.9 их наяд төгрөг байж байгаа. 2026 онд төсвөөс 1.7 их наяд төгрөгийг нь шийднэ. Үүний 1 их наяд төгрөг буюу 58.8 хувийг улсын төсвөөс, 27 хувь буюу 460 тэрбум төгрөгийг нийслэл, орон нутгийн төсвөөс, 9.1 хувь буюу 160 тэрбум төгрөгийг Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээс шийдвэрлэхээр төлөвлөөд ажиллаж байгаа. Тэгэхээрээ шууд төсөвт дарамт орж ирнэ, нэмэгдлээ гэх зүйл байхгүй. Дотоодын нийт бүтээгдэхүүний 5.7 хувийг юуны түрүүнд боловсролд зарцуулъя. Тэгвэл 2030 он гэхэд боловсролын салбарт өнөөдөр сурч байгаа дээр 88 мянган хүүхэд нэмэгдэх төлөвтэй байна. Тэгэхээр энэ асуудлаа боловсролыг дэмжих жилийн хүрээнд шийдчихье гэсэн зүйл яригдаж байгаа.

Энэ жилийн хүрээнд шийдвэрлэх ёстой нэг зүйл бол багш ажилтнуудын цалин хангамжийн асуудал. Үндсэн цалинг өсгөх асуудал байгаа. Үйлдвэрчний эвлэлтэй ярилцаж байна. Цалин өсгөхөөр шууд инфляц юм шиг яриад байдаг. Цалин бол өөрөө хөрөнгө оруулалт, хэрэглээг дэмжих, салбарын асуудлыг шийдвэрлэх нэг хөшүүрэг гэж харж байгаа.

Тэгэхээр Цогтцэций сум 2 сургуультай байгаа. Эндээс ер нь сургуулийн барилга 2019 оноос эхэлсэн боловч ажил нь удаашралтай хэрэгжиж байгаа

учраас цуцлах арга хэмжээг авсан. Гэвч шүүх дээр энэ асуудал нь шийдэгдэхгүй яваад байгаа учир барилгын ажил удаашралтай байна. Тэнд 2,886 хүүхэд төрийн өмчийн 2 сургуульд суралцаж байгаа нь үнэн. Үнэхээрийн нөхцөл байдал хүнд байгаа учраас Боловсролын яам орон нутагтай ярилцаад энэ асуудлыг хамтдаа шийдэхийн тулд ажиллана гэдгээ энэ индэр дээрээс хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар асуулт асуух нь 3 хүртэл, хариулт өгөх нь 5 минутаас тус тус хэтрэхгүй гээд заасан. Одоо Б.Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Багш нарын чадавхыг дээшлүүлж байж бид хүүхдүүдээ сайн мэдлэг, боловсролтой болгоно. Энэ хүрээнд Ховд их сургуулийг сайн сургалттай сургууль болгохын төлөө хэд хэдэн ажлуудыг хийж эхэлж байгаа. Тухайлбал, 13 орчим тэрбум төгрөг тавьж 5 давхар оюутны орон сууц барьж байгаа. Энэний 3 давхарт нь оюутнууд байна. Дээд талын 2 давхарт нь 2 өрөө байруудтай. Мөн сайн багш нар ирж ажиллах боломжийг нээж өгнө. Ховд аймгийн төсвөөс тодорхой хэмжээний цалинг нь нэмэгдүүлж өгөх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Ингэсний үр дүнд сайн багш нар Ховдод байртай, өндөр цалинтай ажиллах боломжийг нээж өгөх юм. Энэ байр барих ажил 2 жилийн дотор дуусна. Үүний дараагаар орон нутгийн болон улсын төсвөөс үндсэн хичээлийн байр болон хуучин 2 оюутны байрыг засаж, олон оюутанг сургах боломжийг нээж өгнө. Дараагаар нь нэг хийх ёстой зүйл бол оюутнуудыг тэтгэлэгтэй болгох тухай асуудал байгаа. Өөрөөр хэлбэл багшаар сурч байгаа оюутнууд бараг төлбөр төлөхгүй байгаа.

Тийм учраас оюутнуудыг тэтгэлэгтэй болгохын тулд аж ахуйн нэгжүүдтэй хамтарч ажиллаж, баруун бүсийн сум болгоны бизнес хийж байгаа хүмүүс, жишээлбэл Ховд аймгийн Ховд их сургуульд сурч байгаа оюутнуудад тэтгэлэг өгөх ажлыг хийнэ. Ховд Их сургуулийг тусад нь бие даалгана. Намайг Удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байхад 2,000 гаруй оюутантай байсан. Харин одоо оюутны тоо дөнгөж 400 гаруй болсон байгаа. Энийг буцаагаад 4,000 болгох зорилтыг тавина. Ингэсний үр дүнд Ховд аймаг залуусын хот болох төлөвлөгөөтэй ажиллаж байгаа гэдгийг хэлье.

2 дугаар асуудал нь олон жилийн өмнөөс буюу 2012 оноос хойш Л.Гантөмөр сайдын хийсэн боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлээд, үүний үр дүнг өнөөдөр хүртэл мөлжөөд явж байгаа. Өнгөрсөн хугацаанд Монгол Ардын намын 5, 6 сайд солигдсон. Одоо боловсролын систем нуран унасан гэдэг зүйл яривал П.Наранбаяр сайд тан дээр асуудлууд ирнэ шүү. Ер нь бухаад өнгөрнө, манай эрх баригч нар бол коммунист үзэл суртлаараа ёстой гайхалтай сайхан хийнэ шүү. Тийм учраас бодолтой байгаарай гэж би танд зөвлөө.

Тэгээд “chromebook”-ийн талаар асууя. Хуучин Л.Гантөмөр сайдын үед өгсөн dell, lenovo дээр багш нар ажиллаад сурчихсан. Тэгэхээр энэ chromebook-ийг гайгүй үнэтэй, дээрээс нь хайлтын аппликэйшнийг бүгдийг нь үнэгүй хэрэглэх боломж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Багш бүрд компьютер, хүүхэд бүрд компьютер гэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орчихсон байгаа. Chromebook бол өнөөдөр dell болон бусад компьютерыг бодвол 2 дахин хямд байгаа. Нэг ширхэг Chromebook-ийн үнэ 880 мянган төгрөгөөс 1 сая 50 мянган төгрөгийн хооронд байгаа. Тэгэхээр dell болон бусад компьютерээс хямд байгаа. Харамсалтай нь манай багш нар ажиллаж сураагүй. Яагаад гэвэл өөр дээрээ “Hard”-гүй учраас багш нар өөрсдийнхөө хичээлийг үүлэн технологи дээрээ ажиллахад датануудаа сануулах, хадгалах, ажиллахад жоохон асуудал байгаа. Мөн google-н иж бүрэн лицензийг бүрэн ашиглаад явах боломжтой. Chromebook бүрэн ашиглаад явбал хямд шийдэл гэж харж байгаа. Энэ хүрээнд багш нарыг сайн ажиллуулж сургах чиглэлээр давхар сургалтуудыг зохион байгуулах хэрэгтэй байна. Тэгээд хэрэглэх программууд дээр нь хаачихсан байгаа зарим нэг программыг нээж, улмаар багш нар программыг шууд хэрэглэж болохуйцаар бэлтгэх шаардлагатай байгаа. Энэ талаар google-тэй ярьж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Засгийн газраас, төсвөөс, Улсын Их Хурлаас сүүлийн жилүүдэд боловсролын салбарт төсөв мөнгөний тухайд боломж бололцоогоор дэмжиж ажиллаж байгаа. Гэхдээ 2019 оны ЮНЕСКО-оос гаргасан үнэлгээний тайлангаас нэг өгүүлбэрийг танд дахин уншъя. Монголын боловсролын системд хэсэгчлэн өөрчлөлт хийх нь үр дүнгүй, эрс өөрчлөлт хийх шаардлагатай, үгүй бол том сорилтуудтай нүүр тулна гэж тухайн тайлангийн дүгнэлт дээр гарч байсан байна. Тэгэхлээр энэ зүйл болоод байна даа. Төсвөөс, төрөөс мөнгө төгрөг анхаарал тавиад байдаг. Гэтэл бодит байдал дээр энэ байгууллагын хэдэн жилийн өмнөх дүгнэлт бид нарт том суурь өөрчлөлт, зарчмын өөрчлөлт ирж байгаа зах зээлийн ачаа даалгаварт нийцэхгүй, тогтолцооны өөрчлөлтүүд байхгүй байгаа учраас жишээ нь өнөөдөр нөхцөл байдал ямар байна вэ? Нэг талдаа их, дээд сургууль төгсөж байгаа залуучууд нь ажлын байран дээр шаардлага хангадаггүй, нөгөө талд нь ажлын байр байгаад байдаг ийм нөхцөл байдалтай байна. Мэргэжилтэй ажиллах хүчний асуудал нь олон салбарын бодлого дээр байдаггүй байна.

10 жилийн суурь боловсролын сургалтын үр дүнг үзэхэд ПИСА-гаас ноднин жил гаргасан үнэлгээний дүнгээс би гуравхан тоо дурдъя. Монголын 9 дүгээр ангийн 3 хүүхэд тутмын 2 нь уншсанаа ойлгох чадваргүй байна. Монгол Улсын 2 хүүхэд тутмын 1 нь байгалийн ухааны хичээлд хангалтгүй дүн авч байна. Хангалттай дүн авч байгаа 100 хүүхэд тутамд 2 л хүүхэд байна. Монгол Улсын 9 дүгээр ангийн хүүхдүүдийн үнэлгээгээр манайхаас бага мөнгө зарцуулж байгаа ижил түвшний Вьетнам зэрэг орнуудаас доошоо орчихлоо. Дунд сургуулийн тогтолцоог үнэлсэн олон улсын бодит үнэлгээ нь ингээд гарчихсан.

Тэгэхлээр ЮНЕСКО-ийн дүгнэлтээр хэсэгчлэн өөрчлөлт хийх биш, томоохон өөрчлөлт хийхгүй бол том сорилтуудтай нүүр тулна гэж байсан хөдөлмөрийн зах зээл дээр илрээд эхэлчихлээ. Мөн олон улсын үнэлгээ,

дүгнэлтээр илрээд эхэлчихлээ. Тэгэхээр энэ дээр ямар бодол саналтай, яагаад ийм суурь асуудал руу, тогтолцоо руу хандахгүй төсөв, төлөвлөгөө, Улсын Их Хурлаас мөнгө батлах ёстой гэдэг хандлагаар яваад байдаг. Энэ дээр бодлогын ямар тодорхой бэрхшээл байгаа талаар тайлбар өгмөөр байна. Уг нь Засгийн газраас Монгол Улсын боловсролын тогтолцоонд хийх ажил бол жинхэнээсээ 14 МЕГА төслийн чинь хамгийн эхэнд нэгд эрэмбэлэгдэх ёстой МЕГА төсөл бол боловсролын салбарт байсан. Саяын суурь өөрчлөлтүүдийг нийгэм бид нараас нэхээд байна.

Д.Амарбаясгалан: П.Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр хэсэгчилж шийдэх биш, системтэйгээр шинэчлэл хийх шаардлагатайг та хэлж байна. Ийм шаардлага байна. ПИСА-гийн шалгалт 2022 онд Монголд хийгдсэн. Энэ шалгалтын дүнгээр Монгол Улсын хүүхдийн математикийн ур чадвар 425 оноо байсан. Энэ математикийн ур чадварын онооны хувьд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-н орнуудын дундаж 472, Азийн дундаж нь 451. Унших чадварын хувьд 378 оноо авсан ба Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-н 476 оноо, Азийн дундаж 427 онооноос доогуур байна. Байгалийн ухааны чадвар 412 оноо авсан нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-н орнуудын дундаж нь 485, Азийн дундаж 449 онооноос доогуур байдалтай байгаа. Иймд ПИСА-гийн шалгалтаар гарсан дүнгийн хүрээнд бид унших чадварыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа. Улмаар боловсролын салбарт 6 иж бүрэн шинэчлэл явуулж байгаа.

Нэгдүгээр хөтөлбөр. Боловсролын ерөнхий хуульд сургалтын хөтөлбөрийг нэг хүүхдийн сурах 10-12 жилийн цикл дотор өөрчилнө гэсэн заалттай. Тэгэхээр 2014 оноос хойш өөрчлөгдсөн энэ цөм хөтөлбөр 2025, 2026 онд өөрчлөх циклд ороод явж байгаа. Энэ жил хөтөлбөрөө шинэчлэхдээ бага сургууль дээр ялангуяа унших чадварт оруулж байгаа. Унших чадвар гэдэг нь нөгөө минутаар уншдаг асуудал ерөөсөө биш, уншсанаа ойлгодог, ойлгосноо хэрэглэж чаддаг ийм чадварыг хэлж байгаа. Хөтөлбөрийн шинэчлэл явагдаж байна. Үнэлгээний шинэчлэл, тэгш хүртээмжийг бий болгох хүртээмжийн шинэчлэл, цахим шилжилт, багшийн хөгжил, цалингийн шинэчлэлүүд гэсэн иж бүрэн, багш руу чиглэсэн 3 тулгуурт бодлого гээд боловсролын иж бүрэн 6 бодлогыг явуулж байгаа.

Гэвч энэ бүхний цаана боловсролын чанар, хүртээмж, багшийн сэтгэл ханамж, чадвартай холбогдоод явж байгаа. Энэ асуудлуудыг иж бүрнээр нь шийдэхээр ажиллаж байна. Математик чадварыг сайжруулахын тулд “eduten” гэх мэт дэлхийн шилдэг хөтөлбөрүүдийг оруулж ирээд ажиллаж байна. Англи хэлний чадварыг сайжруулахын тулд “pearson” хөтөлбөрийг нэвтрүүлэх зэрэг ажлуудыг хийж байна.

2025 оны 3 дугаар сарын 05-ны өдрөөс 5 дугаар сарын 16-ны өдрийн хооронд ПИСА-гийн 2 дахь шалгалтад Монгол Улс орсон. 2026 оны 12 дугаар сард шалгалтын дүн гарна. Шалгалтын дүнгээс бид юуг сайжруулж чадсан байна, юуг хийж чадаагүй байна вэ гэдэг асуудлууд гараад ирнэ. Цахим шилжилт бол хүртээмж, сургалтын амжилт, менежментийг сайжруулахад чиглэж байгаа.

Өнөөдөр “Мэдлэ” сургууль дээр ойролцоогоор 36 мянган хичээл байж байна. Энүүгээр ахлах сургууль сонголтынхоо хичээлүүдийг үзээд явах боломжтой.

Өмнө нь би 5 шинэчлэлийг хэлсэн. 6 дахь шинэчлэл нь гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн систем байгаа. Бид зөвхөн ПИСА-гаар 3 жил тутамд боловсролынхоо чанарыг хэмждэг биш, гүйцэтгэлийн үнэлгээгээр жил болгон өөрсдийнхөө сурлагын чанар, багшийн чанарыг давхар хэмжээд явдаг. Энэ жил гүйцэтгэлийн үнэлгээ бүрэн хийгдэж дууссан. Энэ жилийн хувьд цахим шалгалтын журмаар гүйцэтгэлийн үнэлгээг хийсэн. Түүвэрт 700 сургууль, 29,689 багш, нийт 854,507 сурагчид хамрагдсан байгаа. Ерөнхийдөө бидний гүйцэтгэлийн үнэлгээгээр хийгээд байгаа үнэлгээний дүнгүүд ПИСА-гийн гараад байгаа дүнтэй мөргөдөг байгаа. Тэгэхээр боловсролыг иж бүрнээр нь шинэчлэх ажлыг хийж байгаа гэдгийг та бүхэнд хэлье. Зарим нэг хэсэг дээр нь шинэчлэл хийгдээд, бусдыг нь хаяад байна гэсэн ийм асуудал гарч байгаа бол бид тусгайлсан судалгаа, тайлангаа танд явуулж тайлбарлахад бэлэн байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Би 3 асуулт асууна. Асуулт асуухаасаа өмнө П.Наранбаяр сайд сургалтын хөтөлбөрт хүний эрхийн чиглэл дээр анхаарч байгаа, энэ чиглэлээр сурах бичиг хийж байгаад талархал илэрхийлмээр байна. Яагаад гэхлээр боловсролын асуудал гэдэг улс орны суурь асуудал бөгөөд хүний эрхтэй салшгүй холбоотой. Тэр ч утгаараа бид эрдмийн хэт цахиваас хөгжлийн гал бадарна гэсэн философитой байдаг ард түмэн.

Тэгээд хоёрдугаарт нь цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгө 2475 төгрөг байсан дээр Улаанбаатар хотод эцэг, эхээс нь мянган төгрөг нэмэгдүүлнэ гэж байгаа. Хөдөө орон нутагт энэ асуудал бүрэн шийдэгдээгүй. Ойролцоогоор 7 орчим мянган төгрөг байхад хүүхдийн өсөлт хөгжилтөд шаардлагатай шим тэжээлийг авах боломжтой гэж үзэж байгаа. Энийг үе шаттайгаар ахиулмаар байгаа.

Нэгдүгээр асуултын хүрээнд боловсролын хүртээмжийн ялгаа бол хамгийн том асуудал болчхоод байна. Бид боловсролтой холбоотой төсөв гээд ярихаар аль нэг сумын сургуулийн байр, дотуур байр ч гэдэг юм уу, хатуу дэд бүтцийн асуудлууд яриад байдаг. Гэтэл тэгш хүртээмжийн ялгааг бууруулах чиглэлээр ямар бодлого хэрэгжүүлж байна вэ? Ямар хугацаанд, ямар үр дүн гаргах бодлого хэрэгжиж байгаа юм бэ? Жишээлбэл, Төв аймаг, Дархан, Сэлэнгийн хувьд 2024-2025 оны хичээлийн жилд 69,369 хүүхэд 1-12 дугаар ангид суралцсан. Бүх хүүхдэд захиа бичсэн 4 мянга гаруй хариу авсан. Нийт 4 мянган захианд хариу бичсэн хүүхдийн 70 орчим хувь нь сургууль орчмын аюулгүй байдал, дэд бүтэцтэй холбоотой саналуудыг ирүүлж байгаа жишээтэй. Тэгэхээр эхний асуулт үүнтэй холбоотой байна.

2 дугаарт, сургуулийн дэд бүтэц улсын хэмжээнд бүтэн шийдэхэд дундын хугацаанд ямар хэмжээний санхүүжилт хэрэгтэй бөгөөд энэ онд хэчнээн нь, аль аймаг, сумын хэчнээн хувь нь энд орж чадаж байгаа вэ? Мөн чанар

хүртээмжийн харьцаа, өөрөөр хэлбэл боловсролын төсвийн хэчнээн хувь нь чанарыг ахиулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа вэ? Нөгөө талаасаа хэчнээн хувь нь дэд бүтцэд чиглэж байгаа вэ? Энэ харьцааг мэдмээр байна.

3 дугаарт, боловсролыг дэмжих жил гээд байгаа. Ерөнхий байгаад байна гэж сайдууд өмнө нь хэлсэн. Тухайлбал чанар хүртээмжийг ахиулах жил ч гэдэг юм уу, тодорхой, магадгүй багш нарын нийгмийн асуудлыг шийднэ ч гэдэг юм уу яг тодорхой зорилтуудыг тавимаар байгаа юм. Ерөнхий байвал их ойлгомж муутай байгаад байна.

Дараагийн асуулт нь дотоодын нийт бүтээгдэхүүнээр тэргүүлж байгаа 10 орон тутмын 8 нь боловсролын реформыг амжилттай хийсэн орнууд байгаа. Тэгэхээр таны хувьд боловсролын реформыг хийх тулгуур 3 үзүүлэлтийг юу гэж харж байна вэ? Эдгээр асуултуудыг асууя.

Д.Амарбаясгалан: П.Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Маш оновчтой асуулт тавьж байгаад баярлалаа. Хүний эрхийн чиглэлээр сурах бичиг лавлах материал, гарын авлагыг гаргахаар ажлаа эхлүүлээд ажиллаж байна. Энэ жил сургуулийн өмнөх боловсролд нийслэлд мянган төгрөгийг эцэг, эхээс төлүүлж эхэлсэн нь эерэг үр дүн авчирсан. Ялангуяа цэцэрлэгийн хүүхдүүдийн ирцийн бүртгэл эрс сайжирсан. Мөн эцэг, эхчүүдийн цэцэрлэгийн үйлчилгээнд тавьж байгаа хяналт, цэцэрлэгийн өөрөө удирдах зөвлөл сургуулийн зөвлөлүүдийн удирдлага сайжирсан эерэг үр дүн гарч байгаа гэдгийг танд дуулгая. Цаашид бид боломжтой аймгийн төвүүд, зарим нэг хотуудад энэ бодлогыг үе шаттай хэрэгжүүлээд явна гэж төлөвлөж байна.

Хүртээмжийн ялгааг бууруулах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухайд хувьсах зардлын бүрэлдэхүүнд сургуулийн орчинд хүүхэд хамгааллын зардлыг тусгасан байгаа. Хүртээмжийн ялгааг арилгахад нэгдүгээрт сургуулийн хүртээмжийг Монгол Улсад хүүхэд хаана сурах нь хамаагүй сайн багшаар, сайн сургуульд суралцах боломжийг хангах ёстой. Хамгийн сайн сургууль гэрийн ойр сургууль байх бодлогыг хэрэгжүүлэх юм. Энэ хүрээнд сургуулийн хүртээмжийг бүрдүүлэх хөрөнгө оруулалтыг шийдчихье гэж яриад байгаа. Нийтдээ 3.9 их наяд төгрөг болох бөгөөд 2 дугаар асуудалтай холбоотойгоор хөрөнгө оруулалт дээр бид зөвхөн тооцож байгаа. Үүнээс эхний жилд нь 1.7 их наяд төгрөг хэрэгтэйгээс улсын төсвөөс 1 их наяд төгрөгийг нь, үлдсэнийг нь нийслэлийн болоод орон нутгийн төсвөөс, тэгээд 160 орчим тэрбум төгрөгийг Дэлхийн Банк болон Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад үзүүлэх хөнгөлөлттэй зээлийн хүрээнд шийдэх боломжтой гэж харж байгаа.

Боловсролын чанарын ялгааг арилгахад цахим шилжилтийг ихээхэн ач холбогдолтой гэж харж байгаа. Цахим шилжилт бол орон зайн дарангуйлалд үл өртөж, хүүхэд өөрийнхөө үзье гэсэн хичээл шууд үзэж харж болох зүйл юм. Мөн AI буюу хиймэл оюуны хичээлд ашиглах тал дээр бид зөвлөмж, чиглэл өгч явуулах нь зүйтэй гэж харж байгаа. Гагцхүү хөдөө орон нутагт ялангуяа алслагдсан сумдад интернэтийн хурдны асуудал байдаг. Энийг яаралтай шийдвэрлэхээр

Цахим хөгжлийн яам, мөн Сонгуулийн ерөнхий хороо зэрэг Старлинк ашигладаг газруудтай хамтран ажиллаж байгаа бөгөөд эхнээсээ шийдэж байгаа. Энэ дээр Улсын Их Хурлын дарга их санаачилгатай ажиллаж, энэ хүрээнд манай яамтай хамтран ажиллаж байгааг энд цохон тэмдэглэе.

Боловсролын реформын хувьд тодорхой зорилтуудыг та 3 дахь асуултаар асууж байна. Боловсролын реформд тэгш хүртээмж, багшийн хөгжил, хамгийн чадварлаг хэсэг нь багш болдог ийм боловсролын салбартай болох хэрэгтэй. Агуулга буюу хөтөлбөрийн шинэчлэлийг би хамгийн ач холбогдолтой гэж харж байна. Сайн хөтөлбөр, сайн багш, тэгш хүртээмжтэй сургуулийн орчин, аюулгүй орчин шийдчихсэн цагт ойрын 4, 5 жилдээ мөн цаашдаа боловсролын тал дээр өндөр түвшний, чанарын, ирээдүйг харсан шинэчлэлийг ярих боломжтой болно гэж харж байна.

Таны хэлдэг үнэн. Боловсролын чиглэлээр хөрөнгийг нь шийдэж оруулчихсан улсууд хамгийн сайн хөгждөг. Хэрвээ бид боловсролдоо сайн хөрөнгө оруулж чадсан бол өнөөдрийн эдийн засгийн өсөлтийг ямар ч байсан 20-30 пунктээр өсгөчихсөн байх боломжтой байсан гэдэг нь судалгаагаар гардаг. Хүүхдийн хоолны талаар түрүүн би хэлсэн. Иймэрхүү байдлаар хариулья. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Боловсролын салбарын асуудал дээр ерөнхийдөө 2017 оноос хойш миний ярьж байгаа ганцхан сэдэв байгаа. Энэ бол багшийн цалинг нэмэх асуудал. Өнөөдөр мянган сургууль барилаа гэж ярьж байна. Сая 200 гаруй сургууль, цэцэрлэг нэмж барьж байна гээд. Энэ сайн хэрэг, энийг би үгүйсгээгүй. Тэгээд энэ барьж байгаа сургууль, цэцэрлэгүүд чинь ажиллах боловсон хүчин байна уу? 20 гаруй мянган багшийн дутагдалд орно гээд сая П.Наранбаяр сайд хэлж байна. Тэгэхээр бид нар Монгол Улсын Засгийн газраас 2026 оныг боловсролыг дэмжих жил болгоно гэсэн сайхан санаачилга гаргалаа. Тэгэхээр сая С.Эрдэнэболд гишүүн зөв санаачилга гаргаж байна. Боловсролыг дэмжих жил гэсэн нэр ерөнхий байна, тодорхой асуудлыг шийдэхэд чиглэсэн тодорхой амлалт баймаар байна гэж байна. Тэгэхээр 2026 онд зарлах боловсролыг дэмжих жилийг багш нар, багш ажилчдынхаа нийгмийн асуудлыг сайжруулна гэсэн бодитой бөгөөд тодорхой зорилго тавихгүй бол зүгээр нэг дэмжинэ, тэгнэ гээд бид сүүлийн 30 жил дандаа нэг үлгэрийн юм ярьж явлаа шүү дээ. Тэгэхээр боловсролын салбар дээр багшийн хомсдолоо яаж арилгах вэ гэхээр сургууль, цэцэрлэг яриад байх юм. Улам л багшийн хомсдолд орно шүү дээ. Сургууль, цэцэрлэгийн барилга нэмлээ гээд багшийн хомсдол арилахгүй. Багшийн хомсдолыг юугаар арилгах вэ гэхээр багшийн цалин хөлсөөр арилгана. Багшийн цалин хөлсийг яаж нэмэгдүүлэх юм бэ, ямар бодлого барих юм бэ гэдгээ бүгдээрээ яримаар байна.

Өмнө нь би Байнгын хороон дээр хэлж байсан. Дандаа нэг тулга тойрсон, байгаа оноогүй юм яриад байна бид. Одоо нэг бодитойгоор 2026 оныг үнэхээр боловсролын жил болгоё гэж бүгдээрээ хүсээд байгаа бол Монголын мянга

мянган багш нарын хүсээд байгаа цалинг нь мянган ам.долларт хүргэе. Өнөөдөр багшид 1 сая 400 мянган төгрөгийн цалин өгөөд, багш гар дээрээ 900 мянган төгрөгийн цалин авч байгаа учраас боловсролын салбар боловсон хүчний хомсдолд орчихлоо. Сурлага сайтай хүүхдүүд багшийн мэргэжлийг сонгохоо больсон. Хамгийн сурлага муутай хүүхдүүд багшийн сургуулийг сонгож орж байгаа энэ үнэн шүү дээ. Энийг нугаад байх юм ерөөсөө байхгүй.

Багш нараас ирж байгаа олон саналууд байна. Тухайлбал, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын улсын төсвийн дутуу баригдсан 960 хүүхдийн сургуулийг 2026 онд багтааж дуусгах уу гэдгийг П.Наранбаяр сайдаас асууя. Та өмнө нь дуусгана гэж ярьж байсан. Тэгээд 2026 онд энэ багтаж дуусах уу? Нэг сургууль нь нураад уначихсан, одоо ерөөсөө дэгэн догонтой хүнд байна гээд багш нар яриад байна. Танд ч гэсэн энэ мэдээлэл очсон байх гэж бодож байна. Тэгээд багш нарынхаа нийгмийн асуудлыг ярья. Хэдүүлээ нэг их худлаа хиймэл оюун ухаан, сансрын, сансрын юм битгий ярь, хөрсөн дээрээ буусан юм, амьдралтай юм ярья гэж би бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: П.Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Юуны өмнө Ц.Мөнхтуяа гишүүний хэлээд байгаа цалин өсөх асуудлыг бүгд дэмжиж байгаа. Өнөөдөр цалингийн өсөлтийг эсэргүүцэж байгаа хүн их ховор. Цалинг өсгөхийн тулд манай яам Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай ярилцаж, Засгийн газрын хэмжээнд нь шийдэх ёстой. Энэ жил 6 хувиар үндсэн цалин өссөн. Миний бие үндсэн цалинг өсгөх ёстой гэдэг дээр хатуу байр суурьтай байгаа. Үндсэн цалинг ер нь 2028 он гэхэд таны хэлээд байгаа мянган ам.доллар буюу 3-4 сая руу оруулж ирэх боломжийг бий болгох нь зүйтэй гэж үзэж байгаа. Энэ бол өөрөө эдийн засгийнхаа өсөлттэй уялдаж явдаг тоо. Тэгэхээр үндсэн цалинг нь өсгөж байж, чадварлаг боловсон хүчин энэ салбарт орж ирэх тухай таны хэлээд байгаа саналтай би 100 хувь нэгдэж байна. Өнөөдөр үндсэн цалин энэ жилийн 6 хувийн нэмэгдэлтэйгээ 1 сая 485 мянга төгрөг болчихсон. 2028 онд багшийн гар дээр очих цалин тухайн багшийн ажилласан жил гүйцэтгэл байршлаасаа хамаараад 2.6-3.5 сая төгрөгийн хооронд болохоор байна. Энэ дээр нэмэгдлүүдийг нь орон нутгийн нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл гээд бүгдийг нь нэмж хэлж байгаа шүү. Ийм нөхцөл байдалтай байна. Гэхдээ үндсэн цалинг нь нэмэгдүүлж байж энэ салбарт чадварлаг боловсон хүчин орж ирнэ гэдгийг дахин хэлье.

Цогтцэций сумын сургуулийн тухайд орон нутгийнхаа төсвөөр нэг сургууль барьж байгаа 960 хүүхдийн суудалтай. Нөгөө сургуулийнх нь тухайд шүүхдээд явж байгаа. Энэ шүүхийн шийдвэр нь хэзээ, яаж гарахыг хэлэхэд хэцүү байна. Улсын Их Хурал 2026 оныхоо төсвийг ярилцахдаа энийг баталж чадвал 2026 онд энэ сургуулийг бүрэн ашиглалтад оруулах боломжтой гэж харж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.11-д заасны дагуу намын бүлэг тус бүрээс гишүүн төлөөлж Улсын Их

Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуултуудыг асууна. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Их Хурлын гишүүн Цэндсүрэнгийн Мөнхтуяа асуулт асууна. Асуулт хариулт 20 хүртэл минут үргэлжилнэ.

Ц.Мөнхтуяа: “D.parliament” дээр байрласан багш нарын асуултуудыг сонсоё. Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор 2024 онд зохион байгуулагдсан Монголын багш нарын 8 дугаар их хурлын мянга гаруй төлөөлөгчид санал нэгтгэйгээр багш нарын тэтгэвэрт гарах насыг өөрөө хүсвэл эмэгтэй 50, эрэгтэй 55 настай гарч болдог хуулийн зохицуулалт шаардлагатай байгааг онцолж тус их хурлын шийдвэрт тусгасан. Үүнийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас ямар арга хэмжээ авч байна вэ гэдгийг С.Амарсайхан сайдаас асууя?

Хоёрдугаарт, багш нарын үндсэн цалин 50 хувиар нэмэх шаардлагатай байна. Гүйцэтгэл багш нарын нэр хүндийг унагааж байгаа тул нэг ангид суралцах сурагчдын тоогоор анги даалтын мөнгийг өгөх боломжтой юу гэсэн асуулт байна. Энийг П.Наранбаяр сайд хариулах байх.

Боловсролын салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх үндсэн гарц бол дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 4,7 хувь байгааг 7 хувьд хүргэнэ. Эсвэл төсвийн нийт зардлын 13 хувийг 20 хувьд хүргэх явдал юм. Засгийн газар боловсролыг дэмжих жил 2026 оны хүрээнд энэ чиглэлд бодитой ажил хиймээр байна. Энэ чиглэлээр ямар ажил хийгдэх вэ гэдгийг С.Амарсайхан сайдаас асууя.

Бямбадаш гэдэг багш асуусан байна. Монголын багш нарын дийлэнх нь орон сууцын нөхцөл тааруу, хөнгөлөлттэй зээлийн орон сууцад орох хүсэлтэй байдаг. Гэвч цалин хөлс багаас шалтгаалаад ипотекийн зээлийн шаардлага хангахгүй байна. Иймд Засгийн газраас багш нарт зориулсан үнэ хямд, хүү бага, урьдчилгаагүй орон сууцжуулах талаар ямар хөтөлбөр хэрэгжүүлж байна вэ гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ц.Мөнхтуяа гишүүн нийт хэдэн асуулт байгаа вэ?

Ц.Мөнхтуяа: 10-аад асуулт байна. Би багцлаад 5-ыг асуучихъя. Анхбаяр гэдэг багш асуусан байна. Үндсэн цалингаа нэмбэл өөр давхар ажил хийх шаардлагагүй болж, үндсэн ажилдаа анхаарлаа бүрэн хандуулж чадна. Улмаар сурлагын чанар эрчимтэй сайжирна гэж бодож байна. Одоогоор цалин мөнгө хаанаа ч хүрэхгүй байдаг учир багш нар нэмэлт орлого олох гэж зүдэрч байна. Ажлаасаа гарч, өөр ажил хийх хүсэлтэй болон шийдвэр гаргасан багш нар их байна. Энэ тал дээр ямар бодлого барьж ажиллах вэ гэсэн байна.

Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт гэж маш их алдаа завхралтай юм явагдаж байна. Энэ гүйцэтгэлийн үнэлгээг үндсэн цалин руу оруулах арга хэмжээг авч өгөөч. Ингээгүй тохиолдолд багш нар бараг намар ажил хаялт хийнэ гэсэн шүү. Энэ гүйцэтгэлийн үнэлгээ дээр чинь.

Багш нарын цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах, ажиллах боломж нөхцөлөөр хангах, техник хэрэгсэл, интернэт сүлжээг чанартай, хүртээмжтэй болгох, сургуулийн төсөв, түүний зарцуулалтыг нээлттэй, ил тод болгох, сургуулийн удирдлагыг 5 жил тутамд аттестатчилан сэлгэн ажиллуулдаг байх шаардлагатай байна. Эдгээр асуудлын хүрээнд ямар арга хэмжээ авч ажиллах вэ гэсэн байна. Ийм 5 асуултыг тоймлоод асууя.

Д.Амарбаясгалан: П.Наранбаяр сайдын микрофоныг өгье.

П.Наранбаяр: Баярлалаа. Иргэдээс ирсэн асуултад хариулъя. Багш нарын их хурлын тухайд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор 2024 онд байгуулагдсан хурлын үеэр багш нар 50-55 наснаас тэтгэвэрт гарах боломжтой болгох хуулийн зохицуулалтын талаар ярилцсан. Энэ тэтгэврийн насыг тусгай хуулиар зохицуулдаг, багш нар 50 болон 55 наснаас сонголттой нөхцлөөр хэрэв өөрөө хүсвэл гэсэн байгаа. Үйлдвэрчний эвлэл болоод холбогдох талуудтай хамтраад судалгаа хийгдэж байна. Багшийн ажлын норм нормативыг шинэчлэх судалгааг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн дээр эхлүүлчихсэн байгаа. Багшийн туршлага, мэргэжлийн зэргээс шалтгаалаад норм нормативыг шинэчлэн тогтооно.

2 дахь асуултын тухайд багшийн орон сууцын асуудлыг та хөндөх шиг боллоо. Орон сууцыг ипотекийн зээлд хамруулах зохицуулалт хуулийн заалттай. Тэгэхээр орон сууцыг ипотекийн зээлд хамруулахад онцгой анхаарах ёстой гэж харж байна. Багшийн нийгмийн асуудлыг бид үе шаттайгаар шийдэхдээ Засгийн газраас 2025 онд иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд 13 мянга орчим иргэдийг ипотекийн зээлийн хөтөлбөрт хамруулах, түүнээс 50-аас доошгүй хувийг орон нутагт олгоход зориулаад улсын төсвөөс 123.5 тэрбум төгрөгийг, бусад эх үүсвэрээс 1.3 их наяд төгрөгийг зарцуулахаар тусгасан. Орон нутгийн ипотекийн 3 хувийн зээлийг үргэлж-лүүлэн олгож, амины орон сууцыг ипотекийн зээлд хамрагдах боломжтой болгохоор ажиллаж байгаа.

3 дахь асуулт нь цалин хүрэхгүй байна. Гүйцэтгэлийн үнэлгээний дүнг үндсэн цалинд шингээж болохгүй юу гэсэн асуулт. Тэгэхээр гүйцэтгэлийн үнэлгээг шингээх судалгааг хийж үзсэн. Тэгэхэд гүйцэтгэлийн үнэлгээнд оролцсон бүх багш нарт 5 хувийн нэмэгдлийг нь олгодог болчихъё гээд ярилцаж үзсэн боловч зарим нэг энэ санхүүгийн асуудал хариуцсан байгууллагатайгаа тохиролцож чадаагүй гэдгээ хэлье. Гүйцэтгэлийн үнэлгээг ор тас шууд үгүйсгэж болохгүй. Энийг харин хялбар, нүсэр биш болгох тал дээр шинэчлэлийг хийж байгаа. Ирэх намар гэхэд гаргаад ирнэ. Энэ жил бид анх удаа бүрэн цахимаар зохион байгуулсан. 6 дугаар ангиас дээших хүүхдүүдийн шалгалтууд цахимаар зохион байгуулагдсан. Цаашдаа багшдаа таатай, хүүхдүүддээ ч ээлтэй байдлаар зохион байгуулж, сайн гүйцэтгэлтэй байгаа багш нарыг урамшуул-даг тогтолцоог үргэлжлүүлэх шаардлагатай гэж харж байгаа.

Харин багш хүн ажилласныхаа төлөө, ажлаа хийчихсэн юм чинь энэ гүйцэтгэлийн үнэлгээнээс тодорхой хэмжээнд тэгш хүртэх ёстой гэдэг таны саналтай 100 хувь хуваалцана.

Юуны өмнө үндсэн цалингаа нэмэгдүүлье, цалингаа нэмэгдүүлье гэсэн энэ шаардлагын тухайд бүрэн ойлгож байгаа. Багшийн цалинг нэмэхгүй бол энэ салбар өөрөө сайн багшгүй болох гээд байна шүү. Улсын Их Хурлын гишүүдээ энэ ирэх төсөв дээр цалин нэмэх асуудлыг дэмжээд өгөөрэй. Боловсролыг дэмжих жилийн хүрээнд боловсролынхоо, багш нарынхаа хөгжлийг дэмжих жилийн хүрээнд та бүхэн багш нарын үндсэн цалинг нэмэгдүүлэх тал дээр анхаараад өгөөрэй. Бусад салбартай харьцуулахад энэ салбарын багш, ажилчдын цалин доогуур байгаа шүү гэдгийг би хэлье. Ийм нөхцөл байдалтай байгааг манай судалгаа харуулдаг. Ингээд 4, 5 дугаар асуултыг нийлүүлээд хариулчхаж болж байгаа байх. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ц.Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхтуяа: П.Наранбаяр сайдаа гүйцэтгэлийн үнэлгээг багш нар буруушаагаад болохгүй байна гээд байна. Тэгэхээр та гүйцэтгэлийн үнэлгээ байлгана гэж яриад байх юм. Гүйцэтгэлийнхээ үнэлгээг болиулаач гэдгийг олон багш нар шаардаж байна. Тэгэхээр энэ дээр та мэдрэмжтэй хандаад, судлаад байна, судлаад байна гээд бараг бүтэн жил ярилаа шүү дээ. Энийгээ нэг чигт нь хандуулахгүй бол багш нар энэ намар ажил хаялт хийнэ гэж байна. Энэ гүйцэтгэлийн үнэлгээгээр.

Д.Амарбаясгалан: П.Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Энэ гүйцэтгэлийн үнэлгээ хийх журмыг шинэчилж байгаа. Жишээлбэл, багш хүн өөрөө өөрийнхөө мэргэжлийн хичээлээрээ зааж байгаа хичээл, судлагдахуунаараа үнэлгээгээ аваад, харин хүүхдүүдээс авч байгаа асуулга, хүүхдүүдийн сурлагын чадварыг нь түүврийн аргаар аваад, сургуулийн удирдах зөвлөлөөс үнэлгээг өгөх ойлгомжтой, өөрийгөө үнэлж болох, өөрийнхөө ажлыг шударгаар үнэлүүлж байгаа эсэхээ харж болох боломжийг бий болгосон байдлаар зохицуулж байгаа. Тэгээд мэдээж багш нар хэрвээ энийг ойлгохгүй бол ойлготол нь хамтдаа ярилцъя. Заавал ажил хаяна, заавал жагсана, заавал энэ таалагдахгүй байна гээд асуудалд хурц хандмааргүй байна. Ярилцаад явъя, сайжруулаад явъя.

Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ боловсролын салбарт орж ирснээр олон дэвшлийг авчирч байгааг үгүйсгэж болохгүй. Салбарын үнэлгээний ажил нь бусад салбаруудад нэвтэрч байгаа. Ер нь төрийн албан хаагчийн хувьд цалин нь амьдралынх нь зардалд бүрэн хүрэхүйц үндсэн цалин байх ёстой. Түүний зэрэгцээ сайн ажиллаж байгаа хүний цалин дээр үнэлгээнийх нь шударга оноо орж ирж, орлого нь нэмэгдэж байдаг тогтолцоог бий болгох нь манай боловсролын салбарт хэрэгтэй байгаа. Би дахин хэлье, үндсэн цалин хүрэлцээтэй байж дээр нь нэмж гүйцэтгэлийн үнэлгээ авах ёстой гэж би боддог. Тэгэхээр намар тэгнэ, ингэнэ гэдэг байдлаар энэ танхимд яриад байх нь жоохон зохимжгүй болов уу гэж би бодож байна. Баярлалаа.

Ц.Мөнхтуяа: П.Наранбаяр сайдаа энэ танхимд миний юу хэлэхийг та заахгүй. Би өнөөдөр дураараа зохиогоод яриад байгаа юм биш. Энэ чинь

боловсролын салбарын олон мянган багшийг төлөөлж байгаагийн хувьд тэднийхээ дуу хоолойг би энэ индэр дээрээс хүргэж байна. Тэрнээс өөрийнхөө дур зоргоор энд ярьдаг газар биш, энэ олон мянган багш нарын хүслийг дамжуулж хэлж байгаа юм гэдгийг танд дахин сануулъя. Та миний дууг хориод ингэж ярихгүй гээд байсан. Би танаар дуугаа хориулахгүй хэлэх ёстой юмаа хэлээд явна гэдгээ танд дахин давтан хэлье. Энэ гүйцэтгэлийн үнэлгээ чинь сая завхарсан шүү дээ П.Наранбаяр сайдаа. Цахимаар авна гээд сүлжээ нь гацаад багш нар өөрсдөө орж чадахаа больсон, энийгээ мэдэж байгаа юу? Тэгэнгүүтээ үнэлгээнийхээ төвийн даргыг солиод, өөрийнхөө намын улс төржилт хийгээд, боловсролын салбарт ажиллаж байгаагүй өөрийнхөө намын хүнийг авчраад тавьчихсан. Тэгээд энэ удаагийн гүйцэтгэлийн үнэлгээг чинь бөөн холион бантан жонхуу болсон гэж бүх багш нар хэлж байна.

Хоёрдугаарт, судалгааны хүрээлэнгийн Итгэл захирлыг солиод, ямар ч доктор, профессор зэрэг цол байхгүй, боловсролын бус хүн авчраад тавьчихсан та. Тэгээд өнөөдөр хөтөлбөр шинэчилнэ гэдэг асуудал чинь “failed-чихсэн” бүтээгүй байгаа. Энийг чинь би зохиогоод яриад байгаа юм биш, бодитой .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ц.Мөнхтуяа гишүүн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар 20 минутын цаг дээр Улсын Их Хурлын албан ёсны веб хуудсанд байршуулсан иргэдийн асуултыг асуух дэгтэй. Ингээд асуултаа асууж, хариултаа авч дууссан. Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах асуулт асууна.

Ж.Галбадрах: Энэ өдрийн мэндийг хүргэе. Юуны түрүүнд 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгож санаачилж, жилээ зарласан Засгийн газрын тэргүүн Л.Оюун-Эрдэнэ, Боловсролын сайд П.Наранбаяр нарт олон мянган багш, ажилчид, сурагч, оюутнуудынхаа нэрийн өмнөөс талархал илэрхийлж байна. Бэлтгэлээ сайн хийх ажил үлдлээ. Хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байгаа. Гэвч 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд дөнгөж боловсролд оруулж байгаа хөрөнгө оруулалт 5 хувь байгааг та бүхэн анхаарна биз дээ.

Ингээд дэгийн дагуу нийт иргэдээс ирсэн асуултыг асуух үүргийг Ц.Мөнхтуяа гишүүн бид хоёрт өгсөн юм байна. Ингээд 14 иргэнээс 22 асуулт ирсэн. Би 11 асуултыг нь асуух юм байна. Энэ дагуу иргэдийн үлдсэн асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: 2 гишүүний үүрэг бол веб сайтаар дамжиж иргэдээс ирүүлсэн асуултыг мэдээлэл хийсэн албан тушаалтнаас асууна.

Ж.Галбадрах: Би болж өгвөл П.Наранбаяр сайд гээд байхаас илүү ажлын хэсгийн мэргэжлийн хүмүүсийг хариулж өгөөсэй гэж хүсэж байгаа. Иргэн Бямбадашаас ирсэн асуултыг асууя. Багш нарын дийлэнх нь орон сууцны нөхцөл тааруу, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн орон сууцад орох хүсэлтэй байдаг. Гэвч цалин хөлс багаас шалтгаалан ипотекийн зээлийн шаардлага хангахгүй байна.

Иймд Засгийн газраас багш нарт зориулсан үнэ хямд, хүү бага, урьдчилгаагүй орон сууцжуулах талаар ямар хөтөлбөр хэрэгжүүлэх вэ, хэрэгжүүлж байна вэ гэдэг асуулт байна.

Дараагийн асуулт багш нарын цалин хөлс, нийгмийн хангамжийг сайжруулах, ажиллах боломж нөхцөлийг нь хангах, техник хэрэгсэл, интернэт сүлжээг чанартай, хүртээмжтэй болгох, сургуулийн төсөв, түүний зарцуулалтыг нээлттэй ил тод болгоход сургуулийн удирдлагыг 5 жил тутамд аттестатчилах, сэлгэн ажиллуулдаг байх шаардлагатай байна. Эдгээр асуудлуудын хүрээнд ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ? Энхбаяр гэж хүн. Дөнгөж төгссөн залуу багш нар ямар ч нэмэгдэлгүй 1 сая 484 мянган төгрөгийн цалин авдаг бөгөөд түүнээс татвар, шимтгэл нь хасагдаад, гар дээрээ 1 сая төгрөг авч байна. Энэ мөнгөөр амьдралаа авч явах ямар ч боломжгүй байгаа учраас багшийн ажлаас шантарч байна. Багшийн цалинг хэзээ мянган ам.долларт хүргэх вэ?

Дараагийн асуулт анги удирдалтын хөлсийг нэмэх, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчилсөн багш, ажилтан нарт дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар ямар хууль дүрэм, тушаал, заавар зөвлөгөө байна вэ? Энэ талаар асуусан байна.

Дараа нь цэцэрлэгийн багш олон хүүхдийн дуу чимээнд нэн хүнд нөхцөлд ажилладаг. Иймээс хөдөлмөрийн нөхцөлийг хүнд гэж авч үзээд, хүнд нөхцөлийн нэмэгдэл олгох, мөн 50 настай тэтгэвэрт гарах шаардлагатай байна. Энэ талаар судалсан уу?

Дараагийн асуулт би 50 хүүхэдтэй 1 дүгээр анги даасан багш байна. Анги удирдсан багшийн нэмэгдэл 10 л хувь байдаг. Хөдөө орон нутагт 20 хүрэхгүй хүүхэдтэй ангийн багш адилхан 10 хувь авч байна. Ажлын ачаалал, үүрэг хариуцлага гээд аль ч талаасаа бодоход энэ шударга бус санагддаг. Анги удирдсан багшийн нэмэгдлийг хүүхдийн тоотой уялдуулан олгох шаардлагатай. Энэ талаар ямар арга хэмжээ авч байна вэ? Сумын багш 40 хувь, аймгийн багш 20 хувийн нэмэгдэлтэй ажиллаж байхад стандартаас давсан хүүхэдтэй, хүүхдүүдтэй ангид хичээл заадаг, амьжиргааны өртөг өндөртэй нийслэл хотод байгаа багш нарт ямар ч нэмэгдэл байдаггүй. Мөн хөдөө орон нутгийн багш нарт эхний 5 жил болон дараагийн 3 жил тутамд 6 сарын цалинтай тэнцэх урамшуулал олгодог. Ийм учраас багш нараа хот, хөдөөгөөр давхар ялгаварласан нь болчимгүй үйлдэл гэж үзэж байна. Энэ ялгаварлан гадуурхах үйлдлээ зогсоож, нийслэлийн багш нарт зориулсан ачааллын нэмэгдэл эсвэл түүнтэй дүйцэх тэтгэмж урамшуулал олгох боломжтой юу?

Манай гэр бүлийн хүн бид хоёр хоёулаа багш. Ипотекийн шаардлага хангадаггүй, 12 жил багшлаад өөрийн гэсэн байр сууцгүй байна. Би ажлаасаа түр чөлөө аваад өндөр цалинтай ажил хийж байна. Эндээ гайгүй бол үндсэн ажлаасаа гарна. Яагаад гэвэл багшийн ажил цалин хөлс бага, нийгмийн баталгаа байхгүй, ажлын ачаалал их байдаг. Гүйцэтгэлийн үнэлгээ гэж хачин заваарсан юмаа болих хэрэгтэй. Энэ тал дээр ямар арга хэмжээ авах вэ? Энэ давхардсан бол уучлаарай давхардуулаад гүйцэтгэлийг ярьчихсан байна. Гүйцэтгэлийн

үнэлгээг түрүүн Ц.Мөнхтуяа гишүүн асуусан гэж бодож байна. Иймд Уртнасан гэдэг хүний асуулт давхардсан тул асуултыг орхичихъя.

Цааш нь Боловсролын ерөнхий хуульд төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, МСҮТ, коллежид тасралтгүй 15-аас дээш жил ажилласан багш, ажилтны 1 хүүхдийг төрийн өмчийн их, дээд сургуульд эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр үнэ төлбөргүй сургана гэсэн заалт байдаг. Манай хүүхэд мэргэжлээрээ суралцдаг, тэр нь эрэлттэй, тэргүүлэх мэргэжилдээ багтаагүйгээс өөрсдөө төлбөрөө төлөөд суралцаж байгаа. Ер нь эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр тасралтгүй 10 жил ажилласан гэсэн хэт хатуу заалтаа хасаж болохгүй юу?

Дараагийн асуулт бага ангийн сурагч бүр ямар сургуульд сурч байгаагаас үл хамаарч улсын төсвөөс олгогддог үдийн хоол, хөтөлбөрт хамрагдах ёстой. Ялангуяа орон нутгийн төлбөр багатай хэдхэн сургуулийн эцэг, эхчүүд төлбөртэй сургуульд хүүхдээ сургасныхаа төлөө үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж чаддаггүй байна. Иймд нэг ч хүүхэд ялгаварлагдах ёсгүй тул энэ тал дээр ямар арга хэмжээ авч байна вэ?

Үндэсний цөөнхийн 12 дугаар ангийн зарим төгсөгчид тухайн аймаг нь элсэлтийн шалгалтаар сүүл мушгидаг гэх шалтгаанаар элсэлтийн шалгалтад орох эрхээ хасуулах нь боловсролыг тэгш хүртээж байгаа хэрэг гэж үзэж байна уу сайдаа гэсэн байна?

Дараагийн асуулт, орон нутгийн багш нарт сар бүр олгох хоолны мөнгөний зардал 2025 оны төсөвт суусан уу? Мөн өмнөх жилийн хэмнэсэн зардлаас олгох гэсэн журмын нэг заалт байна. Төсөв нь хүрэхгүй байгаа боловсролын салбарт хэмнэгдсэн төсөв гэж байдаг уу? Ийм юм байж болох уу гэсэн асуултууд ирсэн байна. Зарим хүний асуултыг Ц.Мөнхтуяа гишүүн асуусан гэж үзээд ирсэн асуултуудыг нь байгаагаар нь уншиж сонсголоо.

Д.Амарбаясгалан: П.Наранбаяр сайд хариулт өгье. Нэмж хариулт өгөх албаны хүмүүс 4 дүгээр индэр дээр очно уу?

П.Наранбаяр: Олон асуулт байгаа учраас зарим нэгийг нь хариулахгүй үлдээчхэж магадгүй. Тэр тохиолдолд манай ажлын хэсгээс хариулж өгөхийг хүсье. Унаа, хоолны энэ хоолны мөнгө 2025 оны төсөвт суусан уу гээд. Унаа, хоолны нөхөн төлбөр нь нэг хүүхдэд ноогдох нь хувьсах зардлын бүрэлдэхүүн хэсэгт тусаагүй. 2025 оны батлагдсан төсөв болон сургалтын байгууллагуудын 2024 оны жилийн эцсийн үлдэгдэл эх үүсвэрийг дайчлах замаар олгох чиглэлийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн. Унаа, хоолны нөхөн төлбөрийг орон нутагт 5000 төгрөг, нийслэлд өдөрт 8000 төгрөгөөр тогтоож олгоход жилд 154.4 тэрбум төгрөгийн төсвийн нөлөөтэй байгаа юм. 2024 онд сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад нийт 150.9 төгрөг тэрбум, үүнээс цалингийн сан нь 132.1 тэрбум төгрөг. Ерөнхий боловсролын сургуулиудад нийт 227.5 тэрбум төгрөг, үүнээс цалингийн сан нь 196.5 тэрбум төгрөгийн үлдэгдэл үүссэн байгаа. Тэгэхээр эндээс бүрэн санхүүжүүлэх боломжтой. Харин зарим нэг сургууль дээр хүүхэд цөөнтэй сургууль дээр асуудал үүсэж байгааг ойлгоод, тэрийг яамны зүгээс шийдвэрлэхээр ажиллаж байгаа гэдгээ хэлье.

Үндэсний цөөнхийн 12 дугаар ангийн зарим төгсөгчид аймгийн элсэлтийн шалгалтаар сүүл мушгидаг шалтгаанаар элсэлтийн шалгалтад орох эрхээ хасуулсан гэх зүйл яригдсан уу? гэсэн асуулт байна. Монгол хэл бичгийн шалгалтыг жилд 2 удаа зохион байгуулж байгаа. Ямар ч хүүхдийг сурлагын байдлаас нь шалтгаалаад элсэлтийн шалгалтад оруулахгүй байх нь өөрөө шууд хүний эрхийн зөрчил. Тийм учраас ийм зүйл байж болохгүй гэдгийг яамнаас хэлж байгаа, чиглүүлж байгаа. Баян-Өлгий аймгийн хүүхдүүд, мөн Ховд аймагт байгаа казах болоод тува хэлтэй хүүхдүүдийн сурлагын чанарыг сайжруулахад саяхан гаргасан хос хэлний боловсрол сургалтын талаар баримтлах чиглэл чухал арга хэмжээ болж байгаа улмаар ирэх хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлнэ.

Бага ангийн сурагч өмчийн хэлбэрээс үл хамаараад үдийн хоолны зардлыг олгох нь зүйтэй гэсэн санал ирсэн байна. Энэ бол хуулийн заалттай. Боловсролын ерөнхий хуулийн 38.5.6-д төрийн болон орон нутгийн өмчийн Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны зардлыг улсын төсвөөс бүрэн хариуцахаар зааснаар 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн бус өмчийн сургуулийн бага ангийн суралцагчийн үдийн хоолны зардлыг олгохоо больсон. Өнөөдөр төрийн өмчийн 705 сургуульд суралцаж байгаа бага ангийн 343,289 суралцагчийн үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж байгаа. Төрийн бус өмчийн 180 сургуульд бага ангийн 3,658 суралцагч сурч байна. Бага ангийн суралцагчийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор 2500 төгрөгөөр тогтоож, 2025 оны улсын төсөвт 150 тэрбум төгрөгийг батлан зарцуулж байна.

Төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, МСҮТ-д коллежид тасралтгүй 15-аас дээш жил ажилласан багш, ажилтны нэг хүүхэд их, дээд сургуульд суралцахад нь төлбөргүй хөнгөлөлттэй нөхцлөөр суралцах асуудлыг хөндсөн байна. Энэ талаарх зохицуулал-тыг Боловсролын ерөнхий хуульд эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр сурах тохиолдолд гэж тодорхой заасан. Үүнээс болж хохирч байгаа багш нар байгааг үгүйсгэхгүй. Энэ хуулийн 13.3.6-д тусгагдсан заалтаас болж байгаа гэдгийг танд тайлбарлаж хэлье. Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолын дагуу 2024 онд 571 суралцагчид 2 тэрбум төгрөг 2025 онд 587 суралцагчид 1.5 тэрбум төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлээд байна.

Ипотекийн зээл авах хүсэлтэй боловч цалин орлого хүрэхгүй байна гэсэн асуулт байна. Түрүүн би энэ асуултад хариулсан учраас алгасаад явчихъя. Энэ цалин хүрэхгүй байгаа асуудлаа түрүүнд ярилцсан. Гүйцэтгэлийн үнэлгээний тухайд түрүүнд бас ярьчихсан. Эхнэр бид хоёр хоёулаа багш болохоор гээд ипотекийн зээлийн шаардлага хангадаггүй 12 жил багшлаад өөрийн гэсэн байр сууцгүй байна гэсэн энэ асуултын тухайд аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээний 3.5.2-т мэргэжлийн багшийн хомсдолыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж байгаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцын болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх талаар тусган ажиллаж байна.

Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль багшийн түрээсийн орон сууц, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр хамруулах хөтөлбөрийг Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх гэж заасан байгаа. Энэ заалтыг хэрэгжүүлэхээр ажиллана. Ер нь 8 айлын орон сууц гээд нэг шийдэл байгаа. Мөн багшийн нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр Үйлдвэрчний эвлэлтэй холбогдож, хамтран багш нарын орон сууцын хөнгөлөлттэй зээл болон орон сууцаа сайжруулах нөхцөлийг судлах судалгааг 2025 онд хийхээр төлөвлөсөн байгаа.

Сумын багш нарт 40 хувь, аймгийн төвийн багш нарт 20 хувийн нэмэгдэлтэй ажиллаж байхад нийслэлийн багш нарт өгөхгүй байгаа, багш нараа ялгаварлаж болохгүй гэсэн зүйл дээр хариулахад нийслэлийн багш нарын цалин хөлсний судалгааг бид хийж, саналаа танилцуулна. Гэхдээ нэг зүйл бол хөдөөд багш нар их дутагдалтай байгаа. Ялангуяа англи хэл, математик, физик, хими гээд мэргэжлийн багшийн дутагдал маш их байгаа. Тэгээд энэ дутагдлыг арилгахын тулд хөдөөд багш нарыг шилжүүлэх, суурьшлыг бий болгох зорилгоор явуулж байгаа бодлого гэдгийг та бүхэн ойлгож хандаарай.

Хүүхдийн тооноос хамааруулж анги удирдсан багшийн ачааллыг бууруулах тухайд 44-өөс дээш хүүхэдтэй бүлгүүдэд энэ хичээлийн жилээс эхлээд туслах багшийг ажиллуулах шийдвэрийг гаргаад ажиллаж байна. Анги даалтын нэмэгдлийг 30 хүртэлх хүүхэдтэй ангийн багшид 10 хувь, 30-40 хүүхэдтэй ангийн багшид 15 хувь, 40-өөс дээш хүүхэдтэй ангийн багшид 20 хувь байхаар тооцоход жилдээ 15.7 тэрбум төгрөгийг нэмэлтээр шаардлагатай гэсэн тооцоо гарсан. Үүнийг бид хувьсах зардалд оруулж чадвал энэ асуудлыг шийдэх боломжтой гэж харж байна.

Цэцэрлэгийн багшийн хүнд нөхцөлийн тухай дурдсан. Тэгэхээр 50 болон түүнээс дээш настай багш нар тэтгэвэрт гарах шаардлагатай гэсэн зүйл ярьж байна. Сонголтоороо тэтгэвэрт гарах боломжийн талаар судалж үзэхээр яригдаж байгаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс 2019 онд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмжийн хүрээнд цэцэрлэг, сургуулийн багш нарын хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийсэн. Энэ судалгааны үр дүнгээр цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын байр өнөөдрийн байдлаар хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр үнэлэгдээд байгаа.

Боловсролын салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх тухайд одоо байгаа 4.7 хувийг 7 хувьд хүргэх, эсвэл төсвийн зардлын 13 хувь байгааг 20 хувьд хүргэх юм. Энэ дэмжих жилийнхээ хүрээнд хэрвээ нэмж чадвал ДНБ-ий 5.7 хувь, төсвийн нийт зардлын 15.5 хувь байхаар тооцож Сангийн яам руу явуулсан байгаа. Эдийн засгийн хөгжлийн яаманд бас хүргүүлсэн. Салбарын төсвийг дотоодын нийт бүтээгдэхүүний 7 хувьд хүргэхэд 2025 онд батлагдсан төсвийг 2.5 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэх ийм шаардлага үүснэ. Анги удирдах хөлсийг нэмэх талаар түрүүнд хариулсан.

Дөнгөж төгссөн залуу багш ямар ч нэмэгдэлгүй гээд ярьсан. Тэгэхээр залуу багш нарын шилжилт хөдөлгөөн, ажлаас гарах шалтгаануудын үндсэн нэг шалтгаан нь багшийн цалин хөлс байгаа. Өнөөдрийн байдлаар Засгийн газраас тогтоосны дагуу цэцэрлэгийн багш 1 сая 559 мянган төгрөгийн үндсэн цалин авч байна. Ерөнхий боловсролын сургуулийн хувьд шинэ багш нь 1 сая 494 мянган төгрөгөөс 2 сая 681 мянган төгрөгийг гар дээрээ авч байгаа бол 20-оос дээш ажиллаж байгаад багш нар 2,582,950.0-3,206,550.0 төгрөг авч байна.

Багш нарын шилжилт хөдөлгөөн, ажлаас гаралтад сургуулийн удирдлага, зохион байгуулалт ихээхэн нөлөө үзүүлдэг. Иймээс сургууль, цэцэрлэгийн менежментийг сайжруулах арга хэмжээг 2023 оноос эхлээд хэрэгжүүлж байгаа. Салбарын сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай Боловсролын салбарт хамтран ажиллах гэрээ орон нутгийн удирдлага мэргэжлийн багшийн хомсдолыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, цэцэрлэг, багшийн, ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцын болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх асуудлыг тусган хэрэгжүүлж байна. Энэ оны 3 дугаар сарын байдлаар багшийн дундаж цалин нь 2,809,191.0 төгрөг байгаа нэмэгдлүүдийг бүгдийг нь оруулсан тоо гэдгийг дахин хэлье. Цалинг 3 сая төгрөг хүргэхэд 418.1 тэрбум төгрөг нэмэлтээр шаардлагатай байна. Багш нарынхаа цалин хөлс, нийгмийн хангамжийг сайжруулах тал дээр улсын хэмжээнд 2024 оны 4 дүгээр улиралд ажиллагчдын сарын дундаж цалин 2,332,400.0 төгрөг байхад боловсролын салбарт ажиллагчдын сарын дундаж нь 2,018,100.0 төгрөг байгаа. Энэ нь улсын дунджаас доогуур байгааг би түрүүн дурдсан. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн цалинг жил бүр 6 хувиар нэмэгдүүлнэ гэж үзвэл цаашид цалин нэмэгдээд явах боломжтой гэж харж байгаа.

Боловсролын салбарын цахим дэд бүтцийг бүрэн шийдвэрлэж, боловсролын нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, дэд бүтцийг боловсролын танхим бүрд утастай болон утасгүй сүлжээнд холбогдох боломжийг бий болгох, сургууль бүрд хүүхдийн тоо, хүчин чадлаас хамааруулан орчин үеийн цахим танхим байгуулах, цахим хуваагдлыг арилгах үүднээс суралцагч бүрд зөөврийн төхөөрөмж олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар цахим сургалтын орчин бүрдүүлж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангана.

Сургуулийн удирдлагыг сэлгэн ажиллуулах журам гарсан. Энэ нь нийслэл болоод аймгийн төв дээр байгаа гэдгийг та бүхэнд анхааруулж хэлье. Энэ хичээлийн жилд Улаанбаатар хотод нийт 18 сургуулийн захирлыг сэлгэн ажиллуулсан байгаа. Цаашдаа сургуулийн удирдлагуудыг аттестатчилах, шалгаж үзэх, 5 жил тутамд сэлгэн ажиллуулдаг шаардлагыг бид хүлээж авч байна. Нэг сургууль дээр олон жил хадагдаад байхаараа эерэг биш сөрөг үр дүн нь давамгайлах хандлага байдгийг бүрэн хүлээн зөвшөөрнө.

Орон сууцжуулалтын талаар олон асуулт ирсэн учраас энэ асуудлыг дахин харъя. Боловсролын ерөнхий хуулийн 13.4-т багш, ажилтны амьдрах

нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ гэж заасан байгаа. Тэгэхээр Монгол Улсын Засгийн газраас 2025 онд иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд 13 мянга орчим иргэдийг хөтөлбөрт хамруулах ба үүний 50-аас доошгүй хувийг орон нутагт олгоход зориулан улсын төвөөс 123.5 тэрбум төгрөг, бусад эх үүсвэрээс 1.3 их наяд төгрөгийг зарцуулахаар тусгасан. Орон нутгийн ипотекийн 3 хувийн зээлийг үргэлжлүүлэн олгож, амины орон сууцыг ипотекийн зээлд хамаарах боломжийг олгохоор ажиллаж байна. Түүнүнд тэтгэврийн асуудлыг хариулсан. Багш нарын үндсэн цалинг нэмэх асуудал дээр бид .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 20 минутын хугацаа дууссан байна. Нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын боловсролын салбартай холбоотой асуудлаар мэдээллийг сонсож, иргэдээс ирсэн албан ёсны асуултад асуулт асууж, хариулт авч дууслаа.

---oOo---

1.4. 2025 ОНЫ 6 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД “ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ТАЛААР” ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ



Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, «Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал», “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогуудын хэрэгжилтийг хангах хүрээнд “Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт туссан хүнс,

хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дээрх хөгжлийн бодлого, чиглэлийн хүрээнд:

- уламжлалт өв соёлыг хадгалсан бэлчээрийн мал аж ахуй зонхилсон, дэвшилтэт техник, технологи бүхий эрчимжсэн аж ахуйг хот суурингийн орчимд бүсчилэн хөгжүүлж, генетик нөөцийг тогтвортой, зохистой ашиглан, ногоон эдийн засгийн чиг баримжаатай мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх,
- үржил шим бүхий хөрсөнд тариалсан монгол таримлын өрсөлдөх чадвар, үнэ цэнийг өсгөж, экспортыг нэмэгдүүлэх, технологийн хурдтай хөгжил, хиймэл оюун ухаан, блокчэйний нэвтрэлт, их өгөгдөл зэрэг технологийн дэвшлийг нэвтрүүлэн салбарын үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлэхэд Засгийн газар анхаарч ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар 2024 оны байдлаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 31.7 хувь, экспортын орлогын 5 хувийг тус тус бүрдүүлж, нийт ажиллах хүчний 45.3 хувь нь тус салбарт ажиллаж, орон нутгийн эдийн засагт 85 хувийг эзэлж байна.

Хүнсний аюулгүй байдал, хангамж, иргэдийн эрүүл, зөв амьдрал, хүний бие махбодын хэрэгцээ шаардлагад нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй, дотоодын баталгаат үйлдвэрлэлээс бүрэн хангах, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, экосистемийн тэнцвэрт байдлын

доройтол, цөлжилтийн сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг хангаж ажиллаж байна.

Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал”, “Цагаан-Алт” үндэсний хөдөлгөөн, Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж байгаа “Шинэ хоршоо” хөдөлгөөн, “Атар-4” газар тариалангийн тогтвортой хөгжлийн аян зэрэг дунд хугацааны бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч байна.

Нэг. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн талаар:

Манай Улсын хөдөлмөр эрхэлдэг 4 хүн тутмын 1 нь буюу 308.7 мянган малчид мал аж ахуйн салбарт ажиллаж байна. Малчдын тоо өмнөх оноос 10.4 мянга буюу 3.5 хувиар өсөж, нийт малчдын 185.4 мянга буюу 60.1 хувь нь эрэгтэй, 123.3 мянга буюу 39.9 хувь нь эмэгтэй малчид байна. Мал тооллогын 2024 оны жилийн эцсийн дүнгээр улсын хэмжээнд 57.6 сая толгой мал тоологдсноос 4.7 сая адуу, 5.1 сая үхэр, 480.6 мянган тэмээ, 24.5 сая хонь, 22.9 сая ямаа тус тус тоологдсон байна.

Улсын хэмжээнд 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар 19 сая төл хүлээн авч, төл бойжилт 98.6 хувьтай, бод малын төллөлт үргэлжилж байна. Урьдчилсан байдлаар энэ онд нийт 20 орчим сая төл хүлээн авч, мал сүргийн тоо 77.6 сая толгойд хүрч мал аж ахуйн салбарт өсөлт гарахаар байна.

Хэдийгээр малын тоо өсч, эдийн засагт өсөлт гарахаар байгаа ч Монгол орны бэлчээрийн даац хэвийн жилд 85 сая хонин толгой малыг тэжээлээр хангах нөөцтэй байдаг. 2025 оны зун, намрын улиралд нийт малын тоо хонин толгойд шилжүүлснээр 110.0 сая толгой болж, даацаас 25 сая хонин толгойгоор хэтрэх төлөвтэй байна.

Иймд хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд мал, махны бэлтгэлийг идэвхжүүлэх, гадаад зах зээлийн орчинг өргөтгөх, дотоодын бэлтгэлийг нэмэгдүүлэх зэрэг зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Дотоодын боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, импортлогч улсын шаардлага хангахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал”, “Цагаан-Алт” үндэсний хөдөлгөөн, Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж байгаа “Шинэ хоршоо” хөдөлгөөн, “Атар-4” газар тариалангийн тогтвортой хөгжлийн аян зэрэг арга хэмжээ томоохон хувь нэмэр оруулж байна.

Малын чанар, ашиг шимийг сайжруулах, салбар дундын уялдааг хангах “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 38 дугаар тогтоолын хүрээнд өндөр ашиг шимт сайжруулагчаар хангаж, үржлийн аж ахуйнуудыг чадавхжуулж, мал аж ахуйгаас үйлдвэрлэх мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүллээ.

“Атар-4” аяны хүрээнд өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн үхэр сүргийн тоог 200 мянган толгойд хүргэх зорилтын хүрээнд мах, сүүний чиглэлийн өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн нийт 617 толгой үхрийг үржлийн аж ахуйд нийлүүлээ.

Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 60 сая толгой мал хамруулахаас 58.4 сая толгой мал хамруулж, гүйцэтгэл 97 хувьтай байна. Үүнээс гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 46.2 сая толгой мал, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтад 4.2 сая толгой мал, намрын нэгдсэн дархлаажуулалтад 2.4 сая толгой мал хамрагдсан. Үүний дүнд гоц халдварт өвчний голомтын тоо 49 хувь, халдварын гаралтын тоог өмнөх оны мөн үеийнхээс 98 хувиар тус тус бууруулсан байна.

Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотноо 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-ын 92 дахь удаагийн Ерөнхий чуулганы хуралдааны үеэр Монгол Улсын шүлхий өвчинтэй тэмцэх албан ёсны үндэсний хөтөлбөрийг баталгаажууллаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Дэлхийн банкны Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх (LCP) төсөл хамтран Биокомбинат ТӨХХК-д 1.3 тэрбум төгрөгийн “Шугаман эсийн технологи нэвтрүүлэх төсөл”-ийг амжилттай хэрэгжүүлэн, вирусийн гаралтай вакцины уламжлалт технологийг өөрчлөн шугаман эс (cell line)-ийн технологид шилжүүлснээр вакцины дотоодын үйлдвэрлэл нэмэгдүүлэх боломжийг бүрдүүллээ. “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дэлхийн банкны “Экспортыг дэмжих төсөл”-ийн 1.1 сая ам.долларын санхүүжилтээр Арьс ширний төв лабораторийг бүрэн шинэчиллээ.

Хоёр. Газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар:

Ургац хураалтын 2024 оны жилийн эцсийн дүнгээр 336.1 мянган га талбайгаас 430.0 мянган тонн үр тариа, үүнээс 386.4 мянган тонн улаанбуудай, 18.6 мянган га-гаас 250.8 мянган тонн төмс, 17.2 мянган га-гаас 267.3 мянган тонн хүнсний ногоо, 96.1 мянган га-гаас 246.9 мянган тонн тэжээлийн ургамал, 115.2 мянган га-гаас 53.3 мянган тонн тосны ургамал тус тус хураан авч, 288.1 мянган га-д чанар сайтай уринш бэлтгэсний 150.7 мянган га талбайг нь дэвшилтэт технологиор боловсруулсан байна.

Хураасан ургацын хэмжээг 2023 онтой харьцуулахад улаанбуудай 13.1 хувь, тосны ургамал 3.7 хувь буурсан бол төмс 37 хувь, хүнсний ногоо 20 хувиар тус тус нэмэгдүүлсэн.

“Атар-4” тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг хэрэгжүүлэх хүрээнд улсын төсвийн 9.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар тариалан бүхий аймгуудад тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах зорилгоор нийт 361.2 мянган ширхэг төмөр бетон шон, хөргөлттэй агуулахын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд 13.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 200-500 тонн багтаамжтай төмс, хүнсний ногооны зоорийн барилга, 1.1 тэрбум төгрөгөөр 10 га талбайд жимс, жимсгэний суулгац үржүүлгийн газрыг тус тус байгуулж байна.

Улсын хэмжээгээр 2025 онд хаврын тариалалт 360.7 мянган га-д үр тариа, үүнээс 310.1 мянган га-д улаанбуудай, 17.1 мянган га-д төмс, 16.5 мянган га-д хүнсний ногоо, 144.1 мянган га-д малын тэжээл, 103.7 мянган га-д тосны ургамал, өссөн дүнгээр 7.9 мянган га-д жимс, жимсгэнэ нийтдээ 650.1 мянган га-д тариалалт хийхээр зорилт тавьсан. Тариалалт 6 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд 470.3 мянган га буюу 73.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үүнээс улаанбуудай 264.8 мянган га буюу 85.3 хувь, бусад үр тариа 34.8 мянган га буюу 68.8 хувь, төмс 11.2 мянган га буюу 65.6 хувь, хүнсний ногоо 9.1 мянган га буюу 55.1 хувь, малын тэжээл 31.4 мянган га буюу 21.8 хувь, тосны таримал 118.8 мянган га буюу 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улаанбуудайн тариалалт дууссан бөгөөд одоо малын тэжээлийн тариалалт 21.8 хувь, хүнсний ногооны тариалалт 55.1 хувьтай явагдаж байна.

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2024 оны намрын ургацаас 40.5 мянган тонн хүнсний улаанбуудайг хүлээн авч нийт 70.7 мянган тонн стратегийн нөөцийн хүнсний улаанбуудай, мөн 9 сортын 5.5 мянган тонн үрийн буудайг нөөцийг тус тус бүрдүүлэв.

“Хөдөө аж ахуйн корпорари” ТӨХХК-иар дамжуулан борлуулах үйлчилгээг нэвтрүүлэн, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх реформ хийснээр дотоодын бизнес эрхлэгчид болон дилер компаниудын үйл ажиллагааг идэвхжүүлж, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 5.6 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмж, 9.7 тэрбум төгрөгийн бордоо, 1.3 тэрбум төгрөгийн ургамал хамгааллын бодисыг тариаланчид, фермерүүдэд нийлүүлсэн.

“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ий үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох, борлуулж буй бараа бүтээгдэхүүнийг олон улсын жишиг зарчимд нийцүүлэх зорилгоор “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-иас борлуулж буй бараа бүтээгдэхүүнийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн биржийн арилжаагаар худалдан борлуулж, өнөөдрийн байдлаар 35 удаагийн дуудлага худалдаа, 109 хэлэлцээр зохион байгуулж 41.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн, “Атар-4” аяны хүрээнд улсын төсвийн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Вирусгүй төмсний бичил булцуу өсгөвөрлөх үржүүлгийн лаборатори”-ийг байгуулаад байна.

Гурав. Хүнсний үйлдвэрлэлийн талаар:

Хүнсний үйлдвэрлэлийн салбарын борлуулалтын орлого 2024 онд 10.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 7.25 хувиар өссөн байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд мах, махан бүтээгдэхүүний экспортын орлого нийт 600 сая гаруй ам.долларт хүрч, цаашлаад мах, махан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх нөхцөлийг бүрдүүллээ.

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд зоорийн багтаамж 15 хувь, үтрэмийн багтаамж 7 хувь, тариалангийн талбай 13 хувь, зуны болон өвлийн хүлэмж 28 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл 37 хувь, ажлын байр 21 хувь, дундаж борлуулалтын орлого 31 хувь, дундаж цэвэр ашиг 32 хувь, үндсэн хөрөнгө 55 хувь, эргэлтийн хөрөнгө 38 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 46 хувь, нийгмийн даатгал 60 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

- Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах 8;
- Мал төхөөрөх, мах боловсруулах 10;
- Гурилан бүтээгдэхүүн боловсруулах 12;
- бусад чиглэлийн 9 үйлдвэр нийслэл болон орон нутагт байгуулагдаад байна.

Нийслэлийн хүн амын хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан нийт 8380.0 тонн махыг бэлтгэн нөөцөлсөн ба 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 2900 тонн махыг борлуулж, 5480 тонн махны үлдэгдэл нөөцтэй байна.

2024-2025 онд сүүний урамшууллыг 14 аймгийн 31 үйлдвэр, цехэд нийт 18.9 сая литр түүхий сүү нийлүүлсэн 9920 малчин, фермерт 18.9 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна. Мөн 2025 онд 14 аж ахуйн нэгжид нийт 5.0 мянган тонн үрийн улаанбуудай, 7 аж ахуйн нэгжид нийт 3.0 мянган тонн хуурай сүү, 4 аж ахуйн нэгжид 32.0 мянган тонн хүнсний улаанбуудай импортлох стратегийн хүнсний зөвшөөрөл олгосон байна.

Дөрөв. Хөнгөн үйлдвэрлэлийн талаар:

Хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл технологийн паркуудыг төвийн бүсэд Дархан-Уул аймагт “Төвийн бүсийн Хүнс, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк”, баруун бүсэд Ховд аймагт “Шинэ Ховд аж үйлдвэрийн парк”, нийслэлд “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”, говийн бүсэд Говьсүмбэр аймагт “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”, зүүн бүсэд Дорнод аймагт “Зүүн бүсийн үйлдвэрлэл технологийн парк” байгуулахаар төлөвлөн, ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

Эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 310 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 5 мянган тонн ноолуур бэлтгэсэн нь түүхий ноолуурын 50 хувийг анх удаа үндэсний үйлдвэрүүд худалдан авах боломжийг ханган ажиллаа.

Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 23.7 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 1.2 сая ширхэг бог, 488.5 мянган ширхэг бодын шир бэлтгэх нөхцөл бүрдээд байна. 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар 17 аж ахуйн нэгжийн 117.1 сая төгрөгийн гаалийн татварыг чөлөөлсөн үзүүлэлттэй байна.

4.1. “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний талаар:

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй 1.2 их наяд төгрөгийн арилжааны банкны эх үүсвэр бүхий хөнгөлөлттэй зээлийг 2,577 иргэн, аж ахуйн нэгжид олгож, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамжийн түвшинг нэмэгдүүлж, шинээр 52 хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулж, хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг 714-өөр нэмэгдүүлсэн байна.

Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар мах, махан бүтээгдэхүүний экспортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэснээр 2024 онд 71.1 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолж, 269 сая ам.долларын орлогыг бүрдүүлсэн.

4.2. “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний талаар:

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 63 дугаар тогтоолын хүрээнд:

- ноолуурын бүрэн боловсруулалтын түвшинг 40 хувь, үйлдвэрлэлийг 2.3 их наяд төгрөг, экспортын орлогыг 690 сая ам.долларт хүргэж, шинээр 3000 гаруй ажлын байрыг бий болгох;
- ноосны боловсруулалтын түвшинг 55 хувь, үйлдвэрлэлийг 670 тэрбум төгрөг, экспортын орлогыг 119 сая ам.долларт хүргэж, шинээр 2200 орчим ажлын байр бий болгох;
- арьс, ширний боловсруулалтын түвшинг 50 хувь, экспортын орлогыг 22.4 сая ам.долларт хүргэж, шинээр 3000 гаруй ажлын байр бий болгох зорилтыг дэвшүүлсэн.

Үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах, ноос, ноолуур, арьс ширний бэлтгэл, үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Засгийн газрын хүүгийн дэмжлэгтэй, арилжааны банкны эх үүсвэрээр 121 үндэсний үйлдвэрт 440.9 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.

Хөнгөн үйлдвэрийн салбарт 2024 онд 404.1 сая ам.долларын экспортын орлогыг бүрдүүлж, Засгийн газрын 2025 оны 46 дугаар тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын үйлчлэх хугацааг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэснээр түүхий ноолуурын 50 гаруй хувийг үндэсний үйлдвэрүүд худалдан авсан байна.

4.3. “Шинэ хоршоо” хөдөлгөөний талаар:

Мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, гэнэтийн гамшиг ослын үеийн эрсдэлийг бууруулах, малчин өрхийн

амьжиргааг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдал, тогтвортой нийлүүлэлтийг бий болгох, хоршоологч, үйлдвэрлэгчийн түншлэлийг дэмжиж, жижиг, дунд үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, хотын төвлөрлийг бууруулах ач холбогдол бүхий “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”, “Шинэ хоршоо” хөдөлгөөн өрнүүлэх тухай” Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын хүрээнд “Шинэ хоршоо” хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо”-г Монгол Улсын Шадар сайдаар ахлуулан ажиллуулж байна.

“Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийн 9,689 хоршоо шинээр байгуулагдаж, 95,118 малчин хоршоонд элсэж, 6,885 хоршооны 23,581 малчинд 798.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийг олгож, 300 тэрбум төгрөгийн зээлд батлан даалт гаргасан байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд 2024-2025 онд 57.4 тэрбум төгрөгийг эргэн төвлөрүүлж, нийт 395 төсөлд 55.9 тэрбум төгрөгийн зээл олгож, 1,083 ажлыг байрыг шинээр бий болголоо. Засгийн газрын 2025 оны 48 дугаар тогтоолоор “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгох шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулан батлууллаа.

4.4. “Атар-4” газар тариалангийн тогтвортой хөгжлийн аяны талаар:

Засгийн газрын 2025 оны “Аян өрнүүлэх тухай” 47 дугаар тогтоолоор тариалангийн тогтвортой хөгжлийг хангах “Атар-4” аяныг улс орон даяар эрчимжүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр тус аяныг албан ёсоор зарлан эхлүүлсэн.

Аяны хүрээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд арилжааны банкны эх үүсвэрээр 800.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 522 иргэн, аж ахуйн нэгжид 244.6 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна.

Засгийн газрын 2025 оны “Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай” 166 дугаар тогтоолоор Төв, Дорнод, Хэнтий, Дундговь, Дархан-Уул, Говьсүмбэр аймгуудад тариалангийн талбайг 71.2 мянган га-аар нэмэгдүүллээ.

**2025 ОНЫ 6 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН
ХУРАЛДААНД “ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЛБАРЫН ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ТАЛААР” ХИЙСЭН МЭДЭЭЛЛИЙГ
ХЭЛЭЛЦСЭН ТАЛААР**

Чуулганы нэгдсэн хуралдаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Шаравын Мөнхцэрэн, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Ядамсүрэнгийн Эрдэнэсайхан, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Аюушжавын Нарантуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Мэндбаярын Дондогдорж, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Довчинсүрэн, Салбарын хяналтын газрын дарга Баясгалангийн Батшагай, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цэвэгмэдийн Мөнхнасан, Зээлийн батлан даалтын сангийн Ерөнхий захирал Сарантуяагийн Цогтсайхан, “Шинэ хоршоо” хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны дарга Ёндонгийн Азжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажил”-ын талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, ХҮН намыг Г.Уянгахишиг, Иргэний Зориг Ногоон намыг М.Нарантуяа-Нара нар төлөөлж үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу цөөнхийн төлөөллөөс Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Г.Ганбаатар, Ш.Бямбасүрэн, Б.Жаргалан, С.Цэнгүүн, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, “Шинэ хоршоо” хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны дарга Ё.Азжаргал нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-д заасны дагуу цахим хуудсанд 2 иргэнээс ирүүлсэн 7 асуултыг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар, Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нар асууж, хариулт авав.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайдад баярлалаа. Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөлөл Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар 2024 оны байдлаар Монгол Улсын ДНБ-ий 31 хувь, экспортын орлогын 5 хувийг бүрдүүлж, нийт ажиллах хүчний 45 хувь нь тус салбарт ажиллаж, орон нутгийн эдийн засагт 85 орчим хувийг эзэлж байгаа томоохон салбар хэдий ч хөдөө аж ахуйн салбар, тэр дундаа мал аж ахуйн салбарт ажиллаж буй ажиллах хүчний 50 орчим хувь нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур буюу ядуурлын түвшинд хамрагдаж, үлдсэн хэсэг нь ядуурлын түвшний дээхнүүр орлоготой аж төрж байгааг Үндэсний статистикийн хорооны ядуурлын түвшинд танилцуулсныг эхэнд эш татъя.

Манай улсын хөдөлмөр эрхэлдэг 4 хүн тутмын 1 нь буюу 308 орчим мянган малчид мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа томоохон салбар. Монгол Улсын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах гол салбарын хувьд хөгжлийн буруу бодлого, уялдаагүй төлөвлөлт, онцгүй санхүүжилтийн уршгаар энэ салбарын эдийн засгийн үзүүлэлт 2024 онд 28 орчим хувиар унажээ. Гэвч холбогдох салбарын яам нь малын тоо, хүлээн авсан төл, тариалсан болоод хурааж авсан ургацын тоон статистик тайланг тавьж төрийн гэх нэрээр үргүйдүүлж, үнэ цэн алдуулж буй сонгуулийн далд тогтолцоог дэмжих зориулалттай үндэсний тодотголтой гоё нэртэй хөтөлбөр, аян арга хэмжээний өртөг өндөртэй зохион байгуулалтаас хэтрэхгүй ажиллаж буй нь ард иргэдээ ядуурлын хонхроос гарч чадахгүй, хий эргэхэд хүргэж байна.

Ерөнхий сайдын мэдээлэлд салбарын яамны бодлого нь өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд мал махны бэлтгэлийг идэвхжүүлэхэд чиглэж, бодлогод тусгасан байгаа нь мал аж ахуйн салбарын бодлого үндсээрээ буруу байна гэж дүгнэхэд хүргэж байна. Эрх баригчид 1960-1980-аад оны социалист нийгмийн үеийн нэгдлийн үед үүсгэсэн мал бэлтгэлийн тогтолцоог одоо ч ашиглаж, нийслэлийнхэнд гарал үүсэл нь тодорхойгүй мах нийлүүлж байна. Гэхдээ малчид, иргэдийнхээ хөгжих боломжийг хаасан улс төрчдийн популист амлалтын золиосоор энэ салбарын өрсөлдөөнийг хааж, хөгжлийг боомилж, улмаар бодитоор хөгжих, экспорт хийх, олон 100 мянган малчдын орлого нэмэгдэх, дагаад боловсруулах үйлдвэрлэл хөгжих харьцангуй давуу талыг царцаасан байдалтай байна. Энэхүү мэдээлэлд хүнсний салбарын борлуулалтын орлого 2024 онд 10 их наяд төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 7.25 хувиар өссөн байна гэсэн нь 2024 оны жилийн дундаж инфляц болох 6.8 хувийн нөлөөллийг хасаж тооцоход 1 хүрэхгүй хувийн өсөлтийн тухай яриа байна.

Манай улсын хөдөө аж ахуйн салбарт төрийн бодлого уналтад орсон. Ерөнхий сайдын энэхүү мэдээллийн тоо баримтуудаас харахад бүхэл бүтэн

улсын хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа жирийн компанийн тайлан тооцоо, борлуулалтын дүнгийн хэмжээнд очтолоо дорджээ. Төрийн бодлого тогтворгүй, ончгүй явагдаж олон арван жилийн турш төсвийн хөрөнгө зарцуулан байж өмнө нь хийж бүтээж босгосноо гаалийн татвар тэглэх хуулиар ганцхан жилийн дотор унагаж буй гашуун алдаа ч бидэнд бас байна.

Энэ хүрээнд Ардчилсан намын бүлгийн зүгээс дараах санал зөвлөмжийг гаргаж байна.

Нэгдүгээрт, хөдөө аж ахуйн салбарт суурилсан бэлтгэн нийлүүлэлтийн тогтол-цооны шинэ, бодитой бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, санхүүжилтийн оновчтой тогтол-цоог нэвтрүүлэх шаардлагатай байна.

Хоёрдугаарт, гадаадын зээл тусламжийн зарцуулалтад хяналт тавих, шинээр авах, зээлийн төлөвлөлт, зориулалтыг зөв төлөвлөх, улмаар салбар хоорондын уялдаа болон гадаадын зээлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хоорондын уялдааг хангах замаар үр өгөөж бүтээмжид чиглэх шаардлагатай болсон.

Гуравдугаарт, газар тариалан, мал аж ахуйд усалгаатай тариалалтыг нэвт-рүүлж, нэгж талбайгаас их ургацыг тогтвортой авах боломжийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэх шаардлага-тай байна.

Дөрөвдүгээрт, хүнс, хөдөө аж ахуйн салбарт төр оролцохоос зайлсхийж, төрийн зохицуулалтыг бодлогын суурь асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлж, салбар хоорондын уялдааг хангах шаардлагатай.

Тавдугаарт, татаас, хүүгийн дэмжлэгийг зогсоож, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг зах зээлийн жамаар цэвэр өрсөлдөөнөөр нь хөгжүүлэх эрх зүйн орчин талд бодитой алхмуудыг хийх шаардлагатай.

Зургаадугаарт, төрөөс малын тоо толгойг өөгшүүлэх бус мал сүргийн чанарыг сайжруулах хөрөнгө оруулах таатай орчин бүрдүүлдэг, тариалангийн талбайд хашаа барьж өгдөг бус нэгж га талбайгаас их ургац авахын төлөө ажилладаг бизнесийн орчныг бий болгох, мах нөөцөлдөг бус экспортолдог тогтолцоог хөгжүүлдэг төр байх нь бодлогын үндэс суурь гэж бид үзэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурал дахь ХҮН намын төлөөлөл Гончигдоржийн Уянгахишиг гишүүн үг хэлнэ. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажилтай холбогдуулан Ерөнхий сайдаас Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлсэн мэдээлэлтэй танилцлаа. Гол тоон мэдээллүүдийг өгөхийг зорьсон байгаа ч

эдгээр тоон мэдээллийн цаана байгаа бодлогын мэдээллүүд хангалтгүй байна. Ерөнхий сайдын мэдээллүүдтэй холбоотойгоор дэлгэрэнгүй мэдээлэл хүсэж байсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дээр бодлогын шинжтэй ажлууд хийгдэж байгаа гэсэн ойлголттой байгаа бөгөөд тоон мэдээллүүдээс харахад ахицтай үзүүлэлтүүд олон байна. Цаашид Улсын Их Хурлын мэдээллийн цагаа ашиглан эдгээр тоон үзүүлэлтийн цаана байгаа асуудлын талаар анализ, дүгнэлттэй мэдээллээр хангах нь бодлого тодорхойлогчийн хувьд Улсын Их Хурлын зүгээс шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх таатай эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлнэ гэж харж байна.

Түүнчлэн өмнө нь дурдаж байсанчлан Ерөнхий сайд болон салбарын сайдаас асуулт асууж, хариулт авсны дараа үг хэлэх боломжийг олгодог бол үр дүнтэй байх болов уу гэсэн саналтай байна.

Ингээд Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотойгоор дараах саналыг хэлье.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хүний нөөцийн бодлогод анхаарах зайлшгүй шаардлагатай байна. Жишээ нь, Ерөнхий сайдын мэдээлэлд дурдсанчлан Монгол Улсын хөдөлмөр эрхэлдэг 4 хүн тутмын 1 нь буюу 308,700 малчид байна. Гэтэл малчдын амь амьжиргаа, амьдралын чанар хангалттай сайн биш. Залгамж халаа муудахад хүрч байгааг бид бүгд ярьдаг, мэддэг. Тийм учраас шинэ залуу малчдыг мэдлэгжүүлэх бизнес суурьтай буюу малын ашиг шимийг бүрэн хүртэх боломжтой болгох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжихийн тулд бодлогын арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай байна.

ХҮН намын мөрийн хөтөлбөрийн хүрээнд мал аж ахуйн салбарт Монгол өрх үндэсний хөгжлийн загвар аж ахуй хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгасан ба үүнд талуудын оролцоог ханган хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулагч, үйлдвэрлэгч, хэрэглэгч, зах зээлтэй тэднийг холбох кластерын платформыг хөгжүүлэх, мөн нийлүүлэлт, үйлдвэрлэл, логистик болон маркетингийн нэгдсэн систем бүхий платформыг үүсгэн байгуулах шаардлагатай гэж үзсэн. Түүнчлэн малчдын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор дотоод болон гадаадын зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг хангасан зах зээлийн зарчимд нийцсэн тогтолцоог бүрдүүлэх, бэлчээрийн даацтай уялдуулсан уламжлалт нүүдлийн мал аж ахуй болон хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх шаардлагатай байгаа билээ. Энэ утгаараа салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, үйлдвэрлэл эрхлэх менежментийг сайжруулах арга хэмжээ авах нь нэн хэрэгцээтэй байна гэж харж байна.

Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/77 дугаар тушаалаар малчин өрхийн гишүүний боловсрол сургалтыг дэмжих

арга хэмжээг баталсан. Тус арга хэмжээг 2024-2028 он хүртэл аймгуудад үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн билээ. 2025 онд зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад хэрэгжүүлэхээр 150 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэжээ. Энэхүү санхүүжилт-тээр зүүн бүсийн малчин өрхийн гишүүнийг аймгийн Политехник коллежтой хамтран мал аж ахуйн чадамжийн гэрчилгээ олгох сургалт, ХААИС-тай хамтран энтрепренёрт суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх сургалт, малчин залуу манлайлагч сургалтыг тус тус зохион байгуулж байна. 2024-2025 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр малчин өрхийн 2407 иргэн суралцсан байна. Энэ мэтчилэн салбар хоорондын үр бүтээлтэй хамтын ажиллагаа, бодлогын дэмжлэгүүд цаашид өргөжих байх гэдэгт итгэж байна.

Түүнчлэн бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлж, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, тээвэр, логистик, хөдөө аж ахуйн аж үйлдвэр зэрэг салбарын уялдаа холбоог сайжруулан орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, судалгаа санхүүжилтээр дэмжих бодлого баримтлах, компаниудын бүтээмж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор нийлүүлэлтийн сүлжээний дэд бүтэц, мэдлэг, мэдээлэл, хөрөнгө оруулалт зэрэг тасалдалтай хэсгүүдэд эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх шаардлагатай байгааг мөн анхааралдаа авна уу?

Гуравдугаарт, хөдөө аж ахуйд суурилсан нэмүү өртөг шингэсэн экспортын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үе шат руу шилжих гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжсэн бизнесийн орчныг бүрдүүлэхэд анхаарч шударга өрсөлдөөнд суурилсан компани төвтэй кластерууд хөгжих боломжийг бүрдүүлж мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээ, банк санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн тухайлбал, мах, жимс, жимсгэнэ, арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүний онцгой чанарын судалгаанд үндэслэн үндэстний үнэ цэнийн байршил бүхий эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн орчин, бодлогын зохицуулалтыг боловсронгуй болгохыг мөн хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Одоо мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх цөөнхийн төлөөлөл, гишүүд нэрээ өгье. Нийт 6 гишүүнээр тасаллаа. Ганбатын Очирбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Г.Очирбат: Ерөнхий сайдын мэдээлэлтэй танилцлаа. Ардчилсан намын бүлэг дүгнэлтээ уншиж танилцууллаа. Тодорхой 3 асуулт асууя.

“Шинэ хоршоо” хөдөлгөөн гаргасан. Үүний үр дүн ямар байгаа вэ? Салбарын уялдаа холбоог хангах Үндэсний хороо бас ажиллаж байгаа. Энэ хороо шинэ бүтцээр татан буугдсан уу, буугдаагүй юу? 500 орчим тэрбум төгрөг гарсан. Яг айл, иргэдийн орлого нь хэдий хэмжээгээр яаж нэмэгдсэн бэ? гэдэг эхний асуулт асууя.

Хоёр дахь асуулт нь өнгөрсөн хавар ноолуурын бэлтгэл ажил дотоодын худалдан авалтыг зохион байгуулах ажлын явц хүндрэлтэй байсан. Одоо нөхцөл байдал ямар байгаа вэ? Монголбанкнаас вексель гаргасан. Үр дүн нь хэр байгаа вэ гэж асууя.

Гуравдугаарт, хөнгөн үйлдвэрийн салбартай холбоотой үйлдвэрлэл технологийн паркийг олон жил хүмүүс ярьж ирсэн. Олигтой, бодитой үр дүн байдаггүй. Таны танилцуулгад дурдсанаар 5-6 газарт бүсчилсэн байдлаар уг паркыг дөнгөж байгуулж эхлэх талаар дурдсан байна. Энэ үйлдвэрлэл технологийн паркийн талаар та ер нь ямар бодолтой байдаг юм бэ? Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр энэ чиглэлээр ажлын хэсэг гаргаад, Б.Уянга гишүүн ахлаад санал, дүгнэлт боловсруулчихсан байгаа. Тэгээд таны мэдээлэлтэй хэр зөрөх нь вэ? сонсчихъё.

Д.Амарбаясгалан: Эхний асуултад “Шинэ хоршоо” хөдөлгөөний салбар дундын уялдаа хангах Үндэсний хорооны Ажлын албаны дарга Азжаргал хариулъя. 4 дүгээр индэр.

Ё.Азжаргал: “Шинэ хоршоо” хөдөлгөөний үр дүнгийн талаар Г.Очирбат гишүүний асуултад хариулъя. “Шинэ хоршоо” хөдөлгөөн өрнөж эхлээд 1 жил болж байгаа. Та бүхэн мэдэж байгаа. Өнгөрсөн хугацаанд нийтдээ Монгол Улсын Засгийн газраас 21 аймаг, 330 сумд байгаа 193 мянган малчин өрх, 300 мянган малчиндаа 2 удаа хүрэх ажлыг зохион байгуулсан. Малчин өрх болгонд хүрч ажилласан. 193 мянган малчны хотонд хүрч ажиллана гэдэг бол мөнгө санхүү, хүний нөөц гээд олон нөөц шаарддаг ажил юм байна. Ингээд ажилласан. Хөдөлгөөн өрнөөд эхний 1 жилд мэдээлэл хүргэх ажил чухал байсан. Малчдын сегмент бол зүгээр нэг реклам явуулаад болчихдог биш юм байна лээ. Нүүр тулж уулзаад, ойлгуулаад их ажиллах шаардлагатай ийм бүлэг хүмүүс байдаг гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Сая Ерөнхий сайдын мэдээлэлд гарсан бөгөөд өнгөрсөн 1 жилийн хугацаанд нийт 798 орчим тэрбум төгрөгийн 6 хувийн зээл гарсан. Та бүхэн мэдэж байгаа. Уг зээл эргээд төлөгдөөд эхэлж байгаа. Энэ талаар их олон мэдээлэл байдаг. Тухайлбал, энэ зээлийг эргэж төлөх юм уу, яадаг юм гээд олон мэдээллүүд байдаг. Манай малчид бол хариуцлагатай, санхүүгийн сахилга баттай хүмүүс байдаг. Өнөөдрийн байдлаар нийт зээлэнд хамрагдсан 800 малчдаас 20 орчим тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдчихсэн байгаа. Ямар нэгэн хоцрогдолтой, төлөхгүй байгаа малчин бол байхгүй. Монгол Улсад нууц юм гэж одоо байхгүй болсныг та бүхэн мэдэж байгаа. Монголбанктай бид 7 хоног болгон мэдээллээ солилцдог. Бүх хүн графикийн дагуу, хуваарийн дагуу зээлээ төлөөд явж байгаа. Энэ бол хамгийн эхний чухал үр дүн.

Хоёрдугаарт, би танд нэг тоо хэлье. Татварын ерөнхий газраас авсан сүүлийн тоогоор 2024 оны эцэст 8 мянган хоршоо татварын тайлангаа ирүүлсэн байгаа. Тэд 402 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан байна гэдэг тоо гарсан. 570 сая төгрөгийн татвар төлөх тайланг ирүүлсэн байгаад байна. Энэ бол өмнөх жилүүдийн дунджаас хэд дахин өссөн гэдэг дүгнэлтийг гаргаж байгаа.

Ингээд ажлын байраар нь бид нар бас аваад үзсэн. Хоршооныхоо үйл ажиллагааг эрхлээд, эдийн засгийн харилцаанд ороод явж байгаа хоршоод нийтдээ 1109 ажлын байр шинээр бий болгосон байна. Энэ нь өмнөх оны мөн үзүүлэлттэй харьцуулахад их өсөлттэй тоо гарсан. Гишүүд “Шинэ хоршоо” хөтөлбөрийн үр дүнг их асуудаг. Энэ хөтөлбөр 5 жилийн хугацаатай хөтөлбөр. Одоо дөнгөж 1 жил болж байгаа, хүнээр бол дөнгөж мөлхөж эхэлж байгаа. Цаашаа хөлд ороод, алхдаг, гүйдэг болоод ирэх үед чухал ажлууд хийгдэх шаардлагатай байгаа.

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Энхбаяр сайд 2 дахь асуулт буюу ноолуурын бэлтгэл хангахтай холбоотой асуудлаар хариулт өгье.

Ж.Энхбаяр: Улсын Их Хурлын 63 дугаар тогтоолоор “Цагаан алт” үндэсний хөтөлбөр батлагдсан. Хөтөлбөрийн гол зорилго бол ноос ноолуур, арьс ширнийхээ бэлтгэл, үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой буюу үндэсний хөнгөн үйлдвэрийн салбараа шинэ шатанд гаргах хөдөлгөөн өрнөж байна. Энэ дотроос ноолуур онцгой чухал байр суурь эзэлж байгаа. Монгол Улс дэлхийн ноолуурын зах зээлийн 50 хувийг дангаараа бэлтгэн нийлүүлж байгаа орны онцлог барааны хувьд бидэнд өрсөлдөх чадвар өндөр байна. Үүнтэй холбоотой Засгийн газраас техникийн зохицуулалтууд хийгдсэн. Монгол Улс түүхий ноолуур экспортод гарахгүй, зөвхөн ноолуураа 100 хувь угаана, 100 хувь самнана. Ингээд самнасан ноолуурыг экспортод гаргах гэдэг бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүллээ. Энэ жил анх удаа сүүлийн 30 жил үндэсний үйлдвэрүүд ноолуурын худалдан авалтыг амжилттай зохион байгуулж чадлаа. Ноолуур 100 мянгаас 165 мянган төгрөгийн хооронд ханш тогтож, ноолуурын чанар, өнгө, үнэд ахиц гарсан буюу малчдын хөдөлмөрийг үнэгүйдүүлэхгүй байх, хамгаалах том арга хэмжээ үүний цаана байсан. Ноолуурын зах зээлд урд хөршийн үйлдвэрүүд гол тоглогч байсан. Худалдааны дайнтай холбоотойгоор өндөр тарифын хязгаарлалтад орсон. Энэ нь Монгол Улсын ноолуур 50-70 мянга дээр үнэ тогтоох ийм эрсдэл учирч байсан. Харин “Цагаан алт” хөдөлгөөнийг бид цаг үеэ олж, шуурхай зохион байгуулсантай холбоотойгоор ноолуурын үнэ өмнөх оны үнээс ижил түвшинд явагдлаа. Мөн ноолуурт зориулж бид 121 үндэс .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ер нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээрээ 3 минутад багтааж асууна. Хариултыг 5 минутад багтааж өгнө гэдэг дэгтэй. Тэгэхээр 2 юм уу, 3 хүн хариулт өгч байгаа бол аль болох товчхон, тодорхой хариулт өгөх зайлшгүй шаардлагатай. Бид дэгээ барьж ажиллаж байх нь чухал байгаа учраас дараачийн хүний асуулт дээр Ерөнхий сайд үйлдвэр технологийн паркттай холбоотой асуудлаар нэмээд товч хариулчих нь зүйтэй байх гэж бодож байна. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Өөрийнхөө мэдээллийн цаг дээр мэдээлэл өгсөнд баярлалаа. Өмнөх Ерөнхий сайд өөрийнхөө цаг дээрээс орж ирэхгүй байсанд би ч бас их шүүмжлэлтэй ханддаг байсан хүний нэг. Тэгэхээр ер нь манай парламент дотор мал, малчин ярьдаг асуудал их бага. Ялангуяа Ерөнхий сайдын мэдээлэл хийх цаг дээр. Хөдөө аж ахуйн байнгын хороон дээр л нэг яригддаг асуудал.

Гэтэл уг нь манай улсын нийт хөдөлмөр эрхлэгчийн 4 хүний 1 нь мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа том салбар. Эдийн засгийнхаа цар хүрээгээр бага ч гэсэн хөдөлмөр эрхлэлтийнхээ талбарт бол том салбар байдаг. Тэгээд манай хөдөө аж ахуйн салбар чинь хавартаа нэг ноолуур, намартаа нэг махнаас жоохон мөнгө олдог. Энэ жил үнэндээ ноолуурын үнэ бас их маргаан дагуулсан шүү. Дорноговь, Говийн бүсэд лав 110 мянгаас дээш гарсангүй. Нөгөө талдаа миний асуух гээд байгаа асуулт махны үнийн асуудал байгаа юм. Одоо энэ нөөцийн мах гэдэг юмаа болиоч ээ. Нөөцийн мах гэдэг чинь төрөөс үнийн зохицуулалтад оролцож байгаа хэлбэр шүү дээ. Хүний өмчид халдаж байгаа хэлбэр байхгүй юу. Цаашдаа чөлөөт зах зээл рүүгээ орж, махныхаа үнийг чөлөөлөхгүй бол нэг талдаа төрөөс дэмжээд байгаа юм шиг мөртөө нөгөө талдаа нөөцийн мах гээд үнийг нь хатуу тогтоогоод байдаг. Энэ тал дээр ямар байр суурьтай байх юм бэ? гэдгийгээ нэгдүгээрт тодорхой хэлчихмээр байгаа юм.

Хоёрдугаарт, “Шинэ хоршоо”-ны талаар сая тэнд нэг хүн бас ярьж байх шиг байна. Энэ 798 тэрбум төгрөг буюу бараг их наяд төгрөг. Үүний чинь 308 мянган нь өнөөдөр хөдөлмөр эрхэлж байгаа малчиндаа хуваагдахад 1 малчинд 2.1, Монгол Улсын бүх малчдад 2.6 сая төгрөг өгөх хэмжээний ийм их мөнгө байгаа байхгүй юу. Үр дүн хараахан гараагүй байгаа байх. 1 жил болж байна гэж байна. Гэхдээ эзнээ олж очиж чадаж байна уу, үгүй юү? Уржнан жилийн зуднаар Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Дорноговийн зүүн тал тэр чигээрээ зудад өртсөн. Өнөөдөр малгүй болсон иргэд зээлээ төлж чадахгүй байж байхад малжуулах хийгээд шинэ хоршоо байгуулъя гээд явж байхад нь баахан шинэ хоршоо байгуулчихсан зээл нь олдохгүй байж байна шүү дээ. Өнөөдөр энэ шинэ хоршоогоо байгуулчихаад мөнгөө авъя гэхэд мөнгө нь байгаа юу? 2 дахь асуулт нь энэ.

Ер нь цаашдаа энэ салбарыг, ялангуяа манай мал аж ахуйн салбар бол эмзэг салбар. Үнийг нь чөлөөлж өгөх хэрэгтэй. Гадагшаа экспорт хийх боломжийг нь хангаж өгөх хэрэгтэй. Тэгэхгүй бол төрөөс оролцоод байгаа юм болгон дампуурдгийн жишээ бол Монголын хөдөө аж ахуйн салбар шүү дээ.

Гуравдахь асуулт бол газар тариалан. Саяхан би Хөвсгөл, Булган аймгуудаар яваад ирлээ. Гандуу байна. Сэлэнгэ ямар байгааг мэдэхгүй. Яг энэ таны мэдээлэлд дурдсан шиг энэ жил бид нар идэх гурилаа, нөөцөө бүрдүүлж чадах уу? Газар тариалангийн салбарт өнгөрсөн жилийн бид нарын баталдаг хуулиас болоод хүндрэл учирсан шүү. Тэгээд ийм 3 асуултад хариулт авъя.

Д.Амарбаясгалан: “Шинэ хоршоо” 4 дүгээр индэр. Товчхон хариулт өгнө шүү.

Ё.Азжаргал: Г.Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Зарим хоршоологчдод зээл олдохгүй байгаа, эх үүсвэр байгаа юу гэж асууж байна. Эздэдээ очиж байгаа юу гээд. Энэ зээл хөрөнгө оруулалтын зээл. Эх үүсвэр нь арилжааны банкны эх үүсвэр. Тэгэхээр арилжааны банкнаас тавьж буй шаардлагыг хангасан хүмүүс өнөөдөр зээлээ хэвийн авч байгаа. Зээл хэвийн байгаа. 2 үндсэн шаардлага байгаа. 1 нь малын А данстай байх ёстой. Нөгөөх нь

хоршооны гишүүн байх ёстой. Ингээд энэ 2 шаардлагыг хангасан бол арилжааны банктай харилцаанд ороод явна гэсэн үг. Ямар нэгэн арилжааны банкны шийдвэрт хажуугаас нь оролцох боломжгүй. Шийдвэр бол цэвэр бизнесийн зарчмаараа явж байгаа. Эх үүсвэртэй холбоотой асуулт. Арилжааны банкны эх үүсвэр бол байгаа. Өнөөдөр арилжааны банкнууд зээлээ хэвийн олгож байгаа. Гэхдээ мэдээж банк тодорхой хэмжээний шаардлага тавина. Тэгэхээр зарим нэг хүмүүс банкны шаардлага нь хангаагүйгээс надад зээл өгөхгүй байна гээд гомдсон зүйлүүд өнгөрсөн 1 жилийн хугацаанд гарсан. Тэгээд энэ болгон дээр ойлгуулаад ажилласан. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд нэмж хариулья.

Ж.Энхбаяр: Улаанбуудайтай холбоотойгоор нийт 2024 онд бид гурилын хэрэглээнийхээ 59.1 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 40.9 хувийг импортоор хангасан. Энэ жилийн тариалалтын талбайг дундаж ургацаар тооцоод үзэхэд 2025 оны ургацын урьдчилсан тооцооллоор гурил үйлдвэрлэлд 154 мянган тонн улаанбуудай ноогдож байгаа. Энэ нь өмнөх оныхоос даруй 25 хувиар бага буюу гурилын хэрэгцээний 44 хувийг дотоодын үйлдвэрээр хангах ийм төлөвтэй байна. Тэгэхээрээ бид багаар бодоход дахиад 150-160 мянган тонн улаанбуудай импортоор авахаас аргагүй байдал үүссэн.

Мах бэлтгэлтэй холбоотойгоор орон нутаг өөрсдийн эх үүсвэрээр нөөцөө бэлдэх тогтолцоо ажиллаж байгаа. Яамнаас нөөцийн мах бэлтгэхэд ямар нэгэн үйл ажиллагаанд оролцохгүй байгаа. Экспортыг бүх чиглэлээр урамшуулж байгаа. Экспортлоход ямар нэгэн татварын бөгөөд квотын хязгаарлалт байхгүйгээр махны экспортыг идэвхжүүлж байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд нийт 600 сая ам.долларын мах экспортолж чадсан. Өмнө нь 10-20 сая ам.доллароос гарч үзээгүй. Одоо махны экспортыг бүх талаар идэвхжүүлж байна. Яагаад гэвэл малын тоо боломжийн байна. 20 сая төл авч байна. Үндсэндээ 77, 78 сая малтай болох нь. Бэлчээрийн даац хонин толгойд шилжүүлснээс 20-25 саяар хэтэрч байна. Иймд бид хонь, ямаа, адуу гэсэн 3 төрөл дээр сүргийн бүтцийн тоон хэмжээг багасгах бодлого стратеги барьж байгаа.

Аль болох экспортын бодлогоор энэ тоог багасгах, бэлчээр ашиглалтыг сайжруулах, бэлчээрийн доройтлоос урьдчилан сэргийлэх, нөгөө талдаа малчдын орлогыг нэмэгдүүлэхэд махны экспортыг бүх талаар дэмжиж байгаа. Махны экспорт тун боломжийн байгаа. Мал эмнэлгийн ажил үйлчилгээ цаг хугацаатай, малын гоц халдварт өвчнийг хяналтад авч чадсаны үр дүнд махны экспорт сайн нэмэгдэж байгаа. Ер нь хөдөө аж ахуйг бол цаашид зөвхөн экспортын чиг баримжаатай болгож байж, малчид, тариаланчдын орлогыг олон улсын зах зээл, экспортын үнэтэй уяж өгөх нь орлого нэмэгдэх гол суурь болж байна. Ингээд махны экспорт нь амжилттай гараад ирэхээр малчдын орлого 600 сая ам.долларын мах малчдын орлого болж очсон. Ноолуур 100 хувь самнадаг болсноор бид ноолуураа цэвэршүүлж байна гэсэн үг. Зэсээр бол цэвэр зэс гэдэг шиг цэвэр ноолууртай болчихож байгаа юм. Мөн адилхан өгөөж нь эргээд малчид болон үйлдвэрлэл дээр нэмэгдээд байгаа. Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар салбарын өсөлт их ... /минут дуусав/.

Д.Амарбаясгалан: Г.Занданшатар дарга нэмэлт хариулт өгье.

Г.Занданшатар: Эхлээд Ганбатын Очирбат гишүүний асуусан аж үйлдвэрийн парктэй холбоотой асуултад товч хариулчихъя. Аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц, инженерийн бүтцийн санхүүжилт тодорхойгүй, хангалтгүй, татвар, зээлийн хөнгөлөл-тийн бодлого хангалтгүйгээс аж үйлдвэрийн паркууд бүрэн утгаараа ажиллаж байгаа парк алга байна. Энэ паркуудыг хөнгөлөлт, чөлөөлөлт төсвийн дэмжлэгийг өнөөдөр үзүүлж, байгуулж чадвал 400-500 тэрбум төгрөгийн орлого оруулах бололцоотой гэж үздэг. Тийм учраас аж үйлдвэрийн паркийн эрх зүйн орчныг нэгтгэх, уялдаа холбоог сайжруулах цогц бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа. Энэ бас гадаад гэрээ хэлэлцээртэй ч уялдана.

Хоёрдугаарт, Гомбын Ганбаатар гишүүний асуусан асуултаас үндсэндээ махыг чөлөөллөө гээд дундаас нь малчин биш, үйлдвэрлэгч биш ченжүүд хождог гэсэн тооцоо судалгаатай. Ер нь зах зээлийн харилцаанд төрийн зохицуулалт зайлшгүй шаарддаг. Аймаг, нийслэл мах бэлтгэл, махны нөөцийг бэлтгэж байна. Энэ нөөц бэлтгэлийн ажил бол улирлын шинж чанартай, зоорь бүтээмж, худалдаа, тээвэр логистиктой холбогддог асуудал учраас энийг нээлттэй, ил тод, хяналттай болгож зохицуулах шаардлагатай гэж үзэж байгаа. Энэ талаар нийслэлд махны хангамжийг сайжруулах асуудал үе үед яригдаж ирсэн. Энийг нээлттэй, ил тод болгох нь хамгийн чухал байх гэж бодож байна.

Гуравдугаарт, газар тариалангийн районд гандуу байгаа учраас өнгөрсөн бүтэн сайн өдөр ажил аваад 2 хоногийн дараа Улсын онцгой комиссыг хуралдуулж ган, үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тодорхой арга хэмжээ авах үүрэг даалгавар өгсөн. Үүний дагуу Цаг уурын газраас шинжлэх ухааны үндэстэй тооцоо судалгаа хийж, үүлэнд нөлөөлөх арга хэмжээ газар тариалангийн районд явуулах үүрэг өгсний дагуу Сэлэнгэ аймагт бороо 1, 2, 3 гэсэн экспедиц гаргаж, үүлэнд нөлөөлөх үйл ажиллагаа явуулсны үр дүнд Баруунбүрэн, Хушаад, Зүүнбүрэн, Түшиг, Бугант, Сүхбаатар, Орхон, Орхонтуул, Баянгол, Мандал зэрэг сумдад 1.2мм-18мм хүртэл бороо орсон. Ер нь бол гандуу нөхцөл байдлаас шалтгаалж ургацаа 3-30 хувиар алдах эрсдэлтэй гэж тооцогддог. Ийм учраас улаанбуудай, гурилын хангамжийн асуудалд онцгой анхаарч байна.

Малчдын хувьд, улирлын шинж чанартай малчдын орлогыг тогтворжуулахад мал аж ахуй эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд мал эрүүлжүүлэх, чанаржуулах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” зэрэг үндэсний хөдөлгөөний хүрээнд бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд гаргах тухайлбал, Евро-Азийн зах зээлд 12 тэрбум ам.долларын арьс шир, ноос ноолуур, мах махан бүтээгдэхүүний импортоор авдаг зах зээл байна. Үүний 20 хувьд хүрнэ гэж тооцоход 2.4 орчим тэрбум ам.долларын гадаад зах зээл нээвэл аяндаа борлуулалттай болж дотоод зах зээлийн стандарт, техникийн зохицуулалт, үйлдвэрлэлийг дэмжих нөхцөл бүрдэж, энэ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өглөө. Ер нь Ж.Энхбаяр сайд аа, О.Цогтгэрэл даргын түрүүний хийсэн дүгнэлт, түрүүн Г.Уянгахишиг гишүүний хийж байгаа дүгнэлт бол бас нэг зүйлийг хэлж байгаа шүү дээ. Хөдөө аж ахуйн яам бодлогын томоохон өөрчлөлт хийгээч, боловсон хүчнийг шинэчлэх, мэргэжлийн боловсон хүчин ажиллуулах тал дээр анхаараач гэдэг зүйл яригдаад байгаа юм. Үнэндээ бол бас салбарт реформын шинжтэй бодлого хэрэгжүүлэхгүй бол цаашдаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам явахад их хэцүү болчихсон шүү. Би бас Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ажилласан. Тодорхой асуудлууд дээр зуд, зудын дараах энэ малчдын амьжиргааг дээшлүүлэхтэй холбоотой асуудал дээр нэг хэсэг хамтарч ажилласан. Мэргэжлийн боловсон хүчний хувьд их гологдсон, дутагдсан ийм нөхцөлд яалт ч үгүй оччихсон. Үүнтэйгээ өөрсдөө сайхан эвлэрээд, шинэчлэлээ Ж.Энхбаяр сайд минь зоригтой хийгээд явах хэрэгтэй. Улсын Их Хурлаас таны энэ бодлогыг дэмжээд явахад бэлэн. Одоо жишээ нь Гомбын Ганбаатар гишүүний асууж байгаа нөөцийн мах бэлддэггүй тогтолцоо гэдэг чинь өөрөө малчин өрх өдөр бүр зах зээлд мал, мах, бүтээгдэхүүн нийлүүлж чаддаг болно гэсэн үг шүү дээ. Зөвхөн хавар, намрын цагтаа махаа нийлүүлчхээд, өвөл, хавар, зун хөлдөөсөн мах идээд сууж байдаг ард түмэн байна шүү дээ. Тэгсэн мөртөө мал аж ахуйн эх орон гэж байгаа. Энэ шинэ хоршоо хөдөлгөөний гол зорилго бол малчдыг төрийн гарыг харж амьдрахаас гаргаж өгч байгаа юм. Хүний эрхээр жаргахаар өөрийн эрхээр зовцгооё гэж байна. Урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээл аваад, өөрсдийнхөө аж амьдралыг төрийн гарыг харахгүйгээр авч явдаг болох бололцоог гаргаж өгсөн. Харамсалтай нь манайд нэг сул тал байдаг. Өөр хүний санаачилсан ажлыг өөр хүн хийдэггүй, дэмждэггүй, болж өгвөл унагаах гээд яваад байдаг. Тиймээс ийм бодлогыг хэдүүлээ цааш нь байлгахгүйн тулд ажиллах хэрэгтэй.

Харин нэг зүйлд талархалтай хандаж байгаа нь Төрийн банк, Хаан банк 2 арилжааны зориулалтаар 3 жил хүртэлх хугацаатай хөрөнгө оруулалтын зээлийг малчны малыг нь барьцаалаад, зээлийн батлан даалтын сангаар батлан даалтыг нь гаргаж байгаад олгодог болсонд их талархалтай байгаа юм. Тэгэхгүй бол малчид зөвхөн малчны өндөр хүүтэй зээлээс өөр ямар ч боломжгүй амьдралтай байсан. Жилийн 24 хувийн хүүтэй зээл авна. Намар малаа бойнд шилжүүлэхээр зээлээ нэг төлнө. Хавар ноос ноолуурын цагаар зээлээ төлнө. Тэгээд жилд 24 хувиар банкны мөнгийг өсгөж өгдөг хүмүүс болчихсон байсан.

Одоо бол харин урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл аваад, түүгээрээ бизнес эрхлэх боломжийг гаргаж өгсөн гэдгийг сайхан тодорхой ойлгоод авах хэрэгтэй гэж. Шинэбаярын Бямбасүрэн гишүүн асуулт асууя.

Ш.Бямбасүрэн: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо. Тэгээд 2 асуулт байна.

Нэг хүний сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэх олон улсын стандарт нормоор тооцож үзвэл Монгол Улсын сүүний жилийн хэрэгцээ 170 мянган тонн, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ 190 мянган тонн байгаа юм. Манай улсын хэмжээнд 17 аймгийн 25 сумд сүү хүлээн авч боловсруулах хүчин чадал бүхий 88 үйлдвэр, цех, 82 сүү хүлээн авах хөргөлттэй төв үйл ажиллагаа явуулж байгаа юм

байна. Эдгээр үйлдвэр, цехүүд суурилагдсан хүчин чадлынхаа 50 гаруй хувийг ашиглан үйлдвэрлэл явуулж, жилдээ 60 мянган тонн сүү, 90 мянган тонн сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулж байна. Хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн сүү бол 140 мянган тонн. Ингээд үүнээс харвал бид сүүнийхээ дотоодын хэрэгцээг ер нь бол 100 хувь хангаж байна. Сүүн бүтээгдэхүүнийхээ хэрэгцээг 53 хувь хангаж байна. Үлдсэнийг нь импортоор авч байна гэсэн үг. Хэдийгээр сүүний хэрэгцээгээ дотоодоосоо бүрэн хангаж байгаа боловч нөөц бололцооныхоо 30 хүрэхгүй хувийг бид ашиглаж байгаа. Өөрөөр хэлбэл малчид маань сүүлийн үед үнээгээ саахаа ер нь больчихсон. Яагаад гэвэл дотоодын зах зээл хэрэгцээ нь ханачихсан. Тэгээд үнэ хэтэрхий хямд байгаа учраас үнээгээ саахгүй байгаа юм. Тэгэхээр асуулт нь хөдөө аж ахуйгаас бэлдэх сүүний хэмжээг нэмэгдүүлэхийн тулд малчдыг сүүгээ сааж борлуулах сонирхолтой болгохын тулд боловсруулах үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх, эрэлтийг бий болгох шаардлагатай байгаа. Эхний ээлжид сүүн бүтээгдэхүүнээр дотоодынхоо хэрэгцээг 100 хувь хангахад, цаашлаад экспортод гаргах чиглэлд боловсруулах үйлдвэрлэлийг төрөөс хэрхэн дэмжих юм бэ? Ер нь малчдыгаа малаа саахгүй байна гэх биш, саасан сүү нь үнэд хүрдэг болох нь зөв зарчим шүү дээ. Ингэж байж бид малчдыгаа бодитоор дэмжинэ.

Хоёрдугаарт, “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг ерөөсөө хир халдаахгүй явуулах гээд байгаа юм. Ер нь бол хоршоогоор хөгжсөн улсууд бол эхлээд зах зээлээ тодорхой болгосон байдаг. Худалдан авагчид нь бэлэн байдаг. Тэрийгээ дагаж байж хоршоогоор дамжуулж, анхан шатын боловсруулсан түүхий эдээ бэлдэж, тэр үйлдвэрүүдээ босгож ирдэг. Гэтэл өнөөдөр хүнс, хөнгөн үйлдвэрийн нэг ч үйлдвэрээ босгож чадаагүй байж хоршоогоор дамжуулаад 1 жилд 800 тэрбум төгрөг гаргачхаж байна. Тэгэхээр энэ 800 тэрбум төгрөгт хүүгийн татаас нь хэдэн төгрөг төсвөөс гарч байгаа вэ? Энийг хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Хоршооны хүүгийн татаасад батлагдсан эх үүсвэр 1 их наяд төгрөг байгаа. Өнгөрсөн жил 500 тэрбум төгрөг гараад, богино хугацаанд олгогдоод, тэгээд шинэ эх үүсвэр шаардлага үүссэн. Ингээд 500-г нэмж баталж өгсөн. Үндсэндээ 1 их наяд төгрөг хүртэл энэ хоршоог дэмжих хөнгөлөлттэй зээл явна. Үүний 1 их наяд төгрөгийг олгуулахын тулд хүүгийн бодлогоор дандаа дэмжиж өгч, арилжааны банкнаас эх үүсвэрээр шийдэж байгаа. Төсвөөс гарч байгаа зардал нь 100 тэрбум төгрөг буюу зээлийн хүүгийн 10 орчим хувийг төсөв дээр даагаад, арилжааны банк бол бусад 6 хувийн зээлийн хүүгийн нь гаргаж байна. Тэгэхээрээ 100 тэрбумаар бид 1 их наяд төгрөгийн эх үүсвэрийг гаргаж байгаа гэсэн үг.

Сүүн дээр бол улсын хэмжээнд 17 аймгийн 25 суманд хоногт 904 тонн сүү хүлээн авах, боловсруулах хүчин чадалтай 88 үйлдвэр, цех байна. 150 сая литр сүүг сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрийн аргаар боловсруулсан байна. Сүүнд сэрүүний улиралд литр тутамд урамшууллыг олгож байгаа. Энэ урамшуулал олголтын хугацааг нэмэх санал их байгаа. Нөгөө талаас сүүний хангалт малын тоогоор тооцоод, дэлэнд байгаа сүүг тооцоход хангалттай юм шиг байдаг боловч төвлөрсөн хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангаж чадахгүй байна.

Импортёр их хэмжээний хуурай сүү, сүүн бүтээгдэхүүн авч байгаа. Үүнийг шийдэх гол арга бол байнгын маллагаатай, байнгын саалийн горимд байдаг үнээний фермүүдээр, газар тариалангийн бүс нутгийн тэжээлийн бааз дээрээ тулгуурлаж, хөгжүүлж байж энэ сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангана. Ингэхийн тулд “Атар 4” аяны хүрээнд газар тариалан, мал аж ахуйг хослуулах эрчимжсэн аж ахуй байгуулах төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна. Юуны өмнө үхэр сүргийнхээ чанарыг сайжруулах ашиг шимийг нэмэгдүүлэх үүднээс 200 хүртэл мянган толгой мах, сүүний үхрийг сайжруулагчаар авах хэрэгцээ шаардлага байгаа. Эхний нийлүүлэлтүүд хийгдээд эхэлсэн. Төсөв мөнгөний хувьд хүрэлцээ хязгаарлагдмал байгаа тул тооны хувьд бага байна. Хувийн хэвشلүүдийн зээлийн хүрээнд бас ажлууд эхэлсэн. Тун удахгүй эхний 1500 саалийн Алаг Холштейн үйлдвэрийн үнээ, өсвөр малууд энэ 7, 8 сард цувраад, Монгол Улсад нийлүүлэгдэхээр бэлтгэл ажил хангагдаад явж байна.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: 2024 онд эдийн засгийн өсөлт бидний хүлээснээс, төсөвлөснөөс харьцангуй бага байсан. Тэр дундаа хөдөө аж ахуйн салбар 2024 онд 25 хувь агшсан гэсэн мэдээтэй байгаа. Хөдөө аж ахуйн салбар бол Монголын олон малчин айл өрхүүдийг тэтгэдэг ийм салбар байгаа. Тэгээд эдийн засгийн өсөлт хөдөө аж ахуйн салбар агшсан нь болохоор эдийн засгийн өсөлтийг ч сааруулж байгаа. Малчин өрхүүдийн орлогыг ч бууруулж байгаа. Энэ тал дээр Ерөнхий сайдын мэдээлэлд дурдагдаагүй байна. Ноднин өвлийн зудтай холбоотой, мал хорогдолтой холбоотой асуудал гарсан гэж хэлэх байх. Гэхдээ өнгөрсөн 30 хэдэн жилийн хугацаанд төсвөөс бол байнга татааснууд өгч ирсэн хөдөө аж ахуйн салбарт олон гоё нэртэй хөтөлбөрүүдийг зөндөө олныг хэрэгжүүллээ. Тэгээд ганц хүнд өвлийн зудыг давж чадахгүй, 25 хувиар агшина гэдэг бол энэ салбарын бодлого ерөөсөө бүхэлдээ буруу байна гэсэн үг. Тэгээд 30 жилийн туршид экспортод бараа бүтээгдэхүүн гаргана, кластераар хөгжүүлнэ гэсэн юм яриад яваад байдаг. Зах зээлээ тэлнэ гээд яриад яваад байдаг. Өнгөрсөн 8, 9 жилийн хугацаанд МАН-ын дарга нар бүгдээрээ дор бүрнээ нэг ийм гоё нэртэй хөтөлбөртэй боллоо. “Цагаан алт” гэнэ, “Шинэ хоршоо” гэнэ, “Хүнсний хувьсгал” гэнэ, “Атар 4” аян гэнэ. Тэгээд эдгээр хөтөлбөрүүдийн үр дүн ер нь ямар байгаа юм бэ? Салбарын нэгдсэн бодлого чинь юу байгаа юм бэ? Ганц жилийн зуднаар 4-ний 1-ээр агшчихдаг ийм салбартай сууж байна шүү дээ. Тэгэхээр шинэ Ерөнхий сайд энэ хөдөө аж ахуйн бодлогоо бүхэлд нь ер нь хэрхэн яаж харж байгаа вэ?

Энэ олон татаас, энэ олон хөнгөлөлтүүд чинь ерөнхийдөө танай намын сонгуулиар санал авах арга хэрэгсэл шиг харагдаад эхэлчихлээ шүү.

Тэгээд жишээлбэл банкны салбар дээр тодорхой хэмжээний ачааллууд ирэхээр байна даа. Яаж байна вэ гэхээр өнгөрсөн зудтай холбоотойгоор 1 жилээр малчдын зээлийн эргэн төлөлтийг хойшлуулчихсан байж байгаа. Тэгээд энэ оны 5 дугаар сараас малчид зээлээ эргэн төлж байгаа. 1.3 их наяд төгрөгийн зээл байгаа. Засгийн газраас хэрэгжүүлж буй янз бүрийн бодлогууд хоорондоо уялдаагүй байгаагаас бас ноолуурын орлогын асуудал гарсан. Дээр нь “Шинэ

хоршоо” хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлтүүд орж ирж байгаа. Тэгээд манай малчид ер нь зээлээ төлж чадах нь уу, яах нь. Энэ болгоныг Ерөнхий сайдаас би асуугаад байгаа шүү.

Гуравдугаарт. Сая ноолууртай холбоотой асуудал яригдаж байна. Ерөнхий сайдын мэдээлэлд ноолуурын эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 310 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 5 мянган тонн ноолуур бэлтгэсэн гэнэ. Тэгээд 310 тэрбум төгрөгийн эргэлтийн зээл ямар компаниудад, ямар үнийн дүнтэйгээр олгогдсон бэ? Уг нь ноолуурын салбар гадагшаа экспорт дээр харьцангуй хамгийн давуу талтай салбар шүү дээ. Тэгсэн хэр нь дандаа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Нийт 121 үндэсний үйлдвэрт ноолуур бэлтгэх зээл олгогдсон. Амжилттай болсон. Ахиад хэлье. Анх удаа Монгол Улсын үндэсний үйлдвэрүүд ноолуураа бүрэн авч чадсан. Угаагаад гаргадаг байсан бол 100 хувь самнадаг болсон. Зөвхөн угаадаг самнадгийн зөрүүнд 200 гаруй сая ам.доллар буюу 700 тэрбум төгрөгийн нэмүү өртөг, орлого, ажлын байр татвар болж Монгол Улсад шингэж байгаа юм. Бид ноолуураа цэвэршүүлж чадсан. Нөгөө цэвэр зэс гэдэг шиг цэвэр болгочихсон. Одоо цэвэр самнасан ноолуур олон улсын зах зээлд үнэлэгддэг бараа. 1кг нь өнөөдрийн ханшаар 106 орчим ам.доллар. Энэ бол манай давуу тал. Үүний цаана үйлдвэрлэл, түүний цаана малчдын орлого гээд олон зүйл тогтворждог. Дотоодын үйлдвэрлэл үнэхээр эрс өөрчлөлт хийсэн шүү.

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар хөдөө аж ахуйн салбарын өсөлт 36 хувьтай гарч байгаа. Одоо уул уурхайн мөчлөгийг сөрж, хөдөө аж ахуйн салбарын өсөлт жилийн эцэс гэхэд хамгийн өндөр гарна. Энэ олон хөтөлбөрийн үр дүн одоо л гарч ирж байна. Хөрөнгө оруулалтаа хийгээд, үйлдвэрлэлээ өргөтгөөд, бүтээмжээ нэмэгдүүлээд, хүнээ бэлдэж байна.

Нэг зүйлийг би Улсын Их Хуралд дахин дахин хэлдэг. Хүний нөөцийн бодлого яамнаас гадуур байгаа. Яаманд харьяалагддаггүй. Салбарыг хөгжүүлэх хөдөө аж ахуйн шинжлэх ухааны хүрээлэнгүүд яамнаас гадуур байгаа. Үнэхээр салбарт хүний нөөц дутаж байна. Хүний нөөц бэлтгэгдэж чадахгүй байна. Тэгэхээр энэ тогтолцоог эргэн хараад Хөдөө аж ахуйн яамыг бүрэн хүчтэй зэвсэгтэй болгоод өгөөч ээ гэж би Улсын Их Хурлаас хүсэж байна.

Шинжлэх ухааныг хөгжүүлэх, шинэ инновац, технологи нэвтрүүлэх эрдэмтдийн хүч чадал энэ салбартаа ирж үйлчлэхгүй байна. Бүр өөр яамдад салгаад тавьчихсан. Монгол Улсын нийт ажиллах хүчний 2-ны 1 нь энэ салбарт ажиллаж байна. Нийгмийн тогтвортой байдлыг хамгийн сайн хангах, нийгмийн баялгийг хамгийн сайн хуваарилж байгаа салбар. Олон 100 мянган хүн энэ салбараас ажиллаж амьдарч байгаа. Орон нутгийг эзэнтэй байлгаж байгаа. Тэгэхээр энэ салбарт чиглэсэн 4 үндсэн гол бодлогыг Улсын Их Хурлын үе шаттай баталсан. Үүнд “Атар 4” аян, “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал”, “Шинэ хоршоо” зэрэг хөдөлгөөн байна. Энэ дөрвөө 3 жил буюу 2028 он хүртэл тогтвортой хэрэгжүүлэхэд бол салбар шинэ дүр төрхтэйгөөр шинэ зах зээлд гарах буюу

21 дүгээр зууныхаа хөдөө аж ахуйн салбарын хөгжилд нийцээд гараад ирнэ. Үнэхээр ололт амжилтууд, технологийн шинэчлэлүүд, техникийн шинэчлэлүүд, олон зүйл бүтээмжүүд нэмэгдэж байгаа. Эргэлзэх хэрэг байхгүй. Харин богино хугацаанд эрс өсөлтийг авч байгаа салбар. Хүмүүс урам зоригтой байгаа. Хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж байгаа. Хүмүүс олон мянгаараа хөдөө орон нутаг руу шилжиж аж ахуй эрхэлдэг сонирхол бий болж байгаа. Ялангуяа “Атар 4” аянаар шинээр олгох 200 мянган га талбайг эргэлтэд оруулж байгаа нь олон мянган ажлын байрыг, шинэ бүтээмжийг нэмнэ гэдэгт итгэлтэй байгаа. Харин улс төрийн хувьд тогтвортой байлгах сайн бодлогын дэмжлэгийг тогтвортой байлгах нь их чухал байна. Бодлого сайн хэрэгжиж байгаа. Үүнтэй холбогдуулаад одоо олон үзүүлэлтийг ярьж болохоор байна. Монгол Улсын дотоодын бүтээгдэхүүний 31.7 хувь руу ороод ирлээ. Экспорт 100 сая ам.доллараар нэмэгдэж байна. Одоо тэрбум ам.доллар давсан экспорт хийдэг болж эхэлж байна. Ноолуурыг 1 тэрбум ам.доллар, махыг 1 тэрбум ам.долларт хүргэх бүрэн бололцоотой байна.

Эрдэнэтийн үйлдвэрийг хөдөө аж ахуйн салбар босгох бололцоотой байна. Эрдэнэттэй адилхан борлуулалт хийх бололцоо гарч ирж байна. Ер нь экспортын орон зай сайн нэмэгдэж байна. Энэ хамт олны хийсэн ажлын үр дүн шүү дээ. Тэр ургамал хамгаалал, мал эмнэлэг, мэргэжлийн ажлууд хийгдсэний үр дүнд экспорт, борлуулалт ДНБ-ий эзлэх хувь их нэмэгдээд байгаа буюу 600 мянган хүнийг ажлын байраар тогтвортой хангаж байна. Тэгэхээр энэ салбарт бодлогын дэмжлэгийг сайн хийгээд баймаар байна. Уул уурхайгаас ангид эдийн засгийг босгох хэрэгтэй байгааг бид ойлголоо шүү дээ. Энэ нь яах аргагүй хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбар юм гэдгийг харж байна. Ялангуяа энэ жил мөчлөг унаж байх үед манайх сөрж, сайн өсөлтийг хөдөө аж ахуйн салбар үзүүлнэ.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулт өгье.

Г.Занданшатар: Б.Жаргалан гишүүний асуултад тодруулж, нэмж хариулъя. Жадамбын Энхбаяр сайд тодорхой хариулчихлаа. Тэгэхдээ нэг зүйлийг би онцлон хэлчихмээр байна. 1990 онд манай улсын экспортын 80 хувь нь нэмүү өртөг шингэсэн хөнгөн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн байсан юм билээ. Одоо 5 хувь ч хүрэхгүй байгаа. Энэ хүртэл буурахад гол нөлөөлсөн шалтгаан нь Монгол Улс тариа ногоо тарих хэрэггүй, гаднаас авчихна, хямдхан. Нөгөө харьцангуй давуу талын судалгаа гэдэг шиг Монгол бол харьцангуй нөгөө Трампын бодлогын эсрэг болж байгаа үед бусад улсаас импортоор авч байгаа нь ашигтай. Чөлөөт зах зээлийн бодлого гэдэг нь Дэлхийн худалдааны байгууллагад элссэн бүх улс дотоодын үйлдвэрлэлийг устгасан. Дээр нь түүхий эд бэлтгэлийн сүлжээ, хоршооны тогтолцоо, экспортын тогтолцоо хүртэл бүгд устчихсан учраас 300 мянган хүний ажлын байр байхгүй болж, мал аж ахуй руу шилжсэн байдаг юм. Ингээд мал аж ахуйгаар энэ хүндрэлийг давсан нь дундад зууны үе рүүгээ ухарсан ухралт бараг болсон гэж гадаадын эрдэмтэн судлаачид дүгнэсэн байгаа. Яагаад гэвэл амиа аргацаасан мал аж ахуйн энэ хэлбэр бол өсөж хөгжих хөдөлмөрийн хуваарилалт, экспортод бүтээгдэхүүнээ нэг малчин гаргах бололцоогүй нь ойлгомжтой ийм том өөрчлөлтийн үр дүнг нэг өдөр засах

бололцоогүй. Тэгэхээр энэ олон гоё нэртэй гэж таны шүүмжилж байгаа хөтөлбөр, төслүүд тодорхой үр дүнгээ өгч, олон шинэ аж ахуйн үйлдвэрүүд, дотоодын хүнсний хангамж, үйлдвэрлэлүүд сайжирч, зөвхөн ноолуурын салбар 1 тэрбум ам.долларын бололцоотой болж байна. Утас ээрэх шат дамжлага болгонд 50 мянган эмэгтэй хүн ажлын байртай болно. Ард түмэнд юу хэрэгтэй байна вэ? Ажил эрхлэлт, ажлын байр хэрэгтэй байна. Энэ ажлын байрыг бий болгодог салбар бол хөдөө аж ахуйн нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийн салбар. Түүхийгээр нь ноолуур экспортлоод байгаа биш, 317 орчим сая ам.долларын түүхий ноолуур экспортолдог байсан бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Жишээлбэл, нэг шат нэмээд, самнаад угаагаад, тэгээд утас ээрэх шат болгонд 30 хувийн нэмүү өртгийн ам.долларын экспорт нэмэгдэх, 1 тэрбум ам.доллар хүрэх, махны экспорт одоо 600 сая ам.доллар хүрч ирнэ гэдэг нь шинэ зах зээлд 1 тэрбум ам.долларт хүрэх олон боломжууд нээгдэнэ. Тэгэхдээ одоо хүртэл түүхий эд бэлтгэлийн тогтолцоонд яагаад хоршоо хэрэгтэй юм бэ, яагаад малчин өрхийн нэгдсэн холбоо гэдэг хууль батлагдсан юм бэ, энэ бодлогууд мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж муу байгааг шинэчлэхэд чиглэж байгаа. Өнөөдөр малчид малынхаа сүүний гуравхан хувийг ашиглаж байна. Үхрийн 32, хонины 10 хүрэхгүй хувь. Ийм учраас хөдөө аж ахуйг дэмжих цогц бодлого байж хөгждөг дэлхийн бүх улсын жишиг байгаа. Тухайлбал, Япон, Солонгос, Швед, Дани улсын хоршоо, фермийн бодлогыг бүгдийг нь ажиглаад үзээрэй. Энэ бол мянга мянган хүний хүнсний хангамж, аюулгүй байдал, ажлын байрны асуудал учраас энэ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Хөдөө аж ахуйн салбарын бодлогын тухай бид бүхэн ярьж байгаа. Тэгээд аливаа салбарыг дэмжих бодлого гэдэг нь бодит утгаар нь харахаар энэ салбарт нийлүүлэлтийн сүлжээний эрх зүйн орчин, агуулах сав, эргэлтийн хөрөнгө, татварын бодлого зэрэг томоохон асуудлуудыг Засгийн газар шийдэх ёстой байгаад байгаа юм. Гэтэл салбарын яам ойлгомжгүй үйл ажиллагаа эрхлээд байдаг. Энийг өнөөдөр бас ярихгүй бол болохгүй байна. 2021, 2022 оны тогтоолоор гарсан юм байна. Мал аж ахуй, газар тариалангийн салбарт амжилттай ажиллаж байгаа малчид, тариаланчдыг шалгаруулж шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын 01-ний өдрөөс эхлэн гардуулдаг уламжлалтай. Тэгээд энэ тогтоолын дагуу улсын аварга саальчинд 4 сая төгрөг, аварга фермерт 5 сая төгрөг, улсын аварга малчин, улсын хошоо аварга тус бүрийг дурсгалын цом, мөнгөн аяга, гуулин бүслүүртэй модон хувин, өргөмжлөл, энгэрийн тэмдэг, үнэмлэх, бусад зүйл бүхий 10 сая төгрөг, улсын аварга тариаланч хамт олон тус бүрийг 5 сая төгрөг, улсын аварга тариаланч тус бүрийг 3 сая төгрөг гэх мэтээр шагнахыг бол журамласан байна. Үүнийх нь үр дүнд сүүлийн 2 жилээр тооцоод үзэхээр 207 хүнд 2023 онд 1.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. 2024 онд 292 хүнд 2.4 тэрбум төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамнаас гарсан байна. Тэгээд энэ салбарт 300 мянган хүн ажилладаг. Улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг. Тогтвортой

санхүүжилтийн систем үүсгэх боломжгүй учраас олон хүмүүс шантарч, энэ салбараас гарч байгаа. Засгийн газар уралдаан зарлаж байгаа мэт жилдээ 200, 300 хүнийг түүж аваад, хамгийн түрүүнд нь орсон хүмүүст 2.4 тэрбум төгрөгөөр шагнаж байхаар энэ салбарт хийх их хэмжээний бүтээн байгуулалтад зарцуулах хэрэгтэй байгаа. Тэр утгаараа 300 мянган хүнтэй холбоотой асуудлуудаа шийдээд явбал зүгээр юм биш үү гэж харах юм. Эсвэл одоо энд тавигдаад байгаа төсвөө бид татвар төлөгчдийнхөө ачаанаас нь багасгаад ор тас хасчихвал яасан юм. Айлын хүүхдийг алагчилж үзэж байгаа юм шиг бид ялгавартай байдлаар одон медаль тарааж, иргэдээ талцуулах шаардлагагүй гэж харагдаж байна. Мэдээж энэ салбарт ажилласан, энэ шагналыг авсан хүмүүсийг бол буруутгаагүй. Хөдөлмөрөө эрхлээд, хөдөлмөрөө үнэлүүлж байгаа. Гэхдээ бодит байдал дээр 300 мянган хүн, дээрээс нь 3.5 сая хүний амьдралтай холбоотой чухал асуудал байхад бид бүхэн ач холбогдлоор нь эрэмбэлээд, энэ шагналтай холбоотой асуудлаа цэгцэлчихвэл яасан юм бэ гэдэг санал байна. Тэгээд төрдөө үнсүүлнэ гэж бид бүхэн яриад байдаг. Гэтэл үгүй шүү дээ. Энэ чинь татвар төлөгчдийн мөнгөөр бид бүхэн өгч байгаа гэсэн үг. Тэрийг иргэд маань бас сайн ойлгоосой гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд хариулт өгье. Аварга малчин, аварга саальчин, аварга фермер.

Ж.Энхбаяр: Энэ салбарт хөдөлмөрлөсөн хүнийг урамшуулж байгаа бодлого. Үнэхээр 3.5 сая хүний хоол унд, хүнсийг гол хангаж байна. Ёстой гадаа гадаж, хөдөө хөхөрч байгаа хүмүүс шүү дээ. Энэ шагнал чинь бас их том урам болдог юм. Жишээлбэл, тариаланчид гэхэд нэг шинэ технологи нэвтрүүлчихье, ийм хөрөнгө оруулалт хийчихье, бүтээмжээ нэмчихье, ургацаа нэмчихье гээд. Үүний цаана дандаа нэмүү өртөг, улс орны эдийн засагт хувь нэмэр оруулсан үр дүнг үнэлээд байгаа юм. Тэр малчин гэхэд өөр бусдыг малжуулсан, орон нутгийн хөгжлийн бодлогод оролцсон, малынхаа үүлдэр угсааг сайжруулсан, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлсэн гээд дандаа хөдөлмөрийн өгөөж, бүтээмжийг үнэлээд байгаа. Тэгээд энэ урамшуулах бодлого цаашдаа явах нь зүйтэй гэсэн байр суурьтай байдаг. Харин агуулгыг нь жоохон өөрчлөх зайлшгүй шаардлага байгаа. Жишээлбэл, газар тариалангийн бүс нутагт аварга малчин шалгаруулаад байх шаардлагагүй. Илүү фермерийн аж ахуй, эрчимжсэн аж ахуй, газар тариалан талдаа яваад, бусад уламжлалт мал аж ахуйтай салбартаа аварга малчныхаа бодлогыг үргэлжлүүлээд явах нь зүйтэй гэж үзэж байгаа. Гэхдээ болзлыг улам бүтээмж рүүгээ хөшүүрэгдэх хэрэгтэй болов уу гэж бодож байна. Ашиг шимээ сайжруулсан, бусдад сайн тусалж дэмжсэн, ажлын байраар хангасан тэр талын үр дүнг буюу шагнал олгох шалгуурыг чангатгах нь зүйтэй гэдэгтэй санал нэг байгаа.

Д.Амарбаясгалан: Түрүүнд би нэрийг нь хасаад хэлчихсэн байсан. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Манай хүнс, хөдөө аж ахуйн салбар ер нь нэг учраа олохгүй явж байгаа ийм салбар. Нөгөө дуунд гардаг, жилээс жилд жижгэрсэн жаахан буурал ээж минь гэдэг шиг жилээс жилд

эдийн засагт оруулж байгаа нөлөө, олж байгаа орлого, тэр оролцогчдын ахуй амьдралын түвшин жилээс жилд жижгэрсэн, салбараас нь залуучууд дайжсан нэг ийм байдалтай. Тэгээд бид нар арга хэмжээ авахаараа төрийн дэмжлэг гэдэг. Төрийн дэмжлэг гэхээр зөвхөн санхүү мөнгө баахан ярьдаг. Бусад арга барил, арга хэмжээ гэдэг зүйлүүд байдаггүй. Уг нь энэ зах зээл чинь, эдийн засаг чинь өөрөө эрэлт нийлүүлэлт. Эрэлтийг нь дэмжих үү, нийлүүлэлтийг нь дэмжих үү гэдэг ийм 2 үндсэн бодлого байх шиг байгаа юм. Тэгэхээр бид нар ерөөсөө тэр нийлүүлэлтийн талд дэмждэг, эрэлт буюу нөгөө борлуулалт талаа орхичихдог. Тэгээд нэг ЖДҮ-ийн есөн жорын бүтээгдэхүүн нь зарагддаггүй дампуурсан жижиг ЖДҮ компаниудын түүх өнгөрсөн хугацаанд асар их. Зээлийн үр ашиггүй байдал гээд олон шүүмж хэлбэл зөндөө юм хэлж болно. Үүний оронд ажил хэрэгч нэг санал хэлэх гэсэн юм. Сая Австралид яваад ирсэн. Тэдний хүнсний бүтээгдэхүүнүүд дээр бүгдэд нь 5 од рейтинг, үнэлгээ гээд байдаг юм байна. 5 од дотроо 1 одыг 10 янзаар үнэлчихсэн. Энэ боловсруулалтын түвшин, аюулгүй байдал, хадгалалтын түвшин, гарал үүсэл, олон зүйлээр нь үнэлдэг. Бүтээгдэхүүн дээр нь томоор тавьчихсан. Хэрэглэгч эндээс сонголтоо хийдэг. Би адилхан 2 бүтээгдэхүүнээс миний авах гэж байгаа бүтээгдэхүүн хэдэн одтой вэ? 5 одтой юу, 4 одтой юу, 3 одтой юу. Сахрын агууламж, цардуул уургийн агууламжийг мэдэх боломжтой. Энэ нь ямарваа нэг мөнгө зарахгүйгээр хийж болох ажлын жишээ. Бид нар зүгээр зохицуулалт, төрд байгаа мэдээллийн түвшинд. Тэгээд энэ үнэлгээг гаргуулахдаа дахиад хэн нэг нь төрийн албан хаагч, дарга биш, энийг тэр мэргэжлийн холбоод холбогдох байгууллагууд нь нийлээд гаргачихдаг. Бие биедээ хяналт тавиад явж болдог. Үүнээс гадна дахиад нэг жишээ бол бүтээгдэхүүний шошго. Одоо бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд хамгийн багадаа Австралиас хэчнээн хувийн орц орлоо. Зөвхөн энийг гаргах нь өөрөө үндэсний статистик, гааль, татвар, олон төрлийн мэдээлэл дээр нэгтгээд гаргадаг. Үндэсний үйлдвэрлэл гэдгийг яаж томьёолж, тодорхойлж байгаа юм. Хэдээс дээш хувийн ямар орц найрлагатай байгаа талаарх мэдээллийг үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд нь тавьдаг байна. Энэ бүхний хамгийн гол нь бараа бүтээгдэхүүний шошго, хаяг дээр мэдээллийг тодорхой томьёолсноор хэрэглэгчийн сонголт дээр үлдээдэг байна. Тэрнээс биш бид улсаас зээл авчихсан, татаас өгчихсөн тул энийг заавал чи ав гэж тулгах биш. Хэрэглэгч энийг би авъя гэдгийг өөрөө энэ дээр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.11-д заасны дагуу намын бүлэг тус бүрээс 1 гишүүн төлөөлж, Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуултыг асууна. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар асуулт асууна. Асуулт асуух, хариулт авах хугацаа 20 минут. Эхэлье.

Дав.Цогтбаатар: Баярлалаа. Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажлын талаар Ерөнхий сайдын хийсэн мэдээлэлтэй холбогдуулаад иргэдээс ирсэн асуултыг асууя.

Иргэн Сарантуяа 2 асуулт асуусан байна. Нэгдүгээр асуулт, “Шинэ хоршоо” хөдөлгөөнөөр олгогдсон зээл эздэдээ хүрсэн үү? Малчдад биш сумын төвийн иргэд, аймгийн төвийн иргэд зээл авсан асуудал байгаа гэдэг мэдээлэл байна. Мөнгө угаалт болчихсон юм биш үү? гэсэн асуулт байна. Асуултаа асуугаад шууд хариултаа аваад явах уу?

Д.Амарбаясгалан: Шууд хариулт өгье. 4 дүгээр индэр.

Ё.Азжаргал: Арилжааны банкны зээлэнд хамрагдахад 2 үндсэн шаардлага байгаа талаар түрүүн хариулсан. Малын А данстай малчин иргэнд зээл олгож байгаа. Мал бүхий иргэнд бол олгохгүй байгаа. Банкны шаардлага нь тодорхой байгаа. Өнгөрсөн жилийн хугацаанд нийт 21 аймгийн 329 сумд бол зээл гарсан байгаа. Нэг суманд зээл гараагүй. Тэгэхээр өргөн хүрээгээр улс орон даяар хамарсан.

Д.Амарбаясгалан: Эзэндээ очсон юм уу, очоогүй юм уу? Аймгийн төв дээр амьдардаг иргэд авсан гэж асуугаад байна шүү дээ.

Ё.Азжаргал: Эзэндээ очсон. Аймгийн төв дээр амьдардаг иргэд аваагүй. Мал бүхий иргэд аваагүй. Энэ бол малчныхаа А дансаар нотлогдож байгаа. Баярлалаа.

Дав.Цогтбаатар: Хоёрдугаар асуулт. Хөдөө аж ахуйн салбарын бодит үр дүн, үнэн бодит төрөх, төрөөс үзүүлж буй гэх нэрээр татаас, хүүгийн дэмжлэг, олон улсын зээл тусламжийн хөтөлбөр нэрээр халамжийн бодлого хэрэгжүүлэх болсоор удаж байна. Энэ бодлогоо өөрчилж, шинэчлэх санал санаачилга байна уу? гэж байна.

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо” зэрэг хөдөлгөөн, “Атар 4” аян гэсэн хоорондоо нягт уялдаа бүхий Улсын Их Хурлаар батлагдсан бодлогыг цаашдаа тогтвортой хэрэгжүүлэх ёстой. Энэ бол салбарыг босгох урт хугацааны бодлого. Өнөөдөртөө зээлийн хүүгийн дэмжлэг, татаас, урамшуулал мэтээр харагдаж байгаа боловч үүний цаана олон мянган ажлын байр, олон тэрбум ам.долларын экспорт, олон тэрбум төгрөгийн импортыг дотооддоо орлодог олон үйлдвэр, аж ахуйнууд шинээр бий болж байгаа. Үр дүнтэй хөтөлбөр гэж үзэж байгаа тул энэ хөтөлбөрийг 2028 он хүртэл тогтвортой хэрэгжүүлэх ёстой гэж үзэж байгаа.

Энд зөвхөн “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний үр дүнд хүнсний бүтээгдэхүүн нэр төрөл 37 хувиар өссөн. Үүн дотор сүү, сүүн бүтээгдэхүүний нэр төрөл 58 хувь, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл 44 хувь, гурил, гурилан бүтээгдэхүүний нэр төрөл 43 хувь, мах махан бүтээгдэхүүний нэр төрөл 12 хувиар тус тус нэмэгдэж, хэрэглэгчдэд олон сонголтыг бий болгосон. Газар тариалангийн салбарт гэхэд зоорийн багтаамж 15 хувь, үтрэмийн багтаамж 7 хувь, тариалангийн талбай 13 хувь, хүлэмжийн талбай 28 хувиар тус тус

нэмэгдсэн байна. Хөнгөлөлттэй зээлийн үр дүнд зээлд хамрагдсан аж ахуйн нэгжүүд ажлын байр 21 хувь, дундаж борлуулалтын орлого нь 31 хувь, дундаж цэвэр ашиг нь 32 хувь, үндсэн хөрөнгө нь 51 хувь, эргэлтийн хөрөнгө нь 38 хувь, аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татвар төлөлт 46 хувь, нийгмийн даатгалын төлөлт 60 хувиар тус тус өссөн гэсэн статистик дүн гарч байгаа буюу салбарт хэрэгжиж байгаа бодлого үр дүнгээ өгч байгаа. Дөнгөж эхлэлийн шатанд байна шүү дээ гишүүд ээ. Зарим нь дөнгөж энэ жилээс хэрэгжиж байна. Тогтвортой 4 жил явуулаадахъя. Бодитой үр дүн гарна. Итгэлтэй байгаа.

Д.Амарбаясгалан: Дав.Цогтбаатар гишүүн.

Дав.Цогтбаатар: Дараагийн иргэний асуулт. Иргэн Батбаатар 5 асуулт асуусан. Нэгдүгээр асуулт малчдын орлого сүүлийн 4 жилд аймаг бүрээр хэдэн хувиар өссөн талаар мэдээлэл өгнө үү?

Д.Амарбаясгалан: Мэдээлэл хаанаас өгөх вэ? Малчдын орлого нэмэгдсэнтэй холбоотой асуудлаар.

Дав.Цогтбаатар: Хөдөө аж ахуйн сайд байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Малчдын өнгөрсөн жилийн дундаж орлого бол сарын 1 сая 520 мянган төгрөг. Малчин өрхийн зардал бол 2 сая 100 орчим мянган төгрөг гаргадаг гэдэг статистикийн мэдээг статистикийн байгууллагаас гаргаж өгсөн байдаг. Тэгэхээр орлого нэмэгдүүлэх арга хэмжээг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас энэ олон төсөл хөтөлбөрийн хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлээд ажиллаж байна. Энэ дээр статистикийн газраас албаны хүн байхгүй байгаа учраас шууд хариулж болохгүй байна. Болорчулуун даргад тоо баримт мэдээлэл байна уу? “Шинэ хоршоо” хөдөлгөөнтэй холбоод статистик мэдээ аваад үзэхэд малчдаар дамжиж байгаа зээл шүү дээ. Зарим аймгууд аймгийнхаа нийт төсөвтэй тэнцэх хэмжээний зээл, хөрөнгө оруулалтыг татсан үзүүлэлтүүд байгаа. Жишээ нь Говь-Алтай аймаг орон нутгийнх нь төсөв 75 орчим тэрбум төгрөгөөр батлагдаж байхад хоршооноос зээл авсан малчдын зээлийн дүн нь 60 гаруй тэрбум төгрөг болчихсон байх жишээтэй. Тэгээд энэ нь 2-3 жилийн дараа бодитой үр дүн нь гарч, орон нутгийн хэмжээнд орон нутгийн нийт бүтээгдэхүүн нь 1 хүнд оногдох малчдын хувьд бол сайн үзүүлэлтүүд гарна гэж тооцож байгаа. Дараачийнх нь асуулт.

Дав.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга хариулчихлаа гэж үзэх үү? 2 дахь асуулт бэлчээрийн даац хэтэрсэн гэсэн мөртөө энэ хүрээнд ямар ч үр дүнтэй ажил хийсэн талаар ямар ч мэдээлэл байхгүй байна. Уриа лоозон шиг “Шинэ хоршоо”, “Атар 4” аяныг зохион байгуулж байна гэж бичих нь малчдын дунд тулгамдаж байгаа асуудлыг шийдсэн зүйл байхгүй байгаад хариулт өгнө үү? гэж байна.

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Үнэхээр бэлчээрийн даац хэтэрсэн байгаа. Одоо 25 сая толгой хонин толгойд шилжүүлснээр даац хэтрээд байна. Иймд сүргийн эргэлтийг төлөвлөхөөр хэрэгжүүлэх том бодлого гарсан. Үүнд жил бүр хонин сүргийг 1.7 хувь, ямааг 1.9 хувь, адууг 0.8 хувиар тус тус бууруулах хэрэгтэй байгаа. Харин үхэр сүргийг 0.5 хувь, тэмээг 0.3 хувиар тус тус нэмэгдүүлэх шаардлага байгаа. Тэгээд бэлчээр хамгаалалттай холбоотойгоор жилдээ 650 гаруй сая га бэлчээрийн ургамал хамгаалалтын ажил хийгдэж байгаа. Шавж, өвчин мэрэгчтэй тэмцэх ажлууд хийгддэг. Нөгөө талаар жил бүр 200 орчим гүн худаг гаргаж байна. Гүн өрмийн худаг гаргаж, бэлчээрийг усжуулж, ашиглалтыг сайжруулах ажлууд хийгдэж байгаа. Гол нь бэлчээрийн доройтлоос хамгаалах гол бодлого бол мал, махны экспортыг нэмэгдүүлэх юм. Энэ бодлогыг бид бүх талаар идэвхжүүлж байна. Түрүүн хэлсэн сүүлийн 2 жил 600 сая ам.долларын мах экспортолж чадлаа. Өмнөх жилд 10, 20 сая ам.доллараас гарч үзээгүй байсан. Харин огцом сайн өсөлт байхгүй байгаа гол шалтгаан нь мал эмнэлгийн ажил үйлчилгээтэй шууд холбоотой. Малын вакцин, өвчнийг хяналтад аваад эхлэхээр эрүүл бүсүүдийг бий болгоод улмаар экспорт нэмэгдээд ирнэ. Тэгэхээр махны экспортыг улам сайжруулах 1 тэрбум ам.долларт хүрэхийн төлөө зохион байгуулалт хийгээд явж байна. Мал экспортод гарах тусам малчдын орлого нэмэгдэнэ. Үүнийгээ дагаад сүргийн бүтэц нь зөв болоод байгаа юм.

Нөгөө талаар бэлчээрээс гадна тэжээлийн таримлыг эрс нэмэгдүүлж байгаа. Энэ жил гэхэд 120-оод мянган га-д тэжээлийн таримал таригдаж байна. Илүү ашиг шимтэй, уургийн агууламж сайтай тэжээлийн нөөцийг бий болгосноор мал сүргээ эрсдэлээс хамгаалах, зуд болоод 8, 9 саяар нь хорогдуулдаг биш, тэжээгээд гардаг ийм чадавхыг бий болгох тэжээлийн үйлдвэрүүдийг олноор бий болгож байна. Тэжээлийн аж ахуйнуудыг дэмжиж байна. Ийм байдлаар хариулья даа.

Д.Амарбаясгалан: Дараачийн асуулт.

Дав.Цогтбаатар: Гуравдугаар асуулт. “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд зээл авсан малчдаас хэд нь эргэлтэд оруулж ашигтай ажиллаж байгаа талаар судалгаа мэдээлэл байхгүй байна. Энэ талаар тооцоо судалгаатай хариулт өгнө үү гэж байна.

Д.Амарбаясгалан: Ё.Азжаргал 4 дүгээр индэр.

Ё.Азжаргал: Өнгөрсөн 1 жилийн хугацаанд 2 удаа Засгийн газар малчин өрх болгонд хүрэх ажлыг зохион байгуулсан. Оны өмнө бол Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын тушаал гарч, 330 сум, нийтдээ 652 төрийн албан хаагч оролцож, 121 шуурхай бүлэг ажилласан. Тэгээд асуумж судалгааны үр дүнг та бүхэндээ танилцуулъя. Энэ хөдөлгөөний хүрээнд 13,500 малчин айлд хүрч ажилласан. Үүнээс бол 96 хувь нь зээлийн зориулалтын дагуу зарцуулж байна. Энэ зээл Хөрөнгө оруулалтын зээл байгаа. Үүнээс 87 хувь нь өвөлжилтийнхөө бэлтгэлийг хангахад дэмжлэг болсон гээд судалгааны үр дүнгүүд бол гарсан.

Түрүүн хариулахдаа бас хэлсэн. Нийт 8 мянган хоршоо татварын тайлан ирүүлсэн. Ингээд 402 тэрбум төгрөгийн борлуулалтын ажил хийж, 570 сая төгрөгийн татвар төлөх тайлан ирүүлсэн байгаа. Энэхүү хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлд хамрагдсан нийт 490 хоршоод татварын харилцаанд орж, сайн жишиг хоршоод бий болсон. Нэг зүйлийг нэмээд хэлье. Өнгөрсөн хугацаанд хяналт мониторингийн ажлууд сайн хийгдсэн. Манай Зээлийн батлан даалтын сангийн баг нийт 21 аймгийн 1100 хоршооны 1407 зээлдэгчийн төслийн хэрэгжилтэд хяналт тавьж мониторинг хийж ажилласан байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дараагийн асуулт.

Дав.Цогтбаатар: Бид мэдээлэл авдаггүй юм байна. Тэр мэдээлэл хүргэх ажлаа хүртээмжтэй байдлаар хийвэл бас зүгээр байна. Та хэдийн өөрсдийнх компьютер дээр мэдээлэл байгаад байна. Иргэдэд мэдээлэл байхгүй. Улсын Их Хурлын гишүүдэд мэдээлэл өгөөч гэж хандаж байгааг анхаарч ажиллаарай.

Дөрөвдүгээр асуулт. Нийт малчдын дунд залуу малчдын эзлэх хувь 1992 онд 35 хувь байсан бол 2023 онд 24 хувь болж буурсан байна. Малчдын тоон өсөлт нь малын чанарын өсөлтөд саад болж байгааг онцлоод боловсруулах үйлдвэр хөгжөөгүйгээс гадны зах зээлийг түүхий эдээр хангагч хавсарга улс болж хувирлаа. Малыг гаралтай түүхий эдийн үнэ унаж, хонины нэхийг гэхэд нэг тал хайрцаг тамхины үнэд ч хүрэхгүй байна. Үүнийг яаж шийдэх вэ? Энэ засагт ямар шийдэл байна вэ? Ер нь засагт үр дүнтэй хийсэн ажил байхгүй. Төсвийн мөнгийг үр дүнгүй зарцуулж байна гэж байна.

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Үнэхээр салбарт хүний нөөц дутагдаж байгаа. Нөгөө талаар Монгол Улсын эдийн засаг сайн тэлсэн. Үндсэндээ сүүлийн 10 жил 3 дахин тэлчихлээ. 90 их наяд төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүнтэй болчихлоо. Үйлдвэрлэлд хүн хүрэлцэхгүй байна. Ажиллах хүчний нөөц их дутуу байна. Бид цөөхүүлээ байгаа энэ зовлон манай салбарт байгаа. Тэгэхээр мал аж ахуйн салбарыг үр ашигтай байлгах хэлбэрт оруулах бодлого явуулж байна. Мал маллах нь ашигтай. Тариа тарих нь ашигтай. Ногоо тарих нь ашигтай. Амьдралын баталгаа болдог бодлогыг хэрэгжүүлнэ. Тэр бодлогууд нь бид нарын яриад байгаа “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” зэрэг хөтөлбөрүүд шүү дээ.

Жишээлбэл, “Цагаан алт” хөтөлбөрийн үр дүнд бид ноолуураа гартаа хийгээд авлаа. Энэ жил 30 мянган тонн ноос бэлдэнэ. Ноосоо 100 хувь боловсруулах ажлууд эхэлж байна. Хивсний үйлдвэрүүд, ноосон эдлэлийн үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалтууд, технологийн шинэчлэлүүд сайн явагдаж байна. Зөвхөн хивсэн дээр гэхэд 200 мянган м² сүлжих хүчин чадал нэмэгдэж байгаа. Эрдэнэт хивс, Улаанбаатар хивс машины технологийн шинэчлэлүүд хийгдэж байна. Арьсны салбарт ч шинэ шинэ шугамууд ашиглалтад орж байна. Одоо ид угсрагдаж байна. Тэгэхээр үндэсний үйлдвэртэй байж байж түүхий эд үнэтэй байдаг юм байна. Энийг ноолуур дээр харуулсан. Тийм болохоор үйлдвэрийн бодлогоо байнга дэмжих нь чухал. Энэ бодлогын хүрээнд “Цагаан

алт” үндэсний хөдөлгөөн өрнөсөн. Энэ 1990-ээд он, 2000 оны эхээр бидний гол алдаа бол түүхий эдээ гадны үнийн бодлогод автаж гадагшаа өгсөөр байгаад дотоодын үйлдвэрлэлээ унагааж, бэлтгэгдсэн боловсон хүчин, тоног төхөөрөмжийг үрэн таран болгосон. Тэгээд энэ алдааг засах залруулах үүднээс үндэсний хөдөлгөөнүүд, үйлдвэрлэлийг дэмжих бодлогууд хэрэгжиж байна. Нэлээн үр дүн гарч байна. Ажиллах хүчин бэлтгэгдэж байна. Тэгэхээр нэг зүйлийг дахиад хэлэхэд хүний нөөцийн асуудал, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх бодлогыг онцгой анхаарч өгөөч гэсэн салбар хүсэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт байнга тавьж байгаа. Манай салбараас ангид байгаа хүний нөөц, боловсон хүчин бэлтгэх бодлого мөн шинжлэх ухааны бодлого нь тусдаа яваад байгаа. Тэгээд салбартаа өгөөж их муутай яваад байна. Тэрийг эргэж хараач ээ гэж би хүсэлт тавиад байгаа юм.

Дав.Цогтбаатар: Дараагийн асуулт бэлчээрийн талбай 1970-аад оныхоос 20 сая га-гаар буураад байна. Нийт бэлчээрийн 40 хувь нь 1-3 дахин, 25 хувь нь 3-5 дахин, 20 хувь нь олон дахин даац хэтэрсэн гэсэн судалгаа байдаг. Нийт бэлчээрийн 78 хувь хөрсний элэгдэлд өртөж, цөлжилт эрчимжиж байна. Энэ хүрээнд хийсэн ажил Засгийн газарт байхгүй байна. Яагаад үүнийг шийдэх ажил хийхгүй байна вэ?

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Нийт бэлчээрийн 78 хувь нь хөрсний элэгдэлд орчихсон байгаа. Энэ үнэн. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 1 хүрэхгүй хувьд газар тариалан эрхэлж, бусад 99 хувьд нь мал аж ахуй эрхэлж байгаа. Түрүүн хэлсэн 25 сая толгой-гоор малын даац хэтэрчхээд байгаа. Тэгэхээр ургамлын ургах, нөхөн төлжих чадавх малын тоо толгойтой холбоотой хязгаарлагдаад байгаа. Тэгэхээр экспортын орлого олох маягаар малын тоог зохистой буулгая. Нөгөө талаас үр ашигтай малын тоог нэмье. Нэг малаас авах ашиг шимийг нь сайжруулъя. Ноолуурын гарц, ноосны гарц, махны гарц, сүүний гарцыг нэмье. Жишээлбэл, манай дээр 70 орчим мянган сүүний үнээ саальд ашиглагддаг. Үүнийг 25 мянган үйлдвэрлэг үнээгээр солиход үнээний тоо толгойг зохистой хэмжээнд бууруулж үйлдвэрлэг байдлыг сайжруулах, нөгөө талд бүтээмжийг нэмэх бололцоо байна. Энэ чиглэлээр яамнаас тооноос чанарт шилжих, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх ажлуудыг хийж байна. Нөгөө талаас дэлхийн цаг уурын өөрчлөлт, Төв Азийн тэгш өндөрлөгт өндөрт өргөгдсөн Монгол Улсын хувьд байгаль цаг уурын нөлөөлөл өндөр гараад, дулаарал нэмэгдээд, ган, зудын давтамж нэмэгдээд, уламжлалт мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэхэд бага хэмжээний эрсдэлүүд учирч байгаа. Энийг хамгаалах гол арга бол газар тариаланг эрчимтэй хөгжүүлэх, тэжээлийн таримлын нэмэх, тэжээлийн нөөц баазыг өргөтгөх юм. Улмаар байгаль цаг уурын бэрхшээлийг нүүдлийн мал аж ахуйгаар даван туулахад газар тариалангаа холбож тусалж, хамтарч ажиллах зайлшгүй шаардлага байгаа. Энэ чиглэлээр бодлогын үйл ажиллагаанууд хийгдээд явж байна.

Дав.Цогтбаатар: Дараагийн иргэний асуулт. Улаанбаатар хотын хүнс, махны эрүүл ахуйг сайжруулах тал дээр ямар шийдэлтэй байгааг Ж.Энхбаяр сайдаас асууж өгөөч гэж байна.

Ж.Энхбаяр: Яамнаас зохицуулалтын арга хэмжээг ээлж дараалан авч байна. Жишээлбэл махан дээр гэхэд зөвхөн үйлдвэрийн аргаар төхөөрсөн махыг 8 нэрийн уламжлал дэлгүүрүүдэд худалдаалах техникийн зохицуулалтыг баталсан. Үүнийг энэ жилээс мөрдүүлэх ажлууд хийгдэж байна. Та бүхэн анзаарч байгаа бол дэлгүүрт ангилсан мах зардаг болж байгаа. Гулуузаар нь зардаг, хээрийн бой хийдэг тоо хэмжээ эрс багасаж байгаа. Махны экспорт нэмэгдээд, олон 100 сая ам.долларын мах экспортлоод байгаа гэдэг нь үйлдвэрийн аргаар төхөөрсөн малын тоо нэмэгдээд байна гэсэн үг. Тэгэхээр үйлдвэрийн аргаар төхөөрсөн махны эрүүл ахуйн баталгаат байдал сайжраад байна.

Дав.Цогтбаатар: Улаанбаатар хотын хүнсний хэрэгцээг яаж хангах вэ? Технологийг нь бол ойлгоод байна.

Ж.Энхбаяр: Одоо хүнсний хэрэгцээг мал аж ахуй, газар тариалан зэрэг суурь салбараасаа л хангаж байна. Импорт өндөр байна. Импортыг буулгах бодлого хэрэгжүүлж байна. Тэгэхээр яаж хангах вэ гэдгийг нь би сайн ойлгохгүй болоод байна даа.

Дав.Цогтбаатар: Иргэнээс ирсэн асуулт нь Улаанбаатар хотын хүнсний хэрэгцээг яаж хангах вэ? гэж байгаа юм. Яг хэдэн үйлдвэр Улаанбаатар хотыг тойроод байна гэдэг ч юм уу?

Ж.Энхбаяр: Ер нь төвийн бүсэд хөдөө аж ахуйн гаралтай үйлдвэрлэлийн 99 хувь нь байгаа. Газар тариалангийн нөөцөд тулгуурлаад гол үйлдвэрлэл хүний нөөц, дэд бүтцээ дагаад төвийн бүсэд буюу Улаанбаатар хотод төвлөрсөн байгаа. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын хүнсний хэрэгцээ хангалттай, тогтвортой, сонголттой, хүртээмжтэй байгаа. Хүнсний хангалт дээр ямар нэгэн эрсдэл гараагүй, асуудал үүсээгүй байна.

Дав.Цогтбаатар: Ерөнхий сайдаас нэг асуулт байна. Хөдөө аж ахуйн экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр танай Засгийн газар юу хийх вэ? 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр Малчин өрхийн нэгдсэн холбооны буюу Холбооны тухай хуулийг Улсын Их Хурлаас баталсан. Үүнийг хэрэгжүүлэх чиглэлд ямар ажил хийж хэрэгжүүлэх вэ?

Г.Занданшатар: Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт, гадаад зах зээлийг нээж өргөтгөх шаардлагатай. Гадагшаа мал махны экспорт, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт нээхийн тулд малыг эрүүлжүүлэх бодлого тууштай хэрэгжиж, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад мэдээлэх учиртай. Малыг эрүүлжүүлэх хүрээнд олон улсын стандартыг нэвтрүүлж ажилласнаар сүүлийн 2 жилд малын өвчлөл эрс буурсан, малын өвчин гараагүй, вакцинжуулалтын чанар сайжирсан. Малаа эрүүлжүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлж байж махны экспорт нэмэгдэнэ. Энэ хүрээнд ЕвроАзийн гишүүн 5 орны зах зээл бол 12 тэрбум ам.долларын мал, мах, арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн импортоор авдаг ийм зах зээлийн боломж байна гэж үзэж байгаа. Энд өрсөлдөж зах зээлийн 20 хувьд нэвтрэхэд 2.4 тэрбум ам.долларын шинэ зах зээл гадаадад нээгдэж байна. Хамгийн гол нь дотооддоо бид үйлдвэрлэлийн хүчин чадал, олон улсын стандарт, техникийн зохицуулалтыг

хангах чадавхтай эрүүл малтай байж үйлдвэрлэлийн чадавхаа сайжруулах ёстой. Ингэж чадвал малчдын орлого ч нэмэгдэнэ, үйлдвэрлэлүүдийн хүчин чадал ч сайжирна. .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Асуулт асуух 20 минутын хугацаа дууссан байна.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай асуулт асууна.

М.Мандхай: “Шинэ хоршоо”-нд дундын хоршоог хөгжүүлэх чиглэлээр нэмэлт зээл гарах уу? Хэзээнээс эхлэх вэ гэсэн эхний асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. 4 дүгээр индэр.

Ё.Азжаргал: М.Мандхай гишүүний асуултад хариулъя. Одоо байгаа хоршооны гишүүний малчны зээл гээд бүтээгдэхүүн нь санхүүгийн ерөнхий гэрээгээр зохицуулагдаж байгаа. Энэ гэрээгээр малчинд зээл гарахаар зохицуулагдсан. Одоо “Шинэ хоршоо” хөдөлгөөний дараагийн үе шат болох дундын хоршооны зохион байгуулалтад оруулж буй үе шатыг хийхийн тулд зайлшгүй санхүүжилтийн ерөнхий гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа. Арилжааны банкнуудтай зөвлөлдөхөд арилжааны банкнууд бол эх үүсвэр боломжтой гэдэг ийм хариуг өгсөн. Ингээд одоо бэлтгэл ажлын хүрээнд судалгааг хийгээд, дараагийн үе шат руу оруулах ажлыг зохион байгуулна. Баярлалаа.

М.Мандхай: Хоёр дахь асуулт. Үйлдвэрийн аргаар махны хэдэн хувиа хангаж байгаа вэ? Гар аргаар хэдэн хувиа хангаж байна вэ? Махны техникийн зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа махны үйлдвэрийн аргаар хэзээнээс бүрэн бэлтгэдэг болох вэ? гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Харилт өгье. 4 дүгээр индэр.

Д.Довчинсүрэн: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн байна. М.Мандхай гишүүний асуултад хариулъя. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр худалдааны техникийн зохицуулалт 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хоол үйлдвэрийн үйлчилгээнд хэрэгжээд эхэлчихсэн. Сая 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс бүх махны худалдаанд заавал үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүнийг худалдаалах гээд заагдсан байгаа. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хувь хэмжээ энэ жилийн хувьд суурь түвшин болох 2024 онтой харьцуулахад нийслэлд 15 хувиар нэмэгдсэн байгаа.

М.Мандхай: Дутуу хариулчих шиг боллоо. Махны техникийн зохицуулалтыг хэрэгжүүлж махаа үйлдвэрийн аргаар хэзээ бүрэн бэлтгэдэг болох уу? гэж байна. Тэгээд гар аргаар хэдэн хувиа хангаж байгаа вэ гэсэн асуулт байсан. Тэгээд нэмээд асууя. Хөдөө аж ахуйн салбарт төрөөс урамшуулал татаасыг сүүлийн 30-аад жил олгож ирлээ. ДНБ-д эзлэх хувь буурсан, импортын

хүнсний хараат байдал нэмэгдсэн, идэж байгаа хүнс нь хортой, баталгаагүй, үнэтэй байна. Энэ чөтгөрийн тойргоос хэзээ гарах вэ? гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ 30 жил ийм урамшуулал яваагүй дээ. Сүүлийн жилүүдэд үндэсний хөдөлгөөн гаргаж, хүнсний аюулгүй байдлаа хангахгүй бол, дотоодын үйлдвэрлэлээ сэргээхгүй бол ер нь гадаад улсын хамаарал эрс нэмэгдэж байна. Хүнсний чанар, аюулгүй байдлын асуудал дордож байна гэж үзээд “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг анх Монгол Улсын Төрийн тэргүүн Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжээд эхэлж байна. Ахиц дэвшил үнэхээр гарч байна. Та бүхэн дэлгүүр хоршоонд ороод үзээрэй. Дотоодын хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл эрс өссөн. 52 хүнсний үйлдвэр нэмж ашиглалтад орлоо. 400 гаруй шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн бий боллоо. Манайхан бас нэг үеэ бодвол үйлдвэрлэдэг, тарьдаг, ургуулдаг, бүтээдэг болж байна. Аль болох импортын хүнсний хамаарлыг багасгах бодлогыг бид хэрэгжүүлж байна. Тэрний төлөө энэ салбар ажиллаж байна. Тэгэхээр үр дүн гарна гэдэгт итгэлтэй байна. Одоо байгаа явцын үр дүн хөнгөн үйлдвэр дээр мал, мах дээр ч, арьс шир, ноос ноолуур дээр ч, хүнсний бүтээгдэхүүн дээр ч, үр тариа, тэжээлийн таримал дээр ч ахиц гарч байгаа. Бүтээгдэхүүний нэр төрлүүд байнга нэмэгдэж байгаа. Экспортын шинж чанартай болж байгаа. Бид махаа сайн экспортолж байна. Үр тарианы төрлийн таримлын экспорт 100 сая ам.долларт хүрэхээр болж байна. Ноос ноолуур, арьс шир, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлүүд үйл ажиллагаагаа явуулж байна. Бэлэн боловсруулсан хүнсийг манайхан эхнээсээ экспортод гаргадаг болж байна. Салбар ер нь бодлогын хувьд, үйл ажиллагааны хувьд, үндсэн чиглэлийн хувьд эрс өөрчлөгдсөн. Ахиц их сайн гарч байгаа.

М.Мандхай: Бэлчээрийн талхлалт, сум, аймаг дундын бэлчээрийн газрын маргаан нэмэгдсээр байна. Бэлчээрийн тусгайлсан хууль батлагдахгүй явж ирсэнтэй холбоотой гэж боддог. Энэ хууль батлагдах уу гэж асууж байна.

Ж.Энхбаяр: Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал байх даа.

М.Мандхай: Бэлчээрийн тухай хууль батлагдах уу гэж асууж байна.

Ж.Энхбаяр: Бид хуулиа батлуулахын төлөө салбарын хуулийг боловсронгуй болгох чиглэлээр гишүүдтэй хамтраад хуулийн төслийг өргөн бариад явж байна. Тухайлбал, Хөдөө аж ахуйн тухай суурь хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Малын хөлийн татварын хууль гээд олон хуулиудыг боловсруулаад, Улсын Их Хуралд өргөн барьсан. Тэгээд Улсын Их Хурлын хэлэлцүүлгээр эцэслэн шийднэ шүү дээ. Хуулиа батлуулахын төлөө салбар явж байгаа.

Д.Амарбаясгалан: Иргэдээс ирүүлсэн асуултыг асууж, хариулт авч дууслаа.

Нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

--oOo--

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ**

№61

Эмхэтгэсэн:	Д.Энхмаа
Хянасан:	Ж.Монголжингоо Ч.Онончимэг
Эх бэлтгэсэн:	Б.Төгсзаяа

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хяналт шалгалтын газраас эрхлэн гаргав.

УИХ-ын Тамгын газрын Хэвлэх, олшруулах цехэд бэлтгэв.